

УЛС ТӨР & НИЙГЭМ

ДЭЭЖ МЭДЛЭГ



УЛС ТӨР & НИЙГЭМ

ДЭЭЖ МЭДЛЭГ

Улаанбаатар хот
2022 он

ДАА** 320

ННА* 66

У-314



УЛС ТӨР & НИЙГЭМ ДЭЭЖ МЭДЛЭГ

Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангаас эрхлэн гаргав.

Зохиогчийн эрх @ Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн
Суурин төлөөлөгчийн газар

- © Уг бүтээлийг зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр
бүхлээр нь болон хэсэгчлэн хэвлэх, хайлтын системд
байршуулах, бүх төрлийн хуулбар зэрэг ямар ч хэлбэрээр
хувилж, олшруулахыг Зохиогчийн эрхийн тухай хуулиар
хориглосон болно.

ISBN 978-9919-0-0149-0

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 7-8

Нэгдүгээр бүлэг. Монгол Улсын Үндсэн хууль 9

Нэг.	Үндсэн хуулийн товч түүх	9-16
Хоёр.	Үндсэн хуулийн бүтэц, агуулга	16-25
Гурав.	Үндсэн хууль ба Монголын нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт	25-33

Хоёрдугаар бүлэг. Монгол Улсын төрийн дээд байгууллагууд 34

Нэг.	Монгол Улсын Их Хурал	34-44
Хоёр.	Монгол Улсын Ерөнхийлөгч	44-53
Гурав.	Монгол Улсын Засгийн газар	53-67
Дөрөв.	Шүүх эрх мэдэл	67-85

Гуравдугаар бүлэг. Улс төрийн оролцоо, улс төрийн нам, ИНБ-ууд ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх танин мэдэхүйн ойлголт 87

1.	Бидний мэдэх улс төрийг энгийнээр тайлбарлавал... ..	90-93
2.	Иргэдийн улс төрийн оролцоо	93-102
3.	Иргэдийн идэвх, санаачлага хэрхэн илрэх вэ?	102-110
4.	Иргэний нийгмийн байгууллага, сонирхлын бүлгүүд улс төрд оролцох нь	110-120
5.	Улс төрийн нам: тодорхойлолт, бодлогын шалгуур ба санхүүжилт, дотоод ардчиллын шалгуурын тухайд	121-126
6.	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чиг үүрэг, хэтийн хандлага	126-129

Дөрөвдүгээр бүлэг. Нийгмийн хамгааллын улсын тухай үзэл баримтлал 136

1. Нийгмийн хамгааллын улсын тухай ойлголт 137-139
2. Либерализмын тухай үндсэн ойлголт 140-146
3. Монголын эдийн засгийн бодлого 146-157

Тавдугаар бүлэг. Монгол Улсын нийгмийн хамгаалал, түүний эрх зүйн зохицуулалт 158

1. Нийгмийн хамгааллын талаарх ойлголт 158-160
2. Монголын нийгмийн асрамж, халамжийн уламжлал 160-163
3. Монголын нийгмийн шилжилтийн үеийн буюу 1990-1995 оны нийгмийн хамгааллын бодлогын онцлог 164-172
4. Нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, зорилт 172-174

Зургаадугаар бүлэг. Олон улсын харилцаа олон өнгө, төрхтэй шинжлэх ухаан болох нь 175-193

Долоодугаар бүлэг. Монгол Улсын гадаад бодлого 194-214

ӨМНӨХ ҮГ

ХБНГУ -ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газраас эрхлэн энэхүү товхимолыг уншигчдын гарт хүргэж байна. Товхимолыг гаргаж байгаагийн зорилго нь уншигчид, юуны өмнө залуучуудад Монгол Улсын үндсэн хууль, уг хуулиар буй болсон улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, төрийн тогтолцоо болон тус улсын гадаад бодлогын өөрчлөлтийн талаар танилцуулах зорилготой юм. КАС-ийн суурин төлөөлөгчийн газар нь Монголын нийгмийн ардчиллыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн тогтолцоо, нутгийн удирдлага, төв орон нутгийн чиг үүргийн хуваарилалт гэх мэт олон асуудлаар судалгаа хийлгэх, ном, сэтгүүл гаргах зэрэг ажлыг хийж ирсэн юм.

Улс, нийгмийн ардчиллын үйл явц цаг хугацаа шаарддаг, бас ч саад бэрхшээл давж амжилтанд хүрдэг болохыг дэлхий дахины туршлага харуулж байна. Өөрчлөлт нь дан ганц шинэ хууль баталснаар буй болчихдоггүй байна. Үндсэн хуулиар буй болсон улс төр, төрийн тогтолцоог байгуулж, үйл ажиллагааг нь зүгшрүүлэх, иргэд нийтээрээ Үндсэн хуулийнхаа заалтыг мэддэг, үзэл санааг нь ойлгон, итгэл үнэмшил болгон сахидаг байх нь ардчиллын хөгжил, төгөлдөржилтийн баталгаа юм.

Товхимолын эхний бүлэгт Монгол Улсын Үндсэн хуулийн түүх, түүний бүтэц, ерөнхий агуулга, үндсэн хуулиар баталгаажуулсан улс төр, нийгмийн амьдралын зарчмуудыг танилцуулж байна. Хоёрдугаар бүлэгт шинэ Үндсэн хуулиар буй болсон Монгол Улсын төрийн тогтолцоог, төрийн эрх барих дээд байгууллагуудын Үндсэн хуулиар олгогдсон эрх хэмжээ, чиг үүрэг, өөр хоорондын харилцааны тухай асуудлыг танилцуулж байна. Нэгдүгээр бүлэг болон хоёрдугаар бүлгийн I, II, III дугаар зүйлийг шинжлэх ухааны

доктор, профессор А.Цанжид, хоёр дугаар бүлгийн IV зүйлийг докторант Ц.Ганхуяг бичсэн болно.

Доктор О.Хатанболдын бичсэн гурав дугаар бүлэгт улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагууд, сонгууль зэрэг ардчилсан үйл явцад оролцогч байгууллагууд, тэдний оролцооны гол арга хэрэгслийн талаар танилцуулж байна.

Дөрөвдүгээр бүлэгт ардчилсан нийгэм дэх эдийн засгийн дүр төрх, нийгмийн баримжаатай улсын тухай ойлголт, Монгол Улсын эдийн засгийн бодлогын тухай асуудлыг авч үзсэн юм. Энэ бүлгийг Эдийн засгийн шинжлэх ухааны доктор Б. Батхишиг бичсэн болно.

Тавдугаар бүлэг орчин үеийн олон улсын харилцаа, түүн дэх Монгол улсын оролцоо, Монгол Улсын гадаад бодлогын тухай асуудлыг багтааж байна. Энэ бүлгийг докторант Ц.Баянмөнх, VI, VII бүлгийг судлаач Н.Соёлгэрэл бичсэн болно. Тэдгээрт олон улсын харилцаа, Монгол Улсын гадаад бодлогын тухай авч үзжээ.

Энэхүү товхимолд багтаж байгаа өгүүллүүдийн агуулга нь дан ганц тэдгээрийг бичсэн эрдэмтдийн санаа бодол болно. Товхимол Монгол Улсын Үндсэн хууль, түүний агуулга, Үндсэн хуулиар эх суурийг нь тавьсан Монголын ардчилсан нийгмийн талаарх уншигчдын мэдлэгийг гүнзгийрүүлэхэд тус дөхөм болно хэмээн найдаж байна.

Профессор А.Цанжид

1

Нэгдүгээр бүлэг. Монгол Улсын үндсэн хууль

Профессор А.Цанжид

Нэг. Үндсэн хуулийн товч түүх

Монгол Улс бол Үндсэн хуультай болсон Ази тивийн анхны улс юм. Үндсэн хуулийг дэлхийн олон улсын хэлээр латин хэлнээс гаралтай “байгууламж, тогтоомж, нийлмэл” гэсэн утгатай *constitutio* — хэмээх үгнээс үүсгэн өөр өөрийн хэлээр “*constitution*”, “*constitución*”, “*costituzione*” гэх мэтээр нэрлэдэг. Гэвч Үндсэн хуулиа энэ үгний үндсэн утгыг илэрхийлдэг өөрийн хэлний үгээр нэрлэх нь ч элбэг. Тухайлбал, германаар “*verfassung*”, хинди хэлээр “*sanvidhaan*” (संविधान), лао хэлээр “*ladthathoamanun*” (ລັດຖະທຳມະນູນ) гэх мэтээр нэрлэдэг байна. Гэвч ямар ч улсад үндсэн хууль бол тухайн улсын гол хууль, эрх зүйн хамгийн дээд чадамжтай онцгой хууль байдаг. Үндсэн хууль нь улсын улстөр, эдийн засаг, эрх зүйн тогтолцоог тодорхойлон тогтооно. Үндсэн хууль нь тухайн улсыг байгуулж байгаагийн зорилгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, тусгаар улсыг байгуулсныг улс төр, эрх зүйн талаар үндэслэж байгаа баримт бичиг юм. Дэлхийн ихэнхи оронд анхныхаа Үндсэн хуулийг улс байгуулж буй анхдугаар хурлаараа, эсвэл бүх ард түмний санал асуулгаар баталдаг байна. Түүнчлэн үндсэн хууль нь ихэвчлэн бичмэл хэлбэртэй эрх зүйн нэг бүхэл баримт бичиг байдаг. Гэвч хэд хэдэн салгуу баримт бичигт үндсэн хуулийн шинжтэй заалтууд оруулсан (Швед, Испани гэх мэт), эсвэл маш олон тооны эрх зүйн баримт бичигт тусгасан заалтуудыг уламжлал болгон мөрддөг (Их Британи) зэрэг онцлог бий.

Үндсэн хууль бусад хуулиас ялгагдах хэд хэдэн онцлогтой. Үүнд:



- Улсыг байгуулдаг. Төрийн байгууламж, хэлбэр, төрийн дээд байгууллагын тогтолцоо, иргэдийн эрх үүрэг зэрэг гол гол заалтуудыг агуулна.
- Тухайн улсын бүх нутаг дэвсгэрт үйлчлэх эрх зүйн хамгийн дээд чадамжтай баримт бичиг байдаг.
- Ерөнхийдөө харьцангуй тогтвортой байдаг. Бусад хуультай харьцуулахад нэмэлт өөрчлөлт бага ордог.
- Бусад хуулийг гаргах суурь болдог. Бусад хуулиуд болон эрх зүйн аливаа баримт бичиг түүний хүрээнд, түүний дагуу гарна.
- Түүнийг батлах, өөрчлөх тусгайлсан дэгтэй байдаг.
- Ямар нэг байгууллага, албан тушаалтны батламж зөвшөөрөл шаардахгүйгээр улсын бүх нутаг дэвсгэрт шууд үйлчилж байдаг гэх мэт.

Монгол Улс 1911 онд Манж Чин улсаас тусгаарлаж тусгаар тогтнолоо зарласан. Хаант төр бүхий улс байгуулсан учир Үндсэн хууль баталсангүй. Богд Жавзандамбыг хаан сэнтийд залан их ёслол үйлдсэн болон Богд хаан төрийн яамдыг байгуулж, сайдуудыг тохоон томилсноор улсыг байгуулсан байна. Богд Жавзандамбыг анх эрдэнийн сууринаа залсан ерөөлийн үгэнд “одоо үүнээс аливаа харшлахын шалтгаан нэрийн төдий ч сонсдохгүй, зохилдохын шалтгаан ер хүсэлтэйгээр хурын үргэлжлэл мэт аяндаа хуран чуулж амьтан бүхнийг өнө үүрд амгалангийн их далайд хангуулан цэнгүүлэх хийгээд **ялангуяа улсын алтан сурвалжит эрхэм үндсийг тасралт үгүйгээр залгамжилснаар монгол овогтон олон шавь боолчууд сүлд баяр билгийг хичээе ...**” хэмээсэн нь улсаа сэргээн байгуулж, хаанаа өргөмжлөн тусгаар улсаа байгуулснаа илтгэсэн хэрэг юм (Ж. Амарсанаа, 2012, 15). Энд тод үсгээр бичсэн “улсын алтан сурвалжит эрхэм үндэс” хэмээх үг нь өнө эртний уламжлалтай төрт ёсоо таслахгүй үргэлжлүүлэхээр зориг шулуудсныг илэрхийлнэ.


1921 оны ардын хувьсгалын дараагаар улсын үндсэн хуулийг зохиох ажлыг эхэлжээ. Үндсэн хууль боловсруулах комиссыг анх 1922 оны V сарын 19 -нд Шүүх яамны сайд Н.Магсаржав



Богд Хаант Монгол Улсын төрийн сүлд, далбаа

хурц, Ж. Цэвээн, Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэй байгуулж “... Англи мэт улсын хуулиас товчлон авч эдүгээгийн явуулан буй засгийн байдалд нийлүүлэн зохиох” удирдамж өгчээ. (Монгол Улсын түүх, V боть, 2003, 151). Уг комисс Англи, Швед, Бельги, Голланд зэрэг улсын үндсэн хууль ба үндсэн хуулийн чанартай баримт бичгүүд, бусад бичиг зохиолыг судалж, заримыг нь орчуулсан байна. Үндсэн хууль зохиох комисст өгсөн удирдамжийн агуулга болон комисс гол төлөв хаант засагтай орны үндсэн хууль, холбогдох баримт бичгийг судалсныг үзвэл тэр үед Монгол Улсын эрх баригчид өөрийн улсыг “Үндсэн хууль хаант засагтай улс” болгохыг эрмэлзэж байсан нь илт байна. Гэвч тэр үед Монголд байсан Коминтерний төлөөлөгчид болон Зөвлөлтийн мэргэжилтнүүд зөвлөлт маягийн үндсэн хууль боловсруулахыг тулган, хөндлөнгөөс оролцож байсан учраас бэрхшээл гарч, үндсэн хууль боловсруулах комиссыг дахин байгуулсан байна. Уг комисст Ерөнхий сайд Б. Цэрэндорж, Ж. Цэвээн, Э. Ринчино, Гомбобадамжав нар орсон байна. Тэдний боловсруулсан төслийг 1924 оны XI сард Улсын Анхдугаар их хурлаар хэлэлцэн XI сарын 26 -нд баталсан байна. Анхдугаар Үндсэн хууль нь оршил, 6 бүлэг, 50 зүйлтэй байжээ. Үндсэн хуулиар Тус улсыг Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс” гэж нэрийдэж, “Бүгд найрамдах засгийг явуулах” -аар тунхагласан байна. Үндсэн хуулийн II зүйлд БНМАУ-ын зорилт бол “хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр устгаж, улс төрийн захиргааны явдлыг

жинхэн ардын ёсонд” нийлүүлэх тухай анги ялгаварлсан заалт оруулсан байна. Төрийн тогтолцоог бүрдүүлэхдээ улсын дээд эрхийг Улсын Их Хурал, түүний чөлөө цагт Улсын бага хурал барихаар заажээ. Улсын бага хурал нь их хурлынхаа адилаар байнгын бус ажиллагаатай учир түүний чөлөө цагаар Бага хурлын тэргүүлэгчид, Засгийн газар хоёр хамтран улсын эрх барихаар хуульчилсан байна. Улсын сүлд нь лянхуа цэцгэн суурь дээр соёмбо тэмдэг, улсын туг далбаа нь голдоо улсын сүлдтэй улаан өнгөтэй байна гэж заажээ.



Анхны үндсэн хуулийн эх

Хэдийгээр Зөвлөлтийн үндсэн хуулийн загварыг баримталсан боловч “анхдугаар Үндсэн хууль нь бүхэлдээ Монголын түүхэнд анх удаагаа хаант ёсыг халж, үндэсний ардчилсан өөрчлөлт, эрх зүйн чухал зарчмууд, улс төрийн шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулж, Бүгд найрамдах улсыг тунхаглан зарласнаараа түүхэн ач холбогдолтой” юм (Монгол Улсын түүх, V боть, 2003, 151).



Монгол Улсын төрийн сүлд, далбаа (1924-1940)

Үндсэн хуулиа баталсан нь олон улсын байдал таагүй байсан тэр үеийн нөхцөлд тусгаар тогтнолоо хадгалахад чухал болсон байна. Гэвч гаднын нөлөөгөөр анхны төлөвлөж байсан Үндсэн хуульт хаант засаг бүхий Бүгд найрамдах улсыг буй болгож чадаагүй байна. Уг хуульд ардчилсан ёсны зарчмууд тунхаглагдсан боловч бусдыг зарж амьдрагчид, худалдаачид, мөнгө хүүлэгчид, урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, хийдэд байнга суудаг лам нарын сонгуулийн эрхийг хассан байна.

Монгол Улс 1940 оны VI сард хуралдсан Улсын VIII их хурлаар шинэ Үндсэн хуулийг баталсан байна. Түүний төслийг бүх ард түмнээр хэлэлцүүлж, гарсан саналыг тусгасан байна. Уг хууль 12 бүлэг 95 зүйлээс бүрдэж байв. Түүний I дүгээр зүйлд Бүгд Найрамдах Монгол Ард Улс хөрөнгөтний бус хөгжлийн замаар замнах болно гэдгийг заасан байна. Төрийн тогтолцоог төрийн дээд эрхийг барих Улсын Их хурал, Улсын бага хурал, түүний чөлөө цагт ажиллах Бага хурлын тэргүүлэгчидтэй байхаар хуульчилсан байна. Тус улсын гүйцэтгэн захирах дээд байгууллага болох

Сайд нарын Зөвлөл, түүнд харъяалагдах газрууд, яамд, орон нутгийн захиргааны байгууллагуудын байгуулагдах журам, эрх хэмжээ, гүйцэтгэх үүрэг, хийх ажлыг тодорхой заан хуульчилсан байна. Түүнд “Ард иргэдийн үндсэн эрх ба үүргүүд” хэмээх бүлгийг шинээр нэмж, эрх үүргийг хуульчилсан байна. Мөн улсын сүлд, тугийг шинэчилэн баталсан байна. Улсын сүлд тэмдэг нь голдоо давхиж яваа морь унасан ард, эргэн тойрондоо бусад дөрвөн хошуу малын дүрстэй, доод хэсэгт буй улаан туузан даар “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэсэн бичигтэй байна гэж өөрчилжээ. Харин туг нь өмнөх тугийн адил боловч гагцхүү голдоо “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэсэн бичигтэй байна гэжээ. Иргэдийн сонгуулийн эрхийг анги ялгаварлан хассан заалт хэвээр үлдсэн байна.

Улсын найм дугаар их хурлаар Үндсэн хуулийг баталснаас хойш түүнд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулснаас гадна Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн хурлаас Үндсэн хуулийн заалтын шинжтэй шийдвэрүүдийг гаргаж байжээ. Тэдгээрээс зарим чухлыг нь дурдвал 1944 оны IX сард Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор өмнө нь сонгуулийн эрхийг нь хассан байсан тус улсын харъяат бүх хүнд сонгуулийн эрх олгожээ. Ингэснээр ухаан мэдрэл муу болон ял эдэлж буй хүмүүсээс бусад Монгол Улсын нийт иргэд сонгуулийн эрхтэй болжээ. 1949 оны II сард хуралдсан Улсын IX хурлаас Улсын бага хурлыг татан буулгаж, улсын эрх барих дээд байгууллага бол дан ганц Улсын Их Хурал байхаар болжээ. Түүнчлэн сонгуулийн шинэ системийг буй болгож, өмнө нь баримталж байсан олон шаттай, ил сонгуулийг өөрчлөн бүх шатны сонгуулийг бүх нийтээр тэгш эрхтэй оролцож,



БНМАУ-ын төрийн сүлд, далбаа (1940-1960)

нууцаар саналаа гаргадаг байхаар болсон байна. 1951 онд Улсын Их хурлын сонгуулийг энэ системийг үндэслэн явуулсан байна.

1960 онд гурав дахь удаагаа шинэ Үндсэн хуулийг баталсан байна. Шинэ Үндсэн хууль 10 бүлэг, 94 зүйлтэй байв. Эл Үндсэн хуулиар тус улсыг социалист улс мөн хэмээн тодорхойлжээ. Улсын Их Хурлыг Ардыг Их хурал болгон нэрийг нь өөрчилсөн ба улсын сүлд тэмдэг, далбааг шинэчилсэн байна.



БНМАУ-ын төрийн сүлд, далбаа (1960-1992)

Үндсэн хууль улс орны амьдралын бүхий л талыг социалист зарчимд нийцүүлэхэд чиглэсэн агуулгатай болжээ. Энэ Үндсэн хууль нэг намын ноёрхлыг баталгаажуулж “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог Монгол Ардын Хувьсгалт Нам мөн” хэмээн заажээ. Улсын Их Хурлыг Ардын Их хурал хэмээн нэрийг нь өөрчилсөн байна.

1990 онд болсон ардчилсан өөрчлөлтийн үр дүнд Монгол Улс 1992 онд дөрөв дэх шинэ Үндсэн хуулиа баталжээ. Түүнийг анх удаа олон намын оролцоотой болсон бүх нийтийн ардчилсан сонгуулиар байгуулагдсан Ардын Их хурал хэлэлцэн баталсан байна. Шинэ үндсэн хуулийг боловсруулж эхэлснээс батлах хүртэлх үйл ажиллагаа хоёр жил үргэлжилсэн байна. 1990 оны V сард АИХ -ын чуулганаар БНМАУ-ын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, ардчилсан улс төрийн тогтолцооны үндэс суурийг тавих эрх зүйн нөхцөлийг бүрдүүлсэн байна. Уг өөрчлөлтөөр АИХ -аас гадна байнгын ажиллагаатай Улсын Бага хурлыг буй болгож,

Монгол Улс Ерөнхийлөгчтэй байхаар хуульчилсан байна. УБХ нь дарга, орлогч дарга, 50 гишүүнээс бүрдэж байсан ба түүний суудлыг улс төрийн намуудын талаар явуулсан бүх ард түмний санал асуулгаар хуваарилсан байна. УБХ ардчилсан ёс, зах зээлийн харилцаанд шилжихэд чиглэсэн хуулиудыг батлан гаргасны дотор Үндсэн хуулийн төслийг боловсруулан АИХ-д оруулан хэлэлцүүлсэн юм. Төслийг нийт ард түмнээр хэлэлцүүлэн, улс төрийн намуудын саналыг авч тусгасан байна. Үндсэн хууль батлагдсны дараагаар УБХ -аас шинэ Үндсэн хуулийн дагуу байгуулагдах анхны ардчилсан бүрэлдэхүүнтэй Улсын Их Хурлыг байгуулах сонгуулийн хуулийг боловсруулан баталсан байна. Үндсэн хуулийн төслийг хэлэлцэхэд 7 мянга гаруй байгууллага, 900 мянга гаруй хүн оролцож, 200 мянга гаруй саналыг тусган УБХ хоёр удаа хэлэлцсэн байна. УБХ -аас өргөн барьсан төслийг АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2 -р хуралдаанаар 76 хоног хэлэлцэн 1992 оны I сарын 13 -нд баталжээ.

Хоёр. Үндсэн хуулийн бүтэц, агуулга

Шинэ Үндсэн хууль 6 бүлэг 70 зүйлтэй. Түүний бүтцийг бүлгүүдээр нь харуулъя.

Нэгдүгээр бүлэг. Монгол Улсын бүрэн эрхт байдал. (1-13 -р зүйл)

Хоёр дугаар бүлэг. Хүний эрх, эрх чөлөө (14-19 -р зүйл)

Гуравдугаар бүлэг. Монгол Улсын төрийн байгуулал. (20-56 -р зүйл)

Нэг. Монгол Улсын Их хурал (20- 29 -р зүйл)

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгч (30-37 -р зүйл)

Гурав. Монгол Улсын засгийн газар. (38-46 -р зүйл)

Дөрөв. Шүүх эрх мэдэл. (47-56 -р зүйл)

Дөрөвдүгээр бүлэг. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага. (57-63 -р зүйл)

Тавдугаар бүлэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц (64-67 -р зүйл)

Зургадугаар бүлэг. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах. (68-70 -р зүйл)

Нэгдүгээр бүлэгт Монгол Улсаа тодорхойлсон байна. Тухайлбал,

- Үндсэн хуулийн энэ бүлэгт тодорхойлсноор тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд Найрамдах улс бөгөөд төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс мөн.
- Засгийн бүх эрх ард түмний гарт байна.
- Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна.
- Монгол Улс олон хэвшилт эдийн засагтай байна
- Өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.
- Төр эдийн засгийг зохицуулдаг байна
- Мал сүрэг төрийн хамгаалалтад байна.
- Газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна.
- Газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлж, гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүнд тусгай болзолтойгоор ашиглуулж болно.
- Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэнэ.

Үндсэн хуулийн эдгээр заалтууд нь манай улсын шинж чанарыг илэрхийлж, дүр төрхийг нь тодорхойлж байгаа юм. Энэ бүлэгт Монгол Улсын одоо хэрэглэж байгаа бэлгэ тэмдгүүдийг нэр заан баталгаажуулсан байна. Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал зэрэг нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг мөн гэж заажээ. Түүнчлэн Улаанбаатар хот бол тус улсын нийслэл мөн гэдгийг хуульчилсан байна.

Хоёр дугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг ардчилсан ёсонд нийцүүлэн, хүний эрх, эрх чөлөөний тухай олон улсын баримт бичгийн агуулгын хэмжээнд хуульчилан баталгаажуулснаараа өмнөх үндсэн хуулиудаас эрс ялгаатай юм. Үндсэн хуулийн 16 -р зүйлд иргэний эрх, үндсэн эрх чөлөөг 18 төрөлд ангилан тодорхойлж, эдгээрийг иргэд баталгаатай эдлэнэ хэмээн заажээ. Эдгээр эрх, эрх чөлөөг товч байдлаар илэрхийлбэл:

- Амьд явах
- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах
- Хөдлөх, үл хөдлөх өмчтэй байх
- Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох
- Хуульд заасан тодорхой тохиолдлуудад эд, мөнгөний тусламж авах
- Эрүүл мэндээ хамгаалуулах
- Сурч боловсрох
- Бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх, бүтээлийн эрхээ хуулиар хамгаалуулах
- Төрийг удирдах хэрэгт хуулийн дагуу оролцох
- Сайн дуураараа эвлэлдэн нэгдэх, нам, олон нийтийн болон бусад байгууллагыг байгуулах
- Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байх
- Төрийн байгууллага, ажилтанд өргөдөл, гомдол гаргаж, хуулийн дагуу шийдвэрлүүлэх
- Халдашгүй, чөлөөтэй байх эрх эдлэх. Хуулиас гадуур хэн нэгнийг баривчлах, хорих, нэгжих, мөрдөн мөшгөх зэргээр эрх чөлөөг хязгаарлахыг хориглох. Хүнд эрүү шүүлт тулгаж, хэрцгий хандаж, нэр төрийг нь гутаахыг мөн хориглох
- Эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах
- Шашин шүтэх, эс шүтэх
- Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх
- Төрийн нууцаас бусад асуудлаар төр, түүний байгууллагаас мэдээлэл авах, хайх,

- Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох, гадаад явах, буцаж ирэх зэрэг болно.

Иргэд эдгээр эрхийг баталгаатай эдлэнэ гэж заасны учир бол төрөөс иргэн эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, хамгаалах, эрх зөрчигдсөн тохиолдолд залруулах ёстой гэсэн үг юм. Үндсэн хуульд “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заажээ. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй хэмээн заасан нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах онцгой нөхцөлүүд юм.

Энэ бүлэгт Монгол улсын иргэн хүнлэг шударга ёсыг эрхэмлэн үндсэн үүргээ ёсчлон биелүүлдэг байна гэж заасан. Иргэний үндсэн үүрэгт:

- Үндсэн хууль бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх
- Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
- Хуулиар ногдуулсан албан татвар төлөх
- Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах зэрэг болно.

Үүнээс гадна Монгол Улсын иргэн хөдөлмөрлөх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах журамт үүрэгтэй байна хэмээн заажээ. Иргэний үндсэн үүрэг бол иргэн бүр заавал биелүүлэх ёстой үүргүүд юм.

Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгт Монгол Улсын төрийн байгууллыг тодорхойлсон байна. Энэ бүлэгт буй Монгол Улсын Их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүх эрх мэдлийн талаар хойно илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.



Монгол Улсын төрийн сүлд, далбаа

Үндсэн хуулийн тавдугаар бүлэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай заалтууд багтаж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагддаг. Үндсэн хуульд аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг нийгмийн цогцолбор мөн хэмээн тодорхойлсон байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хэмээн үзэхийн учир нь:

- Тэдгээрийг байгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлыг тухайн нутгийн Хурал, тэнд аж төрж буй иргэдийн саналд үндэслэн Улсын Их хурал шийдвэрлэдэг.
- Тодорхой хилээр бусад нэгжээс тусгаарлагдсан нутаг дэвсгэртэй байдаг. Хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их хурал батлана.
- Хуулиар хүлээсэн чиг үүрэг бүхий удирдлагатай байна
- Нутаг дэвсгэртээ эдийн засаг, нийгмийн үйл ажиллагааг бие даан явуулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэгтэй байх ба чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулсан төсөвтэй байна.
- Өөрийн өмчтэй байна

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь өвөрмөц онцлогтой. Энэхүү онцлог нь нутгийн удирдлагад иргэдийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчмаар илэрхийлэгддэг. Иргэдийн өөрөө удирдах ёс гэдэг бол:



- иргэд тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн болон бусад асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар бүгдээрээ хэлэлцэн олонхын саналаар шийдвэр гаргах,
- Гаргасан шийдвэрээ өөрсдөө хэрэгжүүлэх,
- Шийдвэрийн зөв бурууг болон түүнийг хэрэгжүүлсний үр дүнгийн талаарх хариуцлагыг өөрсдөө хүлээх зэрэгт үндэслэнэ.

Харин төрийн удирдлага гэдэг бол төрийн дээд болон төв байгууллагуудаас улс орон даяар хэрэгжих учиртай нийтлэг шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжүүлэх явдал юм. Эдгээр шийдвэрүүд, ялангуяа хуулийг төрийн эрх мэдлийн хүчээр албадан хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, хуулийг зөрчсөний, хэрэгжүүлээгүйн төлөө хуулинд заасан зохих хэмжээний шийтгэлийг ногдуулдаг гэсэн үг юм. Ийм шийтгэл нь торгохоос эхлэн шоронд хорих хүртэл олон төрөлтэй байдаг. Ийм учраас хуулийг төрийн эрх мэдлийн хүчээр албадан хэрэгжүүлдэг хэмээн үздэг байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь ийм хоёр төрлийн удирдлагыг хослуулж байдаг. Эхлээд өөрөө удирдах ёсны зохион байгуулалтын талаар авч үзье.

Иргэдийн өөрөө удирдах ёс нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, баг, хороонд иргэдийн нийтийн хурлын хэлбэртэй байдаг. Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь маш олон хүн амтай. Манай улсын хамгийн жижиг аймаг болох Говьсүмбэр аймаг 2021 оны эцсийн байдлаар 18 150 хүн амтай байсан бол хамгийн олон хүн амтай Хөвсгөл аймаг 136 794 хүн амтай байжээ. Улаанбаатар хот гэхэд 1,639,172 хүн амтай байжээ. Аймагууд, нийслэлийн хүн ам ийм олон байгаа нь иргэд нийтээрээ цуглаад ямар нэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх боломжгүй болгож байгаа юм. Ийм учраас иргэд дундаасаа төлөөлөгч сонгож, хурлаа байгуулдаг. Сумд гол төлөв хоёр мянгаас дээш хүн амтай байхаас гадна, суурьшил таруу, малаа цаг ямагт хариулгатай байлгах зэрэг болон манай орны амьдрлын онцлогтой холбоотойгоор бас л бүгдээрээ цугларч хуралдах боломжгүй

байдаг учраас Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг байгуулдаг. Нийслэлийн дүүргүүд аймгаас ч олон хүнтэй байдаг учраас мөн л иргэд өөрийн удирдлагыг төлөөлөгчдөөрөө дамжуулан хэрэгжүүлдэг байна. Баг, хороонд иргэд нийтийн хурлаараа асуудлаа шийдвэрлэх учиртай. Гэвч хороо маш олон хүн амтай байдаг, хөдөөгийн багийн иргэд ажил төрлийнхөө онцлогоос хамааран бодит байдалд бас л бүгдээрээ цуглах боломжгүй байдаг. Хүн бүр өөрийн хүслээр нийтийн хуралд оролцож болно. Энэ нь зарчмын хувьд бүгдээрээ хуралд ирж болно гэсэн үг. Гэвч бодит байдалд хэзээ ч бүгдээрээ ирдэггүй. Үүнээс үүдэн иргэдийн нийтийн хуралд оролцогчдын тооны дээд хязгаарыг тогтоодоггүй ба харин доод хязгаарыг хуулиар тогтоосон байдаг. Энэ нь хурлын ирц уг хязгаарыг давсан тохиолдолд хурал, түүний шийдвэр хүчин төгөлдөр болно гэсэн үг юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд “Тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн болон хорооны хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд гурван өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт таван өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хорооны хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно” хэмээн заасан байна. Иргэдийн хурлыг тухайн нэгжид оршин суугаа иргэдийн оролцоотой ардчилсан сонгуулиар дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Хурал дотроосоо тэргүүлэгчид, даргаа сонгоно. Тэргүүлэгчид нь хуралдааны чөлөө цагт өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байна.

Орон нутагт төрийн удирдлагыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хэрэгжүүлнэ. Үндсэн хуульд түүнийг засаг төрийн төлөөлөгч хэмээн тодорхойлсон байдаг. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас нэрийг нь дэвшүүлж, аймаг, нийслэлийн засаг даргыг Ерөнхий сайд, сум, дүүргийн засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн засаг дарга тус тус

мөн дөрвөн жилийн хугацаагаар томилно. Үндсэн хуульд хурал болон засаг даргын харилцааны үндсэн зарчмыг тодорхойлсон байдаг. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Засаг даргыг огцруулах саналыг тавьж болно. Засаг дарга хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй байдаг. Түүний тавьсан хоригийг хурал төлөөлөгчдийн олонхын саналаар хүлээн авахаас татгалзвал уг шийдвэрийг засаг дарга заавал биелүүлэх юмуу эсвэл огцрох тухай саналаа гаргаж болно.

Үндсэн хуульд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон засаг даргын эрх хэмжээг зарчмын хувьд ерөнхий заасан байдаг бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нарийвчлан заасан байдаг. Үндсэн хуулийн заалтын дагуу Засаг дарга нь:

- Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг биелүүлнэ.
- Хууль тогтоомж, Засгийн газар болон харъяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийг тухайн орон нутагтаа хэрэгжүүлнэ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь:

- Тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй. Тэгэхдээ Үндсэн хууль, хууль, тогтоомж, харъяалах дээд байгууллагын тухайн асуудлаар гарсан шийдвэрт нийцүүлэн ажиллах ёстой.
- Улсын хэмжээний юмуу, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд тухайн нутаг дэвсгэрийн хүн амыг зохион байгуулах үүрэгтэй.

Үндсэн хуульд заасан засаг дарга, иргэдийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нарийвчилан, аймгийн, сумын гэх мэтээр засаг захиргааны шат бүрээр зааглан хуульчилсан байна. Мөн түүнчлэн орон нутгийн нэгжийн удирдлагаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг

үүргүүдийг нэрлэсэн байдаг.

Үндсэн хуулийн тавдугаар бүлэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй. Тийм учраас Цэц бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж байх үүрэгтэй. Цэц, түүний гишүүд аливаа албан байгууллага, хүмүүсээс хараат бус, зөвхөн Үндсэн хуулинд захирагддаг байгууллага юм. Үндсэн хуулийн цэц зургаан жилийн хугацаагаар сонгогддог есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их хурал, Гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг нь Улсын дээд шүүх санал болгож, Улсын Их Хурал томилдог. Үндсэн хууль зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг иргэд гаргах эрхтэй байдаг. Мөн Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын ерөнхий прокурор аливаа асуудал Үндсэн хууль зөрчсөн эсэхийг магадлуулахаар хүсэлт гаргаж болно. Үндсэн хуулийн цэц иргэдийн өргөдөл, холбогдох байгууллагын хүсэлтийн дагуу маргааныг хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан тодорхой асуудлаар дүгнэлт гарган Улсын Их хуралд оруулах эрхтэй. Хууль, зарлиг, Улсын Их хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, ард нийтийн санал асуулга, Улсын Их хурал, түүний гишүүний ба ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар гаргасан дүгнэлтийг нь Улсын Их Хурал хэлэлцээд хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзээд эцсийн шийдвэр гаргадаг. Хэрвээ эцсийн шийдвэр нь дээрх асуудлуудаар гаргасан аливаа шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй, түүнийг зөрчсөн байна гэж гарвал тэдгээр шийдвэр хүчингүй болдог байна.

Үндсэн хуулийн зургадугаар бүлэг нь Үндсэн хуульд өөрт нь нэмэлт өөрчлөлт оруулах болон түүнийг өөрчлөх тухай хэм хэмжээг агуулсан байдаг. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа:



- Хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан санал гаргаснаар Улсын Их хурал хэлэлцэж,
- Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёрын саналаар ард нийтийн санал асуулга явуулж
- Нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг Улсын Их хурлаар хэлэлцэж, түүний нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй хувь нь дэмжсэнээр батална.

Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хоёр удаа авч хэлэлцэхэд нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн саналыг аваагүй бол уг асуудлыг Улсын Их хурлын дараагийн сонгуулиар сонгогдсон шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин хэлэлцэхгүй. Түүнчлэн Улсын Их хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг хориглосон байдаг.

Үндсэн хуулийн төгсгөлд **“Мэдэгтүн, сахигтун”** хэмээн бичсэн байдаг. Энэ нь хууль, зарлигийг хүчин төгөлдөр болгож, ард нийтэд мэдээлэн, хэлбэрэлтгүй сахихыг анхааруулдаг байсан монгол төрийн уламжлалыг баримталж буй хэрэг мөн.

Гурав. Үндсэн хууль ба Монголын нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт

Шинэ Үндсэн хууль 1980 -аад оны сүүлч, 1990 -ээд оны эхэнд Монгол Улсад өрнөж байсан өөрчлөлт, шинэчлэлт, ардчиллын үйл явцын үр дүнг хуульчлан, тус улсыг Зөвлөлт маягийн социалист улсаас орчин үеийн ардчилсан улс орон болгох үндэс суурийг тавьж, нийгмийн амьдралын цаашдын өрнөлийг жолоодох хэм хэмжээг бүрдүүлсэн юм. 1990 оноос өмнөх үеийн Монгол улсын байдал төрхийг тодорхойлбол:

- Улс төрийн тогтолцооны хувьд улс төрийн нэг намын засаглал дангаар ноёрхсон, тэр үед олон нийтийн байгууллагууд хэмээн нэрлэгдэж байсан төрийн бус байгууллагууд засгийн эрхийг барьж байсан нэг намын туслах хүчин, дуулгавартай “зарц” нар байлаа.

- Эдийн засгийн салбарт дан ганц төрийн өмч ноёрхож байв. Эдийн засгийг төвлөрсөн төлөвлөгөөгөөр зохицуулж байв. Өрсөлдөөнгүй, үйлдвэрлэл үр ашиг багатай, бүтээмж хангалтгүй, бүтээгдэхүүний чанар сайнгүй байлаа.
- Оюун санааны хүрээнд зөвхөн марксист ленинист үзэл суртлыг мөрдлөг болгон, өөр үзэл санааг нухчин дардаг байв. Соёл урлагийг ноёлогч үзэл сурталд захируулан, бүтээх, туурвих эрх чөлөө хязгаарлагдмал байлаа.
- Хэдийгээр үндсэн хуульд эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийж, санаа бодлоо илэрхийлэх, сонгох, сонгогдох, шашин шүтэх болон эс шүтэх зэрэг хүний эрх, эрх чөлөөг тунхагласан боловч эдгээр нь бодитой бус, тунхаглалын чанартай байжээ. Шашин шүтэх, хувийн өмчтэй байх зэргийг хатуу хориглож, мөрдөн дарж байсан юм. Төрийн эрх барих сонгуулиар зөвхөн эрх баригч намын шилэн сонгож, нэр дэвшүүлсэн хүмүүсийн төлөө саналаа өгдөг байсан учраас олон ургальч үзлийг уралдуулан чөлөөтэй өрсөлдөх боломж хаалттай байв.

1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулиар энэ бүхнийг өөрчлөн Монгол Улсын иргэд нь Үндсэн хуулиараа тунхагласан эрх, эрх чөлөөг бодитой бөгөөд баталгаатай эдэлдэг ардчилсан улс болсон байна. Үндсэн хуулийн оршил нь энэхүү өөрчлөлтийн үндсэн шинж чанарыг илэрхийлсэн байна.

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,



- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна хэмээн дурдсан байдаг.

Энд Монгол Улсын иргэн бүрийн эрхэмлэж явах учиртай чин эрмэлзлийг тодорхойлсноос гадна манай нийгэм хүмүүнлэг, иргэний, ардчилсан шинжтэй байх ёстойг заажээ. Манай нийгмийн шинж чанарыг илтгэж байгаа эдгээр ойлголтуудын талаар товчхон авч үзье.

Хүмүүнлэг нийгэм гэж ямар нийгмийг хэлэх вэ? Энэ бол хүмүүнлэг ёсны үзэл санааг баримталдаг нийгэм юм. Энэхүү үзэл санааны гол агуулга бол хүнийг хамгийн дээд, эрхэм үнэт зүйл хэмээн үзэхэд оршино. Хүн хамгийн дээд үнэт зүйл учраас түүнд харгис хэрцгий хандах, дарлах зэргийг төдийгүй, нэр төр, үнэ хүндийг нь унагаахыг хориглоно. Түүгээр ч зогсохгүй хүн бүр тэгш эрхтэй байж хөгжих, хүсэл эрмэлзлээ биелүүлэх бололцоо нөхцөлөөр хангагдах ёстой. Хүний нэр төрийг хамгаалах, хүндэтгэх гэдэг бол түүнийг бие эрхтэн, үйлдэл, ажил мэргэжлийн янз бүрийн шинж чанарыг харгалзан гутаан доромжлож болохгүй гэсэн үг юм. Харин хүний үнэ хүндийг хамгаалах нь түүнтэй мал амьтантай, харьцаж байгаа мэтээр хандахыг хориглож, хүний нь хувьд тохирсон хүндэтгэл үзүүлэн хандана гэсэн үг юм. Хүн төрөлхтөний түүхийн янз бүрийн үед хүний махыг идэх, хүнийг боолчлох бурангуй үзэгдэл гарч байсан юм. Энэ бол хүний үнэ хүндийг үгүйсгэхийн жишээ юм. Нас барсан хүнд хүндэтгэл үзүүлэх, харамсан гашуудах, хүний ёсоор оршуулах зэрэг нь мөн л хүний үнэ хүндийг хамгаалж буй хэрэг юм.

Хүмүүнлэг ёс бол бас аж төрөх ёсны шинж чанар юм. Эерэг сайн сайхан зүйлд тэмүүлэх, зөв үйлдэл, зан үйлийг сайшаах, сөрөг муу зүйлийг үгүйсгэх зэрэг нь энэхүү аж төрөх ёсны шинж юм. Тийм ч учраас орчин үед аливаа амьтанд хэрцгий хандахыг хүртэл буруушаах болжээ. Гадаадын олон оронд амьтантай хэрцгий балмад байдлаар харьцахыг эсэргүүцэн

устгах, амьтан хамгаалах зорилго бүхий хөдөлгөөн өрнөх болжээ. Хүмүүнлэг нийгмийн гишүүн хувь хүн аливаа мухар сүсгээс ангид байж, бие даан чөлөөтэй үйл ажиллагаа явуулж, хөгжиж, хүмүүнлэг бус үйлдэл, зан авирыг цээрлэдэг байх учиртай. Хүмүүнлэг ёс нь ёс суртахуунтай салшгүй холбоотой байдаг.

Иргэний нийгэм. Иргэний нийгэм гэдэг ойлголтыг янз бүрээр тодорхойлдог. Хамгийн ерөнхий байдлаар хэлбэл иргэний нийгэм гэдэг бол төрийн зүгээс шууд оролцдоггүй, иргэд хоорондын, улс төрийн бус харилцааны хүрээ юм. Иргэд сайн дураараа нэгдэн янз бүрийн эвсэл холбоо байгуулж, чөлөөтэйгөөр өөрийгөө илэрхийлж байдаг харилцааны хүрээ юм. Энэхүү хүрээнд иргэд марк цуглуулагчдын клуб, барилгачид, уран бүтээлчдийн холбоо, спортын холбоод гэх мэт янз бүрийн байгууллагыг байгуулан, тэдгээгээрээ дамжуулан сонирхлоо илэрхийлэх, нийгэмд үйлчлэх, өөрийгөө хөгжүүлэх зэрэг янз бүрийн үйл ажиллагаа явуулна. Иргэдийн ийм төрлийн үйл ажиллагаа нь улс төрөөс ангид, төрийн шууд оролцоогүй өрнөж байдаг. Тэрч байтугай иргэдийн ийм чөлөөт үйл ажиллагаа саад бэрхшээлгүй явах бололцоог төр хангаж, хуулиар хамгаалж байдаг. Манай оронд олон байдаг төрийн бус гэж нэрлэгддэг байгууллагууд бол ийм иргэний нийгмийн байгууллагууд юм. Манай оронд одоо хорин мянга шахам төрийн бус байгууллага ажиллаж байна. Монгол Улсын Их хурал анх 1997 онд Төрийн бус байгууллагын тухай хуулийг баталжээ. Уг хуульд иргэдийн төрийн бус байгууллага байгуулах эрхийг баталгаажуулсан байдаг. Үүнд:

- Иргэд болон төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй,
- Иргэдийн төрийн бус байгууллага байгууллага байгуулах эрхийг хаах, хязгаарлахыг хориглох,
- Төрийн бус байгууллага байгуулах, түүнд орохыг албадахыг хориглох,
- Төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө

хүнийг ялгаварлан гадуурхах, эрх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох зэрэг заалттай байдаг.

Түүнчлэн, төрийн бус байгууллагатай төрийн зүгээс харилцах, түүнийг дэмжих хэм хэмжээг тогтоосон байдаг. Үүнд:

- Төрөөс төрийн бус байгууллагын хууль ёсны эрхийг хамгаалах,
- Төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байх,
- Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болох
- Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон төрийн болон албаны нууцад үл хамаарах мэдээлэл төрийн бус байгууллагад нээлттэй байх,
- Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн, төрийн бус байгууллагыг оролцуулах
- Төрийн бус байгууллага төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар байр сууриа илэрхийлж, мэдэгдэл хийх эрх эдлэх.

Түүнчлэн төрийн байгууллагын эрхэлдэг зарим үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой байдаг юм.

Үндсэн хуульд заасан манай нийгмийн бас нэг чухал шинж бол “ардчилсан” гэдэг нь юм. Ардчилал гэдэг бол ард түмний төлөө ард түмний засаглал мөн хэмээн тодорхойлдог. Ардчилал гэдэг нэр томьёо нь грек хэлний **δῆμος** «ард түмэн» болон засаг κράτος гэсэн хоёр үгнээс гаралтай дῆμοκρατία «ард түмний засаглал» гэсэн үг юм. Эсвэл энэ бол төр засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байдаг нийгэм ч гэж хэлдэг. Монгол улсын Үндсэн хуулинд төр засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байна хэмээн заажээ. Ард түмэн бүхэлдээ төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж засагладаг гэсэн үг. Үүнийг гадаад хэлээр ард түмний “сувернитет” буюу

ард түмний бүрэн эрх хэмээн хэлдэг. Үүний үндсэн санааг монгол хэлээр илэрхийлбэл “ард түмний өөртөө эзэрхэх эрх” гэсэн үг юм. Өөрөө өөртөө эзэн байна гэсэн санаа л даа. Эндээс дараачийн асуулт гарч ирнэ. Ард түмэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу засаглах гэж юу гэсэн үг вэ? Энэ бол бүх нийтээрээ, тухайн тусгаар тогтносон улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа бүх хүн заавал дагаж мөрдөх ёстой шийдвэр- хуулийг гаргаж, түүнийг биелүүлнэ гэсэн үг юм. Тийм болохоор ард түмэн нэг талаас засаглагч, нөгөө талаас тэдгээр шийдвэрийг даган мөрдөж хэрэгжүүлэгч байдаг. Гэвч эдгээр шийдвэрийг гаргах нь тийм амархан биш юм. Учир нь ард түмэн нийтээрээ ижил сонирхол, хэрэгцээтэй байдаггүй. Тариаланч тарьсан будаагаа аль болох өндөр үнээр борлуулахыг хичээнэ. Гурилын үйлдвэрүүд тэр үнэ дээр нь өөрийн зардал, бас ашгаа нэмж зарахыг хичээнэ. Гэтэл хэрэглэгчид аль болохоор хямд үнэтэй талхтай байх гэнэ. Бизнесийн салбарынхан татварыг аль болохоор бага байлгахыг хүснэ. Харин тэр татвараар цалинждаг, тэтгэвэр авдаг хүмүүс түүнийг их байлгахыг хүснэ. Нийгэмд байдаг энэ олон янзын сонирхол заримдаа хурцдаж, зөрчил мөргөлдөөнд хүрэх нь ч бий. Гэтэл бүх хүний сонирхолыг бүрэн хангасан шийдвэр гаргах боломж огт байдаггүй юм. Заавал нэг нь хохирох, нөгөө нь хожих явдал гарна. Дарангуйллын дэглэмийн үед дарангуйлагчид өөртөө ашигтай юмуу, зөв гэж үзсэн шийдвэрээ гаргаж, эсэргүүцэгчдийг нухчин дарна.

Гэвч тухайн нөхцөлд бүх талуудын сонирхлыг ямар нэг байдлаар харгалзсан, талууд хүлээн зөвшөөрч болохуйц, дундын гэмээр шийдвэр гаргаж болно. Асуудлыг ийм аргаар шийдвэрлэх боломж, нөхцөл зөвхөн ардчиллын үед л буй болдог. Үүний тулд ардчиллын суурь зарчим хэмээн нэрлэдэг тодорхой дүрмүүдийг мөрдөх хэрэгтэй байдаг. Тиймээс улс орон Үндсэн хуулиндаа уг зарчмуудыг тусган тунхаглаж, ард түмэн нийтээрээ үндсэн хуулиа дагаж мөрдөхийг зөвшөөрсөн байх учиртай.

Эдгээр зарчмуудын хамгийн эхнийх нь олонхын зарчим юм. Энэ нь шийдвэрийг гаргахад бүгдээрээ оролцож, асуудлыг олонхын саналаар шийддэг байна гэсэн үг юм. Нэгэнт

гарсан шийдвэрийг түүнийг дэмжсэн олонх ч, түүнтэй санал нийлэхгүй байгаа цөөнх ч хэрэгжүүлдэг байх ёстой. Энэ бол ардчиллын үндсэн дүрэм гэж болно. Саналын зөрүүтэй байдлыг ямар нэг зөрчилд хүргэхгүйгээр шийдвэрлэж байгаа хэрэг юм. Бүх шийдвэрийг гаргахад нэг л хэсэг хүмүүс дандаа олонх болно гэж байхгүй. Янз бүрийн асуудлыг шийдвэрлэхэд олонх, цөөнх солигдож байдаг гэсэн үг.

Эл зарчмаас урган гардаг өөр нэг зарчим бол цөөнхийн саналыг хүндэтгэх юм. Цөөнх болсон хүмүүс гарч байгаа шийдвэрийг нэг бол буруу гэж, эсвэл өөрсдөд нь хохиролтой гэж үзэж байгаа учраас л түний эсрэг саналтай байгаа хэрэг шүү дээ. Тийм учраас олонх нь цөөнхийн үзэл, санаа бодлыг анхааралтай сонсох, харгалзах, хамгийн гол нь цөөнх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх ёстой. Ялангуяа гарч буй шийдвэр цөөнхөд хэтэрхий хохиролтой байгаа үед олонх цөөнхийн саналыг үл тоомсорлох нь зөрчилд хүргэх, түүнийг хурцатгах аюултай юм. Олонх нь цөөнхийн саналыг хүндэтгэсэн үзэж сонсдог, гарах гэж байгаа шийдвэрт харгалздаг байваас л бидний дээр ярьсан бүгдээрээ хүлээн авч болохуйц, дундын гэмээр шийдвэр гарах боломж бүрдэнэ.

Дараачийн чухал зарчим бол шийдвэр гаргахад бүх нийтээрээ оролцох юм. Энэ бол нийгмийн бүх анги, бүлгүүд шийдвэр гаргахад оролцож, өөрсдийн үзэл бодол, сонирхлын үүднээс гарах гэж байгаа шийдвэрийн талаар тунгаан бодож, саналаа өгнө гэсэн үг. Тийм учраас жишээлбэл, улстөрийн аливаа сонгуульд /парламентийн, ерөнхийлөгчийн г.м./ улсын иргэд бүгдээрээ оролцох ёстой байдаг. Хүн төрөлхтөний түүхээс үзвэл, хүмүүсийг янз бүрийн байдлаар ялгаварлан, сонгуульд оролцох эрхийг нь хязгаарлаж байсан байдаг. Боолчууд, эмэгтэйчүүд, ядуу хүмүүс, тухайн орон нутагт үндсэн хөрөнгөгүй хүмүүс, бизнес эрхэлж байгаад дампуурсан хүмүүсийг сонгуульд оролцуулдаггүй байсан тохиолдол элбэг байжээ. Ийм хязгаарлалтууд аажмаар алга болж одоо ардчилсан хэмээн тооцогдож буй бүх улс оронд бүх нийтийн сонгуулийн эрх буй болжээ. Ял эдэлж буй болон мэдрэлийн өвчтэй гэдэг

нь эмнэлэгийн дүгнэлт магадлагаа, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хүмүүсээс бусад насанд хүрсэн бүх иргэд сонгуульд оролцдог. Насанд хүрсэн хүн гэдгийг ихэвчлэн 18 насаар, маш цөөхөн улсад 20 насанд хүрснээр тооцдог. Ийм насанд хүрсэн хүнийг бусдын тусламжгүйгээр бие даан шийдвэр гаргах чадамжтай болсон гэж үздэг учраас ийнхүү хязгаар тогтоодог байна. Сонгох эрхтэй салшгүй холбоотой эрх бол сонгогдох эрх юм. Дэлхий дахинд парламентийн гишүүн, ерөнхийлөгч, орон нутгийн хурлын гишүүн зэрэг сонгуульт албан тушаалд сонгогдох хүмүүст тухайн албан тушаалын онцлогоос хамааруулан насны, эрүүл мэндийн, оршин суусан хугацааны зэрэг болзолуудыг хуулиар тодорхойлсон байдаг. Учир нь эдгээр хүмүүс маш олон хүний хувь заяанд нөлөөлдөг шийдвэрүүдийг гаргах үүрэгтэй учраас зохих хэмжээний мэдлэг, туршлагатай байх хэрэгтэй байдаг.

Шийдвэр гаргахад бүх нийтээрээ оролцохын хамт тэдгээр хүмүүс тэгш эрхтэй байх ёстой. Үүнийг “нэг хүн - нэг санал” гэсэн зарчмыг хэрэглэн бодитой хэрэгжүүлдэг. Бизнесийн байгууллагад тухайн компанид эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээг харгалзан шийдвэр гаргахад оролцож байгаа хүмүүсийн санал харилцан адилгүй тоо хэмжээтэй байж болдог. Гэтэл улс төрд бол санал өгч байгаа хүний хөрөнгө чинээ, албан тушаал, боловсрол, нас, хүйс зэрэг ямарваа шинж чанараас үл хамааран хүн бүрийн өгсөн санал нэг л санал гэж тооцогдоно. Дотоод харилцаагаа ардчилсан ёсоор зохицуулдаг ашгийн бус байгууллагууд (нийтдээ төрийн бус байгууллага хэмээн нэрлэгддэг аливаа ажил мэргэжлийн холбоод, залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага г.м.) бас л дээрх зарчмуудыг мөрдлөг болгодог байна.

Хүн аливаа шийдвэрийг гаргахын тулд тухайн юмны талаар маш сайн мэддэг, энэ талаарх олон янзын мэдээллийг олж мэдсэн байх учиртай. Мэдэхгүй юмныхаа талаар санал өгөхөд хэцүү, нөгөө талаар өгсөн санал нь өөрийнх нь эрх ашигт хохиролтой байж ч болно. Тийм учраас хүний мэдэх эрхийг хангах нь чухал байдаг. Энэ нь ардчилсан аливаа нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хөгжсөн,

үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулдаг байхыг шаардана. Түүнээс гадна тэдгээр хэрэгсэл улс төрөөс юмуу, бизнесийн байгууллага зэрэг аливаа гаднын хүчнээс хараат бус, тэдний захиалгаар нийтлэл, нэвтрүүлэг явуулдаггүй байх ёстой. Телевиз, радио, сонин, нийгмийн сүлжээ зэрэг нь үүнд хамаарна. Эдгээр хэрэгслүүд мэдээллээ өөр хоорондоо хамааралгүй янз бүрийн эх сурвалжаас олж авдгийн дээр тэнд ажиллаж байгаа сэтгүүлчид өөр өөрийн үзэл бодол, итгэл үнэмшилтэй байдаг. Энэ нь тэдний ярьж бичиж байгаа зүйл өөр өөр, заримдаа бүр эсрэг тэсрэг ч болоход хүргэнэ. Хувь хүн эдгээр мэдээллийг уншиж сонсоод харьцуулан өөрийн бодол санаагаа цэгцэлж, зөв бурууг тунгаана. Ингэснээр саналаа таамгаар бус ухамсартайгаар өгөх чадвартай болдог. Хэрвээ тэгж чадахгүй бол бусдын ятгалга нөлөөнд орж, өөрийн эрх ашигт хортой шийдвэрийн төлөө саналаа өгөх ч тохиолдол гарч болох юм. Ийнхүү мэдээллийг олж авахаас гадна өөрөө ч бас санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг байх ёстой ба ийнхүү санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг нь хуулиар баталгаажуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, хүн санаа бодлоо илэрхийлсэний төлөө түүнийг шийтгэж, мөрдөж мөшгөхийг хуулиар хориглож, энэ эрхээ чөлөөтэй эдлэх боломжийг бүрдүүлсэн байдаг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой учраас ижил төстэй үзэл бодолтой хүмүүс нэгдэж улс төрийн нам байгуулж, төрийн эрхийг барихын төлөө өрсөлдөх, ТББ байгуулж сонирхлоо илэрхийлэх, хамгаалах нөхцөл бүрдэнэ.

Үндсэн хуулиар тунхагласан монголын нийгэм чухамхүү энд дурдсан зарчим, хэм хэмжээг хангах ёстой учраас “ардчилсан” хэмээн тодорхойлж байгаа юм.

2

Хоёрдугаар бүлэг. Монгол Улсын төрийн дээд байгууллагууд

Нэг. Монгол Улсын Их Хурал


Ардчилсан нийгэмд төрийн эрх мэдлийг хуваарилах, тэнцвэртэй байлгах зарчмыг баримтлан төрийн дээд байгууллагуудыг зохион байгуулдаг. Үүний тулд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх байгууллагыг тус тусад нь байгуулж, чиг үүргийг нь үндсэн хуулиар зааглан тодорхойлдог. Ингэхийн учир нь улс оронд төрийн бүх эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн нэг байгууллага үүсэхээс сэргийлж байгаа юм. Хуулийг зөвхөн нэг байгууллага, эсвэл нэг юмуу цөөн хэдхэн хүн өөрийн дур зоргоор тогтоодог, түүнийхээ дагуу улс нийгмийн амьдралыг удирддаг, бусад байгууллага, хүмүүсийн буруутай эсэхийг өөрөө шийддэг, шийтгэдэг, хүсвэл өмнөх хуулиа өөрчилдөг байх юм бол бүх эрх мэдэл нэг гарт төвлөрч, дарангуйллын засаглал тогтдог. Ийм байдал хэмжээгүй эрхтэй хаант засгийн үед юмуу, эсвэл цэргийн дарангуйлал тогтсон үед буй болдог байна. Хүн төрлөхтөний түүхэнд ийм гашуун туршлага элбэг бий. Тийм учраас хүн төрлөхтөн төрийн эрх мэдлийг хуваарилах, эрх мэдлийн салбар хооронд харилцан тэнцвэртэй байлгах, зохион байгуулалтын аргыг олж хэрэглэсэн юм. Манай оронд ч хаант засагтай байсан, нэг намын эрх мэдэл дангаар ноёрхож байсан үед төстэй байдалтай байсан юм. 1992 онд баталсан шинэ үндсэн хуулиар төрийн ийм тогтолцоог халж ардчилсан тогтолцоог буй болгосон юм.

Үндсэн хуулийн дагуу Монгол улсад хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал, гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар, шүүх эрх мэдлийг олон шатны шүүх хэрэгжүүлдэг. Тэгэхдээ төрийн дээд байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангахын тулд тэнцвэржүүлэх механизмыг хуулиар тогтоосон байдаг. Үүний тулд дээр дурдсан гурван

байгууллага тус бүрийн үйл ажиллагаанд бусад нь хяналт тавих эрхтэй байхаар хуульчилсан байдаг. Тухайлбал, хууль тогтоох эрхийг зөвхөн Улсын их хурал эдлэх боловч хуулийг тайбарлах эрхийг Улсын дээд шүүх эдлэнэ. Ерөнхийлөгч болон Засгийн газар хууль санаачлах эрхийг эдлэнэ. Эдгээр нь хууль тогтоох талаарх Улсын их хурлын эрх мэдлийг гүйцэтгэх болон шүүх салбарт олгосон эрхүүдээр тэнцвэржүүлж байгаа хэрэг юм.

Хууль тогтоох байгууллагын тухай ярихын өмнө төрийн хэлбэрийн тухай ярьвал цаашдаа илүү ойлгомжтой болно. Ардчилсан орнуудын төрийн хэлбэрийг ерөнхийд нь парламентийн бүгд найрамдах улс, ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс хэмээн хоёр ангилдаг. Парламентийн бүгд найрамдах улсад парламент нь бүх нийтийн сонгуулиар байгуулагдах ба парламентад олонх суудал авсан нам, эвсэл засгийн газрыг байгуулдаг. Ерөнхийлөгч нь парламент юмуу, парламентийн гишүүдээс гадна орон нугийн төлөөлөгчид оролцсон хурлаас сонгогдоно. Засгийн газрыг ерөнхий сайд толгойлно. Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсад парламент болон ерөнхийлөгчийн аль аль нь бүх ард түмний сонгуулиар тодорно. Ерөнхийлөгч өөрөө засгийн газрын тэргүүн байдаг. Гэвч дэлхийн улс орнуудад эл үндсэн хоёр хэлбэрийн аль алиний нь шинжийг агуулсан завсрын гэмээр хэлбэртэй төр бүхий улсууд олон байдаг. Жишээлбэл, Франц, ОХУ зэрэг улсад парламентад олонх суудал авсан нам засгийн газрыг байгуулж, ерөнхий сайд засгийн газрыг толгойлон ажиллахын зэрэгцээ ерөнхийлөгч нь бүх ард түмний саналаар сонгогддог, харьцангуй өргөн эрх мэдэлтэй байдаг. Ийм улсыг хүчтэй ерөнхийлөгчтэй хэмээн тодорхойлдог. Судлаачид ийм завсрын маягтай хэлбэр бүхий төртэй улсуудыг “хүчтэй ерөнхийлөгчтэй”, “хагас буюу холимог засаглалтай” гэх мэтээр янз бүрээр тодорхойлдог байна. Улс орнуудыг ийнхүү төрийн хэлбэрээр нь ангилахдаа ерөнхийлөгчид хуулиар олгогдсон эрх мэдлийн нь цар хүрээнээс хамааруулан үздэг байна. Монгол Улсын хувьд эдгээр улстай төстэйгөөр УИХ- аас гадна Ерөнхийлөгч нийт ард түмний саналаар сонгогддог. Гэвч Монгол Улсын ерөнхийлөгч нь дээр дурдсан орны ерөнхийлөгчтэй

адил гүйцэтгэх засгийн ажилд гүнзгий оролцдоггүй бэлгэ тэмдэгийн шинжтэй байдаг. Судлаачид манай улсын Ерөнхийлөгч бүх ард түмний саналаар сонгогддог болон түүнд хуулиар олгогдсон эрх хэмжээ харьцангуй их байдгийг харгалзан Монгол Улсын төрийг “парламент ерөнхийлөгч хосолсон холимог”, “хагас ерөнхийлөгчийн засаглалтай” гэх мэтээр янз бүрээр тодорхойлсон байна.



Зураг 1. Монгол улсын шинэ үндсэн хуулиар буй болгосон Монгол Улсын төрийн тогтолцоо

Хууль тогтоох байгууллагыг ерөнхийд нь парламент хэмээн нэрлэдэг. Энэхүү нэр нь ярих гэсэн утгатай parler гэсэн үгнээс гаралтай бөгөөд зарим оронд хууль тогтоох байгууллагаа эл нэрээр нэрлэсэн байдаг (англ. parliament, фр. Parlement). Их Британи, Франц, Чех, Канад, Казакстан зэрэг олон оронд ийм байдаг байна. Гэтэл хууль тогтоох байгууллагаа уламжлалаа даган үндэсний хэлээрээ нэрлэх тохиолдол олон бий юм. Тухайлбал, ХБНГУ -д Бундестаг, Израилд Кнессет, Киргизэд Жогорху кенеш, Шведэд Риксдаг гэж нэрлэдэг байна. Ард түмний төлөөлөгчид цугларч асуудлыг шийдвэрлэдэг явдал эртний Грек, Ромоос эхлэн хэрэглэгдэж байжээ. Төв Азийн нүүдэлчид, ялангуяа монгол угсааны улсуудад хаад зонхилогчдоо сонгох, дайн хийх эсэх зэрэг томоохон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг эе хэмээх хурал эртнээс нааш байсаар иржээ.

Гэвч дэлхий дахины эрт үеийн болон дундад зууны үед байсан хуралдаанууд нь гол төлөв эрх мэдэлтэй дээд анги, давхаргынхан оролцдог зөвлөгөөний шинжтэй байсан байна. Хамгийн эртний парламент бол X зуунд үүссэн, Мэн арлын Тинвальд, Исландын Альтинг ажээ. Харин орчин үеийн парламент XIII зууны Англид үүссэн гэж үздэг байна. Тэр үед хааны дэргэд хааны зөвлөл хэмээх байгууллага буй болж, хаан түүний зөвшөөрөлгүйгээр татвар нэмэх эрхгүй болсон байна. Дэлхий дахины түүхээс үзвэл парламент нь эхэн үедээ хаант засаг болон ард түмний хоорондын зөрчлийг зөөллөх маягийн байгууллага байснаа аажмаар төрийн хууль тогтоох дээд байгууллага болон өөрчлөгдсөн байна.

Орчин үеийн ардчилсан улсуудад байдаг парламентийн онцлог шинж бол бүх нийтийн чөлөөт сонгуулийн үр дүнгээр байгуулагдаж, хууль тогтоох эрх мэдлийг дангаараа эдэлдэг явдал юм.

Монголчуудын түүхэнд янз бүрийн хэлбэртэй зөвлөлдөх байгууллага байнга байсаар иржээ. Эртний үедээ олон овгийн толгойлогчид оролцдог “эе” хэмээх хурал байжээ.

Их Монгол улсын үед “Их хуралдай” хэмээх байгууллага буй болж дайн хийх, бэлтгэлийг хангах, хаадыг тодруулах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг байжээ. Тэр нь хааны санаачлагаар зарлан хуралдуулдаг, язгууртны хурал байсан байна. Түүний гол цөм нь Чингис хааны алтан ургийнхан оролцсон зөвлөгөөн байжээ. Харин Хубилай хааны байгуулсан Юань гүрний үед алтан ургийнхан бүгдээрээ оролцдог журам эвдэгдэж, монгол төрийн бодлогын асуудлыг Хубилай хааны шадар монгол, хятад хүмүүс оролцдог ордны зөвлөгөөн болж хувирсан байна. Монголын Юань гүрэн мөхсөн XIV зууны төгсгөл үеэс “ноёдын чуулган” хийх болжээ. Учир нь монголчууд өөр зуураа тэмцэлдэн тархай бутархай харьцангуй биеэ даасан хэдэн хэсэг болсон байна. Ийм нөхцөлд томоохон ноёд цуглаж чуулан хууль тогтоодог болсон байна. Гэвч ийм чуулган нь нийт монголын хуралдай биш байснаар барахгүй чуулганы үеэр цус асгаруулсан тэмцэл ч гарах тохиолдол байсан байна. Гэсэн ч ноёдын чуулган нь зарим үед монголчуудыг нэгтгэх, нягтруулахад чиглэсэн чухал шийдвэр гаргаж байжээ. Жишээлбэл, 1639 онд болсон Цагаан нуурын чуулганаар Өндөр гэгээн Занабазарыг Халхын шарын шашны тэргүүнээр өргөмжилсөн нь түүхэн ач холбогдолтой болсон юм. 1640 онд Ил Тарвагатайн Улаан бураа гэдэг газар болсон чуулганаар нийт Монгол даяар мөрдөх Их цаазыг баталсан байна.

Монгол улс 1911 онд Манжаас салж, тусгаар улс болсны дараа парламенттай болох анхны оролдлогыг хийжээ. 1914 оны эхээр Ерөнхий сайд Т. Намнансүрэн, Сэцэн хан Ц. Навааннэрэн, Цэргийн яамны дэд сайд Жамъяндорж нар хамтран Улсын хурал байгуулах тухай өргөх бичгийг Богдод айлтгасан байна. Богд хаан зөвшөөрч “гуйсан ёсоор болгогтун” хэмээн цохсон байна. Улсын хурал дээд, доод гэсэн хоёр танхимтай байжээ. Түүний гишүүдийг томилдог байсан байна.

1921 оны хувьсгал ялсны дараа анхдугаар үндсэн хууль батлагдах хүртэл “Улсын түр” цагийн хурлыг байгуулжээ.

1924 оны 11 -р сэд Улсын анхдугаар их хурал хуралдаж Үндсэн хуулийг баталжээ. Анхдугаар үндсэн хуулиар Улсын Их Хурал ба түүний чөлөө цагт хуралдах Улсын Бага Хурлыг буй болгосон байна. 1960 оны Үндсэн хуулиар хууль тогтоох байгууллага – Ардын их хурлыг буй болгосон байна. Ардын их хурлын депутатыг бүх нийтийн сонгуулиар сонгодог байсан боловч, тэр үед Монгол Улс улс төрийн нэг намтай байсан учраас сонгууль өрсөлдөөнгүй болж, сонгогчид намаас дэвшүүлсэн хүмүүсийн төлөө саналаа өгдөг байсан учраас парламент нь жинхэнэ ардчилсан ёсны парламент биш байжээ. Улсын их хурал болон Ардын их хурал нь байнгын ажиллагаатай бус байсан байна.

1990 онд БНМАУ-ын Үндсэн хуульд нэмэлт оруулж, байнгын бус ажиллагаатай Ардын их хурал болон байнгын ажиллагаатай Улсын Бага хурлыг бүх нийтийн чөлөөт сонгуулиар байгуулжээ. Эдгээр хурлууд 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдах хүртэл үйл ажиллагаа явуулж байгаад мөн онд болсон чөлөөт, ардчилсан сонгуулиар байгуулагдсан Улсын их хуралд халаагаа өгсөн байна. Эдүгээ Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага бол байнгын ажиллагаатай Улсын Их хурал юм. УИХ нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар тус улсын төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалана хэмээн заасан.

Иргэдийн итгэлийг хүлээж, хууль тогтоох эрх авсан төлөөлөгчдийн байгууллагын хувьд улсын бүх нутаг дэвсгэрт мөрдөгдөх ёстой хууль тогтоох байгууллага мөн учраас эрх барих дээд байгууллага юм. Түүнчлэн Засгийн газрын гишүүдийг томилох, шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч хууль гаргах, үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох эрх эдлэнэ. Өөрөөр хэлбэл, бусад төрийн дээд байгууллагын эрх мэдэл нь ямар нэг хэмжээгээр УИХ -аас үүсэлтэй байна гэсэн үг юм. Улсын нийт нутаг дэвсгэрт, эсвэл хэсэгчилсэн зарим нутагт онц байдал тогтоох, дайны байдал зарлах, энэ талаар Ерөнхийлөгчийн гаргасан зарлигийг батлах юмуу хүчингүй болгох зэргээр

уг асуудлаарх эцсийн шийдвэрийг гаргана. Мөн улсын хилийг тогтооно. Төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлно. Энэ бүхэн нь бас УИХ хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн гэж үзэх үндэс болж байгаа юм.

УИХ 76 гишүүнээс бүрдэнэ. УИХ-ын гишүүдийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд саналаа чөлөөтэй, шууд, нууцаар гаргаж сонгоно. УИХ -ын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байдаг. УИХ байнгын ажиллагаатай учраас гишүүний бүрэн эрх төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, дараагийн сонгуулиар сонгогдсон шинэ гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болдог байна.

УИХ - ын чиг үүрэг нь түүний үндсэн зорилгоор тодорхойлогдоно. УИХ -ын үндсэн зорилт ард түмний төлөөллийн дээд байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оршино. Эл зорилтыг хэрэгжүүлэхийн тулд УИХ дараах үндсэн чиг үүрэгтэй.

- Хууль тогтоох
- Төрийн дотоод гадаад бодлогын үндсийг тодорхойлох,
- Хянан шалгах
- Үндсэн хуулинд заасан онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэх

Хууль тогтоох чиг үүргийнхээ дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөх хууль батлах, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах зэрэг эрхийг эдлэнэ. УИХ нь хууль болон тогтоолын хэлбэртэй бусад шийдвэрийг гаргана. Мөн Монгол Улсын үндсэн хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.

Төрийн дотоод гадаад бодлогын үндсийг тодорхойлох чиг үүргийнхээ хүрээнд төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсвийг батлана.

Хянан шалгах чиг үүргийнхээ хүрээнд:

- Хууль, УИХ -ын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах
- Улсын төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж батлах

Онцгой чиг үүргийнхээ хүрээнд:

- Ерөнхийлөгчийн ба УИХ, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах,
- УИХ -ын байнгын хороо, Засгийн газар болон хуульд зааснаар өөрт нь тайлагнадаг байгууллагуудын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх,
- Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь зөвшөөрч хууль гаргах, Ерөнхийлөгчийг чөлөөлөх, огцруулах,
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар өөрт нь шууд тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох,
- Засгийн газрын өргөн мэдүүлснээр тус улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх,
- Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт болон үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох,
- Ард нийтийн санал асуулга явуулах
- Өршөөл үзүүлэх шийдвэр гаргах
- Улсын цол, одон медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Онцгой чиг үүрэгт хамаарч буй чиг үүргийн зарим нь байгууллагуудыг байгуулах, албан тушаалтныг томилох зэрэг үйл ажиллагаа байдаг учраас тэдгээрийг төр судлалын ухаанд зохион байгуулалтын чиг үүрэг хэмээн нэрлэх нь бий.

УИХ -ын гишүүнээр Монгол Улсын сонгуулийн эрх бүхий, хорин таван нас хүрсэн иргэн сонгогдох эрхтэй. УИХ -ын гишүүн нь хуульд зааснаар төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон, ард түмний элч юм. УИХ -ын гишүүн зөвхөн өөрийг нь сонгосон тойргийн иргэдийн бус, бүх ард түмний төлөөлөгч юм. Тиймээс нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх үүргийг хуулиар хүлээсэн байдаг. Гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, улс төрийн намын сонгуульт албан тушаал, багшлах болон эрдэм шинжилгээний ажил, төрийн бус байгууллагын сонгуульт албан тушаалыг хашиж болох ба өөр ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгэх хориотой байдаг. Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зориулсан баталгаагаар хангагдана. Гишүүний цалин, нэмэгдэл, унаа, албан томилолт, бичиг хэрэг, холбооны зардлыг Улсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ. Гишүүн бусдыг доромжлох, гүтгэхээс бусдаар хэлсэн үгнийхээ төлөө хариуцлага хүлээдэггүй, гадаадад томилолтоор явахдаа дипломат эрх ямба эдэлдэг, унааг нь дайчлахыг хориглодог. Гишүүний харилцуур утас болон бусад тусгай хэрэглээний холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон шуудан, захидал харилцааны болон мэдээллийн нууцыг задруулахыг хориглоно. УИХ -ын гишүүнийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан болон түүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан тохиолдолд бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ. Тэгэхдээ гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо, Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар нууцаар санал хурааж, түдгэлзүүлэх эсвэл эс түдгэлзүүлэх тухай шийдвэр

гаргана. Ерөнхийлөгчөөр сонгогдсон, хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн, хүндээр өвчилсний улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гаргасныг үндэслэн цаашид гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Улсын Их Хурал үзсэн, Үндсэн хуулийн цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан болон тангарагаасаа няцсан гэсэн дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн, гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон, нас барсан зэрэг тохиолдлуудад УИХ -ын гишүүний бүрэн эрх дуусгавар болно.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган юм. Хагас жил тутамд 75 -аас доошгүй хоног чуулна. Чуулган нь нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд, түр хороо, түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ. Улсын Их Хурлын чуулган анхдугаар, ээлжит, ээлжит бус, онцгой гэсэн хэлбэртэй байдаг. Түүнчлэн Монгол Улсын түүх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай салшгүй холбоотой түүхэн ой, үйл явдлыг тэмдэглэх, гадаад улсын өндөр дээд зочин нэгдсэн хуралдаанд үг хэлэх бол хүндэтгэлийн хуралдаан хийдэг байна.

УИХ -ын зохион байгуулалтын үндсэн нэгж нь байнгын хороо, суудал бүхий намуудын бүлэг юм. Түүнчлэн дэд хороо, тодорхой асуудлыг шийдвэрлэн санал боловсруулах эрх бүхий түр хороо, хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хяналт, шалгалтын дэд хороог байгуулна. Дэд хороо нь байнгын хорооны харъяанд байгуулагдаж байнга ажиллана. Байнгын хороо, дэд болон түр хороод нь асуудлыг хуралдаанаараа хэлэлцэн, хэлэлцэж буй асуудлаар санал боловсруулан УИХ -ын нэгдсэн хуралдаанд оруулна. Байнгын болон бусад хороодын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь мөн хуралдаан юм. Байнгын хороонд гишүүдийг хувиарлахдаа мэргэжил, өөрийн нь саналыг харгалзахаас

гадна нам, эвслийн бүлгийн төлөөллийг хангана. УИХ -д суудалтай нам, эвсэл бүлэг байгуулна. Тэгэхдээ тухайн нам, эвслээс албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон 8 -аас доошгүй гишүүнтэй бол бүлэг байгуулах эрхтэй байдаг. Намын бүлэг нь хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн дотоод, гадаад бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх, УИХ -ын бүтцийн байгууллагуудад гишүүнээ оруулах талаар УИХ -ын даргатай зөвшилцөх, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах зэрэг эрхийг эдлэнэ. Сонгуулиар олонх болсон нам, эвсэл байхгүй тохиолдолд намууд сонгуулийн дараа зөвшилцөж олонхыг бүрдүүлсэн нам, эвсэл нь нэгэн бүрэн эрхийн хугацаанд тогтвортой ажиллах эвслийн гэрээний дагуу нэг эвслийн бүлэг байгуулна. Хэрвээ Байнгын хороо нь хэлэлцэж байгаа асуудлын талаар хариуцсан салбар, чиглэлийнхээ дагуу, мэргэжлийн үүднээс авч үзэж, санал, дүгнэлт гаргадаг бол нам, эвслийн бүлэг нь баримталдаг үзэл суртал, улс төрийн байр суурь, боловсуулсан бодлогынхоо үүднээс асуудалд хандаж санал, дүгнэлт гаргадаг байна.

Улсын их хурлаар хууль хэлэлцэх хэм хэмжээг Үндсэн хууль болон Улсын их хурлын тухай хууль, Улсын их хурлын өөрийн нь тогтоосон дэгээр тогтоосон байдаг. Хууль хэлэлцэх үйл явц нь хууль санаачлахаас эхэлдэг. Үндсэн хуульд заасан ёсоор Монгол Улсад хууль санаачлэх эрхийг Ерөнхийлөгч, Улсын Их хурлын гишүүн, Засгийн газар эдэлдэг.

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгч

1990 оноос өмнө Монгол Улс нийгмийн өөр тогтолцоотой байсан учраас үндсэн хуулинд төрийн тэргүүний тухай заалт байхгүй. Хэдий тийм боловч БНМАУ -ын Ардын их хурлын Тэргүүлэгчдийн дарга төрийн тэргүүний чиг үүргийг хэрэгжүүлдэг байжээ. 1990 онд болсон ардчилсан өөрчлөлтийн үр дүнд 1960 оны үндсэн хуульд

нэмэлт оруулснаар Монгол Улсын төрийн тогтолцоонд Ерөнхийлөгчийн институт анх буй болжээ. Уг хуульд “БНМАУ -ын Ерөнхийлөгч бол Ардын төрийн тэргүүн, БНМАУ -ын тусгаар тогтнол, Монголын ард түмний эв нэгдлийн баталгаа мөн” гэж заажээ. Улмаар 1992 онд батлагдсан Үндсэн хуульд Монгол Улсад Ерөнхийлөгчийн институт байхаар хуульчилсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн хэмээн Үндсэн хуульд заажээ. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэн зургаан жилийн хугацаагаар сонгогдоно. Ерөнхийлөгчийн тухай хуульд зааснаар Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн 33 – р зүйлийн нэгдэх хэсэгт Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг тодорхойлсон байдаг. Түүнчлэн мөн зүйлийн 4 дэх хэсэгт Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг хуулиар олгож болно хэмээн заажээ. Тэгэхдээ тодорхой бүрэн эрх нь үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх ёстой. Монгол Улсын ерөнхийлөгчийн бүрэн эрхийг түүний хэрэгжүүлдэг чиг үүргийн дагуу хуваарилан авч үзье.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүний хувьд:

- Төрийн тамгыг хууль тогтоомжид заасны дагуу барих.
- Бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газарт чиглэл өгөх,
- Гадаад харилцаанд улсаа төлөөлж, УИХ – тай зөвшилцөн Монгол улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах,
- Монгол улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг УИХ – тай зөвшилцөн томилох буюу эргүүлэн татах,
- Улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон медалиар шагнах,

- Уучлал үзүүлэх,
- Монгол улсын харъяат болох, харъяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох,
- Ерөнхий сайдаар томилох саналыг УИХ -д оруулах,
- Засгийн газрын гишүүнээр томилох хүмүүсийн талаар Ерөнхий сайдын саналтай танилцах
- Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор томилох,
- Улсын дээд шүүхийн санал болгосноор Ерөнхий шүүгчийг томилох,
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилох тухай саналаа Улсын Их Хуралд оруулах. Улсын Их Хурал уг саналыг татгалзсан бол өөр хүнийг санал болгоно.
- Үндсэн хуулийн Цэцийн гурван гишүүнийг томилох саналыг УИХ -д оруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж өөрөө тарах шийдвэр гаргахыг Улсын Их Хуралд санал болгох тухайгаа зөвшилцөхөөр Улсын Их Хурлын даргад албан ёсоор мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уул саналыг зөвшөөрөөгүй нь Ерөнхийлөгч саналаа Улсын Их Хуралд оруулахад саад болохгүй.

Эдгээр чиг үүрэг нь төрийн дээд байгууллагуудыг зохион байгуулахтай холбоотой учраас төрийн тэргүүн – Ерөнхийлөгч тэдгээрийг хэрэгжүүлдэг байна

Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд:

- Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгнө. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн

дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

- Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газартай тохиролцон тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.
- Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөж томилно.
- Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгааг хууль тогтоомжид заасны дагуу зарлана.
- Зэвсэгт хүчний нийтлэг дүрмүүдийг батална.
- Зэвсэгт хүчний дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэгт хүчнийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэр гаргана.

Ерөнхийлөгч улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хамгаалах, нийгэмд эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх үүрэгтэй бөгөөд энэ хүрээндээ улсын Аюулгүй байдлын зөвлөлийг толгойлдог. Ерөнхийлөгчийн тухай хуульд Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг дээдэлж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг, улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Тийм учраас шаардлагатай тохиолдолд улс төрийн асуудлаар улс төрийн нам хүчний хооронд зуучлах, зөвшилцөл буй болгох талаар хүчин чармайлт гаргана. Үндсэн хуультай холбоотой зөрчил гарах, ямар нэг шалтгаанаар засгийн газрыг байгуулж чадахгүй удах, улс оронд эмх замбараагүй байдал үүссэнээс, улс төрийн намуудын нэгдмэл байр суурь, зөвшилцөлийг буй болгох шаардлага гарч болно. Ийм тохиолдолуудад Ерөнхийлөгчийн ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч байх үүргийн хүрээнд явуулах үйл ажиллагаа ач холбогдолтой болдог.

Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийг зохих байгууллагаас гаргуулан авч, шаардлагатай асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд санаачлан оруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавина.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл Тагнуулын байгууллагын тодорхой үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авна.
- Батлан хамгаалах, улсын болон эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын эрх баригчдын илтгэл, мэдээллийг сонсоно.

Дээр дурдсан зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд хэрэгжүүлдэг чиг үүргүүд ч Үндэсний аюулгүй байдлын тэргүүний чиг үүрэгт хамаарна.

Төр судлалд Ерөнхийлөгчийг ихэвчлэн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хамааруулж үздэг. Монгол улсын Ерөнхийлөгчийн хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлнэ гэсэн хуулийн заалтыг үзвэл төрийн эрх мэдлийн аль ч салбарт хамаарахгүй байдалтай байдаг. Ерөнхийлөгчийн төрийн эрх мэдлийн салбаруудын үйл ажиллагааны уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх болон улс төрийн зөвшилцөл, итгэлцэлийг буй болгоход санаачлагч, хошуучлагч байх үүрэг нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудалд Засгийн газарт чиглэл өгөхөөс илүү оролцдоггүй байхыг шаардана. Засгийн газарт чиглэл өгөх тухай зарлигт Ерөнхий сайд хүлээн зөвшөөрч гарын үсэг зурснаар зарлиг хүчин төгөлдөр болдог. Ийм зохицуулалт парламентийн

бүгд найрамдах улс хэмээн нэрлэдэг төрийн хэлбэр бүхий орнуудад түгээмэл байдаг ба түүнийг давхар гарын үсгийн зарчим гэдэг. Эл зарчмын улс төрийн агуулга нь Ерөнхийлөгчийн зохицуулагч, эв нэгдлийг илэрхийлэгчийн байр суурийг хамгаалах, чиглэлд заасан үйл ажиллагааны төлөөх хариуцлагыг Засгийн газарт оногдуулж байгаа хэрэг юм. Ерөнхийлөгч сонгогдсоныхоо дараа намын харъяалалаас түдгэлздэг нь мөн ийм агуулгатай юм. Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгосон чухал эрх бол хууль тогтооход оролцохтой холбоотой эрхүүд юм. Энэ хүрээнд Ерөнхийлөгч:

- Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах ба бусад үед улс орны чанартай хойшлуулшгүй чухал асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулган чуулахыг санаачилна.
- Улсын Их Хурлын чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, төрийн бодлогын аливаа асуудлаар Улсын Их Хуралд саналаа оруулна.
- Хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хуулийн болон түүнтэй холбогдох шийдвэрийн төслийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.
- Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина.
- Хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар саналаа илэрхийлж болно. Энэ нь уул хуульд хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй.
- Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хуралд оруулна

УИХ -д суудалтай намууд дангаараа болон хамтран Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ. Тэгэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгчийн сонгууль хоёр

шаттай байдаг. Анхан шатны сонгуульд сонгуулийн эрх бүхий Монгол Улсын нийт иргэд шууд оролцож, саналаа нууцаар гарган Ерөнхийлөгчийг сонгодог. Анхан шатны сонгуулиар олонхын санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж УИХ хууль гаргадаг. Ийнхүү Ерөнхийлөгчийг анхан шатны сонгуулиар тодруулж, улмаар УИХ бүрэн эрхийг нь зөвшөөрч хууль гаргаж байгааг үндэслэн Ерөнхийлөгчийн сонгуулийг хоёр шаттай гэж үздэг. Гэвч чухамдаа анхан шатны сонгуулиар ялагч тодорч байгаа учраас ийнхүү сонгууль хоёр шаттай гэж үзэх нь эргэлзээтэй юм. Хуулийн дагуу Ерөнхийлөгч УИХ -д ажлаа хариуцана гэж заасантай уялдуулан түүнийг сонгогдсон гэж үзэж УИХ хууль гаргадаг гэж үзэж болох юм.

Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байна. 1992 онд баталсан Үндсэн хуулиар эл хугацаа дөрвөн жил байсныг 2019 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар зургаан жил болсон байна. Ерөнхийлөгч Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ, засгийн газрын гишүүн болон хуулиар тогтоосон чиг үүрэгт нь хамааралгүй бусад ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгэхийг хориглоно. Төрийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжилж байх ёстой учраас Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа тангараг өргөснөөр эхэлж, дараагийн ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болдог. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их хуралд тангараг өргөдөг. Ерөнхийлөгч УИХ -ын чуулганд тааллаараа оролцох ба УИХ болон ард түмэндээ хандан илгээлт гаргана. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ асуудлаар зарлиг, захирамж гаргадаг. Зарлиг, захирамж нь тус улсын нийт нутаг дэвсгэрт хүчинтэй байна. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх зарлиг нь түүнд өөрөөр заагаагүй бол төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа, бусад

зарлиг, захирамж тэдгээрт өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Үндсэн хуулийн гучин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Ерөнхийлөгч хуулиар тодорхойлогдсон чиг үүргүүдээ биелүүлэх баталгаагаар хангагдсан байдаг. Үүнд:

- түүний бие, нэр төр, ордон, өргөө, унаа халдашгүй дархан байна;
- нийслэл хотод ордон, өвөл, зуны өргөөтэй байх бөгөөд тэдгээрийн зардал, үйлчилгээг улс хариуцна;
- албан ёсны айлчлал, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон төрийн ёслол, хүндэтгэлийн болон бусад арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Түүний цалин, жилийн зардлын хэмжээг Улсын Их Хурал тогтооно;
- тусгай зориулалтын холбоо, аюулгүй байдлыг хангахаар тоноглогдсон уналгын хэрэгслээр хангагдана;
- түүний амь бие, ордон, өргөө, холбоо, уналгын хэрэгсэл улсын хамгаалалтад байх бөгөөд эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхдийг нь шаардлагатай үед улсын хамгаалалтад авна;
- түүний эрүүл мэндийг онцлон хамгаална.

Ерөнхийлөгч албан татвар болон бусад албан дайчилгаанаас чөлөөлөгддөг байна.

Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн УИХ-р хэлэлцэн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар огцруулна хэмээн Үндсэн хуульд заажээ.

Ерөнхийлөгчийг түр эзгүйд, эсхүл Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Улсын Их Хурлын

дарга хууль тогтоомжид заасны дагуу Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Ерөнхийлөгчийн биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос үүрэгт ажлаас чөлөөлж өгөхийг хүсэж Улсын Их Хуралд өргөдөл гаргасан бөгөөд уг хүсэлтийг ёсоор болгосон, Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу огцруулсан, нас нөгчсөн зэрэг тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болдог байна. Ямар тохиолдолд Ерөнхийлөгчийг түр эзгүй гэж үзэхийг Ерөнхийлөгчийн тухай хуульд тодорхойлсон байна. Үүнд:

- эрүүл мэндийн хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсныг эмнэлгийн дүгнэлт үндэслэн Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн;
- өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;
- түр эзгүй гэж Ерөнхийлөгч өөрөө албан ёсоор үзсэн зэрэг болно.

УИХ-ын дарга, Ерөнхийлөгч эрүүл мэндийн шалтгаанаас түр эзгүй байгаа болон өөрөө түр эзгүй гэж албан ёсоор үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч өөрөө албан ёсоор түүнд шилжүүлсэн бүрэн эрхийг л хэрэгжүүлнэ. Харин Ерөнхийлөгч огцорсон, өөрөө хүсэлтээрээ чөлөөлөгдсөн болон нас барсан тохиолдолд түүний бүхий л бүрэн эрхийг УИХ -ын дарга бүрэн хэрэгжүүлдэг байна. УИХ -ын дарга Ерөнхийлөгчийг түр эзгүй байх, түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацаанд гарсан зарлиг, захирамжид “Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч” хэмээн гарын үсэг зурах ёстой ажээ.

Шинэ Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль анх 1993 онд болсон ба түүнээс хойш 7 удаа, нийт найман удаа Монгол Улсын иргэд Ерөнхийлөгчөө бүх нийтээрээ сонгосон байна. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн

хугацаа 4 жил байсныг 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 6 жил болгосон ба Ерөнхийлөгч дахин нэг удаа улиран сонгогдохыг хуулиар зөвшөөрч байсан бол дээрх нэмэлт өөрчлөлтөөр нэг хүн ерөнхийлөгчөөр нэг бүрэн эрхийн хугацаанд ажиллах хязгаарлалтыг тогтоожээ.

Гурав. Монгол Улсын Засгийн газар

Дээр дурдсан төрийн эрх мэдлийг хуваарилах, харилцан тэнцвэртэй байлгах зарчмын дагуу Монгол улсын төрийн гүйцэтгэх байгууллага бол Засгийн газар юм. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” хэмээн заажээ. Төрийн гүйцэтгэх байгууллага гэдэг нь түүний хуулиар тогтоосон чиг үүргээр тодорхойлогдоно. Үндсэн хуулиар Засгийн газар нь дараах бүрэн эрхтэй байдаг. Үүнд:

- Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг орон даяар зохион байгуулах,
- Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, Улсын Их хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх,
- Салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх,
- Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг авах,
- Төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны үйл ажиллагааг чиглүүлэх,
- Улсын батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах,
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

- Төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх,
- Улсын Их хуралтай зөвшилцөж, дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах зэрэг болно.

Эдгээрээс гадна Монгол Улсын засгийн газар нь Үндсэн хуулиас бусад, холбогдох хуулиудаар тодорхойлогдсон тодорхой бүрэн эрхүүдтэй байдаг. Тэгэхдээ тодорхой бүрэн эрхүүд нь Үндсэн хуулиар тодорхойлогдсон үндсэн бүрэн эрхийн хүрээнд багтаж байдаг. Засгийн газрын тухай хуульд дээр дурдсан үндсэн бүрэн эрхүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой бүрэн эрхүүдийг нарийвчлан заасан байдаг.

Хуулийн биелэлтийг хангах:

- Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах арга замыг тодорхойлон уул ажлыг нэгтгэн удирдана.
- Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангана.
- Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавина.
- Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, улсын үйлдвэрийн газар, байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид хянан шалгаж, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын илтгэл, мэдээллийг хэлэлцэнэ.
- Нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгж хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.
- Шаардлагатай бол нам, олон нийтийн байгууллага,

хувийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлагын хүсэлтийг үндэслэн тэдгээрийн мэдээллийг хэлэлцэж болно.

- Хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдээлэл, сургалт, хууль тогтоомж тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулна.
- Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн тухай Улсын Их Хуралд тогтмол мэдээлнэ.

Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаар:

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.
- Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, улсын төсвийн биелэлтийг

хангах ажлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулна.

- Эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна.
- Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Улсын хэмжээнд баримтлах шинжлэх ухаан-техник, технологийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Үндэсний баялаг, төрийн өмчийг хамгаалах арга хэмжээ авч, хуулиар олгосон эрх хэмжээний дотор төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулна.

Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгааллын талаар:

- Соёл, урлагийг өмчийн олон хэлбэрт түшиглэн хөгжүүлэх бодлого, түүний эдийн засаг, эрх зүйн баталгааг хангах арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.
- Ард түмний оюуны өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, уламжлалт зан заншлыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Бүх шатны боловсролын тогтолцоо, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ. Хууль тогтоомжид заасны дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажилд улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулна.
- Хүн амын бодлого, түүний дотор хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын талаар төрөөс явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

- Ажил эрхлэлт, мэргэжлийн сургалт, хөдөлмөрийн асуудлаар оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, иргэдийн хөдөлмөр, ахуй, орон сууцны нөхцөлийг сайжруулах, хэрэглэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авна.
- Гэр бүлийг бэхжүүлэх, нийгмийн халамж, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эх нялхас, тахир дутуу хүмүүс зэрэг нийгмийн эмзэг хэсгийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна.

Салбар, салбар хоорондын болон бүс нутгийн хөгжлийг хангах талаар

- Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоон хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд эдийн засгийн салбаруудын хүч чармайлтыг нэгтгэн чиглүүлж, салбар хоорондын харилцан ажиллагааг зохицуулна.
- Аймаг, бүс нутгийн харьцангуй жигд хөгжлийг хангах, тэдгээрийн хооронд эдийн засгийн зөв зохистой хэлхээ холбоо тогтоон бэхжүүлэх нийтлэг зарчим, загвар боловсруулан хэрэгжүүлж, энэ талаар нутгийн өөрөө удирдах байгууллагуудад шаардлагатай туслалцаа үзүүлнэ.
- Орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгжийн бие даасан байдлыг улс орны хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын нийтлэг ашиг сонирхолтой уялдуулан зохицуулна.

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах талаар:

- Байгаль, орчныг хамгаалах эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, энэ

хүрээн дэх Засгийн газрын болон Засгийн газрын бус /олон нийтийн/ байгууллагын үйл ажиллагааг зохицуулна.

- Байгалийн баялгийг судалж, нөөцийн хэмжээ, эдийн засгийн нэгдсэн үнэлгээг тогтоох, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал болон үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шүтэлцээг хангах нэгдсэн арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.
- Байгалийн тэнцвэрт байдлын хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгоно.
- Гамшиг болон аюул, орчны ноцтой бохирдолтоос сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгахад улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авна.
- Газар, түүний хэвлий, ус, ойн сан, агаар мандал, ургамал, амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горим, дурсгалт болон нөөц газрын хилийн зааг, хамгаалалтын горим тогтоож, биелэлтийг нь зохион байгуулна.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаар:

- Аппаратыг чадваржуулан хямдруулж, боловсронгуй болгох шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, энэ талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.
- Төрийн албаны ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

- Захиргааны хяналт, удирдлагын хүрээн дэх хяналт шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулна.
- Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тогтоон, тэдгээрийн орон тооны болон зардлын төсвийн хязгаарыг баталж, зохих шатны удирдах ажилтныг томилж, чөлөөлнө.
- Төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын болон тэдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг нийтлэг зорилтод чиглүүлэн зохицуулна.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалтын болон аргачилсан туслалцаа үзүүлж, тэдгээрийн бие даасан ажиллагааг хангах арга хэмжээ авна.
- Аймаг, нийслэлийн Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдлыг хянан шалгаж, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана. Шаардлагатай бол өөрийн тодорхой бүрэн эрхэд хамаарах тухайлсан асуудлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлж болно.

Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаар:

- Хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, жендэрийн эрх

тэгш байдлыг хангах асуудлаар Засгийн газрын бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.

- Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажлыг нэгтгэн удирдана.
- Хүн амд үзүүлэх хууль зүй, засаг захиргааны үйлчилгээг зохион байгуулна.
- Төрийн удирдлагын хүрээн дэх мэдээллийн албыг зохион байгуулж, хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах нөхцөл бүрдүүлнэ.
- Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх талаар:

- Улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн талаар төрийн гадаад бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.
- Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрыг Улсын Их Хурлын холбогдох шийдвэрийг үндэслэн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэж, тэдгээр байгууллагын дүрэм, орон тооны хязгаарыг баталж, ажилтны цалингийн дундаж нэгжийг тогтооно.
- Монгол Улсаас гадаад улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.
- Гадаад улс, олон улсын байгууллагад суух Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлыг шийдвэрлэнэ.

- Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад өөрийн эрх хэмжээний дотор Монгол Улсыг төлөөлнө.

Гадаад улстай гэрээ, хэлэлцээр байгуулах талаар:

- Улсын Их Хуралтай зөвшилцөн дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын өмнөөс олон улсын гэрээ байгуулна.
- Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн орох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.
- Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.
- Байгууллага хоорондын шинжтэй Монгол Улсын олон улсын гэрээний хэлэлцээ хийх болон гарын үсэг зурах журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- Олон улсын гэрээгээр Монголын талын хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгаж, зохион байгуулна.
- Олон улсын гэрээнээс үүсэн гарсан асуудлаар Монголын талын эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авна.

Засгийн газар нь бүтцийн хувьд Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Монгол Улсын засгийн газрын гишүүдэд сайд нар орно. Түүнчлэн зарим үед тэргүүн шадар, шадар сайдтай байж болно. Тэд ихэвчлэн салбар хоорондын үйл ажиллагааг хөндсөн тодорхой асуудлыг хариуцах ба Ерөнхий сайд эзгүй бол түүнийг орлоно. Сайд нар ихэвчлэн төрийн захиргааны аль нэг төв байгууллага буюу яамны үйл ажиллагааны хүрээнд хамаарагддаг тодорхой асуудлыг хариуцан ажиллана. Зарим тохиолдолд яамгүй, тодорхой асуудал хариуцсан сайдтай байдаг. Тухайлбал, одоо ажиллаж буй Засгийн газарт ийм сул сайдууд ажиллаж байна. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа нь дөрвөн жил байдаг. Засгийн газар танхимын зарчмаар ажилладаг.

Энэ нь засгийн газрын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний хуралдаан бөгөөд шийдвэрийг гишүүдийн олонхын саналаар гаргадаг гэсэн үг юм. Түүнчлэн танхимын тэргүүн Ерөнхий сайд огцорвол засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцордог.

Засгийн газрыг байгуулахдаа эхлээд ерөнхий сайдыг томилно. Ээлжит сонгуулиар Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч ерөнхий сайдаар томилуулахаар санал болгон Улсын Их Хуралд оруулан хэлэлцүүлж томилуулдаг. Хэрвээ аль ч нам, эвсэл олонх суудлыг аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл Улсын Их Хуралд суудалтай бусад нам, эвсэлтэй зөвшилцөн, Ерөнхий сайдад нэр дэвшүүлдэг. Харин Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд Улсын Их хурал, Ерөнхийлөгчид танилцуулаад өөрөө томилно. Төрийн үйл ажил тасралтгүй байх зарчим засгийн газрын хувьд ч мөрдөгдөх бөгөөд Ерөнхий сайдын бүрэн эрх түүнийг Улсын Их Хурал томилсноос эхэлж, шинэ ерөнхий сайд томилогдсноор дуусгавар болно. Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцана. Засгийн газар бүхэлдээ Улсын Их хуралд ажлаа тайлагнана.

Засгийн газрын бүтцийн гол байгууллага бол яам юм. Шинэ үндсэн хуулийн дагуу байгуулагдсан удаа дараагийн засгийн газруудад харилцан адилгүй тооны яам ажиллаж иржээ. Засгийн газрын тухай хуулийн 2022 оны 8 -р сарын 29 ний өдрийн шинэчилсэн найруулгын дагуу одоо ажиллаж буй засгийн газар 16 яамтай болжээ. Яамдыг үндсэн чиг үүргийн болон чиглэлийн яам хэмээн ангилна. Нийгмийн амьдралын бүхий л салбарт хамааралтай хууль тогтоох, санхүүжүүлэх, гадаад харилцааг эрхлэх гэх мэтийн асуудлыг Засгийн газрын хүрээнд эрхлэх яамыг үндсэн чиг үүргийн хэмээн нэрлэнэ. Үндсэн чиг үүргийн яамд дотроос хууль зүй, сангийн, гадаад харилцааны гэх мэт яамд ямар ч засгийн газарт заавал байдаг. Эрүүл мэнд, боловсрол, эрчим хүч гэх мэт болон бусад тодорхой салбарын ажлыг эрхэлсэн яамдыг

чиглэлийн яам гэдэг байна. Аль нэг салбарыг дангаар нь хариуцсан яам байхад хоёр юмуу хэд хэдэн салбарыг хамтад нь хариуцсан яам байж болдог. Жишээлбэл, 2000 – 2004 онд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг нэг яам хариуцаж байсан бол 2016 – 2020 онд уг яам боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын асуудлыг, 2020 оноос хойш боловсрол, шинжлэх ухааны асуудлыг хариуцаж байна. Засгийн газрын гишүүн, сайд нь өөрийн хариуцсан асуудлын дагуу тухайн чиглэлийн яамыг толгойлно. Засгийн газарт яам толгойлоогүй, тодорхой асуудлыг хариуцсан шадар сайд, дэд сайд байж болно. Шадар сайд нь тодорхой асуудал хариуцахаас гадна Ерөнхий сайдыг эзгүйд түүнийг орлоно. Одоогийн Засгийн газарт Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга зэрэг сайдууд ажиллаж байна.

Яамдад дэд сайд ажиллаж болно. Засгийн газрын тухай хуулийн дагуу Сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, агентлагийн үйл ажиллагааг сайдын өмнө хариуцах үүрэг бүхий дэд сайдууд ажиллаж байна. Дэд сайдаас гадна Монгол Улсын яам Төрийн нарийн бичгийн даргатай байна. Төрийн нарийн бичгийн дарга нь яамны аппаратын гүйцэтгэх ажлыг зохион байгуулан удирдаж, сайд үйл ажиллагаагаа шуурхай явуулахад шууд туслах үндсэн чиг үүрэгтэйгээс гадна сайдаас өгсөн үүрэг даалгаврыг хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрт нийцүүлэн биелүүлнэ. Төрийн нарийн бичгийн дарга нь улс төрийн албан тушаалтан биш, харин тухайн яамны хэмжээнд төрийн захиргааны хамгийн том албан тушаалтан юм. Тэрбээр тухайн яамны хариуцсан асуудлын хүрээнд төрийн ажлыг хуулийн дагуу зөв зохион байгуулж явуулах, яамны ажлын албыг удирдах, албан хаагчдыг хуулийн дагуу ажилд томилж, чөлөөлөх, удирдах үүрэгтэй байдаг. Түүнийг засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг байна.

Засгийн газар, Ерөнхий сайд, гишүүн огцрох, бүрэн эрх нь дуусгавар болох, дахин томилох асуудлыг тухай асуудлыг Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуулиар зохицуулсан байдаг. Ерөнхий сайд дараах тохиолдлуудад огцорно. Үүнд

- Улсын Их хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавьж, түүнийг хэлэлцээд Улсын Их хурлын гишүүдийн олонх дэмжсэн бол
- Ерөнхий сайд өөрөө улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл үзүүлэх тухай тогтоолын төслийг оруулж Улсын Их хурлын нийт гишүүдийн олонх нь дэмжсэн бол

Ерөнхий сайд чөлөөлөгдсөн, огцорсон, нас нөгчсөн тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно. Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах асуудлыг Ерөнхий сайд өөрөө хуулийн дагуу шийдвэрлэнэ. Сайд өөрөө биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ гаргаж болно. Түүнчлэн өөрийн эрхэлсэн асуудлын хүрээний бодлогын асуудлаар Ерөнхий сайдтай, эсхүл гишүүдийн олонхтой санал зөрсөн зэргээс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох хүсэлтээ Ерөнхий сайдад гаргаж болно. Засгийн газрын гишүүн сайдын орон гарвал нөхөн томилох, засгийн газрын өөр гишүүнд түр хугацаагаар орлуулна.

Засгийн газрын бүтцийн өөр нэг байгууллага бол Засгийн газрын агентлаг юм. Агентлагийг засгийн газар Улсын Их хурлаас баталсан бүдүүвчийн дагуу байгуулна. Агентлаг нь тохируулах болон хэрэгжүүлэх гэсэн ангилалтай.

“Тохируулагч агентлаг нь татвар, төлбөр, торгууль, цэрэг арми, шорон гяндан, бүртгэл хяналт, газар нутаг, иргэний

харъяалал гэх мэт төрийн төрлөх мөн чанараас үүсмэл олон чиг үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ ашиг орлого олох зорилгогүй, нийтийн үйлчилгээний шинжтэй, хувийн хэвшлийн юмуу засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломж хязгаарлагдмал тийм чиг үүргийг хэрэгжүүлдэг” бол “хэрэгжүүлэгч агентлаг нь иргэд, хуулийн этгээдэд нийтийн захиргааны үйлчилгээг ... хүргэх зорилготой” агентлаг ажээ¹.

Өнөөгийн үйлчилж байгаа хуулийн дагуу засгийн газар харъяандаа тодорхой асуудлаар Үндэсний хороодыг байгуулан ажиллууж байна. Засгийн газрын тухай хуульд “Засгийн газар хилийн боомтын, олимп, нийтийн биеийн тамир, спортын болон нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах асуудал хариуцсан Үндэсний хороог байгуулж болно” хэмээн Үндэсний хороодыг нэр цохон заажээ.

Монгол Улсын засгийн газар, Ерөнхий сайд нь хуулиар тогтоосон үйл ажиллагааны баталгаатай байдаг. Тухайлбал, Ерөнхий сайдын бие, нэр төр, уналга, зориулалтын орон сууц халдашгүй дархан байх, нийслэл болон түүний орчмын газарт өвөл, зуны зориулалтын орон сууцтай байх, албан ёсны болон ажлын айлчлал, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээ, зориулалтын өвөл, зуны орон сууцны зардал, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлэх, Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурлаас тогтоосон цалин, зардалтай байх, тусгай зориулалтын унаа, холбоогоор хангагдах, эрүүл мэндийг нь онцлон хамгаалах зэрэг баталгааг хуулиар тогтоожээ. Мөн түүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, бие, орон сууц, албан тасалгаа, уналгад нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглох ба түүний амь бие, орон сууц, уналга, холбооны хэрэгсэл улсын хамгаалалтад байна. Шаардлагатай бол

1. Ш. Цогтоо, 2013, 6-, 63

Ерөнхий сайдын эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхдийг нь улсын хамгаалалтад авна. Монгол Улсын засгийн газрын гишүүдийн үйл ажиллагаа ч хуулиар тогтоосон баталгаатай байна. Засгийн газар нь ажлын албатай байдаг. Энэ нь засгийн газрын Хэрэг эрхлэх газар юм. Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрыг үйл ажиллагаагаа амжилттай явуулахад шаардлагатай бүхий л бололцоогоор хангаж байдаг. Түүнчлэн орон нутгийн төрийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, төрийн алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Манай оронд Засгийн газрын хэрэг эрхлэх газрыг Засгийн газрын гишүүн сайд толгойлж байдаг.

Орчин үед засгийн газар улс орны амьдралд маш чухал үүрэг гүйцэтгэдэг болсон ажээ. Аль ч орны засгийн газрын хувьд бусад байгууллагаас ялгагдах хэд хэдэн онцлогтой.

- Засгийн газар бол нийгмийн амьдралын олон талын асуудлаар мэргэшсэн байгууллага байдаг. Эдгээр асуудлыг хариуцсан эрүүл мэндийн, боловсролын, хөдөө аж ахуйн гэх мэт яамдтай байх ба тэдгээрт мөн л тухайн чиглэлээр мэргэшсэн алба хаагчид ажиллаж байдаг. Түүнээс гадна тэдгээр яамд нь
- харъяандаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай байдаг. Тийм учраас төрийн бодлогыг шинжлэх ухаанд тулгуурлан зөв боловсруулахад засгийн газар чухал үүрэг гүйцэтгэнэ.
- Засгийн газар бол маш шуурхай үйл ажиллагаа явуулж чаддаг. Орчин үеийн нийгмийн амьдралд асар хурдацтай үйл явдлууд өрнөдөг. Байгаль, нийгмийн гаралтай онц байдал буй болох нь элбэг болсон юм. Ийм тохиолдолуудад маш түргэн арга хэмжээ авах шаардлага гардаг. Засгийн газруудад ийм чадвар, боломж байдаг тул эдгээр арга хэмжээг эрхэлдэг байна.

- Засгийн газар бол улс орондоо бүтээн байгуулалт хийх, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэхэд оройлон оролцох учиртай манлайлагч байгууллага байдаг.

Ийм учраас ард түмэн засгийн газарт их итгэл найдвар хүлээлгэж, бас ч түүнд өндөр шаардлага тавьж байдаг юм.

Ашигласан ном зохиол

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
- Монгол Улсын Их хурлын тухай хууль
- Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль
- Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль
- Ж. Амарсанаа. Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. Уб., 2012
- А. Цанжид. Улс төрийн шинжлэх ухаан. Уб., 2010
- Ш. Цогтоо. Захиргааны эрх зүй. Тусгай анги. Уб., 2013

Дөрөв. Шүүх эрх мэдэл

Хууль зүйн магистр С.Ганхуяа

Хууль зүйн тогтолцооны үндэс, суурь нь шүүхийн тогтолцоо юм. Учир нь шүүх эрх мэдэл нь гэмт хэрэг үйлдсэн болон тохиролцсон хэлцлээсээ буцдаг “ичих нүүргүй” иргэн, хуулийн этгээд болон дураараа аашилсан төрийн албан тушаалтнаас иргэний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах замаар хуулийн засаглал (rule of law)-ын хэрэгжилтийг хангадаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1-т зааснаар шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх,

аймаг нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ. Эдгээр шүүхийг эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажлын төрлөөр дагнан байгуулдаг. Учир нь дагнан мэргэшсэн шүүгч хэрэг маргааныг тал бүрээс нь шинжилж, бодитой байдлаар хянан шийдвэрлэх магадлал өндөр гэж судлаачид үздэг байна. Шүүхийн ажлын төрлийг товч тайлбарлавал, эрүүгийн хэргийн шүүх нь Эрүүгийн хуулиар тусгайлан тогтоосон гэмт хэрэг (хүн алах, хулгай хийх, залилах гэх мэт) үйлдсэн гэм буруутай эсэх, гэм буруутай бол ямар төрлийн эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг, иргэний хэргийн шүүхийн хувьд эдийн (мөнгө, орон сууц гэх мэт) болон эдийн бус (нэр төр, оюуны өмч гэх мэт) баялагтай холбоотой эрх зөрчигдөн эсэх, зөрчигдсөн бол тухайн эрхийг ямар байдлаар сэргээх асуудлыг тус тус хянан шийдвэрлэдэг. Харин захиргааны хэргийн шүүх нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх, зөрчсөн бол захиргааны шийдвэрийг хууль бус болохыг тогтоох, хууль ёсны шийдвэр гаргахыг захиргааны байгууллагад даалгах зэрэг асуудлыг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй.

Шүүхийн бие даасан байдал

Төрийн эрх мэдлийг хуваарилах онолоос үүсэлтэй шүүхийн бие даасан байдал² нь нэгдүгээрт, бүтцийн бие даасан байдал, хоёрдугаарт, эрх мэдлийн бие даасан байдал, гуравдугаарт, төсвийн бие даасан байдал, дөрөвдүгээрт, шүүгчийн бие даасан байдал гэсэн ойлголтыг өөртөө агуулдаг.

1. Бүтцийн бие даасан байдал

Шүүх гэж хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг ойлгоно гэж Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хуульчилсан. Харин Монгол Улсын шүүхийн

тогтолцоо, зохион байгуулалтын хувьд Улсын дээд шүүх буюу хяналтын шатны шүүх, аймаг, нийслэлийн буюу давж заалдах шатны шүүх, сум буюу сум дундын, дүүргийн буюу анхан шатны шүүхээс бүрдэж байдаг. Эдгээр шүүхэд ажиллах шүүгчийг сонгон шалгаруулах ажлыг ямар байгууллага зохион байгуулах, шүүгчийг ямар албан тушаалтан томилох, томилогдсон шүүгч хуулиар хориглосон зүйлс хийсэн тохиолдолд ямар байгууллага сахилгын хариуцлага тооцох зэрэг нь асуудал шүүхийн бүтцийн бие даасан байдалд хамаарах асуудал тул эдгээрийг нарийвчлан авч үзье.

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж олох, томилогдсон шүүгчийн эрх ашгийг хамгаалах зорилготой Шүүхийн ерөнхий зөвлөл нь 10 гишүүнтэй. Эдгээр гишүүний тавыг шүүгчид дотроосоо, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлэн Улсын Их Хурал дөрвөн жилийн хугацаагаар нэг удаа томилдог. Тус зөвлөл нь Улсын дээд шүүхээс бусад шүүхийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцөж, Улсын Их Хурал, Засгийн газарт өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулдаг. Мөн бүх шатны шүүхийн шүүгчийн цалин хөлсний хэмжээг тогтоох саналаа Улсын Их Хуралд уламжлан, шийдвэрлүүлнэ. Зөвлөл нь шүүхийн захиргааны албыг удирдах, шүүгч, түүний гэр бүлийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах зэрэг ажлыг хариуцна. Хэрэв Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, ийм шинж бүхий үйл ажиллагаа явуулсан бол Ерөнхий зөвлөл хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт явуулах саналаа Улсын дээд шүүхэд хүргүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй. Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцох эрхгүй.

Шүүхийн ерөнхий зөвлөл нь хуульчдаас шүүгчийг шилж олохын тулд хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт гэсэн сонгон шалгаруулах хоёр шалгалтыг зохион байгуулж, шалгалтад тэнцсэн хуульчийг шүүгчийн албан тушаалд ажиллуулах саналаа Ерөнхийлөгчид хүргүүлдэг. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь үйл ажиллагааны тайлангаа Улсын дээд шүүхэд танилцуулдаг болсон.

Ерөнхийлөгчийн чиг үүрэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн сонгон шалгаруулж, шүүгчийн албан тушаалд дэвшүүлэн санал болгосон хуульчийг Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 1-т зааснаар шүүгчээр томилон, энэ тухай зарлиг гаргадаг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосон хуульч нь хуулиар тогтоосон шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж Ерөнхийлөгч үзвэл энэ тухай саналаа Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлдэг. Хэрэв Ерөнхийлөгчийн санал үндэслэлтэй байвал Шүүхийн ерөнхий зөвлөл шинэ нэр дэвшигчийг санал болгодог. Харин Ерөнхийлөгчийн санал үндэслэлгүй байвал тухайн нэр дэвшигч хуульчийг шүүгчээр томилуулах саналыг дахин гаргах хуулийн зохицуулалттай.

Шүүхийн сахилгын хорооны чиг үүрэг. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэгтэй Шүүхийн сахилгын хороо есөн гишүүнтэй. Есөн гишүүний дөрвийг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаатай, нэг удаа томилдог. Шүүгчийг сахилгын зөрчил гаргасан гэж үзсэн хүн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Шүүхийн сахилгын хороонд өргөдөл, эсхүл мэдээлэл гаргана. Шүүхийн сахилгын хорооны илтгэгч гишүүн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй. Сахилгын

хэргийг Шүүхийн сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэдэг. Уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй шүүгч гомдлоо Сахилгын хороонд гаргах ба үүнийг Шүүхийн сахилгын хорооны хуралдаанаар хянан үзэж, шийдвэрлэнэ. Уг хяналтын тогтоолыг хүлээн зөвшөөрөөгүй шүүгч Улсын дээд шүүхэд гомдол гаргаж, Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаанаар хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалттай.

2. Эрх мэдлийн бие даасан байдал

Орчин үеийн Монгол Улсын шүүх эрх мэдлийн бие даасан байдлын түүхэн үйл явцын талаар судлаач Ч.Ганбат дараах дөрвөн үе шатад ангилан авч үзсэн байдаг³.

- Шүүх эрх мэдлийг гүйцэтгэх засаглал, түүний байгууллагууд хэрэгжүүлж байсан үе (1921-1926 он хүртэл).
- Шүүх эрх мэдлийг шүүхтэй зэрэгцсэн “шүүх” гэсэн хаягтай тусгай байгууллага гүйцэтгэх засаглалын хүрээнд багтан хэрэгжүүлж байсан үе (1926-1930 он)
- Шүүх эрх мэдлийг иргэний болон цэргийн шүүхийн нэгдмэл тогтолцоогоор нэг намын ангич үзэл баримтлалаас шууд хараат байдлаар хэрэгжүүлж байсан үе (1930-1992 он).
- Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгыг Үндсэн хууль болон бусад хуулиар хуульчлан тогтоож, энэ чиглэлд өөрчлөлт шинэчлэл хийж буй (1992 оноос хойших)

Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-т “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, 2-т “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэж тус тус заасан нь шүүх мэдлийг зөвхөн шүүх байгууллага бие

3. *Шүүгчийн хараат бус шүүхийн бие дааж ажиллах зарчим ба шүүн таслах ажиллагаа, Шинэ толь. 1999. №28*

даан эрхлэн хэрэгжүүлэх үндсэн баталгаа болдог. Түүнчлэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг алдагдуулсан хууль тогтоомж болон хэм хэмжээний акт гаргахыг хориглодог.

3. Шүүхийн төсвийн бие даасан байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 3-т “Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэж заасны дагуу Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар шүүхийн төсвийн бие даасан байдлыг хангах зорилгоор дараах зохицуулалтыг тусгасан.

- Шүүхийн төсөв нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүх, дагнасан шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны төсвөөс бүрдэнэ.
- Шүүхийн төсвийг батлахдаа Засгийн газар Улсын дээд шүүх болон бусад шүүхийн төсвийг бууруулахгүйгээр улсын төсөвт тусгана.
- Улсын Их Хурал жилийн төсвийг хэлэлцэн батлахдаа Улсын дээд шүүх болон Ерөнхий зөвлөлийн санал, тайлбарыг сонсож, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх журмыг баримтална.
- Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулахыг хориглоно.
- Төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглодог.

Түүнчлэн шүүх нь зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу нийлүүлсэн эд хөрөнгө, зээл тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөрийн хандив, санхүүгийн туслалцааг авах ба эдгээрээс бусад төрлийн хандив, санхүүгийн туслалцаа авч болдоггүй.

4. Шүүгчийн бие даасан байдал

Шүүгчийг хуулиар тогтоосон алба хаших насны дээд хязгаар хүртэл томилдог болсон нь хараат бус байдлын чухал баталгаа болсон. Энэ хугацаанд шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэх, сэлгэн ажиллуулахыг хориглодог. Мөн захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар ажлаас чөлөөлж огцруулахгүй. Шүүгчийн бие даасан байдлаа хангах үүднээс шүүгчийн улс төрийн намд харьяалагдах, улс төрийн нам, олон нийтийн байгууллага болон иргэдэд улс төр, шашны асуудлаар байр сууриа илэрхийлэх, хөдөлмөрийн маргаанаа зохицуулах зорилгоор албан үүргээ орхих, зогсоох, ажил хаялт зарлах зэрэг хувийн буюу иргэний эрхийг хуулиар хязгаарладаг.

Түүнчлэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад аливаа этгээдээс ямар нэгэн хэлбэрээр нөлөөлөхийг оролдсон үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичиг буюу нөлөөллийн мэдүүлгийг хөтөлж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх байдлаар өөрийн бие даасан байдлаа баталгаажуулдаг. Харин хэн нэгэн этгээд шүүгчид нөлөөлөх оролдлого гаргасан тохиолдолд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй бол тухайн шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар бүх шатны шүүхийн шүүгч нь бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглодог. Мөн хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай ганцаарчлан уулзах, харилцах нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх боломжтой гэдэг утгаар хориотой. Үүний зэрэгцээ хүний оролцоотой хэргийг хуваарилах ажиллагаа нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлдөг тул программ хангамжийн дагуу цахим сугалаагаар хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилдог болсон.

Шүүгчийн амь нас, ажлын байр, хувийн болон албаны орон сууц, ажил хэргийн нэр хүнд, эзэмшиж, ашиглаж байгаа хувийн болон албаны тээвэр, холбооны хэрэгсэл, бичиг баримт, ачаа тээш, бусад эд хөрөнгө, захидал харилцааны мэдээлэл халдашгүй байдаг. Мөн шүүгч нь өөрийн аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор бие хамгаалах тусгай хэрэгсэл эзэмшиж, биедээ авч явах эрхтэй.

5. Ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын Иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх...” үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхээр заасан. Энэ хэсэгт, Монгол Улс дахь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх үндсэн ойлголтыг өгөхийг зорилоо.

Иргэн⁴, хуулийн этгээд⁵ төрийн байгууллага зэрэг иргэний хэргийн оролцогчийн гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүх хүлээн авч хэрэг үүсгэн, хянан шийдвэрлэхтэй холбогдсон нийгмийн харилцааг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа гэнэ. Энэ ажиллагааны үндсэн зорилго нь тухайн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрхийг төрийн албадлагын журмаар хэрэгжүүлэх явдал юм. Гэхдээ шүүх маргааныг хуулийн дагуу шийдэх болон хүчин төгөлдөр болсон шийдвэрийг хэрэгжүүлэх хоёр тохиолдолд төрийн албадлагын журам хэрэгжинэ. Харин бусад үед нэхэмжлэгч, хариуцагч хоёр тал төрийн оролцоогүйгээр, маргааны агуулга, иргэний хэргийн хувь заяаг өөрсдийн хүсэл зоригоор шийддэг. Өөрөөр хэлбэл, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, дуусгавар болгох,

4 Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т зааснаар иргэн гэж Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн буюу байгалийн хүнийг ойлгоно (англи: *natural person*, хятад: 自然人).

5 Хуулийн этгээд гэж компани, төрийн болон төрийн бус байгууллага бөгөөд байгалийн бус, харин хуулийн дагуу үүссэн хүн гэсэн ойлголт (англи: *legal person*, хятад: 法人).

өөрчлөх асуудал нь зөвхөн оролцогч талуудын гарт бий. Нэхэмжлэгч, хариуцагч нь тухайн иргэний хэргийн “хувь заяаны эзэн” тул ижил эрх эдэлж, адил үүрэг хүлээдэг. Эдлэх эрхийн хувьд, эсрэг талын шаардлага, тайлбар, гаргаж өгсөн нотлох баримттай танилцах, тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, гэрчээс мэдүүлэг авах, шинжээчийг томилуулах болон, шүүх хуралдааны үеэр оролцогчдоос асуулт асуух зэрэг болно. Харин хэргийн талаар үнэн зөв тайлбар өгөх, шүүхэд гаргасан тайлбараа өөрөө нотлох, шүүхийн дуудснаар очих, шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Эдгээр эрхийг эдэлж, үүргээ биелүүлэхдээ өөрийн биеэр, эсхүл өөрийгөө сайн дурын үндсэн дээр итгэмжлэлийн дагуу төлөөлөгч, хүсэлт, гэрээний дагуу өмгөөлөгчөөрөө төлөөлүүлэх хэрэгжүүлэх боломжтой. Хэрэв төлөөлөгчид итгэмжлэл өгсөн бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохгүй, харин өмгөөлөгчтэй оролцож байгаа тохиолдолд биечлэн оролцож болох ба өөрөө хүсвэл оролцохгүй ч байж болно.

Өмгөөлөгч гэж эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан хуульч. Үйлчлүүлэгчийнхээ эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй. Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-15.1.16 дахь заалтын дагуу өмгөөлөгчид 16 төрлийн хориглох үйл ажиллагааг тодорхойлсон. Жишээлбэл, шүүх хурал дээр үйлчлүүлэгчийнхээ хүсэл зоригийн эсрэг байр суурь илэрхийлсэн (15.1.4), эсрэг талтай үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр харилцсан (15.1.4) өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэнэ.

Маргаанаа шүүхээр шийдүүлэх гэж байгаа бол “ямааны мах халуун дээрээ” гэдэг шиг аль болох хурдан хугацаанд шийдвэрлэж, шүүхэд нэхэмжлэлээ гаргаж өгөх хэрэгтэй.

Учир нь иргэний хэргийг шийдвэрлэхэд ерөнхий хөөн хэлэлцэх хугацаа 10 жил, гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа зургаан жил гэхчлэн Иргэний хуульд тусгайлан заасан хөөн хэлэлцэх хугацаа үйлчилдэг. Шүүх хуралдаанаас өмнө талууд өөрсдөө эвлэрлийн гэрээ байгуулах болон эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрлийн гэрээ байгуулах гэсэн хоёр арга замаар иргэний хэргийг хялбаршуулсан журмаар шийддэг. Аль ч тохиолдолд, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж нь хэн ч гомдол гаргах эрхгүй, эцсийн шийдвэр болон тогтож, тухайн эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй бол шууд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлэх боломжтой болно. Өөрөөр хэлбэл, шууд биелэгдэх хүчин чадалтай эвлэрлийн гэрээг байгуулах нь давж заалдах шатны шүүх хурал, хяналтын шатны шүүх хуралд зарцуулах цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэх давуу талтай.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шат мэтгэлцэх байдлаар явагддаг. Энэхүү мэтгэлцэх зарчим гэдэг нь эсрэг талын оролцогчтой “хэрэлдэх”, “муудалцах”, “доош нь хийх” гэсэн ойлголт биш. Харин тухайн үйл баримт, гэм буруу байгааг нотлох, эсхүл тухайн үйл баримт, гэм бурууг үгүйсгэх байдлаар мэтгэлцээн явагдана. Иймд мэтгэлцэх байдал нь нэхэмжлэл гаргаж, түүнд хариу тайлбар өгөх, нотлох баримт гаргаж өгөх, шүүх хуралдаанд үг хэлэх, тайлбар өгөх, нотлох баримтыг шинжлэн судлах, шүүх хурал дээр нөгөө талаас асуулт асуух гэсэн олон хэлбэрээр илэрдэг. Үндсэндээ болоод өнгөрсөн, бодит үйл явцын талаарх нөхцөл байдлыг хэн илүү ойлгомжтой байдлаар шүүгчид мэдүүлж, үндэслэлтэй зөв үнэлэлт дүгнэлт өгч, эдгээрт холбогдох нотлох баримтыг гаргаж чадна, тар талд шүүхийн шийдвэр гарах магадлал нэмэгдэнэ гэсэн үг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд өөртөө ашигтай нөхцөл байдлыг өөрөө

нотлох үүрэгтэй. Үнэндээ шүүх бодит үнэн, болсон явдлыг тогтоодоггүй. Харин шүүгч өөрийн сонсож, танилцсан бодит баримт материалд үндэслэн шийдвэрээ гаргадаг. Иймд хэргийн материалд авагдсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын үнэн, худлыг шүүгч өөрийн дотоод итгэл, үнэмшлээрээ үнэлэн дэнсэлдэг учир шүүхэд цугларсан нотлох баримт хамгийн их ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, хэн өөрт ашигтай нотлох баримтыг хэргийн материалд олноор оруулсан байна, түүний талд шүүхийн шийдвэр гарах магадлал нэмэгдэнэ гэсэн үг. Нотлох баримт гэдэгт нэхэмжлэгчийн нэхэмжлэл, хариуцагчийн хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл, бусад бичмэл баримтууд болон шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг, шинжлэн судалсан видео болон аудио бичлэг зэрэг багтана. Түүнчлэн эсрэг талын тайлбарыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл эсэргүүцээгүй нөхцөлийг нотлох баримтгүй байсан ч шүүх үнэн зөвд тооцдог. Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх үед л өөрт ашигтай бүх нотлох баримтыг шүүхэд гарган өгөх шаардлагатай. Учир нь давж заалдах болон хяналтын шатанд нотлох баримт шинээр хүлээн авдаггүй.

Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүмүүс шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хуралдааны танхимд орж ирэхэд суудлаасаа босох ёстой. Учир нь "... шүүхэрхмэдлийг Монгол Улсын нэрийн өмнөөс хэрэгжүүлж, шүүх бүрэлдэхүүн, шүүгчийн онцгой хариуцлагатай шийдвэр гаргадаг чиг үүрэгтэй холбоотой бөгөөд ингэж (суудлаасаа босож) байгаа нь хэлбэрийн төдий харагдах боловч хүмүүжлийн болон урьдчилан сэргийлэх ач холбогдолтойн гадна шүүх хуралдаанд оролцогчид болон уг хуралдааныг сонирхсон этгээдүүд шүүх хуралдааны дэгийг сахих, хэрэг маргааныг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, улмаар шүүхээс зөв шийдвэр гарахад нөлөөлөх нэг хүчин зүйл болдог..."⁶. Түүнчлэн өвчний улмаас босож чадахгүй байгаагаас бусад бүх тохиолдолд шүүх хуралдааны үеэр мэдүүлэг, тайлбар өгөх, асуулт асуух, асуултад хариулахдаа суудлаасаа босно. Шүүхийн шийдвэрийг уншиж сонсох үед мөн суудлаасаа босох хуулийн зохицуулалттай.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Давж заалдах шатны шүүхэд гомдлоо гаргах ба гомдолд шүүхийн шийдвэрийн аль зүйл, заалт, үндэслэлийг зөвшөөрөхгүй байгаагаа, давж заалдах шатны шүүх хуралд биечлэн оролцох хүсэлт зэргийг тусгах шаардлагатай. Уг гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхэд гаргах ба давж заалдах шатны шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлагдахгүйгээр иргэний хэргийг бүхэлд нь хянан үзэж магадлал гаргадаг. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг Улсын дээд шүүх нэгд, анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, хоёрт, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн, гуравт, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэсэн гурван тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалттай. Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хяналтын гомдлыг хэлэлцэж, хэрэв дээрх гурван тохиолдлын аль нэг нь гарсан байна гэж үзвэл хэргийг хянаж, аль нь ч алга гэж үзвэл хэлэлцэхээс татгалздаг.

- **Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга:** Эрх зүйч мэргэжилтэй, шүүх хуралдааны даргалагч шүүгчийн удирдлага дор шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, уг тэмдэглэлийг хэргийн оролцогчид танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэрэгт хавсаргах зэрэг чиг үүрэгтэй.
- **Шүүгчийн туслах:** Эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан төрийн захиргааны ажилтан. Шүүгчийн туслах нь шүүгчийн удирдлага дор иргэдээс шүүхэд ирүүлсэн хэрэг, маргааны баримт бичгийн бүрдлийг судалж, шүүгчид танилцуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх, шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтын хангахад оролцох гэх мэт чиг үүрэгтэй.

- **Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч:** Эрх зүйч мэргэжилтэй, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Маргааны талаар шийдвэр гаргахад нь талуудад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.
- **Шүүгч, шүүх бүрэлдэхүүн:** Эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй төрийн тусгай албан хаагч. Шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргадаг. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1-50.1.40 дахь заалтын дагуу шүүгчид 40 төрлийн хориглох зүйлийг хуульчилсан. Жишээлбэл, хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа зүй бус авирласан (50.1.20), мөн шүүх хуралдаан явцад гар утас хэрэглэх зэргээр хэрэгт хамааралгүй өөр бусад үйл ажиллагаа явуулсан (50.1.34) шүүгчид сахилгын шийтгэл ногдуулна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг шүүх байгууллагын дээр дурьдсан албан тушаалтнуудтай харилцаанд ордог.

6. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц (Шүүх)- ийн статус, чиг үүрэг

Үндсэн хуулийн хяналт тавих практик анх 19 дүгээр зууны эхээр Америкийн Нэгдсэн Улсад хэрэгжиж эхэлсэн байна. Энэхүү Америк маягийн загвараас гадна Австри, Франц маягийн загвар бий болж, дэлхий дахинд хэрэгжиж эхэлжээ. Дэлгэрүүлбэл, Үндсэн хуулийн мэргэжлийн хяналтыг ердийн шүүх гүйцэтгэдэг Америк загвар, Үндсэн хуулийн шүүх хэмээх тусгай биеэ даасан хараат бус төрөлжсөн шүүх байгуулсан Австри загвар, зөвхөн зөвлөх буюу урьдчилсан хяналтын ажиллагаа явуулдаг Франц загвар зэргийг өнөөгийн улс, орнууд өөрийн орны онцлогт тохируулан хуульчлан, хэрэгжүүлж байна.

Монгол Улс 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиараа хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан

хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгосон тул ардчилсан төрийн тогтолцооны нэн чухал байгууллага болох Үндсэн хуулийн дээд хяналтын байгууллагыг “Үндсэн хуулийн цэц” нэрээр байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийг сахин хамгаалах энэ байгууллагын нэрийг сонгохдоо монгол төрийн болон үндэсний уламжлалыг бодолцсон байдаг. Нэг талаас, Их Монгол Улсын үеэс хаанд зөвлөх эрх бүхий Цэцдийн (Сэцдийн) зөвлөл ажиллаж, Цэц гэдэг үгийг төрийн чухал институтийн түүхэн уламжлалыг хүндэтгэсэн. Нөгөө талаас, монгол үндэсний бөхийн маргаан бүхий асуудлыг шийдэж ирсэн үндэсний уламжлалыг ч бодолцжээ.⁷

“..Барилдаж байгаа хоёр бөхийн хооронд унагасан, унагаагүй тухай маргаан гарсан тохиолдолд уг хоёр бөх, тэдний хоёр засуулчаас гадна хоёр бөхийн шүтэн бишрэгч үзэгчдийн хооронд хүртэл маргаан гардаг. Энэ бүгдийг шийдвэрлэх үүрэгтэй Хөлийн цэц (шүүгчид) ажилладаг бөгөөд Хөлийн цэцээс уг хоёр бөхийн маргааныг шийдэх талаар гаргасан шийдвэрийг хэн ч эсэргүүцдэггүй заавал биелүүлдэг. Хөлийн цэцийн шийдвэр хамгийн шударга бөгөөд эцсийн байдаг уламжлал одоо хүртэл хадгалагдаж байдаг юм... Иймд Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэх байгууллагыг Цэц гэж нэрлэснийг шүүхээс огт өөр ямар нэг байгууллага гэж үзэж болохгүй.”

УИХ-аас батлагдан гаргасан олон зуун хууль, тогтоомж, эрх зүйн акт Үндсэн хуульдаа нийцэж байх нь Үндсэн хуулийн өөрийн хүчин чадлыг илтгэх чухал хүчин зүйл юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн хүчин чадлыг хангахын тулд оршин байхын зэрэгцээ төрийн тэргүүн, төрийн эрх барих дээд байгууллага, төрийн гүйцэтгэх дээд байгууллагын дур зоргыг хязгаарлах эрх бүхий Үндсэн хуулийн шүүх юм.

7 Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар. УБ., 1999, 4

Үндсэн хуулийн цэцийн статус. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан, энэхүү хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрх бүхий байгууллагын хувьд Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болдог. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулиар олгосон статус нь төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал, төрийн тэргүүн болох Ерөнхийлөгч, төрийн гүйцэтгэх дээд байгууллага болох Засгийн газрын албан ёсоор батлагдан гарсан аливаа шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж, Үндсэн хуулийн заалт зөрчсөн тухай дүгнэлт гаргаж, маргааныг магадлан шийдвэрлэх эрхтэйгээр Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих байдлаар илэрхийлэгддэг. Түүнчлэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл бий эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй. Харин Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг хэрэгжүүлдэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэрийг хянаж үзэх эрхгүй.

Аливаа хууль, эрх зүйн бусад акт, түүнчлэн дээд албан тушаалтны үйл ажиллагаа нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргаан нь хууль зүйн гэхээсээ илүү улс төрийн шинжтэй маргаанд тооцогддог. Учир нь “Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид Үндсэн хуулийн абстракт хэм хэмжээг бодит маргаанд хэрэглэх үедээ парламентаас баталсан хууль хэлбэрээр түр зуур эвлэрсэн хэдий ч эцэслэн шийдвэрлэгдээгүй улс төрийн зөрчилдөөнөөс зайлсхийж чаддаггүй”⁸ байна. Ийм нарийн төвөгтэй (төрийн бодлогын) асуудлыг шийдэхийн тулд Үндсэн хуулийн цэцийн гишүүн (шүүгчид) эрх зүйн өндөр мэдлэг, мэргэжилтэй байхаас гадна иргэний эр зоригтой, төрийн бодлогын хэмжээнд сэтгэдэг, үндсэн хуулийн эрх зүйгээр дагнан мэргэшсэн хуульч, улс төрч байх учиртай⁹. Иймд Үндсэн хуулийн цэцийн гишүүн

8 Christmas Landfried. *Judicial Power...* 2019,4

9 Ч.Энхбаатар, *Үндсэн хуулийн эрх зүй*. 2007, 276

нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, дөчин нас хүрсэн Монгол улсын иргэн байхаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц есөн гишүүн (шүүгч)-ээс бүрдэх бөгөөд нь Улсын их хурал гурав, Ерөнхийлөгч гурав, Улсын дээд шүүх гурвыг тус тус санал болгож, Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилдог. Хэдийгээр хуульд тусгайлан заасан байгууллага (Улсын Их Хурал, Дээд шүүх), албан тушаалтан (Ерөнхийлөгч)-аас нэр дэвшин Улсын Их Хурлаас томилогддог ч гэсэн Үндсэн хуулийн цэцийн гишүүн тэдний ашиг сонирхлыг төлөөлөх, Үндсэн хуулийн цэц үйл ажиллагаагаа тэдгээрийн өмнө хариуцах, тайлагнах үүрэг хүлээдэггүй. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн нь ажил үүргээ гүйцэтгэхдээ зөвхөн Үндсэн хуульд захирагдах ёстой. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн гишүүн аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байх баталгааг Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, болон холбогдох бусад хуулиар хангадаг.

Үндсэн хуулийн цэцийн чиг үүрэг. Үндсэн хууль бол төр болон иргэдийн хооронд хийсэн “нийгмийн гэрээ” гэдэг утгаар нийгмийн харилцааг зохицуулахаар эрх бүхийн байгууллага, албан тушаалтнаас гаргадаг эрх зүйн баримт бичгүүдэд тавигдах хамгийн үндсэн шалгуур болж тэдгээр нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн нэг дэх чиг үүрэг нь дараах эрх зүйн баримт бичиг Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, дүгнэлт гаргах юм.

- Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, тогтоол, шийдвэр
- Ерөнхийлөгчийн зарлиг болон бусад шийдвэр
- Засгийн газрын тогтоол, шийдвэр
- Монгол Улсын олон улсын гэрээ,

- Сонгуулийн төв байгууллагын ард нийтийн санал асуулга явуулах шийдвэр болон Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар гаргасан шийдвэр.

Эдгээр эрх зүйн баримт бичиг Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, тогтоол, зарлиг, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад шийдвэр бүхлээрээ буюу зөрчилтэй зүйл, хэсэг, заалт хүчингүй болно. Хэрэв Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг баримтлан маргааныг дахин хянаж үзээд Үндсэн хуульд нийцээгүй гэсэн цэцийн тогтоол гаргавал тухайн маргааны хувьд эцсийн шийдвэр юм. Ингэснээр мөн тухайн хууль, тогтоол, зарлиг, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад шийдвэр бүхлээрээ буюу зөрчилтэй зүйл, хэсэг, заалт хүчингүйд тооцогддог.

Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн хоёр дахь чиг үүрэг нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлыг эцэслэн шийдвэрлэх юм.

Гурав дахь нь чиг үүрэг нь дараах төрийн өндөр албан тушаалтнуудыг огцруулах үндэслэл байгаа эсэх асуудлыг хянан үзэж, дүгнэлт гаргадаг.

- Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл байгаа эсэх
- Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэл байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх болон Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл байгаа эсэх
- Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэх

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т зааснаар УИХ-ын гишүүн „Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.» хэмээн Төрийн сүлдэнд тангараг өргөдөг.

Сүүлийн хоёр чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулийн цэц их суудлын хуралдаанаар буюу 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй хянан үзэж, дүгнэлт гаргадаг. Нэгэнт Үндсэн хуулийн цэц их суудлын хуралдаанаар эцэслэн шийдвэрлэсэн тул Үндсэн хуулийн цэцийн энэ төрлийн дүгнэлттэй албан тушаалтан маргах хууль зүйн үндэсгүй. Өөрөөр хэлбэл цэцийн шийдвэр шууд хүчин төгөлдөр болдог.

Үндсэн хууль зөрчигдөж байгаа талаар Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах эрх Монгол Улсын иргэд төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд ямар нэг тусгай болзол, хязгаарлалтгүйгээр олгогдсон байдгаараа онцлогтой. Өргөдөл мэдээлэлд Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомжийн нэр, батлан гаргасан он, сар, өдөр, дугаар, түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа албан тушаалтны нэр, хаяг үйл ажиллагааны талаар буюу ямар байдлаар Үндсэн хуулийн ямар заалтыг зөрчсөн тухай, маргаж байгаа асуудлын талаарх өөрийн байр суурь, Цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж байгаа шаардлагаа тодорхой тусгай ёстой. Түүнчлэн Үндсэн хуулийн цэц нэр, хаяггүй өргөдөл, мэдээллийг хүлээж авдаггүй тул өөрийн нэр, хаягаа бичих учиртай.

Эх сурвалжийн жагсаал:

1. Ш. Цогтоо, 2013, 6-, 63
2. Монгол Улсын Үндсэн хууль
3. Монгол Улсын Шүүхийн тухай хууль
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
5. Өмгөөллийн тухай хууль
6. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль
7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
8. Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль
9. Олон улсын гэрээний тухай хууль
10. Монгол Улсын Их Хурлын тухай хууль
11. 姜爱丽, “论媒体监督与司法独立”, 2018, <http://www.weifanglawyer.org.cn/index.php/shows/10/229.html>
12. Ч.Ганбат, “Шүүгчийн хараат бус шүүхийн бие дааж ажиллах зарчим ба шүүн таслах ажиллагаа”, 1999, Шинэ толь, №28, <https://academy.edu.mn/content/28-199923/>
13. Улсын дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, 2007, 244.
14. Г.Совд, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар” (судалгаа, хэрэглээний), 1999, 4.
15. Christine Landfried, “Judicial Power: How constitutional courts affect political transformations”, 2019, 4.
16. Ч.Энхбаатар, “Үндсэн хуулийн эрх зүй”, 2007, 276.

3

Гуравдугаар бүлэг. Улсын төрийн оролцоо, улс төрийн нам, ИНБ-ууд ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх танин мэдэхүйн ойлголт

Доктор О.Хатанболд

Монгол Улс бол Азийн пост-социалист орнуудаас ганцаараа ардчиллын замыг тууштай сонгож, улмаар улс төр, эдийн засгийн шилжилтийг хооронд нь уялдуулж, тодорхой утгаар зэрэгцүүлж, бас тайван замаар хийснээрээ онцлогтой. Ганц хэмээн онцлохын учир нь Хятад, Хойд Солонгос, Вьетнам, Лаос зэрэг Азийн социалист байсан орнууд нь бидэнтэй адил замыг сонгоогүйд байгаа юм. Гэхдээ энэ улсууд (Хойд Солонгосоос бусад) бүгд л зах зээлийн эдийн засгийн харилцаа, нээлттэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх замаар харьцангуй амжилттай хөгжиж ирсэн. Аливаа улсын тогтвортой хөгжил нь тэдний сонгосон засаглалаас хамаарахын зэрэгцээ хөгжлийн төлөө төрийн цэгцтэй бодлогынхоо залгамж чанарыг хадгалан хэрэгжүүлж ирсэнтэй ихээхэн холбоотой гэдэг нь харагдаж байна.

Ардчилал, зах зээлийн замыг сонгож өөрийн улсын үндэсний онцлогт нийцүүлж, хөгжлийнхөө зам, загварыг бүтээж хөгжихийн сонгодог жишээг өнөөгийн Япон, Өмнөд Солонгос, Тайланд зэрэг Азийн өндөр хөгжилтэйд тооцогдох дорнын соёлтой, ардчилсан тогтолцоотой улс орнуудын өнөөдрийн дүр зургаас харж болохоор байна. Угтаа ардчилал нь өөрийн тогтносон аль ч үедээ хамтын шийдвэр гаргахад бүх нийтийн хяналтыг тогтоох, энэхүү хамтын хяналт дор бүгд эрх тэгш байдалтай оролцох гэсэн хос зарчмыг агуулна. Нөгөө талаас, ард түмэн шударгаар засаглалаа тогтоохыг «демократия» гэх агаад энэ бол нийгмийн асуудал мөн тул эцсийн дүндээ хүний асуудал юм. Ингэхлээр нийгэм бол хүний нийгэм, харин хүн бол нийгмийн хүн юм. Энэ бодит

байдлаас үүдэлтэйгээр нийгмийн хүмүүн бүтцийг сонирхож¹ үзэх зайлшгүй хэрэгтэйг өгүүлнэм. Тиймээс ардчилалд нийгэм дэх хүмүүсийн олон янзын үзэл, олон ургалч байдал төдийгүй иргэдийн эрх тэгш байдлыг урьдаас тооцсон таамаглал байх учиртай. Учир нь, хүмүүс төрсөн цагаасаа хэлэн бүгд тэгш эрхтэй төдийгүй хүн болсныхоо хувьд бүгд ижилхэн. Гагцхүү өсч торниж, нийгмийн амьдралд оролцох явцад хүмүүс өөр хоорондоо тэгш байж чаддаггүй. Үүнд нэг талаас улс төрийн соёл, улс төрийн идэвхтэй оролцоо чухал нөлөөтэй.

Судлаачдын үзэж байгаагаар 1990-ээд оноос улс төрийн соёлын судалгааны эрчим бага зэрэг буурсан ч гэлээ энэ нь улс төрийн соёлын судалгаа буурсан бус, харин судалгааны чиглэл ерөнхийгөөс тодорхой, тусгай чиглэл рүү хандах болсон төдийгүй улс төрийн соёлын суурь онол, үзэл баримтлал, парадигмд тодорхой хувьсал өөрчлөлт гарсны илрэл гэж болно. Үүнийг тодруулбал, улс төрийн соёлын онол, парадигмыг дотор нь Г.Алмонд, С.Верба нарын сонгодог онол, арга зүй ба бусад гэж хуваан үздэг. Тэгэхээр өнөөгийн улс төрийн соёлын судалгааны онол, арга зүй үндсэндээ Г.Алмонд С.Верба нарын үзэл баримтлалын бүтээлч үргэлжлэл хэмээн хэлэх хэрэгтэй болов уу. Тухайлбал, Г.Алмонд, С.Верба нарын «Харьцуулсан улс төрийн систем»(1956) хэмээх эрдэм шинжилгээний өгүүллээр улс төрийн соёлын онол мэндэлсэн түүхтэй. Үүний дараа «Улс төрийн соёл, улс төрийн хөгжил»(1965) хэмээх бүтээлдээ дэлхийн 13 орны улс төрийн соёлыг харьцуулан судалсны зэрэгцээ тэдгээрийн ялгаатай байдлыг тодорхойлохыг оролдсноороо онцлогтой. Улс төрийн соёл нь улс төрийн системийн, түүний бүрдэл хэсгүүдийн харилцаан дахь улс төрийн өвөрмөц чиг баримжаа, баримтлал болохыг тогтоосон байдаг. Энэ нь дараах онцлогтой аж.

Нэгд **«Танин мэдэхүйн чиг баримжаа»** буюу улс төрийн систем, түүний үүрэг ролийн тухай бас түүний биелүүлдэг хүмүүсийн тухай, цаашлаад оролт, гаралтын тухай мэдлэг, итгэл үнэмшлийг;

Хоёрт **«Хачин авирын чиг баримжаа»** буюу улс төрийн систем, түүний үүрэг роль болон албаны хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон мэдрэмжийг;

Гуравт **«Үнэлэмжит чиг баримжаа»** буюу улс төрийн объектуудын тухай итгэл үнэмшил, санаа бодол зэргийг багтаадаг

Дээрхээс үзвэл, иргэдийн хувьд улс төрийн бодлого хөтөлбөрийг боловсруулах, улс төрийн шийдвэр гаргах үйл явцад шууд оролцох боломжийг бий болгосноор олон нийт өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлж, санал санаачилгыг өрнүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн үндсэн хууль болон бусад хуулиар олгогдож, хамгаалагдсан эрх мэдлээ бүрэн дүүрэн эдэлж байгаа эсэхийг онцолсон гэсэн үг. Тодруулбал, Макс Веберийн нэрлэсэнчлэн «тохиолдлын улс төрчид» биш, гагцхүү үнэн зөв, шударга улс төрч хэмээх эрх үүргээ бүрэн² харуулж чадах болно. Ардчиллын энэхүү хэлбэр жирийн иргэдийг эрх мэдэлжүүлэх замаар тэдний оролцоог бүрэн дүүрэн хангах, өөрсдийн эрх, боломж бололцооны хүрээнд аливаа улс төрийн шийдвэр гаргахад идэвхтэй оролцох боломжийг бий болгоод зогсохгүй аливаа зүйлд тохиолдлын, гэнэтийн мэт байр сууринаас хүнийсэх байдлаар хандах хандлагыг бууруулдаг. Ингэснээрээ хүний эрхийн наад захын шаардлага, иргэний оролцооны хамгийн энгийн хэлбэрүүд ч олонхын хувьд хангагдахгүй байгааг олж илрүүлснээр түүний улс төрөөс хүнийсэх хандлагыг бууруулж болох юм.

Иргэдийн бүх талын оролцооны зүй ёсны хэрэгцээг хангах бодит боломжийг өргөтгөх тэдний идэвхтэй, шийдвэрлэгч чанартай оролцооны чадавхыг бэхжүүлэх, уг оролцооны зохион байгуулалтын хэлбэрийг нарийсгаж, арга замыг шинэтгэн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

2 Вебер М. Улс төр бол мэргэшил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн. Уб., 2003. 47 дахь тал

Ингэхийн тулд (i) иргэдэд ардчиллын үнэт зүйлсийг эзэмшүүлэн өөрийншүүлэх; (ii) хүний хөгжлийг дэмжин урамшуулсан нийгэм-эрх зүйн орчинг бүрдүүлэх; (iii) засаг төрд хяналт тавьж үр ашигтай нөлөөлөхүйц иргэний нийгмийн үйл ажиллагааны хүчтэй механизмыг бий болгох; (iv) иргэд болон шийдвэр гаргагчдын харилцааны эгэл бөгөөд ажил хэрэгч ёс журам тогтоон хэвшүүлэх; (v) мэдээллийн нээлттэй эх үүсвэр, чөлөөт урсгалыг өргөтгөх, суурь орчин, тэгш боломжийг бүрдүүлэх зэрэг үндсэн зорилтуудыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай. Ингэснээр засаг төрийн болон олон нийтийн үйл хэрэгт эрх, ашиг сонирхлоо хамгаалан оролцох иргэдийн ухаалаг хэрэгцээг төлөвшүүлж, улмаар тэдний оролцооны идэвх сул, соёл сайнгүй, оролцооны сэдэл дутмаг буйг ардчиллын утга чанарыг ухаалгаар өрнүүлж элбэгшүүлэхийн зэрэгцээ түүнийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд³ чухал нөлөөтэй.

Энэ бүхнээс сүүлийн жилүүдэд өнгөц харахад бодит амьдралд иргэдийн нийгэм, улс төрийн идэвх оролцоо нэлээд идэвхжсэн хандлага ажиглагдах болсон. Үүний учир нь нийгмийн жижиг бүлгүүд үзэл бодлоороо нэгдэж иргэний нийгмийн байгууллагын бичил нэгжүүдийг бүрдүүлж дуу хоолойгоо төр засагт хүргэх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан зохион байгуулах⁴ замаар төрийн бодлогод бодитой нөлөөлөх явдлыг чухалчлах болсон явдал юм. Ингэхийн тулд тухайн дэвшүүлж буй асуудлынхаа гол мөн чанар, түүнээс гарах үр дагавар, хүчин зүйлсийг тооцоолон үзэхдээ өнөөгийн иргэдэд (i) улс төрийн талаарх мэдлэгийг маш энгийнээр тайлбарлан ойлгуулахыг нийгмийн шинжлэх ухааны салбарынхан ихээхэн хичээх болов. Ийм учраас, (ii) иргэдийн улс төрийн оролцоо, (iii) иргэдийн санаачлага, (iv) улс төрийн нам, (v) ИНБ-ууд ба эвсэл холбоод, (vi) хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан дээр дурдсан агуулгыг хялбаршуулан танилцуулахыг эл нийтлэлдээ тодруулав.

3 Чулуунбаатар Г. ХХ, ХХI зууны зааг үеийн монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. «Сансудай» ХХК. Уб., 2009. 291 дэх тал

4 Энхболд Д. Монголын залуучуудын улс төр, нийгмийн оролцооны өнөөгийн байдал. ФСЭХ, ШУА. «Философи, эрх зүйн судлал-XXV». «Арвин судар» ХХК. Уб., 2010. 107-121 дэх тал

1. Бидний мэдэх улс төрийг энгийнээр тайлбарлавал...

Улс төр (грек хэлээр: *Πολιτικά, politiká*, «хотын хэрэг») нь нөөц баялгийн хуваарилалт, статус зэрэг хувь хүмүүсийн хоорондын эрх мэдлийн харилцааны бусад хэлбэрүүд эсвэл бүлэг хэлбэрээр шийдвэр гаргахтай холбоотой үйл ажиллагааны нэгдмэл цогц юм.

Бидний мэдэх улс төр хаанаас эхэлсэнийг тоймлон авч үзье. Үнэндээ египетчүүд, ромчууд, грекчүүд бол улс төрийн гүн ухааныг илэрхийлж, улс төрийн институцийг оновчтой шинжлэн судалсан анхны ард түмэн гэж болно.

Улс төр бол бүлгээрээ амьдарч байгаа хүмүүсийн шийдвэр гаргах арга зам буюу хүмүүс овог аймаг, хот, улс гэх мэт бүлгээрээ хамт амьдрахын тулд тэдгээрийн хооронд хийгддэг нийгмийн гэрээ хэлцэл хэмээн маш энгийнээр ойлгож болно. Үнэндээ, улс орнуудын төр засаг тухайн нийгмийнхээ томоохон бүлгүүд болон ард иргэдтэйгээ нийгмийн гэрээ хэлэлцээр хийхэд маш их цаг зарцуулдаг. Тэгэх ч ёстой болов уу. Энэ бол иргэдийн улс төрийн эрх мэдэл ямар төвшинд буйгаас шууд шалтгаална гэсэн үг.

Тэгвэл тэрхүү улс төрийн эрх мэдэл гэдэг нь улс төрчид, удирдагчид болон бусад хүмүүсийн засгийн газрын бодлогод нөлөөлж, улмаар ард түмэн, улс орнууд ямар шийдвэр гаргаж байгааг хянах чадварыг хэлнэ⁵. Энэ хүрээнд какистократизм⁶ буюу хамгийн муу хүмүүсийн засгийн газар, стратократизм⁷ буюу армид суурилсан цэргийн засаглал (засгийн газар), бохир төр бий болдог. Харин бохир улс төр гэдэгт бусдыг хов живт хутгах, хилс хэрэгт гүтгэх кампанит ажиллагаа явуулах, гутаан доромжлох байдлаар нэр хүндийг нь унагахыг хэлдэг. Түүнээс гадна, бохир заль мэх хэрэглэн гүтгэх, гүтгэлэг маягийн халдлагыг зохион байгуулалттайгаар хийх явдал бүдүүлэг улс төрийг улам бүр өдөөдөг гэж болно.

5 Дэлгэрэнгүйг <https://study.com/academy/lesson/political-power-territoriality-definition-example.html>- ээс үзнэ үү.

6 Дэлгэрэнгүйг <https://www.merriam-webster.com> -ээс үзнэ үү.

7 Дэлгэрэнгүйг <https://www.merriam-webster.com> -ээс үзнэ үү.

Энэ бол улс төрийн нийгэмшилтэй холбоотой гэж үзэж болох юм. Учир нь улс төрийн нийгэмшил (*political socialization*) нь зөвхөн ноёрхогч үзэл суртал, улс төрийн институтын зүгээс бие хүнд үзүүлэх зорилготой нөлөөлөл бус харин системийн зорилго, үнэт зүйлсийг хадгалах механизмыг хэлдэг. Нэг үгээр, бие хүн улс төрийн системтэй харилцан үйлчлэх замаар буюу систем өөрөө өөрийгөө үйлдвэрлэх, шинэ гишүүдийг сургаж бэлтгэх явцад илэрдэг хос үйл явц юм. Энэ нь түүний элементээр дамжин илэрдэг жамтай. Өөрөөр хэлбэл, хүмүүс улс төрийн соёлыг улс төрийн нийгэмшүүлэх үйл явцаар дамжуулан хүүхэд ахуй насандаа олж авдаг. Ийнхүү олж авсан соёл нь гэр бүл, сургуулийн багш нараар дамжин тухайн хүүхдийг нийгэмшүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлдэг болох нь судалгаанаас ажиглагддаг. Үүний нэг тод жишээ бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл бөгөөд улс төрийн нийгэмшүүлэх үйл явцад хамгийн өндөр нөлөө үзүүлэх хандлага хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээнээс үүдэлтэйгээр эл нөхцөл байдал улам бүр нэмэгдсээр байна.

Үүнээс улс төрийн нийгэмшил олон янзаар явагддаг. Эртний грекийн сэтгэгч Платон (МЭӨ 390) «Бүгд найрамдах улс» (*The Republics*) хэмээх бүтээлдээ сайн язгууртны дэглэмийг бий болгохыг чухалчилсан байдаг. Тэрбээр эл номондоо гол төлөв боловсролын тогтолцоог түлхүү тайлбарлаж, улмаар залуучуудад юу заах талаар онцлон тэмдэглэсэн нь сонирхолтой байв. Тодруулбал, дэглэмийн үнэт зүйлсээр хүмүүжсэн хойч үеийг төлөвшүүлэх нь дэглэм оршин тогтноход чухал ач холбогдолтой хэмээн үзсэнтэй холбоотой⁸. Платоныхоор гэр бүл, сургууль, үе тэнгийхэн, шашин, нийгмийн цөөнх, хэвлэл мэдээлэл, засгийн газар гэх мэт нийгмийн бүлгүүд бүгд өөр өөрийн өвөрмөц хэлбэрээр улс төрийн нийгэмшлийг төлөвшүүлэх учиртай ажээ.

Хүний амьдралын хэмнэлээр авч үзвэл, хамгийн эхлээд нийгэмшилд нөлөөлдөг субъект бол гэр бүл аж. Тэгэхдээ гэр бүл, бичил бүлгийн зүгээс нийгэмшилд үзүүлж буй нөлөөний

8 Хатанболд О, Хишигдаваа А. Улс төрийн соёлын тухай. Танин мэдэхүйн цуврал-91. ред. Цанжид А. ШУА. «Глобал партс» ХХК. Уб., 2022. 8 дахь тал

чиглэл, агуулгад төрөөс шууд нөлөөлөх бололцоо маш бага. Харин сургууль, цэцэрлэг, арми гэх мэт байгууллагын хүний нийгэмшилд гүйцэтгэх үүргийн агуулга, чиглэлд төрөөс шууд нөлөөлж болно. Хэрвээ ардчилалд шилжиж буй нийгэмд нийгэмшилтийн үйл явц бүх насныханд бусад үеийнхээс илүү эрчимтэй явагддаг гэж үзвэл нийгэмшлийн үйлдэгч (субъект) нь хэн байх вэ гэдэг асуулт дэвшигдэх⁹ болно. Хэвийн үед нийгэмшлийн гол үйлдэгч нь гэр бүл, боловсролын байгууллага, бичил орчин, мэдээллийн хэрэгсэл, шилжилтийн үед цөм хамтдаа өөрчлөгддөг байна. Тэдгээрийн соёлын өөрчлөлт янз бүрийн шинж чанартай, чиглэлийн хувьд ч янз бүр байх нь ойлгомжтой. Тухайлбал, Бага насны хүүхдүүд бусадтай харьцуулахад гэр бүлдээ илүү их цаг хугацааг өнгөрүүлдэг. Тиймээс тэдний ирээдүйд гэр бүлийн дадал, итгэл үнэмшил, зан үйл, хандлага хамгийн чухал нөлөө үзүүлэхийн зэрэгцээ ирээдүйн амьдралд суралцах хандлагыг гэр бүл төлөвшүүлдэг болохын илрэл мөн. Гэр бүл бол улс төрийн нийгэмших үйл явцын чухал эх сурвалж, бас суурь нь болдог төдийгүй эцэг, эхтэйгээ төстэй улс төрийн итгэл үнэмшлийг өөртөө шингээж, бас төлөвшүүлдэг гэж хэлж болно. Хүүхдүүд сургуульдаа эх орныхоо талаар суралцдаг бөгөөд энэ нь иргэний боловсрол гэж нэрлэгддэг сургалтын хөтөлбөрийн нэгээхэн хэсэг. Сургалтын хөтөлбөр нь түүх, төрийн онол, нийгмийн ухааны хичээлээр дамжуулан хүүхэд, залуучуудыг сайн иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдэх учиртай. Түүнээс гадна, ямар ч насны найз нөхөд, танилууд хүний итгэл үнэмшилд нөлөөлдөг учраас үүнийг үе тэнгийхэний бие биендээ нөлөөлөх үзэгдэл хэмээн үздэг. Зарим тохиолдолд эл нөлөөлөл нь эерэг бас сөрөг байж болно. Гэхдээ улс төрийн нийгэмшлийн явцад харилцан бие биенийхээ үзэл бодол, шийдвэрийг хүндэтгэн үзэж, хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, хууль ёсыг дагаж мөрдөх нь нийгмийн хамгийн чухал үнэт зүйл гэдгийг мартаж болохгүй. Харин шашин бол нарийн нийлмэл бүтэцтэй бөгөөд түүнийг шашны ухамсар, шашны үйл ажиллагаа, зан үйл, шашны харилцаа, шашны байгууллага болох сүм хийд бүрдүүлдэг. Тодруулбал,

9 David E. Arter: *The Politics of Modernization*. Chicago-London. 1967. p.179

шашин, улс төрийн аль аль нь хүний нийгмийн амьдрал, оршин тогтнолын хэрэгцээ шаардлагаар бий болдог үүсмэл шинжтэй¹⁰ үзэгдэл юм. Үүгээрээ нийгмийн амьдралын тодорхой орон зай, цаг хугацаанд зэрэгцэн оршдог хэмээн энгийнээр тайлбарлаж болох юм.

2. Иргэдийн улс төрийн оролцоо

Иргэдийн улс төрийн оролцоог энгийнээр тайлбарлавал иргэний соёлоор дамжин илэрдэг гэж болно. Аливаа эрүүл саруул ардчилал нь иргэний соёлын хөгжлөөс ихээхэн хэмжээгээр шалтгаалдаг. Ардчилсан нийгмийн иргэний соёл (*The Civic Culture*) гэдэг нь хувь хүн, бүлэг хүмүүсийн чөлөөтэй сонгож авсан үйл ажиллагааны үр дүнд бий болохоос гадна улс төрийн тогтолцооны төрөл бүрийн үйл явцад ард түмэн оролцдог улс төрийн соёлын идэвхтэй оролцоонд суурилсан улс төрийн соёлын нэг чухал төрөл юм. Чөлөөт нийгмийн иргэд нь өөрсдийнхөө ашиг сонирхлыг илэрхийлж, эрхээ эдэлж, өөрсдийн амьдралын төлөө үүрэг хариуцлага хүлээдэг явдал болно. Тэд хаана ямар ажил хийх, хаана амьдрах, улс төрийн аль нэг намд нэгдэх эсэх, юу уншиж судлах зэргийг өөрсдөө л шийднэ гэсэн үг.

Эдгээр нь улс төрийн биш хувь хүний шийдвэр болно гэжээ. Нийгмийн соёлын уран сайхны илрэл болох утга зохиол, урлаг, жүжиг, кино зэрэг нь засгийн газраас хараат бус бие даан оршин тогтох учиртай. Ардчилсан нийгмийн иргэний соёл нь улс төрийн боловсрол олгох боломжийг ямагт дэмжиж, улмаар нийгэм-эдийн засгийн суурь байдлын олон янзын ялгаатай байдлыг соргогоор мэдэрч, түүнийг арилгахын төлөө иргэний улс төрийн боловсрол, ардчиллын соёлыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд чиглэгдэх учиртай.

Улс төрийн оролцоо гэдэг нь маш энгийнээр бол улс төрийн хүрээг бүрдүүлдэг бас нөлөөлж оролцуулдаг үйл

¹⁰ МУИС. Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг. Гхэвлэл. Ерөнхий ред. Төртөгтох Ж, Мөнхбат С. Хэвлэлийн ред. Ууганбаяр С, Дөлгөөн Б, ба бусад. «Адмон принт» ХХК. Уб., 2020. 784 дэх тал

ажиллагаа юм. Улс төрийн оролцоо нь санал өгөхөөс эхлээд жагсаалд оролцох, шийдвэр гаргахад нөлөөлөл үзүүлэх аливаа чөлөөт арга хэмжээ явуулах, цаашлаад сонгогдсон төлөөлөгчдөө захидал илгээх зэргээр илэрдэг. Тэгэхээр улс төрийн оролцоо бол иргэд улс төрийн систем, улс төрийн институтуудын төлөвшилт, үйл ажиллагаа улс төрийн шийдвэр гаргах, боловсруулах явцад нөлөөлөхийг хэлнэ.



Америкийн улс төрч С.Верба, Н.Ни нар улс төрийн оролцоог иргэдийн идэвхжилийн нөлөөгөөр тэдний хүсэн хүлээсэн зүйлийг засгийн газарт хүргэхийг хэлнэ хэмээн тодорхойлжээ¹¹.

Улс төрийн оролцоонд: бүрэн эрхт төлөөлөгч томилох үйлдэл (сонгогчдын үйл байдал), сонгуулийн компанийн үед улс төрийн нам, нэр дэвшигчдийг дэмжиж идэвхтэй үйл ажиллагаа явуулах, хурал цуглаан, жагсаалд оролцох, улс төрийн нам болоод сонирхлын бүлгийн үйл ажиллагаанд оролцох зэргийг хамааруулж болно. Харин идэвхийн төвшингөөр нь: идэвхтэй хийгээд идэвхгүй гэж ангилан оролцооны хэлбэр, идэвхийн төвшин гэсэн хоёр параметрийн үндсэн дээр улс төрийн оролцоог 4 хэлбэрт хувааж болно хэмээжээ.




Уламжлалт оролцоо гэдэг нь бидний энгийн иргэдээс хүсэн хүлээдэг үйл ажиллагаа буюу сонгуульд оролцох явдал юм. Улс төрийн уламжлалт оролцоонд санал өгөх, улс төрийн кампанит ажилд сайн дураараа оролцох, сонгуулийн сурталчилгаанд хандив өгөх, аливаа улс төрийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцдог, улс төрийн тодорхой бүлэг (улс төрийн нам,

¹¹ Цанжэд А. Улс төрийн шинжлэх ухаан. Уб., 2001

хөдөлгөөн, эвсэл гм)-т гишүүнээр элсэх, төрийн албан тушаал хаших зэрэг орно.

Үнэндээ, улс төрийн зан төлөв (political behaviour) бол улс төрийн системийн үйл ажиллагаанд нийгмийн субъектүүдийн тухайлбал, иргэдээс төрийн байгууллага, тэдгээрийн ажилтны бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих, тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа оролдлогыг иргэдийн улс төрийн оролцоо хэмээн үзэх тодорхойлолтыг ерөнхий үндэслэл болгосон байдаг. Энэ утгаараа улс төрийн систем ардчилсан шинжтэй байхын тулд иргэдийн улс төрийн оролцоо өргөн байх боломжийг аль болохоор хангах нь чухал.

Иргэдийн улс төрийн оролцооны олон янзын арга хэлбэр байдаг боловч үндсэнд нь нийцтэй ба нийцгүй оролцоо гэж ангилдаг. Нийцтэй оролцооны хамгийн түгээмэл хэлбэр бол иргэдийн сонгуульд оролцох оролцоо хэлнэ. Харин төр, нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрдөггүй тийм оролцоо нийцгүй оролцоо гэнэ. Түүний хэлбэр нь нийтийн эд хөрөнгөд хохирол учруулахуйц жагсаал, цуглаан хийх, татвар төлөхөөс зохион байгуулалттай татгалзах, замын хөдөлгөөнд саад хийх, төр засгийн хаягаар доромжлолын үг хана туурганд бичих, нийтийн хэрэгцээний эд зүйлийг эвдэх зэргээр илрэн гардаг¹².



Уламжлалт бус оролцоо нь хууль ёсны боловч ихэнхдээ зохисгүй гэж үздэг үйл ажиллагаа юм. Уламжлалт бус улс төрийн оролцоо гэдэгт өргөдөлд гарын үсэг зурах, улс төрийн бойкотыг дэмжих хэлбэрээр эсэргүүцлийн жагсаал, цуглаанд оролцохыг ойлгоно.

Хууль бус улс төрийн оролцоо нь улс төрийн аллага, терроризм, хулгай, эвдэн сүйтгэх замаар өрсөлдөгчийнхөө

12 Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. ННФ. Уб., 2006



кампанит ажлыг хорлон сүйтгэхийг хэлнэ. Нэг ёсондоо хууль зөрчсөн үйл ажиллагаа юм. Ихэнх тохиолдолд хууль ёсны арга хэрэгслээр улс төрийн дорвитой өөрчлөлт гараагүй бол хүмүүс хууль бус оролцоонд хандах нь түгээмэл байдаг.

Иргэдийн оролцоо, тэр дундаа залуучуудын нийгмийн идэвх, оролцоог дээрх онолын үүднээс холбогдох ангилал, үзүүлэлтүүдийн дагуу тодорхойлох явдал чухлын зэрэгцээ бас нэг гол үндэслэл бол үндэсний хэмжээнд төр засгийн бодлогоор оролцоог нэмэгдүүлж дээшлүүлэх талаар олон баримт бичиг, бодлогын хөтөлбөрүүдийг боловсруулан гаргасан ч тэдгээр нь бодит байдалд биелэлээ олохгүй байгааг дурдах нь зүйтэй.

Ер нь хүмүүс яагаад оролцох ёстой вэ гэвэл ардчилсан иргэд улс төрийн оролцоог тодорхой түвшинд, тэр дундаа энгийн оролцоог биширч, хүлээн зөвшөөрдөгт оршиж буй хэрэг мөн. Гэхдээ улс төрд оролцох нь хэцүү байж ч бас болно. Гагцхүү оролцохын тулд, та цаг хугацаа, магадгүй мөнгө олох хэрэгтэй ч байж болох юм. Тэгвэл хүмүүс яагаад үүнийг хийдэг талаар дараах ойлголт нийтлэг байдаг.

Олон хүмүүсийн хувьд оролцоо бол ардчилсан иргэний хариуцлагын үүрэг учраас оролцоог чухалчилдаг. Харин зарим нэгний хувьд хувийн ашиг сонирхлын үүднээс асуудлыг өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, ашиг тус хүртэхийн тулд оролцдог, үүнийг ашиг тусын төлөөх оролцоо гэж болох. Зарим нь зүгээр л өөрсдийнхөө үйл ажиллагаанаас эсхүл улс төрөөр дамжуулан олж авсан найз нөхдөөсөө үүдэлтэйгээр нийгмийн үйл ажиллагаанаас таашаал авах зорилгоор оролцдог явдал юм.

Зарим оронд хүн амын нэлээд хэсэг нь улс төрд огт оролцдоггүй. Жишээлбэл, АНУ-д ерөнхийлөгчийн сонгуульд санал өгөх эрхтэй нийт иргэдийн тал орчим нь л санал

өгдөг байх жишээтэй. Энэхүү оролцоогүй байдал нь хэд хэдэн хандлагыг илэрхийлдэг: Тухайлбал,



Сэтгэл ханамж: Оролцооны дутагдал нь одоогийн нөхцөл байдалд сэтгэл хангалуун байгааг илтгэнэ. Хэрэв тэд ямар нэгэн асуудалд сэтгэл дундуур байсан бол хүмүүс оролцоог чухалчилдаг.



Эрх чөлөө: Ардчилсан нийгэмд хүмүүс оролцохгүй байх нь тэдний сонголт, бас эрх чөлөөний илэрхийлэл нь болно.



Апати: Олон хүмүүс улс төрийн талаар сайн мэдэхгүй, бас түүнийг тоодоггүй учраас улс төрөөс ангид байхыг чухалчилдаг

Эх сурвалж: <https://www.google.com/search?q=icon+of+freedom&tbm=isch&ved>.

Өөрөөр хэлбэл, улс төрөөс гадуур, улс төрийн ноёрхлоос хамаардаггүй, сонгууль, улс төрд идэвхгүй байр суурь баримталдаг гэсэн үг. Учир нь, эрх мэдэлтэй хэн ч тэдний санаа бодлыг сонсохгүйгээр үл барам төр засаг нь тэдэнд хайхрамжгүй ханддаг хэмээн боддог учраас хүмүүс улс төрд оролцохоос зайлсхийдэг аж.

Олон нийтийн санаа бодол, түүнд нөлөөлөх зүйл нь гагцхүү эрх баригчдад нөлөөлдөг тухайн улсын хүн амын үзэл бодлоос бүрдэнэ. Ардчилсан нийгэмд улс төрчид ажлаа авч үлдэхийг хүсвэл олон нийтийн санаа бодлыг хүсэн хүсээгүй сонсох хэрэгтэй болно. Хэрэв, улс төрчид, олон нийтийн үзэл бодлыг үл тоомсорлох аваас тэдний эсрэг санал өгөхөд бэлэн байдаг учраас улс төрчид аливаа дургүйцэгч этгээд бүрийг өөрийнх нь сонгогчид хэмээн үзэж, харилцахаас өөр арга замгүй. Засаглалын хувьд янз бүр байлаа ч гэсэн олон нийтийн санаа бодлыг анхаарахгүй байж хэрхэвч болохгүй. Хүн амын дийлэнх олонхи нь засгийн газрыг эсэргүүцвэл уг дэглэмд хувьсгал гарах, бүр цаашлаад нуран унах ноцтой

аюул ч нүүрлэж болзошгүй. Тиймээс олон нийтийн санаа бодлыг үнэлэх явдал өнөөгийн цаг дор нэн чухал зүйл.

Хүний нийгэмд байгалиас заяасан эв эеийг олж ийнхүү тэнцүүлэх ид шидтэй шийдвэр гэж байдаггүйн адил эцсийн эцэст ардчиллын ёс журам, хувь хүний эрхийн тухай заалтуудыг олонх нь хэрхэн хүндлэн сахихаас хамаардаг. Ардчилал өөрийн хууль ёсоор оршин тогтнох эрхтэй гэдэг тухайд зөрөлдөхгүй бол бусад ямар ч маргаан, санал зөрөлдөөнийг ардчилсан нийгэм даван туулах чадвартай нь маргашгүй үнэн.

Ардчиллын нягтралын үйл явцад улс төрийн соёл ямар үүрэгтэй байх талаар олон эрдэмтэд саналаа илэрхийлдэг. Хуан Линц, Алфред Степан нарынхаар бол ардчиллын зарчмууд ба түүнийг илэрхийлэгч байгууллагууд нь ард түмний хувьд «цорын ганц тоглоом» гэж тооцогдсон тохиолдолд л ардчиллын нягтралын асуудлыг ярьж болно. Өөрөөр хэлбэл, ардчиллын нягтрал бол олон хэмжүүрт үзэгдэл бөгөөд үүнд улс төрийн институцийн ба соёлын үнэлэмжийн хоёулангийнх нь шилжилтийг багтаан үздэг.

Ардчиллын соёл нь олон аргаар ардчиллыг дэмжин хөгжүүлдэг зүйл юм. Тухайлбал, урлаг бол орчин цагийн хүндрэл, бэрхшээл, дургүйцэл бухимдлыг тусган харуулах, аливаа нийгмийг төлөөлөх үүднээсээ ардчилсан үзэл санаа, практикийг түгээн дэлгэрүүлэх нэг чухал хэрэгсэл юм. Мөн аливаа орны түүх, түүний институтүүдийн онцгой ардчилсан, нийтийг хамарсан талуудыг ёслол тэмдэглэх бүх нийтийн баяр ёслолын аргыг ч ашиглаж болно. Хамгийн гол нь, улс төрийн боловсролыг өргөн хүрээнд олгоход, нэн ялангуяа олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, төр засгийн бодлогод шүүмжлэлтэй хандах, нийгмийн гишүүд бие биетэйгээ харилцах сувгаар хангахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх нь тодорхой¹³. Ардчилсан институци хямралыг даван гарч

13 Энхболд Д. Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлохуй. Шинжээчдийн судалгааны тайлан. Ред. Хатанболд О. ШУА. Философийн хүрээлэн. Уб., 2019. 27 дахь тал

чадах үгүй нь зарим нэгэн хүчин зүйлсээс үүдэлтэй. Угтаа улс төрийн манлайлагчид, эгэл жирийн иргэд нь ардчилсан үзэл санаа, үнэт зүйл, дэг журамд хүчтэй дэмжлэг үзүүлж байдаг орнуудад тогтвортой ардчилал тогтох боломж нэмэгдэж байдагт оршино. Тэрхүү дэмжлэг нь ардчилсан санаа бодол, ардчиллыг тууштай баримтлах явдал нь тухайн орны соёлд үндэслэсэн, тодорхой хэмжээгээр үе дамжиж байдаг ба тэр тохиолдолд хамгийн найдвартай зүйл болдог. Нэг үгээр, энэ орон ардчилсан улс төрийн соёлтой байна гэсэн үг.

Ардчилсан улс төрийн соёл нь ардчилал болон улс төрийн тэгш эрх нь хүслэн болсон зорилго гэдэгт итгэх иргэдийн итгэл төлөвшихөд тусалдаг. Энэхүү хүслэнт зорилго нь зэвсэгт хүчин ба цагдаад тавих хяналт, сонгогдсон манлайлагчдын гарт бүхэлдээ байх ёстой. Өөрөөр хэлбэл, сонгогдсон төлөөлөгчид нь үр нөлөө бүхий оролцоотой, засгийн үйл ажиллагаандаа хяналт тавьдаг байх, чөлөөтэй шударга, байнга явагдах сонгууль нь сонгох тэгш эрхтэй, засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байхыг урьтал болгохыг чухалчилна. Түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь үр нөлөөтэй оролцоо, мэдээлэлд үндэслэгдсэн мэдлэг чадвартай байх, альтернатив эх булгаас мэдээлэл авах боломж нь засгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үр нөлөөтэй оролцоог бий болгож байх учиртай.

Аливаа мэдээлэлд үндэслэгдсэн мэдлэг чадвартай байх, холбоодын бие даасан байдал нь үр нөлөөтэй, хяналттай, мэдээлэлжсэн мэдлэг чадвартай байх, иргэний нийгэмд хамрагдсан байдал зэрэг нь төр засагтаа хяналт тавьдаг чадвартай байхыг голчилно. Үүнтэй холбоотойгоор иргэд улс нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцдог байх хэмээх ардчиллын суурь институцийг¹⁴ ямар ч нөхцөл байдалд хамгаалах ёстой. Чингэхдээ иргэдийн хооронд үүссэн улс төрийн санал зөрөлдөөн болон ялгаанд тэвчээртэй харилцахыг шаарддаг, оршин байх эрхийн амин чухал сүнс учир жижиг хамтын нийгэмлэгийг биш, харин улс орныг удирдахад зайлшгүй хэрэгтэй байсан учраас л үүссэн.

14 Даль А. Роберт. Ардчиллын тухай. орч. Ганхуяг Д. Уб., 2004. 82 дахь тал

Улс төрийн соёл нь үр ашигтай, нээлттэй ил тод байх, итгэлцэл зэрэг үнэлэмж болон олон төрлийн хандлага, байр суурь, итгэл үнэмшилтэй холбоотой. Эдгээр нь нийлбэрээрээ тухайн иргэний улс төрийн амьдрал, иргэний нийгэм дэх оролцоо, үзэл бодолд нөлөөлнө. Үүний дотроос бусдаасаа хамгийн суурь утгыг илэрхийлдэг нь ардчиллын талаарх хандлага, байр суурь хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл, ардчилал нь бусад альтернатив хувилбараас илүү дээр гэж үзэх итгэл үнэмшил тулгуур, суурь нь болно. Ардчиллын субстантив ойлголт болох ард түмний засаг гэсэн ухагдахуунаас энэ нь улбаатай. Сүүлийн үеийн бараг бүх судалгааны дүгнэлтээр иргэдийн дийлэнх нь ардчиллыг ямар нэгэн болзолгүйгээр дэмжих дэмжлэг үгүй бол ардчилал нь бүрэн бус хэвээр¹⁵ байна гэдгийг нотолдог. Үнэндээ, зарим судлаачдын үзэж байгаачлан «ардчилсан үнэлэмж нь ардчилсан институцийн хувьд нөхцөлдүүлэгч болдогийг онцлохдоо эсрэг үйлчлэлийн асуудал байдаггүй»¹⁶ хэмээн үзэж болхоор байна. Улс төрийн итгэл үнэмшил, үнэлэмж нь хүмүүсийн үйл байдалд нөлөөлж, тодорхой нөхцөлд хэрхэхийг тодотгохдоо бусад альтернативийг хязгаарладаг. Тэгэхээр ардчиллыг хөгжүүлэх зорилт бол тухайн орны дотоодын, тухайлбал иргэд, тэдгээрийн холбоод, мэргэжлийн хамт олон, шашны бүлэглэл, нийгэм, эдийн засгийн байдал, засгийн газрын байгууллага, улс төрийн нам, байгууллагуудын асуудал юм. Тиймээс ардчилсан өөрчлөлт хийх, ардчиллыг хөгжүүлэх үйл явц зөвхөн тухайн орны дотоод асуудал байх тухай ойлголт нь ардчилал иргэдийн хууль ёсны дэмжлэг дээр оршин тогтнодог өөрийнх нь зүй тогтлоос үүдэлтэй.

Энэ утгаараа хүний эрх, хөгжлийн төлөөх оролцоот, хариуцлагатай засаглал дахь иргэдийн оролцоо бол орчин үеийн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй улс орнуудын нийгмийн хөгжлийн практикт нэгэнт бодит байдал болон төлөвшиж ирээдүйн дүр төлөвийг тодорхойлох хандлага

15 Ганбат Д. Ардчиллагдах үйл явц ба монголчуудын үнэлэмж. Хүний эрхийг хангаж ардчилсан засаглалыг бэхжүүлэх Мянганы хөгжлийн зорилго. Үндэсний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. Уб., 2008. 64 дахь тал

16 Inglehart R, Christian W. *Modernization, Cultural Change and Democracy: The Human Development Sequence*. New York.: Cambridge University Press, 2005

болон нийгмийн хөгжлийн гол шинж бүрэлдэн төлөвших үйл явцын илрэл болох болсон. Ардчилсан эрх үүрэг, эрх чөлөөний бүх хэлбэр, хувийн санал санаачилга, үйл ажиллагааны бие даасан арга хэмжээ, улс төр, эдийн засаг ахуйн болон бизнесийн хараат бус байдал, мэдээллийн чөлөөт орон зайн нэгдмэл шинж. Тийм болохоор, аль ч улс үндэстний иргэн, арьс өнгө, үндэс угсаа, нийгмийн байдлыг ялгаварлахгүйгээр иргэний ардчилсан эрх чөлөөг эрх үүрэг хариуцлагын зохистой нэгдэлд нь хуулийн хүрээнд хүн болгонд адил тэгшээр эдлүүлэх нь иргэний нийгмийн гол шинж болох төдийгүй ард түмний амьдралын материаллаг бодит ахуй, ухамсар, оюун санааны ертөнцийн орчин ахуйгаар¹⁷ бас нөхцөлддөг. Өөрөөр хэлбэл, ардчилсан засаглалын аливаа асуудалд иргэдийн бодит оролцоог бүрдүүлэхийг онцгойлон анхаарч ажиллах цаг үеийн шаардлага гарч буйг харуулж байна.

Энэ талаар Жон Стюарт Милл, Роберт А.Даль зэрэг онолчид иргэдийн эрэлт хэрэгцээ, эрхэм зүйлийг үр ашигтай хангахад зориулагдсан засгийн газрын чухал тодорхойлолт гэж үзсэн¹⁸ байдаг. Харин Роберт Патнэм иргэний нийгмийн орчин үеийн шинж чанарыг (i) иргэдээс нийгмийн үйл хэрэгт идэвхтэй оролцох; (ii) бүх иргэдийг тэгш эрх, үүргээр хангах; (iii) нийгэмд эв нэгдэл, итгэлцэл, тэвчээртэй байдлыг хэвшүүлэх; (iv) ардчилсан засгийн тогтвортой байдал, үр өгөөжийг дээшлүүлэх гэж тайлбарладаг¹⁹. Энэ мэтээр орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд «иргэний нийгэм» хэмээх ойлголтын тодорхойлолтыг «иргэн ба нийгэм» гэсэн ойлголтыг харьцуулан шинжилсний үндсэн дээр судлаачид гаргаж тавих болсон нь энэхүү ойлголтыг хамгийн өргөн утгаар нийгмийн хөгжлийн тодорхой төлөв байдал, иргэн бүрийн хувийн эрх чөлөө, сонирхлыг дээдэлсэн нээлттэй нийгмийн тогтолцоо гэж үзэх болсон. Эндээс иргэдийн

17 Чулуунбаатар Г. ХХ, ХХI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. *ФСЭХ. Уб, 1999, 55 дахь тал.*

18 Баяр Н. Төлөвлөгөөнөөс бүлэг рүү: нийгмийн сүлжээ ба иргэний нийгэм. *Философи эрх зүйн судлал-XXV. ФСЭХ. Уб, 2010, 159 дэх тал.*

19 Putnam R. *Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy.* Princeton University Press. NY, 1993. pp. 86-90.

оролцооны асуудал нь төр иргэн хоёрын харилцааны хүрээний асуудал мөн бөгөөд төр нь иргэдтэйгээ олон улсын, үндэсний, орон нутгийн гэсэн түвшинд харилцаж, иргэд төртэй хувь хүнийхээ хувьд эсвэл иргэний нийгмийн байгууллагууд зэргээр зохион байгуулагдсан бүлэгт оролцогчийн хувиар төртэй харилцдаг бөлгөө.

Тиймээс иргэдийн оролцоо бол иргэд, олон түмнийг нийгмийн амьдралд үр нөлөөтэй, идэвхтэй, үүрэг хариуцлагатай бодит эзэн ёсоор оролцдог үйл явдал юм. Чингэхдээ нийгмийн хөгжлийн шинэ хандлага болсон нийгмийн хариуцлагыг ухамсарласан арга замыг бүрдүүлж хамтын оролцоог буй болгох нь улс төрийн соёлын нэг чухал хэсэг төдийгүй соёл иргэншлийнхээ бодит, өвөрмөц онцлог, шинж хэлбэрийг агуулсан зарчимд суурилсан, хуулийг дээдэлсэн, хүнлэг иргэний оролцоог бүрдүүлэх нь тухайн улсын ардчиллын агуулга, мөн чанар, төлөвшил, хөгжлийн үнэн дүр төрхийг илтгэдэг. Нийгмийн ардчилсан тогтолцоо, чөлөөт зах зээлийн хөгжлийн явцаар иргэдийн ахуй амьдрал төр засаг, улс төрчдөөс хамаарах байдал аажмаар багасаж, харин өөрсдийнх нь идэвх санаачилга, хүчин чармайлтаас илүү хамаарах байдал аажим боловч нэмэгддэг жамтай.

3. Иргэдийн идэвх, санаачлага хэрхэн илрэх вэ?

Улс төрийн томоохон өөрчлөлт хийх, төрийн бодлогын чанартай шийдвэр гаргахад түүнд оролцогч гол талууд мэдээлэл солилцох, түгээх, маргаан, хэлэлцүүлэг хийх бүлэглэлүүд үүсч бий болох, зөвшилцөлд хүрэхэд хангалттай орон зай, цаг хугацаа байх шаардлагатай болдог. Гэхдээ тэрхүү маргаан, хэлэлцүүлгийн чанар, шийдвэр гаргах үйл явц хэр зэрэг оролцоотой байснаас өөрчлөлт, шинэчлэлтийн саналыг хүлээн авах, түүнийг үр нөлөөтэй²⁰ хэрэгжүүлэх явдал үүнд хамааралтай. Үүнээс ардчиллын орчин үеийн онолын протектив ардчиллын үзэл санааг

²⁰ Улс төрийн шинжлэх ухааны холбоо. Үндэсний өвөрмөц соёлын орчин дахь ардчиллын зарчмын үйлчлэл. Эрдэм шинжилгээний грант төслийн тайлан. Уб., 2008. 16 дахь тал

баримтлагчид ардчилал бол аль нэгэн тодорхой эдийн засгийн номлолтой холбоогүй гэдэг. Харин ардчиллын талыг баримтлагчид эдийн засгийн эрх чөлөө нь аливаа ардчилсан нийгмийн амин чухал эд эс мөн боловч, засгийн газрын оролцоо хувийн үйлдвэр, хараа хяналт хосолж байж түүнийг бэхжүүлэх, мөн нийгмийн шударга ёс бүх хүрээнд үр өгөөжтэй орлогын тэгш хуваарилалтгүй бол ямар ч үр дүнгүй хий хоосон зүйл бөгөөд эдийн засгийн эрх чөлөөгүй бол улс төрийн эрх чөлөө байж болохгүй²¹ тухай онол-практикийн санал зөвлөмжийг чухалчилдаг тал бий.

Түүнчлэн улс төрийн соёлын бодит хэлбэрүүдийн нэн чухал элементүүдийг нийлүүлж иргэний соёлыг хослуулан бүрдүүлэх боломжтой. Үүнээс гадна иргэний соёл бол ардчиллын тогтвортой байдлыг нөхцөлдүүлэгч биш, харин ардчиллын үр дүн байж болох тухай асуудлыг хөндөхөд хүргээд²² зогсохгүй шударга ёсны үзэл санаагаар дамжуулан нийгмийн чинээлэг амьдрал, эдийн засгийн болон нийгмийн сонголтыг²³ бүрдүүлдэгээрээ онцлог.

Чингэхлээр ардчиллыг олон нийтийн хэлэлцүүлэг, ард иргэдийн чадавх, бүтээмжийг тодруулах зорилгоор хүний эрхийн талаарх ойлголт, шударга ёсыг дэлхийн улс орон бүрт үнэлэхийг онцолж буй нь чухал ач холбогдолтой. Нөгөө талаар орчин үеийн төрийн хөгжлийн хэд хэдэн чухал онцлогууд болох төлөөллийн олон намт ардчилал байхын зэрэгцээ цэгцэрсэн систем²⁴ байж иргэд нь үндэсний тухайн нэгдмэл байдалд хамаарах ухамсараараа сэтгэл хангалуун байхын чухлыг онцлон тодорхойлсон.

Ардчиллыг хэмжих үнэт зүйлсийн тогтолцооны талаар Давид Истон улс төрийн бодлогын талаар тайлбарлахдаа нэр хүндтэй үнэт зүйлсийн хуваарилалттай адил бөгөөд

21 Хаек А. Ф. Фридрих. *Боолчлогдох замд. орч. Чойжил П. «Монсудар» ХХК. Уб., 2005. 86 дахь тал*

22 Hague R. *Breslin S. Political Science: A Comparatvie Introduction. NY., 1992. p.137*

23 Sen Amartya. *The Belknap Press of Harvard University Press. Cambridge, UK. Massachusetts, USA. /www.google.mn/?gws_rd=cr,ssl&ei=MbIMVcX2DoSpogTePQ#q=Amartya+Sen*

24 Гидденс А. *Социологи. ред. Ганхуяг Д. НИУС, МУИС. «Адмон» ХХК. Уб., 2006. 248 дахь тал*

түүнийг өнгөрсөн, эдүгээгийн аль алинд нь тохируулан нийгэм дэх «үнэт зүйлсийн» хуваарилалтын мөн чанарыг нэн тэргүүнд тавьж, түүнд багтсан анхдагчуудыг тодруулах явдал хэмээн үзжээ. Бихевиралист ба пост-бихевиралист онол, үзэл баримтлалууд 1950, 1970-аад оны үед улс төрийн шинжлэх ухаанд хувьсгал хийсэн мэдлэгийн салбар болсон. Д.Истоныхоор энэхүү мэдлэгийн салбарын нэн чухал зүйл бол нийгмийн үнэт зүйлсийг үр нөлөөтэй, ижил тэнцүү хуваах ойлголтыг улс төрийн нэр томъёонд оруулж, улмаар улс төрийн системийн хандлагын талаарх орчин үеийн онолыг улс төрийн шинжлэх ухааны судалгаанд оруулснаар шинэчлэлийг хийж чадсан төдийгүй иргэдийн идэвх, санаачлагыг өрнүүлэх чухад алхам болсон. Үүнийг Бингхам Г.Пауэл орчин үеийн ардчилал бол оролцоо, тогтвортой байдал ба хүчирхийлэл хэмээн үзсэн нь ардчиллыг бэхжүүлэн хөгжүүлэхэд сонгуулийг сайтар судлах, харьцуулсан улс төр судлалын тэргүүлэх эрдэмтэн судлаачдыг татан оролцуулах нь чухал үндэс суурь²⁵ болно хэмээн тайлбарласан. Тэрбээр иргэдийн хүсэл эрмэлзэл, сонирхол хэрэгцээ зэргийг засгийн газар нь хэр зэрэг харгалзаж чадаж байгаа болон хариу өгөх үүрэг нь хариуцлагын босоо тогтолцоотой хэр дүйцэж буй эсэх, нөгөө талаас оролцоо, өрсөлдөөнтэй ардчиллын үйл явцад иргэдийн сэтгэл ханамжид хэр нөлөөлж байгаа болон түүнийг хуулийн талаас нь харж болохыг онцолсон. Үүнээс ардчилсан засгийн газрууд нь «иргэдийн хүсэн хүлээсэн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлж» чадаж байгаа тохиолдолд хариуцлагатай байна гэсэн үг. Түүнийхээр ардчилсан хариуцан тайлагнах гинжин холбоос бол өрсөлдөж байгаа улс төрийн намуудаас дэвшүүлж байгаа олон янзын бодлого дундаас иргэд өөрсдөө чөлөөтэй сонголт хийх байдлаар сонголтыг өргөжүүлэх; иргэдийн сонгуулиас хүсэн хүлээж байгаа санаа бодол нь агрегаци болон төрийн бодлого болох бөгөөд тухайн ардчиллын хэлбэрээс хамааран улс, улсад арга зам нь өөр өөр байх; мөн сонгогдсон албан тушаалтнууд эсвэл тэдний томилсон төлөөний хүмүүс нь бодлогыг боловсруулж үр дүнг нь

25 Bingham G.P. *Elections as instruments of democracy: Majoritarian and Proportional visions.* Yale University Press. New Haven., Connecticut. USA. 2000.

гаргадаг явдал зэргээр илэрдэг²⁶ хэмээн тайлбарлажээ. Харин С.Верба, Г.Алмонд нар «Иргэний соёл» бүтээлдээ ардчилсан улс төрийн соёл бол бүх нийтийн дунд үндэсний улс төрийн талаарх зохих нөхцөл байдлыг шаарддаг хэмээн үздэг. Үүнийг тодруулбал, иргэд олон нийт үндэсний улс төрийн тогтолцооны талаарх мэдээлэл хомс байх нь иргэдийг бэлэнчлэх нийгмийн тогтолцоонд татагдахад хүргэдэг аж. Харин сонгодог иргэний соёл нь хувь хүн бүрийн төсөөллөөр дамжуулан тухайн дутагдаж буй мэдээ мэдээлэл, ухамсрыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр алслагдсан нутаг оронд оршдог ард иргэдэд улс төрийн аливаа үйл явцаас залхах, түүнээс хөндийрөх хандлага ажиглагдахаас урьдчилан сэргийлэх боломжийг олгодпоогоороо онцлог. Тодруулбал, ардчилал нь ажил хэрэгч бөгөөд амьдралд дөт байдаг аливаа асуудлыг шийдэхдээ аль нэг үзэл суртлыг турших биш харин түүнийг жинхэнэ амьдрал дээр үзэж гэмээ нь түүний ашигтай, ашиггүйг нь үзнэ. Үүгээрээ ардчилал нь нийгмийг шинэчлэлд хүргэдэг. Ардчилсан тогтолцоо нь алдаа дутагдал гаргасан эсвэл хэрэгцээгүй болсон бодлого, улс төрчдийг тогтмол, тайван аргаар халж өөрчлөх боломж олгож нийгмийн бүлгийн болон үе хоорондын шинэчлэлийг хэрэгжүүлдэг²⁷ шинэ улс төрийн систем болон хувирдаг.

Нийгэм эдийн засаг, социал, улс төрийн цогцоор илэрхийлэгдэх нийгмийн бүлгүүдийн олон үзүүрт ашиг сонирхолд тулгуурлан улс төрийн үзэл баримтлалууд бий болдог. Ардчилсан нийгмийг сонгон авч хөгжиж буй улс орнуудад нийгмийн сайн сайхан байдал хэр хангагдаж буйг илэрхийлэх үзүүлэлтүүдэд хүмүүс үзэл бодол, үйл ажиллагаагаараа хэрхэн нэгдэж байгаа эсэх, нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд хэрхэн оролцдог, хэр сонирхдог тухай асуудлууд урган гарч ирнэ. Энэ нь үзэл баримтлалын ялгаа, иргэд төр засгийн байгууллагууд болон бусад нийгмийн институтүүдийн үйл ажиллагаанд итгэх итгэл ямар

26 Дيامонд Л, Морлино Л. Ардчиллын чанар: Судалгааны тойм. Судалгааны өгүүллийн эмхэтгэл. АШБСТО-ын V бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл. «Нэнчин» ХХК. Уб., 2005. 73-75 дахь тал

27 Charles K. Waves of Democratization. Studies on Comparative International Development. Spring, 1998. pp. 43-44

түвшинд байгаа зэргээр илэрхийлэгддэг. Улмаар тухайн улс орны хөгжлийг тодорхойлох чухал хэрэгсэл болдгийн хувьд эдгээр нь иргэдийн нийгэм, улс төрийн үйл ажиллагааны оролцооны түвшинг давхар тодорхойлох нь зайлшгүй. Нийгмийн ил тод байдал, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломжоор иргэд хэрхэн хангагдаж буй байдлыг тодруулснаар оролцооны түвшинг үнэлэх ба ардчиллын нэг чухал үнэт зүйлийн төлөвшлийг тодорхойлж болно.

Иргэдийн хувьд улс төрийн бодлого хөтөлбөрийг боловсруулах, улс төрийн шийдвэр гаргах үйл явцад шууд оролцох боломжийг бий болгосноор олон нийтийн дуу хоолойгоо илэрхийлж санал санаачилгыг өрнүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн тэд Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдож, хамгаалагдсан эрх мэдлээ бүрэн дүүрэн эдэлж байна гэсэн үг мөний сацуу Макс Веберийн нэрлэсэнчлэн “тохиолдлын улс төрчид” биш, гагцхүү үнэн зөв, шударга улс төрч хэмээх эрх үүргээ бүрэн²⁸ харуулж чадах болно. Өөрөөр хэлбэл, ардчиллын энэхүү хэлбэр жирийн иргэдийг эрх мэдэлжүүлэх замаар тэдний оролцоог бүрэн дүүрэн хангах, өөрсдийн эрх, боломж бололцооны хүрээнд аливаа улс төрийн шийдвэр гаргахад идэвхтэй оролцох боломжийг бий болгоод зогсохгүй аливаа зүйлд тохиолдлын, гэнэтийн мэт байр сууринаас хүнийсэх байдлаар хандах хандлагыг бууруулахыг “идэвхжүүлэлтийн ардчилал”-ын гол ач холбогдол оршино²⁹.

Иргэдийн шууд болон төлөөлөн оролцох оролцооны ардчиллын үндсэн хэсгүүд хослох боломжийг баталгаажуулж, улмаар хүний эрхийн наад захын шаардлага, иргэний оролцооны хамгийн энгийн хэлбэрүүд ч олонхын хувьд хангагдахгүй байгааг олж илрүүлснээр түүний улс төрөөс хүнийсэх хандлагыг бууруулж болох юм.

28 Вебер М. Улс төр хувь зохиол бөгөөд ажил мэргэшил мөн. Иргэний улс төрийн боловсролын хөгжлийн төв. Улс төрийн дээд сургууль. УБ., 2010. 47 дахь тал.

29 Buechi R. Activating Democracy. October 2014. (Accessed April 21, 2015).

www.activatingdemocracy.com/three%20types%20of%20democracy/#!/prettyPhoto/

Үнэндээ иргэдийн бүх талын оролцооны зүй ёсны хэрэгцээг хангах бодит боломжийг өргөтгөх тэдний идэвхтэй, шийдвэрлэгч чанартай оролцооны чадавхийг бэхжүүлэх, уг оролцооны зохион байгуулалтын хэлбэрийг нарийсгаж, арга замыг шинэтгэн үр ашгийг дээшлүүлэхийн тулд:

- иргэдэд ардчиллын үнэт зүйлсийг эзэмшүүлэн өөриймшүүлэх;
- хүний хөгжлийг дэмжин урамшуулсан нийгэм-эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- засаг төрд хяналт тавьж үр ашигтай нөлөөлөхүйц иргэний нийгмийн үйл ажиллагааны хүчтэй механизмыг бий болгох;
- иргэд болон шийдвэр гаргагчдын харилцааны эгэл бөгөөд ажил хэрэгч ёс журам тогтоон хэвшүүлэх;
- мэдээллийн нээлттэй эх үүсвэр, чөлөөт урсгалыг өргөтгөх, суурь орчин, тэгш боломжийг бүрдүүлэх зэрэг үндсэн зорилтуудыг цогцоор шийдвэрлэх шаардлагатай.

Ингэснээр засаг төрийн болон олон нийтийн үйл хэрэгт эрх, ашиг сонирхлоо хамгаалан оролцох иргэдийн ухаалаг хэрэгцээг төлөвшүүлж, улмаар тэдний оролцооны идэвх сул, соёл сайнгүй, оролцооны сэдэл дутмаг буйг ардчиллын утга чанарыг ухаалгаар өрнүүлж элбэгшүүлэхийн зэрэгцээ түүнийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд³⁰ чухал нөлөөтэй аж.

Сүүлийн жилүүдэд өнгөц харахад бодит амьдралд иргэдийн нийгэм, улс төрийн идэвх оролцоо нэлээд дээшлэх хандлага ажиглагдах боллоо. Учир нь нийгмийн жижиг бүлгүүд үзэл бодлоороо нэгдэж иргэний нийгмийн байгууллагын бичил нэгжүүдийг бүрдүүлж дуу хоолойгоо төр засагт хүргэх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан зохион байгуулах³¹ зэрэг үйл ажиллагааг тогтмол явуулах болсныг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сурталчилж байгаа билээ.

30 Чулуунбаатар Г. XX, XXI зууны зааг үеийн монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. Уб., 2009. 291 дэх тал

31 Энхболд Д. Монголын залуучуудын улс төр, нийгмийн оролцооны өнөөгийн байдал. ШУА. ФСЭХ. Философи, эрх зүйн судлал-XXV. Уб., 2010. 107-121 дэх тал

Чингэхлээр, төрийн бодлогод бодитой нөлөөлөхийн тулд тухайн дэвшүүлж буй асуудлынхаа гол мөн чанар, түүнээс гарах үр дагавар, хүчин зүйлсийг тооцоолон үзэх хэрэгтэй. Тиймээс нийгмийн ил тод байдал, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломжоор иргэд хэрхэн хангагдаж буй байдлыг тодруулснаар оролцооны түвшинг үнэлэх ба ардчиллын нэг чухал үнэт зүйлийн төлөвшлийг тодорхойлж болно. Эвлэлдэн нэгдэж бүлэг холбоо байгуулах, амьдарч буй орон нутагт нь төрийн бус сайн дурын үндсэн дээр нэгдэн ажиллаж буй байгууллагуудын үйл ажиллагааны идэвхжилээр тодорхойлохдоо дараах зүйлд онцгойлон анхаарч ач холбогдол өгөх шаардлагатай³². Үүнд:

1. Эрх мэдлийг төвлөрүүлэхээс сэргийлж, хариуцлага хүлээх чадвартай улс төрийн системийг урамшуулдаг ардчилсан механизмтай байхыг хариуцлагын тогтолцоо шаардах ёстой. Чөлөөтэй, шударга явагддаг сонгууль бол үүнд хүрэх эхний алхам юм. Үүний төлөөллийг хангасан, мэдрэмжтэй засаглалын институцийг цаашид бэхжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг хангах, ард түмэнд санал бодлоо илэрхийлэх боломж өгөх зэргээр бататгах.
2. Хариуцлага хүлээх чадвар нь практик дээр иргэдийн өөрсдийн эрхийн тухай мэдлэг, төрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, мэдээллийн чөлөөт урсгал, түүнчлэн төлөвлөлт, худалдан авах үйл ажиллагаа, зарлагын тойм, төслийн нарийн учир зэргийг оролцуулсан төрийн байгууллагуудын дүрэм журам, үйл ажиллагааны ил тод байдлыг бий болгох, түүнд тэдний өөрсдийн идэвхтэй ажиллагааны сэдэл санаачилгыг өрнүүлэх.

Төрсасгийн удирдлага, хууль тогтоох байгууллага (парламент), Засгийн газар нь ардчиллыг хөгжүүлэн бэхжүүлэх төрийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг хангах үйлсэд засаг төрийн байгууллага, албан тушаалтан бүрийн санал санаачилга, хариуцлагыг дээшлүүлэн, иргэний нийгэм

³² Чулуунбаатар Г., Хатанболд О. Төлөөллийн ардчилал, Философи, эрх зүйн судлал. УБ 2014, 142-143.

болоод нутгийн өөрөө удирдах байгууллага, ТББ, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог идэвхтэй татан оролцуулж, иргэдийн идэвхтэй, бодит сэдэл, хүсэл санаачилгыг өрнүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн оновчтой зохицуулалт, дэмжлэгээр ханган, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө идэвхийлэн оролцож ардчилал, ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэхэд чухал манлайлал болох учиртай³³.

Үүгээр бид юуг хөндөх хэрэгтэй вэ гэвэл, ардчилсан нийгэм дэх улс төрийн идэвх, оролцоог дээшлүүлэхийн тулд нийгмийн тодорхой нэг хэсэг бүлгийн үйл байдал, зан үйлийн асуудлыг тодруулах нь бодит нөхцөлд хэрхэн уялдаж буйг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Дээр дурьдсан идэвхжүүлэлтийн ардчиллын практикт хэрхэн үйлчилж буйг тодруулах замаар нийгмийн бүлгүүдийн хамгийн идэвхтэй, өвөрмөц бүлэг болох залуучуудын нийгэм, улс төрийн идэвхийг хөндөснөөр тэдний нийгэм-улс төрийн ирээдүйн чиг хандлага хэрхэн төлөвшиж буйг тодруулахад чиглэгдэх болно.

Угтаа ардчилал нь өөрийн тогтносон аль ч үедээ хамтын шийдвэр гаргахад бүх нийтийн хяналтыг тогтоох, энэхүү хамтын хяналт дор бүгд эрх тэгш байдалтай оролцох гэсэн хос зарчмыг агуулна. Нөгөө талаас, ард түмэн шударгаар засаглалаа тогтоохыг «демократия» гэх агаад энэ бол нийгмийн асуудал мөн тул эцсийн дүндээ хүний асуудал юм. Ингэхлээр нийгэм бол хүний нийгэм, хүн бол нийгмийн хүн. Энэ бодит байдлаас үүдэлтэй нийгмийн хүмүүн бүтцийг сонирхож³⁴ үзэх зайлшгүй хэрэгтэйг өгүүлнэм. Тиймээс ардчилалд нийгэм дэх хүмүүсийн олон янзын үзэл, олон ургалч байдал төдийгүй иргэдийн эрх тэгш байдлыг урьдаас тооцсон таамаглал байх учиртай. Учир нь, хүн төрөхөөс бүгд тэгш эрхтэй. Хүн болсныхоо хувьд бүгд ижилхэн. Гагцхүү өсөж торниж, нийгмийн амьдралд оролцох хэмжээгээр хүмүүс өөр хоорондоо тэгшхэн байж чаддаггүй. Үндсэн хуулийн үзэл

33 Хатанболд О., Энхболд Д. Ардчилсан нийгэм дэхь ард түмний оролцоо хандлага. *Social Problems in the Developing countries...* УБ, 2013, 18

34 Дауи-Ёндон Б. Хөгжлийн философи... УБ., 2019, 244-245

санаагаар баяжсан ардчилал сүүлийн 30 жилийн хугацаанд оргилуун хүсэл, сэтгэл хөдлөлөөс хальж, олон түмний өдөр тутмын аж байдал, үйл хэрэг нэгэнт болсон тул өнөөдөр бид ардчиллын чанар ямар байгаа, гол сул тал нь чухам юу болох, ардчиллыг бэхжүүлэхэд бид юунаас эхлэх ёстойг авч үзэх³⁵ нь зайлшгүй хэрэгтэй.

4. Иргэний нийгмийн байгууллага, сонирхлын бүлгүүд улс төрд оролцох нь

Орчин үеийн хөгжингүй иргэний нийгмийн шинж чанарыг тодорхойлогч нийгмийн капитал хэмээх нэр томъёог нийгмийн шинжлэх ухааны үгсийн санд 1980-аад оноос дахин орж ирсэн түүхтэй³⁶. Үүнийг социологич Жеймс Коулмен тодорхойлохдоо иргэний нийгмийн хүрээнд буй болсон хувь хүмүүсийн хоорондын харилцаанд гарсан итгэлцэл, харилцан туслалцах чадамж, хүмүүсийн бүлгээр ажиллах чадвар³⁷ хэмээсэн байдаг. Тэгэхээр нийгмийн капитал гэдэг нь байгууллага, олон нийтийн бүлгүүдэд оролцож буй хүмүүс хоорондын харилцааны сүлжээнээс үүсдэг харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа юм. Ихэнх тохиолдолд нийтийн үйл ажиллагаа гэхээсээ илүү хувийн үйл ажиллагаа нь нийгмийн капиталыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг аж. Үүнээс үзвэл, нийтээрээ сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрч даган мөрддөг хэм хэмжээ, үнэлэмж дээрээ тулгуурлаад хамтын зорилгодоо хүрэхийн төлөө хүмүүс хоорондоо хамтран ажиллаж буй бүхий л тохиолдлыг багтаах явдал гэж өргөн утгаар нь ойлгоно. Тэрхүү нийгмийн капиталыг бий болгохын тулд юуны өмнө хүмүүс хоорондын нийгмийн харилцааны найдвартай, тогтвортой чанар нь өнөөгийн нийгмийн нэг тодорхойлогч шинж болох болов. Угтаа итгэлцэл нь нийгмийн харилцааны хувь хүний эргэн тойрны хүмүүсээс эхлэд нийгмийн бусад байгууллагууд болох иргэний нийгмийн болон төрийн

35 Хатанболд О. Монгол дахь ардчилалын чанар, төлөвших үйл явцын онцлог, ЭБЭИ, УБ, 2019, 123

36 ФСЭХ, ШУА. Монголын Ардчилалын төлөвшил., УБ, 2011, 168

37 Coleman, James. *The Foundation of Social Theory* Cambridge, 1990, 300-318

байгууллагуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагаан дээр тулгуурлана. Нэг үгээр нийгмийн хамгийн ойрын орон зайдаа хүмүүс бие биедээ итгэж туслахыг хэлж буй.

Нийгмийн капиталыг бүрдүүлдэг дараагийн чухал нөхцөл бол сайн дурын байгууллагуудад иргэд хэдийчинээ өргөн хүрээнд чөлөөтэй, идэвхтэй хамрагдаж чөлөөт үйл явуулж чадна төдийчинээ иргэний ардчилсан нийгмийг төлөвшүүлж чадна. Тиймээс өнөөгийн нийгэмд нийгмийн капиталыг эдийн засгийн хөгжил, тогтвортой чөлөөт ардчиллыг хангах чухал нөхцөл хэмээн олон хүмүүс үздэг. Үүний нэг илрэл бол «иргэний нийгэм» гэсэн нэр томъёог заримдаа нийгмийн капиталыг бий болгодог харилцааны ижил утгатай үг болгон ашиглах болсон. Энэ нь иргэний нийгэмд нийгмийн капитал хүмүүсийн хооронд амархан илэрч, бас дамжин төлөвшдөгөөс шууд хамаардаг зүйл.

Ардчилсан нийгэмд хүмүүс бусдад итгэж, санал нийлэхгүй байгаа хүмүүстээ хүлээцтэй хандахыг эрэлхийлдэг. Ийм хандлаггүй ардчилал дампуурч, эцсийн дүндээ хамтын ажиллагаанд суурилсан засаглалын хэлбэр хэврэгшдэг жамтай. Энэ утгаараа нийгмийн капиталын голлох хоёр төрөл болох бэхжүүлэгч, уялдуулагч шинж чанар чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн капитал нь нийгмийн гишүүдийн хоорондын холбоог бэхжүүлдэг тул улс төр судлаачид нийгмийн капиталыг ардчиллын зайлшгүй чухал нөхцөл хэмээн үздэг. Тодруулбал, бэхжүүлэгч (bonding) нийгмийн капитал нь нэгэн төрлийн бүлгүүдийн дотор эсвэл тэдгээрийн хоорондын харилцаа, дотоод холбоог батжуулагч шинжтэй. Харин уялдуулагч (bridging/linking) нийгмийн капитал нь нэг сүлжээг нөгөө сүлжээтэй холбож, мэдээлэл тархаалт, харилцан солилцоог хөгжүүлэх боломжийг өргөжүүлдэгээр³⁸ ардчилсан нийгэмд бүлэг хоорондын харилцан итгэлцлийг нэмэгдүүлдэг. Үүгээр нийгмийн капитал бол ардчилалд чухал үүрэгтэй. Нэг үгээр хүмүүсийг холбоход хамгийн хялбар холбогч төдийгүй бусад хүмүүстэй ажиллах нь иргэдийн дунд хамтын нийгэмлэг, итгэлцлийн

38 Конрад Аденаур сан. Захиргааны шинжлэх ухааны тайлбар толь, 2022, 193

мэдрэмжийг бий болгож чаддагаараа нийгмийн капитал ардчилалтай нягт холбоотой. Эрсдэл, тогтворгүй байдал хэдийчинээ их байна, тэнд харилцан итгэлцэл төдийчинээ хамгийн чухал хөрөнгө нь юм. Энэ төрлийн итгэлцэл нь цаг хугацаагаар шалгаран бэхждэг жамтай. Үүнээс л хамтрагч болон үйлчлүүлэгчээ нарийн лавтай мэдрэх боломжийг олгодог урт удаан хугацааны хувийн хэлхээ холбоо нэлээн үнэ цэнэтэй³⁹ болдог.

Аливаа ардчилалтай улс орны хувьд хамгийн хэцүү ажил бол иргэний нийгмийг бий болгох явдал юм. Учир нь иргэний нийгэм нь засгийн газрыг эсэргүүцэх үндэс болдогоороо авторитар дэглэмээс эрс ялгаатай. Эсрэгээрээ авторитар дэглэм нь иргэний нийгэмд хамгийн их саад учруулдаг гэж болно. Тухайн дэглэмийн засгийн газрууд иргэдийнхээ дунд айдас, үл итгэлцлийг бий болгож, ихэвчлэн бүлгүүд болон хувь хүмүүсийг бие биенийх нь эсрэг болгон эргүүлж, хооронд нь талцуулдаг. Энэ арга тийм ч таатай бас найдвартай арга биш болохыг өнгөрсөн цаг хугацаа бидэнд бэлхнээ харуулсан.

Харин ардчилсан дэглэмтэй улс орнуудад иргэд нь иргэний нийгэмд хамтран ажиллаж дасаагүйгээс нийгэмд итгэлцэл, хүлээцтэй байдлыг бий болгоход заримдаа бэрхшээлтэй тулгарах нь бий. Гэхдээ үүнээс айж эмээхээс илүүтэй ардчиллыг дэмжих эрмэлзэл дүүрэн байж нийгмийн капиталыг бодит утгаар нь бэхжүүлэн баталгаажуулах байдлаар иргэний нийгмийг төлөвшүүлэх нь нийгмийн капиталын ардчилах үйл явцад оруулж буй том хувь нэмэр болно.

Үүнийг Роберт Путнамын өнөөгийн өнцгөөс тайлбарласанчлан нийгэмд эв санаа, итгэлцэл, тэвчээр хэрэгтэй. Энэ нь оппортунизм, хувийн эрх ашгаа нийтийн эрх ашигт нийцүүлэх тийм сахилга батыг тогтоон барих явдал юм. Ингэснээр, ардчилсан засгийн тогтвортой

³⁹ Динелло Н. Кеннан. Төлөвлөгөөнөөс бүлэг рүү: нийгмийн сүлжээ ба иргэний нийгэм. Орч. Баяр Н. ФСЭЗХ, ШУА. Философи, эрх зүйн судлал-XXV. Уб., 2010. 157 дахь тал // [http://ru.wikipedia.org/wiki/социальная_сеть_\(социология\)](http://ru.wikipedia.org/wiki/социальная_сеть_(социология)).

байдал, үр ашгийг дээшлүүлэх хамтын нөхөрлөлийн өвөрмөц сургуулийг илэрхийлдэг иргэний нийгэмлэг бүрэлдэн хөгжих үндэс суурь болно. Бүх иргэдийг тэгш эрх, үүргээр хангах замаар тэднээс нийгмийн аливаа үйл хэрэгт идэвхтэй оролцох бодь сэтгэлийг биш гагцхүү «гэгээрсэн» хувийн сонирхол, нийгмийн эрх ашигт нийцсэн сонирхлыг л зорилгоо болгодог⁴⁰ байхыг чухалчилсаар ирсэн.

Энэ бүхэн нь хүн төвтэй иргэний нийгмийг үндсэнд нь ойлгож, түүгээр дамжин нийгэм дэх иргэдийн оролцоо нэмэгдэх боломжтой гэж үзэх учиртай. Ардчилсан нийгэмд иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг, оролцооны асуудал нь онолын төдийгүй практикийн хувьд судлуштай тулгамдсан асуудал болон тавигдаж ирсэн. Нэг үгээр ардчилсан өөрчлөлтийн үйл явц гүнзгийрэхийн хирээр иргэний нийгмийн тухай асуудал нь өөрөө хүн төрөлхтний улс төрийн философийн хөгжлийн явцад боловсрон өнөөг хүртэл явж ирсэн түүхтэй.

Иргэний нийгмийн орчин үеийн хандлагыг тодруулахдаа орчин үеийн иргэний нийгмийн талаарх альтернатив тодорхойлолтуудыг авч үзэх нь чухал. Иргэний нийгмийн үр ашигтай, бодитой хяналтыг нөлөөллийн арга хэмжээ болгон ашиглах нь зүйтэй. Тухайлбал, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа болон ёс суртахууны байдалд хяналт тавих, иргэдийн үнэт зүйлс, итгэл үнэмшил зэрэг нийгмийн харилцааны хэм хэмжээ, ардчиллын практикийг илэрхийлэх оролдлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Энэ нь иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, түүний нийгмийн хүрээллийн асуудлыг төр засгаас гарч буй алив согогтой бодлого, үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх боломжийг бүрдүүлнэ. Энэ утгаараа иргэний нийгэм нь өнөөгийн ардчилсан улс төрийн соёлд зөвшилцлийн зарчмыг баримтлан шийдвэрт нөлөөлөх үйл ажиллагааны ач холбогдол хэмээн ойлгох нь зүйтэй.

1960, 1970-аад оны үеэс сонирхлын бүлгүүдийн дунд нэн шинэхэн гарч ирсэн нэр томьёо болох олон нийтийн

40 Putnam R, Leonard R, & Nanetti R. *Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy*. Princeton, NY: Princeton University Press, 1993. pp. 86-90

сонирхлын бүлэг бүрэлдэн тогтсон явдал юм. Мөнхүү бүлэг нь нийгмийн тодорхой хэсгүүдийг болон түүнийг бүхэлд нь хамарч чадсан төдийгүй нийгмийн сайн сайхны төлөө нийтийн хүчээр тэмцэж, хамтран ажиллахыг үндсэн зорилтоо болгосон⁴¹ аж. Олон нийтийн сонирхлын бүлгүүдийн тэмцлийн гол зарчим бол ихэвчлэн хүрээлэн буй орчны асуудал, дайныг эсэргүүцсэн хөдөлгөөн зохиох, нийгмийн шударга бус үйл ажиллагааг эсэргүүцэх зэрэгт маш өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг байв. Харин дэлхийн нийтийг түгшээсэн хүйтэн дайны үед барууны олон нийтийн сонирхлын бүлгүүдийн тэмцлийн гол цөм нь хүйтэн дайн, цөмийн зэвсгийг эсэргүүцсэн жагсаал, албан шаардлага байсан бөгөөд дарангуйлагч төрт хавчигдан гадуурхагдаж буй ард иргэдийн эрх чөлөө, хүний эрхийн асуудал байв.

Түүхийн хууднаас харвал, олон нийтийн сонирхлын бүлэг анх үүсэж бий болсон Америк зэрэг хөгжингүй оронд, нийгмийн томоохон хэсгийг хамарч чадсан далайцтай арга хэмжээ зохион байгуулдаг ч тухайн үеийн нийгмийн дунд бий болсон олон зүйлийн бусармаг үйлдлийг төдийлөн арилгаж чадаагүй. Нөгөө талаар 250 гаруй мянган гишүүдийг эгнээндээ багтааж чадсан Америкийн Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа нь хүн амын хувьд харилцан адилгүй төвшинд байсан ч тэд өөрсдийн дуу хоолойгоо тухайн үеийн улс төрийн томоохон хүчин болох Бүгд найрамдахчууд болон Демократуудын үйл ажиллагааг бага ч болон либераль төвшинд хүргэж чадсан гавьяатай ажээ. Өөрсдийгөө олон нийтийн сонирхлын бүлэг хэмээн тунхагласан ихэнхи бүлгүүд нь бусдаас маш бага дэмжлэг авдаг байв. Гэтэл тухайн үед Америкт үйл ажиллагаа явуулж байсан олон нийтийн сонирхлын бүлгүүдийн тоо 83-т⁴² хүрсэн бөгөөд тэд хоёр том сангаас санхүүгийн туслалцаа авдаг байсан тухай нэгэн судалгаа нотолжээ. Хэд хэдэн бүлгүүд нь өөрсдийн санхүүжилтийн 90 хүртэлх хувийг тухайн сангуудаас авдаг байсан бөгөөд тэдгээр бүлгүүд нь өөрийн

41 John J.Harrigan. *Politics and the American Future*. Hamline University Press, 1990. p 196.

42 Мөн тэнд. 190 дэх тал.

санхүүждэг байгууллагын захирал, эздийн үзэл бодлыг бусдад тулгах, түүнийг төлөөлөх зэргээр олон нийтийн дунд өөрсдийн нэр хүндийг дээшлүүлэх явдал ихээхэн газар авах болсон. Энэ тухай Америкийн улс төр судлаач, эрдэмтэн Жак Волкер Америкийн сонирхлын бүлгүүдийн дэмжлэг ба үүсэл гарал хэмээх өгүүлэлтээ нэг бус удаа дурдсан байдаг. Аль нэг байгууллага, хөрөнгө мөнгөтэй, эрх мэдэлтэй хүний дуу хоолой болж, тэдний эрх ашгийн төлөө үйлчилдэг олон нийтийн сонирхлын бүлгүүд манайд газар авах болсон нь бусад шударгаар үйл ажиллагаа явуулдаг, дэвшүүлсэн зорилтоо биелүүлэхийн төлөө ажиллаж байгаа олон нийтийн сонирхлын бүлгүүдийн хэтийн оршин тогтнолд ихээхэн хүндрэл учруулах болно.

Цаг хугацаа улиран өнгөрөх тусам олон нийтийн эрх ашгийг хамгаалах, тэдний үзэл бодлоо илэрхийлэх дуу хоолойг шийдвэр гаргагчдын төвшинд хүргэж, асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийн төлөө сонирхлын бүлгүүд идэвхийлэн ажиллахыг хүсдэг ч тэд хөрөнгө мөнгөний гачигдал, санхүүгийн хомсдлоос шалтгаалан хэт нэг талыг баримтлах эсвэл нэг талд үйлчлэх, тэдний дуу хоолойг илэрхийлэгч болох явдал ажиглагдах боллоо. Үүнийг даган төрийн бус байгууллагуудын дунд сонирхлын бүлгүүд үүсэх асуудал эрчимтэй хөгжих болсон. Түүний нэг тод жишээ бол далан жил нэг намын удирдлага дор тоталитар дэглэмд байсан монголчууд 1992 оны ардчилсан Үндсэн хуулийнхаа 16 зүйлийн 10-т заасанчлан Монгол Улсын иргэд “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” болсон юм.

Энэ төрлийн харилцааг зохицуулж буй гол хууль нь 1997 онд батлагдсан “Төрийн бус байгууллага”-ын тухай хуулийн 1 зүйлийн 4-т зааснаар “төрийн бус байгууллага” гэж иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл

бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагын нэрлэнэ хэмээн заасан байна. ТББ-ууд нь дараах зарчмаар байгуулагдан ажиллаж болно.

- *сайн дурын*
- *төрөөс хараат бус*
- *өөрийгээ удирддаг*
- *ашгийн төлөө бус*
- *нийгмийн болон өөрийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс үйл ажиллагаагаа явуулдаг*
- *ил тод, хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болно*⁴³

Сонирхлын бүлгүүдийн дараагийн нэг хэлбэр бол төрийн албаныхан сонирхлын бүлгүүдийн хэмжээнд ажиллахыг хичээдэг явдал юм. Тэд ихэвчлэн төрийн бодлогын талаар тайлбар хийх, тэдний үйл ажиллагааг засаж залруулах, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлж буй төрийн бодлого, аливаа шийдвэрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавихыг чухалчилдаг. Орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийн үйл ажиллагааг тогтворжуулахад ихээхэн анхаарал хандуулдаг нь нэг талаас засгийн газар болон бусад төрийн институтүүдийн төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэдэг мэт харагддаг. Гэвч тэдгээр төрийн агентуудын сонирхлын бүлгүүд нь олон нийтийн дунд орж ажиллах, тэдний хүсэл сонирхлыг өөрсдийн үйл ажиллагаандаа тусгахын оронд ёс төдийхнээр төрийн хүнд машины аргаар ажиллах гэсэн хандлага нийтлэг ажиглагддаг гэж болно. Төрийн албаныхан угтаа ард түмэнд үйлчилж, тэдний хүсэл сонирхлыг өөрсдийн бодлого, хөтөлбөртөө тусгаж чаддаг, гарах үр дүнг бодит амьдралтай нөхцөлдүүлэх чадвар, чадавхитэй байх нь тэдний нэг чухал асуудал юм. Чухамдаа нийгэм нь амьдралаа илүү сайн зохион байгуулахын тулд төрийн аппаратыг бий болгосон. Гэтэл яваандаа төр нь

43 Төрийн бус байгууллагын тухай хууль. 1 зүйлийн 5. Уб., 1997

нийгмийнхээ дээр гарч нийгэм нь төрдөө үйлчлэх болов. Төрийн аппаратыг хэт шүтэх нь яваандаа ард түмнийг төрийн машиныг хөдөлгөгч шатахуун мэт үзэхэд хүргэнэ. Энэ нь эцэстээ төрийн араг яс нь үндэстний амьд биеийг идэж дуусгахаар амьгүй араг яс бүхний эзэн болгож үлдээх болно.

Тиймээс ч олон нийтийн сонирхлын бүлэг нь төрийн агентуудын үйл ажиллагаа, тэднээс хэрэгжүүлж буй бусад бодлого шийдвэрт нөлөөлөх, тэрхүү үйл ажиллагаанд болон төрийн бодлого ба хууль тогтоох үйл явцад олон нийттэй зөвлөлдөх байдал, мөн тулгамдсан асуудлыг төр засгийн сонорт хүргэж өөрсдийгөө ойлгуулах эрх зүйн орчин тийм тааламжтай биш ч гэсэн өнөөгийн монголд бий болсон улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн болон сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагаагаар зарим нэг эерэг алхамууд хийгдэх эхлэлийг эрчимжүүлэх болсон.

Улс төрийн хөдөлгөөнүүд. Ард иргэдийг улс төрийн үйл амьдралд албадан оролцуулах ёсгүй. Харин ч түүнд оролцохгүйгээр өөрсдийн дургүйцлийг илэрхийлэх эрх чөлөөтэй байна. Харин ард иргэдийн идэвхтэй оролцоо дутагдвал ардчилал доройтон сулардаг. Аливаа ардчилсан нийгэмд ард иргэд нь олон тооны хувийн байгууллага, холбоод, сайн дурын бүлгүүдэд нэгдэн ажиллах боломжтой байдаг. Тэдгээрийн нилээд нь улс орны бодлогын асуудлыг эрхэлж байдаг ч тун цөөхөн нь засгийн газрын хяналтад ажилладаг, эсвэл тэднээс санхүүждэг. Хувь хүмүүс сайн дураараа төрөл бүрийн засгийн газрын бус байгууллагад чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх эдлэх нь ардчиллын нэг үндэс мөн. Үзэл бодол, сонирхол нэгтэй хүмүүс нэгдвэл аливаа улс төрийн яриа хэлэлцүүлэгт тэдний зүгээс нөлөөлөх, санал бодлыг нь хүлээн авах боломж үлэмж нэмэгдэнэ. XIX зууны үеийн Францын агуу их улс төрч Алексис де Тосквилл энэ тухай «Ардчиллын замаар бүрэлдэн тогтсон улс оронд ч аль нэг бүлэглэлийн дарангуйлал, хэн нэгний зоргоор загнах засаглал тогтохоос урьдчилан сэргийлэхийн тулд

эвсэл холбоод юунаас ч илүү хэрэгтэй» гэж дурдсан байдаг.

Улс төрийн сонирхлын бүлгүүдийн хамгийн хувирамтгай, барьцгүй хэлбэр нь улс төрийн хөдөлгөөн юм. Улс төрийн хөдөлгөөнүүд нь нийгмийн бусад ашиг сонирхлын бүлгүүдийн явуулж буй бодлого, үйл ажиллагаанаас огт ялгаатай төдийгүй тэднээс илүү өргөн далайцтай байдаг нэг зүйл бол тэд нийгмийн үндсэн өөрчлөлтийг бий болгохыг зорьдогт оршиж байгаа юм. Улс төрийн сонирхлын бүлгийн өөр нэгэн онцлог зүйл бол өөртэйгээ нэгэн ижил зорилго бүхий жижиг сонирхлын хэд хэдэн бүлгүүдийг өөртөө багтаахын хамт ямар ч жижиг улс төрийн хөдөлгөөн аливаа нэгэн асуудлыг бие даан шийдвэрлэх боломжгүй юм.

Өнөөгийн улс төрийн хөдөлгөөнүүдийн уламжлалт улс төрийн сонирхлын бүлгүүдээс ялгарах нэг онцлог нь өөрсдийн дагалдагчдын ёс суртахуун, тэдний сэтгэлийг татахын төлөө зүтгэлтэй ажиллах явдал үлэмж нэмэгдсэн. Түүхийн хуудаснаа тэмдэглэгдснээр улс төрийн хөдөлгөөнүүд нь хөгжлийн явцдаа тухайлбал, 1950, 60-аад оны үед иргэний эрх чөлөөний хөдөлгөөн байсан бол 1960-аад оны сүүлчээс хүйтэн дайны эсрэг иргэний хөдөлгөөн болон өөрчлөгдсөн, харин өнөөдөр эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөн, эвангелист шашны эрхийн хөдөлгөөн, улс төрийн эрхийн тэгш хуваарилалтын хөдөлгөөнөөр хувьсан өөрчлөгдөж тэдний үйл ажиллагаа ч дэлхийн өнцөг булан бүрт хүчээ авах болсныг энд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.

Ер нь эсэргүүцэл бол ардчиллын нэгэн шалгуур гэж үзэж болох юм. Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ард иргэд аливаа асуудлыг шийдвэрлэхэд оролцох эрхэм зарчмыг сахин хамгаалахын тулд үндсэн асуудлаар нэг саналтай байж, аль аль талаа хүндэтгэх явдал чухал юм. Гэтэл эсэргүүцэж байгаа тал ба эсэргүүцлийн бай бологчид нь үндсэн асуудлын талаар санал нийлэхгүй бол энэхүү зөрөлдөөн нь хорсон бухимдах, уурлаж ундууцахад хүргэх талтай байдаг. Ийм үед үг хэлэх, хуран цугларах эрхийг хамгаалахын зэрэгцээ дэг журмыг чанд сахиж, айлган сүрдүүлэх, үймээн

самуун гаргахгүйгээр аль алиных нь тэнцвэрийг хангах нь чухал. Дэг журам сахиулах нэрийдлээр тайван эсэргүүцлийг дарвал дарангуйлалыг төрүүлэх бол ямар ч хяналтгүй, догшин ширүүнээр эсэргүүцлээ илэрхийлэхийг зөвшөөрвөл эмх замбараагүй анархи байдалд хүргэдгийг дэлхийн зарим нэгэн улс оронд гарсан сүүлийн үеийн үйл явдлууд бэлхнээ харуулсаар байна.

Улс төрийн сонирхлын бүлгүүд нь ямар ч тохиолдолд өөрийн статусыг тодотгосон дүрмийг гаргаж, түүнийгээ мөрдөхийг урьтал болгодог. Товчоор хэлбэл, бүлгүүд өөрсдийн улс төрийн зорилгодоо хүрэхийн тулд улс төрийн тогтолцоог барьцаалах, түүгээр дамжуулан өөрсдийн эрх мэдлээ нэмэгдүүлэх, нөлөөгөө бэхжүүлэхийг оролдохын зэрэгцээ өөрсдөдөө ашигтай боломжийг эрэлхийлэх үүднээс шинээр сонгогдсон гишүүдийг татан оролцуулахыг эрмэлздэг нь үнэн зүйл. Мөнхүү зорилт нь тэдэнд өөрсдийн дэвшүүлсэн квотыг батлах, улс төрийн радикал өөрчлөлтийг ашиглан байр сууриа бэхжүүлэх зэрэг бусад ашигтай нөхцлийг бүрдүүлэхийн төлөө ажиллах нь нийгэм, улс төрт үүсээд байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхээс илүү хэтийн зорилтоо биелүүлэх, байр сууриа бэхжүүлэхийг урьтал болгодог сонирхлын бүлгүүдийн улс төрийн ашиг сонирхол болох илрэл мөн. Чухамдаа ардчилсан ёсонд хүний зан төрхийн талаар хэд хэдэн төсөөлөл байдаг. Үүний нэг нь хэрвээ боллоцгоог нь хангавал ихэнх тохиолдолд хүмүүс өөрсдийгээ шударга, чөлөөтэйгээр удирдан залах чадалтай гэж үздэг. Өөр нэг нь аливаа нийгэм өөр өөр ашиг сонирхол, хувь хүмүүсээс бүрэлддэг учраас тэдний дуу хоолойг сонсож, үзэл бодлыг нь хүндэтгэх явдал чухал юм.

Өнөөдрийн Монголд үүсэн бүрэлдэж буй төрөл бүрийн сонирхлын бүлгүүдийг тухайлбал иргэний нийгмийн болон ТББ-уудыг “гэрлийн түмэн цэг”-тэй адилтган үзэж болох авч энэхүү зүйрлэлийг аль ч ардчилсан нийгэм дэх харилцан адилгүй байдал, олон эшт үзэл бодолд ч хамруулж болох юм. Ардчиллын дуу хоолойд засгийн газар, түүний улс төрийг дэмжин талархагчид төдийгүй сөрөг хүчний дуу

ч сүлэлдэн нийлж байх учиртай. Үүний дүнд ч иргэний нийгмийн болоод сонирхлын бүлгүүд, орон нутгийн холбоод, улс төрийн эвсэл холбоод, хэвлэл мэдээллийнхэн, эрдэмтэн судлаачид, шашны байгууллагынхан зэрэг бусад иргэдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, явуулахыг зорьдог байгууллагуудын бүгдийнх нь дуу хоолой бас нэмэгдэнэ.

Улс төрийн сонирхлын бүлгүүд нь өөрсдийн хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, зорилтынхоо хэмжээгээр засгийн газарт нөлөөлөх бусад хүчин зүйлсийн хувьд хэд хэдэн тодорхой арга замуудыг баримтлах шаардлагатай. Төрийн бодлогод бодитой нөлөөлөхийн тулд тухайн дэвшүүлж буй асуудлынхаа гол мөн чанар, түүнээс гарах үр дагавар, хүчин зүйлсийг тооцоолон үзэх хэрэгтэй. Энэ нь үнэндээ, ямар ч сонирхлын бүлгүүдийн дэвшүүлж буй зорилт нь төрийн бодлогын төвшинд нөлөөлж чадаж байна уу үгүй юу гэдэгт хариулт өгөх зорилготой юм. Тиймээс ч сонирхлын бүлгүүд нь ерөнхийдээ гурван арга замаар төрийн бодлогод нөлөөлөх боломжтой. Нэгдүгээрт, тухайн бодлогыг санаачлахад чухал үүрэгтэйгээр манлайлан оролцох, хоёрдугаарт, ганц-зорилтот бүлэг нь бодлого боловсруулах үйл явцад онцгой ач холбогдол өгч ажиллах, гуравдугаарт, сонирхлын бүлгийн тогтолцоо нь сонирхлын олон янзын хэлбэрүүдийг дэлгэн харуулах, мөн түүгээр дамжуулан төрийн бодлогод нөлөөлөх боломжийг эрэлхийлэх явдал хэмээн хэлж болно.

5. Улс төрийн нам: тодорхойлолт, бодлогын шалгуур ба санхүүжилт, дотоод ардчиллын шалгуурын тухайд

Улс төрийн намын тухай асуудал нь улс төр судлаачдын маргаан хэлэлцүүлгийн гол сэдэв байсаар ирсэн бөгөөд энэ маргаан нь гол төлөв улс төрийн намын нийгэмд эзлэх байр суурь, үүргийн асуудлын эргэн тойронд өрнөдөг. Харин олон арван жилийн турш үргэлжилсэн маргаан мэтгэлцээний дүнд ардчилал нь олон янзын идеал хэв маяг, бодит загваруудтай байлаа ч эцэстээ орчин үеийн ардчилалд намын гүйцэтгэх үүрэг онцгой хэвээр буй. Үүнийг өрнөдийн томоохон судлаачид хүлээн зөвшөөрөх болсон нь санамсаргүй⁴⁴ хэрэг огт биш. Харин Ричард Катц орчин үеийн ардчилал бол намын ардчилал бөгөөд улс төрийн нам бол либерал ардчиллын үр дагавар хэмээн дүгнэсэн⁴⁵ бол, С.Элдерсвелд намыг орчин үеийн нийгмийн улс төрийн гол бүтэц мөн гэж онцолсон байдаг⁴⁶. Гэсэн хэдий ч намуудыг тойрсон эл маргаан өнөөдрийг хүртэл зогсоогүй ч энэ нь цаашдаа сэдвийн өргөн хүрээг хамран шинэ байдлаар өрнөж, дээрх судлаачдын санааг сөргүүлсэн янз бүрийн дүгнэлт үндэслэлүүдийг гаргах болсон⁴⁷. Энэ нь бүх эрх мэдэл, бүх санаачлагыг гагцхүү нам гартаа авч, бүх зүйлийг намын хэмжүүрээр авч үзэх нь орчин үеийн ардчиллын нэн тэргүүний сул тал хэмээн үзэж буйн илрэл гэж болно.

Үүнээс үзвэл, орчин үеийн улс төрийн нам, намын системийн тухай ойлголт XVII зууны Британи, XVIII зууны АНУ-аас үүсэлтэй. Британий хувьд иргэний дайн, дайны дараах хувьсгал, Алдарт хувьсгал (Glorious Revolution)-ын үр дүнд бий болсон фракцууд органик байдлаар удаан хугацааны туршид нам болж төлөвшсөн тул тус улсад улс төрийн намд зориулж баталсан тодорхой бие даасан хууль бараг байдаггүй. Үнэн хэрэгтээ, улс төрийн намын тухай

44 Richard S.Katz, Peter Mair (1995). //Changing Modes of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party, in Party Politics, 1, (1995): pp. 5-28

45 Katz, R.A. Theory of Parties and Electoral Systems, Baltimore: Johns Hopkins University Press. 1980.

46 Eldersveld. S. Political Parties in American Society. NY, 1982. p.1

47 Ковлер А.И. Кризис демократии? (Демократия на рубеже XXI века) М., 1997. p.1

тогтсон ойлголт нь бичигдээгүй хууль, улс төрийн соёл, хэм хэмжээгээр зохицуулагдаад удаж буй тул заавал “dejure” хуульд тусгаж өгөх шаардлагагүй⁴⁸ байдаг.

Лари Даймонд, Ричард Гунтер нарын “Намуудын төрөл ба чиг үүрэг” өгүүлэлд орчин үеийн улс төрийн намын долоон чиг үүргийн тухай дурдаад намуудын гүйцэтгэдэг гол чиг үүрэг нь элитийг татан оролцуулахад оршдог болохыг онцлон тэмдэглэсэн. Үүнийг тодруулбал, сонгуулийн үйл явцын хоёр үед хамаатай: 1. Сонгуульд тухайн намыг төлөөлөн өрсөлдөх хүнийг тодруулж, нэрийг нь дэвшүүлэх, 2. Намууд нэр дэвшигчээ дэмжүүлэхийн тулд сонгогчдынхоо сэдлийг идэвхжүүлж, зарим тохиолдолд тэднийг сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцох бололцоогоор хангах зорилготой сонгуульд дайчлах, 3. Янз бүрийн асуудлаар сонголт, алтернативыг бүтэцжүүлэх буюу асуудлыг бүтэцжүүлэх чиг үүрэг, 4. Нийгмийн янз бүрийн бүлгийг төлөөлөх чиг үүрэг, 5. Ашиг сонирхлыг нэгтгэн нягтруулах, 6. Засгийн газрыг байгуулах ажиллуулах чиг үүрэг, 7. Нийгмийг интеграцчлах чиг үүргийг гүйцэтгэдэг⁴⁹. Намын эдгээр чиг үүргийг хэлбэрийн хувьд нь дотоод, гадаад гэж ангилан заагласан. Намын гадаад чиг үүрэгт: тухайн намын нийгмийн улс төрийн систем болон төрийн засаглал, засаглалын харилцааны хүрээнд гүйцэтгэх бүлэг чиг үүргүүдийг багтаан үздэг бол, дотоод чиг үүрэгт: намын өөрийнх нь улс төрийн бие даасан амьд организмын хувьд оршин тогтноход нь хэрэгтэй түүний дотоод амьдралын хүрээний бүлэг чиг үүргийг хамруулсан байдаг. Тэгвэл, Ж. Болдбаатар, А. Цанжид нар “Улс төрийн намаас нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг” хэмээх өгүүлэлдээ «намын нийгэмд гүйцэтгэх үүргийг ерөнхий байдлаар авч үзсэн байдаг. Тодруулбал, нийгмийн бүлгүүдийн сонирхлыг илэрхийлэх, томъёолох, үндэслэх; нийгмийн бүлгүүдийг идэвхжүүлэх, нэгтгэж, нягтруулах; үзэл суртал, улс төрийн номлолыг бий болгох; улс төрийн

48 Төгөлдөр Я, Одмаа Б, Мягмарсүрэн Д, ба бусад. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал. Санал, зөвлөмж. ИИФ. ШУТИС. Уб., 2021. 98 дахь тал

49 Richard Gunther and Larry Diamond, “Types and Functions of Parties,” in Larry Diamond and Richard Gunther, eds., *Political Parties and Democracy* (Baltimore: Johns Hopkins University Press, 2001), pp. 7-8.

системийг төлөвшүүлэх, түүний бүрдэл хэсэг, үйлчлэлийн ерөнхий зарчим зэргийг тодорхойлоход оролцох; төрийн засаглалын төлөө тэмцэлд оролцох; төрийн бодлогыг тодорхойлох, засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох; боловсон хүчнийг бэлтгэж, төрийн болон бусад байгууллагын албан тушаалуудад ажиллуулах; олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх; нийгмийн гишүүдийн улс төрийн нийгэмшилтэд тус дөхөм болох нэрлэж болохыг дурдсан»⁵⁰ байдаг. Тэд цааш нь намуудад тэдгээр чиг үүргээ бодитой хэрэгжүүлэхийн тулд тодорхой нөхцөл хэрэгтэй байдаг талаар сонирхолтой санааг дэвшүүлсэн байдаг.


Бодлогын намын тухай ойлголт 1950-иад оноос хойшхи үеийн АНУ-ын улс төр судлалаас үүсэлтэй гэж судлаачид үздэг (Downs, 1957; Lipset and Rokkan, 1967). Уг ойлголт нь улс төрийн процессыг иргэд/сонгогчдын болон тэдний хүсэл эрмэлзэл, ашиг сонирхлыг төлөөлөх, биелүүлэх үүрэг бүхий улс төрч/нам хоёрын хоорондын харилцаа холбооны үр дүнд бий болдог аж. Энэхүү “principle-agent” онолын суурь агуулга нь дараах таван зарчмаас бүрддэг байна.



Эх сурвалж: Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал, Я.Төгөлдөр нар. Уб., 2021. 101-102 дахь тал

50 Болдбаатар Ж, Цанжид А. Улс төрийн намаас нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг. Бодрол, бясалгал. 1991 № 8, 35-36 дахь тал

Бодлогын нам иргэдээс дэмжлэг авахын тулд өрсөлдөгч намаас аль болох өөр үзэл санаанд суурилсан бодлогын хувилбарыг дэвшүүлж, үзэл санаагаараа голчлон өрсөлддөг. Бодлого нь ихэнхдээ улс нийтийг хамарсан томоохон зорилттой уялдаатай байдаг бөгөөд сонгуульд тухайн намыг дэмжсэн эсэхээс үл хамаарч бүх нийтэд ашиг тус өгөх зорилттой байх нь элбэг⁵¹. Бодлогын намын шалгуур үзүүлэлтүүдэд⁵² дараах зүйлс багтдаг



Улс төрийн намын санхүүжилтийн асуудал нь тулгамдсан сэдэв мөн. Учир нь энэ асуудлыг зохистой шийдвэрлэх нь улс төрийн төдийгүй эдийн засгийн үлэмжхэн ач холбогдолтой. Өнөө үед эдийн засгийн хямрал доройтлыг засамжлах, нам дахь авлигын сүлжээг саармагжуулах үйл явц намуудын санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэснээс ихээхэн хамаарч байна. Улс төрийн нам өнөөдөр улс орны улс төрийн амьдрал, үйл явцад онцгой үүрэг нөлөөтэй оролцож байгаа нь бодитой зүйл билээ. Тийм болохоор намуудын шинэчлэл, түүнийг тойрсон асуудал үнэхээр анхаарал татаж буй нь зүй ёсны хэрэг.

51 Я.Төгөлдөр нар. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал, ННФ, ШУТИС. Уб., 2021. 101-102 дахь тал

52 Herbert Kitschelt, Steven I. Wilkinson. *Patrons Clients and Policies*. Cambridge University Press. 2007. p.110

Улс төрийн намууд бол төлөөллийн ардчилалд онцгой үүрэгтэй оролцогч институт мөн. Энэ агуулгаараа үзэл суртлын болон төрийн бодлого зохицуулалтын үйл хэрэгт чухал нөлөөтэйн дээр улс төр дэх шударга өрсөлдөөнийг дэмжин тэтгэхэд намуудын үүрэг их юм. Намууд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээн дамжуулах, бас гүйцэтгэгчийн үүргийг өөртөө хүлээдэг. Нэг үгээр хэлбэл засгийн газрын шийдвэр, бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах үр нөлөөтэй суваг, чухал механизм нь улс төрийн намууд байдаг. Улс төрийн намууд өөрт хамаарах үүргээ ардчилсан, үр өгөөжтэй байдлаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн болон бусад бодит эх үүсвэр, эдийн засгийн нөөц хүчтэй байж, түүний дэмжлэгт дулдуйдах нь тэдний оршин тогтнох хийгээд улс төрийн намуудын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангах суурь нөхцөл нь болдог. Чингэхдээ тухайн хуримтлуулсан нөөц боломжийг өөрийн улс төрийн институцийн суурь бүтцийг бэхжүүлэх, иргэдтэй харилцах, тэдний улс төрийн оролцоог дээшлүүлэх, нийгмийг нийгэмшүүлэх үйл хэрэгт зохистой ашиглах, түүний хүртээмж нөлөөг өргөн түвшинд түгээн дэлгэрүүлэх нь намуудын эн тэргүүнд анхаарах зүйл даруй мөн.

Ихэнх ардчилсан орнуудад улс төрийн намууд өөрсдийн санхүүжилтийг хувийн болон төрийн эх үүсвэрээс авч, үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэхдээ дараах хоёр зүйлийн харьцаа тэнцвэрийг хангах тал дээр анхаардаг байна. Тодруулбал Израйлийн улс төрийн намуудын санхүүжилтийн дийлэнх хувь (85 орчим хувь)-ийг улсын буюу төрийн сангаас дэмжлэг авч санхүүждэг бол АНУ-ын улс төрийн намууд их төлөв хувийн секторын эх үүсвэрээс санхүүждэг байна. Хэдий тийм боловч АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын зардал, үйл ажиллагааны эх үүсвэр нь шууд төрийн сангаар дамжин суурь санхүүжилтээ авдагаараа онцлогтой. Энэ бүхэн нь намууд төрийн болон хувийн эх үүсвэрийн санхүүжилтийн харилцан хамаарал, тэнцвэрийг аль болохоор хангахад

анхаардагийг харуулж байна. Намын санхүүжилтийн дээрх хоёр хувилбар нь улс төрийн орчны хамаарал, нөлөө үр дүнг шаардахын хамт түүнд зохион байгуулалтын болон захиргааны нэмэлт тодорхой арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагыг зүй ёсоор нөхцөлдүүлдэг байна.

Зарим тохиолдолд, төрийн болон хувийн эх үүсвэрээс зэрэгцэн санхүүжих хэлбэр нь маргаан, хэлэлцүүлэг дагалдуулдаг хэдий ч түүнийг Үндсэн хуулиар баталгаажуулан зөвшөөрдөг тул бэрхшээл төдийлөн үүсдэггүй байна. АНУ-д улс төрийн намуудын хувиараа хандивлагчид нь тус орны Үндсэн хуулиар хамгаалагдаж байдаг төдийгүй тэдэнд олгогдсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх суурь эрх чөлөө нь мөн давхар нээлттэйгээр хэрэгжиж байдаг.

Намын санхүүжилтийг алив улс төрийн намын оршихуйн суурь нөхцөл гэж үздэг. Нам санхүүжилтийн асуудлаа зүй зохистой шийдвэрлэсэн байдлаас хамаарч улс орны улс төрийн амьдрал, тогтолцоо, улмаар эдийн засгийн өнөөгийн байдал төлөв тогтворжин зүгшрэх учиртай. Өдгөө намын санхүүжилтийг үр нөлөөтэй, зохистой шийдвэрлэх ямар хувилбар, боломж, механизм, гарц шийдэл байж болох вэ? гэдэг дээр улс төрчид, судлаачид ухаанаа уралдуулж, санал бодлоо идэвхтэй солилцсоор байдаг.

6. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чиг үүрэг, хэтийн хандлага

Олон орны улс төрчид, шинжээчид санал асуулгад найдах явдал үлэмж нэмэгдэхийн хирээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч энэхүү санал асуулгын талаар тогтмол мэдээлдэг болсон. Энэ нь улс төрийн оролцоог бодитоор төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй. Социологичдын үздэгээр «Шөл болгонд давс хэрэгтэйг мэдэхийн тулд амтлах шаардлагагүйтэй адил олон нийтийн санал бодлыг мэдэхийн тулд хүн бүрээс санал асуулга явуулах» шаардлагагүй. Тиймээс үнэн зөв тусгасан түүврийн аргаар нийт ард иргэдийн санаа бодлыг тандан судлах нь өнөө

цагийн чухал үнэлгээний хэлбэр юм. Мэдээж хэрэг, олон нийтийн санаа бодолд олон хүчин зүйл нөлөөлдөг нь илт. Тухайлбал, улс төрчид, өндөр албан тушаалтнууд олон нийтийн дэмжлэгийг авахын тулд идэвхтэй сурталчилгаа явуулахыг эрмэлздэг. Тэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, радио, сонин сэтгүүлээр ярилцлага өгч, жагсаал цуглаан зохион байгуулж, үг хэлж аль болохоор сонгогчдыг сонсохыг хичээдэг. Энэ нь тэдний хувьд улс төрчийн үүднээс таалагдах, өөрийгөө таниулахыг зорьдог нэг ёсны харилцамжийн хэлбэр гэж болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн бүхий л томоохон үйл явдлуудыг өргөнөөр мэдээлэхийг хичээдэг. Үнэхээр ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн аливаа эерэг, сөрөг үйл явдлуудыг түргэн шуурхай, үнэн зөв мэдээлэх нь чухал авч үүнийг баталгаатай эх сурвалжаас дамжуулахыг чухалчлах ёстой. Учир нь хүмүүсийн дийлэнх нь улс төрийн мэдээллээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олж авдаг учраас түүний үзүүлэх үр нөлөө асар их.

Улс орны нийгэм, эдийн засгийн статус нь хүмүүст харилцан адилгүй байдлаар нөлөөлдөг. Жишээлбэл, баян хүмүүс татварын бууралтаас илүү их ашиг хүртэх тул хөрөнгийн ашгийн татварыг бууруулах төсвийг ядуу хүмүүсээс илүү их дэмждэг.

Улс төр судлаачидын хувьд аливаа асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх замаар бусдын үзэл бодолд нөлөөлөхийг чухалчилдаг учраас улс төрд анхаарлаа илүү хандуулдаг. Энэ бол улс төрийн соёл ардчиллын соёлоор илэрдэг болохын бодит нотолгоо юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухайд: Ихэнх улс төрийн намуудын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагуудад зарцуулах хөрөнгө зардал ихээхэн чухал байр эзэлдэг. Тухайлбал, Сонгуулийн компанийн үеэр хэвлэл мэдээлэлд намын нийт санхүүжилтийн 40-70 орчим хувийг зарцуулдаг бөгөөд энэ нь улс төрийн намуудын санхүүжилтийн

тогтолцоонд тодорхой жин дарж, намуудын мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлах, үйл хэрэгт нь зарцуулагддаг байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх мэдээллийн цаг нь хоёр үндсэн аргаар хангагдана. Энэ нь засгийн газраас тодорхой тогтсон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг санхүүжүүлэх, эсхүл засгийн газрын зүгээс өөрийн зөвшөөрөлтэй мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэнцвэртэй мэдээллийг олон нийтэд давтамжтай байдлаар цацах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн хувийн болон төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл дамжуулах боломж орчинг тэнцвэртэй бүрдүүлэхийг чухалчилдаг. Ихэнх оронд олон нийтийн телевиз, радио байдаг бөгөөд тэдгээр нь парламентийн болон сонгуулийн улс төрийн үйл ажиллагаанд оролцоход нь улс төрийн намуудад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Германд энэ үүргийг хэрхэн ханган биелүүлж буйг тус улсын Үндсэн хуулийн шүүхээс өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу олон нийтийн болон хувийн салбарын хэвлэл мэдээлийн хэрэгслээр тэнцвэртэй дамжуулахыг шаарддаг. Гэхдээ улс төрийн намуудын зүгээс энэ чиглэлээр нарийн тогтсон стандарт, мөрдөх журам төдийлэн байхгүй ч, АНУ зэрэг зарим улсад төрийн болон хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн намууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд түгээхэд арилжааны хамгийн доод үнийг санал болгодог.

Канадад чөлөөт, хувийн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрийн үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн цагийг дамжуулах нарийн тогтсон нөхцөл байдал байдаггүй ч тухайн мэдээллийг дамжуулахдаа аль нэг талыг баримталсан байдлаас аль болох зайлсхийх, тэнцвэртэй байр суурийг ханган ажиллахыг шаарддаг. Зарим орнуудад улс төрийн намуудад мэдээллийн цагийг олгоходоо тодорхой хязгаартайгаар олгодог. Түүнчлэн Энэтхэг, Израйль зэрэг улсад улс төрийн намууд сонгуулийн кампанийн үеэр төлбөртэй сурталчилгаа, нэвтрүүлэг явуулахыг хатуу хориглодог. Австрали, Канад, Шинэ Зеланд, Швед, АНУ-д

зар сурталчилгаанд төлбөр төлөхийг зөвшөөрдөг. Канадад сонгууль болохоос өмнөх 48 цагийн дотор сурталчилгаа явуулахыг хориглоно.

Солонгост улс төрийн намуудад төлбөртэй нэвтрүүлэг, сурталчилгаа явуулахыг зөвшөөрдөггүй ч харин нэр дэвшигчдэд зөвшөөрдөг. Хэрэв тухайн улс төрийн намууд, нэр дэвшигчдийн зүгээс өөрсдийн үйл ажиллагааны талаар бэлтгэсэн нэвтрүүлгийг өөрсдөө хийсэн бол түүнийг олон нийтэд түгээх, өргөн нэвтрүүлгээр цацах тохиолдолд эхлээд хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллагуудаас тухайн нэвтрүүлгийг хянан үзэж, тодорхой шалгуураар хяналт тавсаны дараа уг мэдээллийг олон нийтэд цацдаг байна. Австрали, Канад, Солонгос, Шинэ Зеланд, АНУ зэрэг улс орнууд үүнтэй нэгэн адил тодорхой дагаж мөрдөх зохицуулалттай⁵³.

Иргэдийг мэдээлэлээр хангах, мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг бодитой хангахын тулд мэдээлэл үнэн зөв, хүртээмжтэй бодитой байхын хэрээр иргэдийн оролцооны үр дүн бодитой бөгөөд зохистой, сайн байх учиртай. Оролцогчид тодорхой төсөв төлөвлөгөө болон шийдвэрийн талаар үнэн зөв өргөн мэдээлэлтэй байх, төрийн зүгээс мэдээллийг олон нийтэд богино хугацаанд шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг бүрэн хангах, иргэдийн хүссэн мэдээллээ хайх, олж авах боломж бололцоо нөхцөл бүрэн хангагдсан байх шаардлагатай байгаа юм. Учир нь мэдээлэл иргэдийг идэвхжүүлж, асуудлын учир начирыг эргэцүүлэх, оролцооны учир холбогдыг ойлгох, өөрсдийн иргэний эрх, эрх ашгаа хамгаалах, үүргээ ухамсарлах, оролцоонд өдөөх хүчтэй хэрэгсэл, механизм болдог. Иймд иргэдийг мэдээллээр хангахад чиглэгдсэн төрийн бодлого, зохицуулалт, санаачлага, үйл ажиллагааны хэлбэр механизм хүчтэй бөгөөд олон талтай байх нь нэн чухал асуудал болон тавагдаж буй юм.

53 Улс төрийн намуудын санхүүжилт: харьцуулсан судалгааны тойм. Орч. Хатанболд О. *Философи, эрхийн судлал-XXXI. Философийн хүрээлэн. ШУА. Уб., 354-362 дахь тал*

Дүгнэлт

Нийгмийн амьдралын төвшинд нийгмийн бүлгүүдийн ялгаатай, зарим талаараа зөрчилтэй ашиг сонирхол нь хөдөлгөгч хүчин зүйл болох боломжтой. Тодруулбал, нийгэм-эдийн засаг, социал, улс төрийн цогцоор илэрхийлэгдэх нийгмийн бүлгүүдийн олон үзүүрт ашиг сонирхолд тулгуурлан улс төрийн үзэл баримтлалууд бий болдог. Харин иргэний нийгэм болоод нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог идэвхтэй татан оролцуулах нь нэн чухал. Ингэснээр иргэдийн санаачилгыг өрнүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх⁵⁴ эрх зүйн оновчтой зохицуулалт, дэмжлэгээр ханган, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө идэвхийлэн оролцож ардчилал, ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэхэд чухал манлайлал болж чадна.

Улс төр, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцуулах идэвх сонирхолыг нь өдөөхөд чиглэгдсэн төрийн бодлого-зохицуулалтын дорвитой механизм төдийлөн үйлчилж чадахгүй байдаг нь олон түмний улс төрийн оролцооны ерөнхий идэвхжүүлэлтийн үйл явцад таатай нөлөө үзүүлж чадахгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй. Иргэдийн дунд улс төрд оролцох оролцооны хэлбэрийг дан ганц сонгуульд оролцох оролцоо гэж төсөөлөн ойлгох хандлага байсаар байгаа юм. Сонгуульд оролцох оролцоо нь тэдний улс төрийн оролцооны зөвхөн нэг гол хэлбэр төдийгүй иргэдийн Үндсэн хуулиар хүлээсэн үндсэн эрх, үүрэг нь болох тодорхой. Гэвч манайд иргэдийн сонгуулийн оролцоо харьцангуй буурч байгаа баримтыг судлаачид гаргаж тавьж байгаа нь анхаарал татаж байна.*

Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо нь манай ардчиллын хөгжлийн шинж байдал түүний өөрчлөлт хувиралтай холбогдох нарийн үе шат бүхий төвөгтэй үйл явц юм.

54 Хатанболд О, Энхболд Д. Ардчилсан нийгэм дэх ард түмний оролцоо, хандлага. ЭШ-ний хурлын илтгэлийн эмхтгэл. ФСЭХ. Уб., 2013. 18 дахь тал

9. David E. Apter. The Politics of Modernization. Chicago-London. 1967
10. МУИС. Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг. I хэвлэл. Ерөнхий ред. Төртогтох Ж, Мөнхбат С. Хэвлэлийн ред. Ууганбаяр С, Дөлгөөн Б, ба бусад. «Адмон принт» ХХК. Уб., 2020
11. Цанжид А. Улс төрийн шинжлэх ухаан. Уб., 2001
12. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. ННФ. Уб., 2006
13. Энхболд Д. Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлохуй. Шинжээчдийн судалгааны тайлан. Ред. Хатанболд О. ШУА. Философийн хүрээлэн. Уб., 2019
14. Даль А.Роберт. Ардчиллын тухай. орч. Ганхуяг Д. Уб., 2004
15. Ганбат Д. Ардчиллагдах үйл явц ба монголчуудын үнэлэмж. Хүний эрхийг хангаж ардчилсан засаглалыг бэхжүүлэх Мянганы хөгжлийн зорилго. Үндэсний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. Уб., 2008
16. Inglehart R, Christian W. Modernization, Cultural Change and Democracy: The Human Development Sequence. New York.: Cambridge University Press, 2005
17. Чулуунбаатар Г. XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. ФСЭХ. Уб, 1999
18. Баяр Н. Төлөвлөгөөнөөс бүлэг рүү: нийгмийн сүлжээ ба иргэний нийгэм. Философи эрх зүйн судлал-XXV. ФСЭХ. Уб, 2010
19. Putnam R. Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy. Princeton University Press. NY, 1993
20. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. Үндэсний өвөрмөц соёлын орчин дахь ардчиллын зарчмын үйлчлэл. Эрдэм шинжилгээний грант төслийн тайлан. Уб., 2008.
21. Хаек А. Ф. Фридрих. Боолчлогдох замд. орч. Чойжил П. «Монсудар» ХХК. Уб., 2005
22. Hague R. Breslin S. Political Science: A Comparatvie Introduction. NY., 1992

- төлөвших үйл явцын онцлог. Эрдмийн бүтээлийн эмхэтгэл-I. «Соёмбо принтинг» ХХК. Уб, 2019
36. ФСЭХ, ШУА. Монголын ардчиллын төлөвшил. Хамтын бүтээл. Уб., 2011
 37. Coleman, James S. The Foundations of Social Theory. Belknap of Harvard UP. Cambridge, MA, 1990
 38. Конрад Аденауэр сан. Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь. ред. Батсүх Ш, Бурмаа Н, Долгоржав Я. Уб., 2022
 39. Динелло Н. Кеннан. Төлөвлөгөөнөөс бүлэг рүү: нийгмийн сүлжээ ба иргэний нийгэм. Орч. Баяр Н. ФСЭХ, ШУА. Философи, эрх зүйн судлал-XXV. Уб., 2010//[http://ru.wikipedia.org/wiki/социальная_сеть_\(социология\)](http://ru.wikipedia.org/wiki/социальная_сеть_(социология)).
 40. Putnam R, Leonard R, & Nanetti R. Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy. Princeton, NY: Princeton University Press, 1993
 41. John J.Harrigan. Politics and the American Future. Hamline University Press, 1990.
 42. Мөн тэнд.
 43. Төрийн бус байгууллагын тухай хууль. 1 зүйлийн 5. Уб., 1997
 44. Richard S.Katz., Peter Mair (1995). //Changing Modes of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party, in Party Politics, 1, (1995) Katz, R.A. Theory of Parties and Electoral Systems, Baltimore: Johns Hopkins University Press. 198Eldersveld. S. Political Parties in American Society. NY, 1982
 45. Ковлер А.И. “Кризис демократии? (Демократия на рубеже XXI века) М., 1997
 46. Төгөлдөр Я, Одмаа Б, Мягмарсүрэн Д, ба бусад. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал. Санал, зөвлөмж. ННФ. ШУТИС. Уб., 202
 47. Richard Gunther and Larry Diamond, “Types and Functions of Parties,” in Larry Diamond and Richard Gunther, eds., Political Parties and Democracy (Baltimore:Johns Hopkins University Press, 2001).

48. Болдбаатар Ж, Цанжид А. Улс төрийн намаас нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг. Бодрол, бясалгал. 1991 № 8,
49. Төгөлдөр Я нар. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал, ННФ, ШУТИС. Уб., 2021.
50. Herbert Kitschelt, Steven I.Wilkinson. Patrons Clients and Policies. Cambridge University Press. 2007
51. Улс төрийн намуудын санхүүжилт: харьцуулсан судалгааны тойм. Орч. Хатанболд О. Философи, эрхийн судлал-XXXI. Философийн хүрээлэн. ШУА. Уб., 2014
52. Хатанболд О, Энхболд Д. Ардчилсан нийгэм дэх ард түмний оролцоо, хандлага. ЭШ-ний хурлын илтгэлийн эмхтгэл. ФСЭХ. Уб., 2013.
53. Цэцэнбилэг Ц. Монголын иргэдийн оролцоо, түүний эрх зүйн орчинг шинжлэхүй. Философи, эрхийн судлал-XXIX. Уб., 2014

4

Дөрөвдүгээр бүлэг. Нийгмийн хамгааллын улсын тухай үзэл баримтлал

Доктор Б.Батхишиг

Монгол орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт 1990 оноос шилжиж эхэлсэн. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бол хувийн өмчгүй, зөвхөн нийгмийн өмчид тулгуурласан, бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг улсын нэгдсэн төлөвлөгөөгөөр тогтоодог тогтолцоо юм. Энд бүх барааны үнэ ба ажиллагчдын цалин хөлсний хэмжээг улсаас тогтоодог, гадаад худалдааг зөвхөн улсын байгууллага хийдэг. Эдийн засгийн энэ тогтолцоо хязгаарлагдмал болох нь нотлогдсон тул зах зээлийн эдийн засагт шилжих зорилт дэвшүүлж хэрэгжүүлжээ. 1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”¹ гэж заасан билээ.

Зах зээлийн эдийн засаг бол хувийн өмчид голлон суурилсан, төрийн өмч, нийтийн өмч зэрэг өмчийн бусад хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг, бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нь эрэлт, нийлүүлэлтийн хуулиар зохицуулагддаг, гадаад худалдааг үйлдвэр, аж ахуйн нэгж, хувь хүмүүс эрхлэх эрх чөлөөтэй эдийн засгийн тогтолцоо юм. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг төрөөс анхаарч шийдвэрлэх шаардлагатай болдог.

1 Монгол Улсын Үндсэн хууль, 1992, 5 дугаар зүйл, www.legalinfo.mn

1. Нийгмийн хамгаалын улсын тухай ойлголт

Нийгмийн хамгааллын улс /Welfare State/ хэмээх үзэл баримтлал 19 дүгээр зууны сүүлээр үүсэж, 20 дугаар зуунд үлэмж хөгжжээ. Энэ нь өндөр насны тэтгэвэр, ажилгүйдлийн тэтгэмж, эрүүл мэндийн тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж зэрэг хүн амын нийгмийн хамгаалал, нийгмийн тусламжийн асуудлыг төр тодорхой хэмжээгээр шийдвэрлэх ёстой гэсэн үзэл баримтлал юм. Уг үзэл баримтлал хүн амыг адил тэгш нөхцөл боломжоор хангах, баялгийг тэгш хуваарилах, амьжиргааны доод түвшинг хангаж чадахгүй хүмүүст улс туслах үүрэгтэй гэсэн зарчмуудад үндэслэгдэнэ.

Герман улсад 1883 онд эрүүл мэндийн даатгал, 1884 онд осол аюулын даатгал, 1889 онд өндөр насны тэтгэвэр, 1927 онд ажилгүйдлийн даатгалын тухай хууль тогтоомж батлагдаж, хүн амын нийгмийн хамгаалын тогтолцоо бүрэлдэж эхэлжээ. Германы энэхүү бодлого хөрш Франц зэрэг бусад улсад нөлөөлж, нийгмийн хамгааллын зарим арга хэмжээ авахад хүргэсэн байна. Харин нийгмийн хамгааллын улс /Welfare State/ гэсэн нэр томъёог Английн сүмийн хамба лам Виллиам Темпле өөрийн бичсэн номондоо анх хэрэглэжээ.

Нийгмийн хамгааллын тогтолцоо дэлхийн II дайны дараа улс орнуудад ихээхэн дэлгэрч, янз бүрийн хэлбэр болон хүрээгээр хөгжсөн байна. Хөгжлийн онцлогоос нь хамаарч нийгмийн хамгааллын улсын харилцан адилгүй загварууд бий болсныг эрдэмтэн судлаачид тогтоожээ. Тухайлбал, Дани улсын социологич Г.Еспинг-Андерсен нийгмийн хамгааллын улсын гурван гол загварыг онцлон авч үзсэн байна². Үүнд, нэгд, **консерватив** загвар нь нийгмийн хамгааллын үйлчилгээг зах зээлийн болон хувийн салбараар биш, харин улсаас нэгдсэн журмаар үзүүлдэг хэлбэрийг хэлэх бөгөөд Герман улс уг загварт хамаарах ажээ. Хоёрт, **социал-демократ** загвар нь хүмүүсийн орлогын түвшинг харгалзахгүйгээр нийтийг хамарсан нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх бөгөөд хүн бүр нийгмийн хамгааллын

2 Welfare State, www.sciencedirect.com

тогтолцооны үр шимийг адил тэгш хүртэх ёстой гэж үздэг. Энэ загвар Швед, Норвег, Финлянд, Дани зэрэг Скандинавын орнуудад хөгжсөн бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд орлого дахин хуваарилалтын систем буюу өндөр татварын систем гол үүрэгтэй ажээ.

Гуравт, нийгмийн хамгааллын улсын **либерал** загвар бий бөгөөд энэ нь нийгмийн хамгааллын үйлчилгээг зах зээлийн гол зарчим болон хөдөлмөрийн оролцоотой холбон үздэг. Тухайлбал, өндөр насны тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал зэрэг нь хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хамаарна. Энэ загварыг АНУ голлон ашигладаг. АНУ-д нийгмийн хамгааллын улсын, холбооны нэгдсэн болон холбооны улс тус бүрийн, мөн буяны байгууллагын, ажил олгогчийн ба хувийн зэрэг янз бүрийн хэлбэр байдаг. Гэхдээ тус улс дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 16 хувийг эрүүл мэндийн салбарт зориулдаг байна.

Нийгмийн хамгааллын улсын эдгээр загвар нь тэдгээрийн түүхэн хөгжил, шашин шүтлэг, уламжлалтай холбоотой. Жишээ нь, каталог шашинтай Испани, Итали, Франц зэрэг улсад нийгмийн хамгааллын тогтолцоо хожуу үүсч хөгжсөн. Учир нь уг шашны ёсоор нийгмийн хамгааллын асуудлыг буяны үйлс гэж үзэж иржээ. Харин Лутеран шашин ажил хувь ерөөл, ногдсон үүрэг гэж үздэг учир ядуурлыг хүний залхуу лазан зан чанарын үр нөлөө хэмээн үздэг. Ийм шашинтай Дани, Швед, Герман улсад нийгмийн хамгааллын тогтолцоо эрт үүсч хөгжсөн бөгөөд нийтийг хамарсан шинжтэй юм.

Шинэчлэгдсэн протестант шашин ядуу хүмүүс бол бурхнаас гэсгээгдсэн хүмүүс гэж үздэг бөгөөд ийм ч учир гуйлга гуйх, нийгмээс туслалцаа үзүүлэх явдал бараг байгаагүй. Харин сүм хийд ядууст туслах ажлыг хийж иржээ. АНУ-д нийгмийн хамгааллын үйлчилгээ бүүр хожуу буюу 1930-аад оноос хязгаарлагдмал байдлаар үүссэн бөгөөд нийгмийн хамгааллын улсын нэгдсэн систем хөгжөөгүй нь протестант шашны уламжлалтай холбоотой³.

3 *Государство всеобщего благоденствия, www.bigens.ru*

Нийгмийн хамгааллын улсын дээрх гурван загвараас өөр нэг загвар бол социалист загвар юм. 1945-1990 онд 15 улсыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн социалист систем гэж байсан бөгөөд тэдгээр улс үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх нийгмийн өмчийн хэлбэрт тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, нэг нам бүхий улс төрийн тогтолцоотой байв. Эдгээр улсад их сургууль хүртэлх бүх шатны сургуулийн сургалт, эмнэлгийн үйлчилгээ үнэ төлбөргүй байсан, мөн тэтгэвэр, тэтгэмжийн нэгдсэн систем үйлчилж байв. Харин 1990 онд социалист гэгдэж байсан ихэнх орон, түүний дотор Монгол Улс хуучин социалист системээс татгалзаж, ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн билээ.

Нийгмийн хамгааллын улсын нийгмийн хамгааллын тогтолцоог бүх нийтийг хамарсан ба зорилтот бүлэгт хаягласан гэсэн хоёр хэлбэрт хувааж үзнэ. Зарим улс нийгмийн хамгааллын тогтолцоонд нийт хүн амыг адил тэгш хамруулах ёстой гэж үздэг бол өөр олон улс нийгмийн хамгаалал зайлшгүй шаардлагатай хүн амын тэр хэсэгт хүртээх хэрэгтэй хэмээдэг. Сүүлийн үед зорилтот бүлэгт хаяглан хүртээх хандлага давамгайлах болж байна. Бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоо нь асар их хэмжээний хөрөнгө мөнгө шаардах бөгөөд үүнийг бүрдүүлэхийн тулд татварын хэмжээг өсгөхөөс өөр аргагүй. Иймд социал-демократ загвартай Скандинавын орнууд хүртэл нийгмийн хамгааллын тогтолцоогоо эргэн харж шинэчлэх, татварын төрөл болон хэмжээг багасгах болжээ. Тухайлбал, Швед улс 1990-1991 онд татварын шинэчлэл хийж, баялгийн татвар, өвлөж авсан хөрөнгийн болон бэлгийн татвар зэргийг 2004-2006 онд цуцалжээ.

Нийгмийн хамгааллын улсын нийгмийн хамгааллын тогтолцооны хөгжлийг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх нийгмийн хамгааллын зардлын хувь хэмжээгээр тодорхойлох болжээ. 2020 оны байдлаар Европын улсуудад энэ үзүүлэлтийн хамгийн бага нь Ирландад 13.4%, хамгийн их нь Францад 31% байв⁴.

4 Welfare State, The Free Encyclopedia Wikipedia

2. Либерализмын тухай үндсэн ойлголт (*Basic consideration of Liberalism*)

Улс төрийн үзэл суртлын янз бүрийн хэв шинжүүд бий. Тухайлбал, консерватизм, либерализм, социал-демократ үзэл, социализм, коммунизм, национализм, радикализм гэх мэт. Эдгээрээс либерализмын үзэл суртлыг авч үзье. Либерализм бол хувь хүний эрх, эрх чөлөөг хангахын төлөө тэмцэх хэрэгтэй гэсэн улс төрийн үзэл суртал юм. Өргөн утгаар нь авч үзвэл энэ нь хувийн өмч, зах зээлийн эдийн засаг, либерал ардчилал, хувь хүний эрх чөлөө, хүний эрх, хуулийн засаглал, эдийн засгийн ба улс төрийн эрх чөлөө, хэвлэлийн болон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, шашин шүтэх эрх чөлөө зэргийг дэмждэг.

Либерализм нь хэмжээгүй эрхт хаант засаглал, үе дамжин онцгой эрх эдлэх ёсыг халах, худалдааны хориг саадыг арилгах, худалдаан дахь хаадын гэр бүлийн монополийг устгах зэрэг үзлийг дэвшүүлэн анх гарч ирсэн. Соён гэгээрүүлэлтийн үеийн Английн философич Жон Локк либерализмын үзэл санааг анх дэвшүүлэн тавьжээ. Хүн бүр амьдрах, эрх чөлөөтэй байх, өмчтэй байх байгалиас заяасан эрхтэй, ямар ч засгийн газар эдгээр эрхийг хааж боож болохгүй гэж тэрбээр үзэж байв⁵. 1988 оны Британий хувьсгал, 1776 оны Америкийн хувьсгал, 1789 оны Францын хувьсгал бүгд либерал үзлийг гол уриагаа болгож ардчилал, эрх чөлөөний төлөө тэмцсэн билээ.

Либерализм хэмээх үг нь латины liber буюу чөлөөт гэсэн үгнээс гаралтай. Хэдийгээр либерализмыг янз бүрээр тайлбарладаг ч гэсэн энэ нь хэд хэдэн үндсэн үзэл баримтлалд тулгуурладаг. Үүнд:

- хувь хүний эрх чөлөө ба тэгш эрхийг хамгаалах;
- хувийн өмч ба хувь хүний эрхийг дэмжих;
- хязгаарлагдмал эрхтэй, үндсэн хуульт засгийн газрыг хүлээн зөвшөөрөх;
- олон ургальч үзэл, хүлээцтэй, тэвчээртэй байх, өөртөө засах ёс зэрэг үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх.

5 *Liberalism, The Free Encyclopedia Wikipedia*

Харин консерватизм бол нийгмийн амьдралын уламжлалт хэвшлийг хамгаалдаг үзэл суртал юм. Консерватизмын гол төлөөлөгчид тухайн улсын нийгмийн байгуулал, бүтцийг бэхжүүлэх нь чухал гэж үзэж, түүнийг шинэчлэх аливаа оролдлогыг эсэргүүцдэг.

Либерализмыг улс төрийн либерализм, **эдийн засгийн либерализм** гэх мэтээр ялган үздэг. Бид энд эдийн засгийн либерализмыг илүү тодорхой авч үзье. Эдийн засгийн либерализмыг үндэслэгч нь сонгодог улс төрийн эдийн засгийн ухааны гол төлөөлөгч, Шотландын философич, эдийн засагч Адам Смит юм. Тэрбээр 1776 онд хэвлүүлсэн “Улс үндэстний баялгийн мөн чанар, учир шалтгааныг шинжлэхүй” хэмээх алдарт бүтээлдээ зах зээлийн эдийн засгийн үндсэн хууль, зарчмуудыг нээн тодорхойлсон. Тэрбээр уг бүтээлийнхээ IV ботид бичихдээ “Аль ч нийгмийн жилийн бүтээгдэхүүн түүний хөдөлмөрийн жилийн нийт бүтээгдэхүүний арилжааны өртөгтэй яг тэнцэнэ. Аливаа хүн өөрийн капиталаа аль болохоор эх орны аж үйлдвэрийг дэмжихэд зарцуулах, бүтээгдэхүүн нь хамгийн их өртөгтэй байхаар түүнийг чиглүүлэхийг хичээдэг. Энэ нь нийгмийн жилийн бүтээгдэхүүн хамгийн их байхад зайлшгүй хүргэдэг. Тэрбээр нийгмийн ашиг тусын тулд үйлчилнэ гэж боддоггүй, түүнд ямар дэм үзүүлж байгаагаа ухамсарладаггүй. Гадаадын биш дотоодын үйлдвэрлэлийг дэмжихийг илүүд үзэхдээ тэрээр өөрийн хувийн аюулгүй байдлаа л бодно. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг хамгийн их байхаар үйлдвэрлэлийг явуулахдаа өөрийн ашгийг л тооцно, гэхдээ энэ болон бусад тохиолдолд үл үзэгдэх гар түүнийг ерөөсөө санаанд нь байгаагүй зорилго руу хөтөлнө. Гэхдээ уг зорилго түүний санаанд байгаагүйгээс болж нийгэмд алдах юм байхгүй. Тэрээр өөрийн хувийн сонирхлоо хөөхдөө нийгмийн сонирхолд ухамсартайгаар хүссэнээсээ илүү үр дүнтэй үйлчилдэг.”⁶ гэжээ.

А.Смит ийнхүү зах зээлийн эдийн засгийн харилцаа нь хүмүүсийн хүсэл зоригоос хамаарахгүй, харин бодит

6 Adam Smith, *An inquiry into Nature and Causes of the Wealth of Nations*, MetaLbri, 2007, Book IV, p.349

хуулиудаар зохицуулагддаг болохыг нээсэн юм. Иймд төр засаг бараа, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт, үнэ, зах зээлийн чөлөөт өрсөлдөөн зэрэгт хөндлөнгөөс оролцох хэрэггүй юм гэж үзэж байв. Төр засаг зөвхөн улсыг батлан хамгаалах, төрийн ажлыг зохион байгуулах, хууль, шүүхийн байгууллагын ажлыг эрхлэн явуулахаар үйл ажиллагаагаа хязгаарлах ёстой гэжээ.

Зах зээлийн харилцааны хөгжилд хувь хүний эрх чөлөө, аминч үзэл нэн чухал гэдгийг мөн онцолсон. Тухайлбал, хувийн сонирхол ба нийгмийн сонирхол бол мөнхийн сэдэв бөгөөд тэдгээрийг хооронд нь яаж уялдуулах вэ гэдэг асуудал олон зууны турш эрдэмтэн мэргэд, улс төрийн зүтгэлтнүүдийн бодол санааг чилээж иржээ. Харин эсрэг тэсрэг энэ хоёр сонирхлын хоорондын зөрчлийг шийдвэрлэх асуудлыг А.Смит дараах байдлаар хөнджээ. Аливаа хүнд ойр тойрныхны тус дэм зайлшгүй хэрэгтэй. Гэхдээ тэр бүр гуйж гувшаад бүтэхгүй. Харин тэдний аминч үзлийг хөндөх нь чухал. “Надад хэрэгтэй байгаа юмыг өг, оронд нь чамд хэрэгтэй юмыг өгье” гэх саналыг тавих хэрэгтэй⁷. Тэгвэл бие биендээ хэрэгтэй байгаа бараа, үйлчилгээний ихэнхийг бие биенээсээ олж авч болно гэжээ.

А.Смит гадаад худалдааг либералчлах буюу чөлөөтэй болгох нь эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болохыг тодорхойлсон. Тэрбээр энэ тухай бичихдээ “Зарим бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх талаар зарим орон үнэхээр байгалаасаа давуу талтай байдаг. Шотландад хүлэмж бариад сайн чанарын усан үзэм тариалж, түүгээр мөн сайн дарс хийж болно. Гэвч энэ нь гадаадаас авчирч болох мөн тийм чанарын дарснаас 30 дахин үнэтэй байх болно. Шотландад дарс хийхийн тулд гадаадын дарс оруулахыг хориглох нь ухаалаг явдал уу?”⁸ гэжээ.

Гадаад худалдааг либералчлахын эсрэг бодлогыг протекционизм гэнэ. Гаалийн тариф, квот болон

7 *Adam Smith, An inquiry into Nature and Causes of the Wealth of Nations, MetaLbri, 2007, Book I, p.16*

8 *Adam Smith, An inquiry into Nature and Causes of the Wealth of Nations, MetaLbri, 2007, Book IV, p.350-351*

тарифын бус янз бүрийн аргаар дотоодын зах зээлийг гадаадын импортоос хамгаалах бодлого, үйл ажиллагааг протекционизм гэнэ. Энэ нь английн protection /хамгаалалт, ивээл/ гэсэн үгнээс гаралтай.

А.Смитийн эдийн засгийн либерализмыг Английн эдийн засагч Д.Рикардо, Ж.Милль, Францын эдийн засагч Ж-Б. Сей нарын онолчид улам хөгжүүлсэн юм. Тухайлбал, Ж-Б. Сей зах зээлийн нөхцөлд илүүдэл үйлдвэрлэл байх ёсгүй, учир нь нийлүүлэлт нь өөрийн эрэлтийг бий болгодог, өөрөөр хэлбэл, зах зээлийн эдийн засаг өөрөө өөрийгөө зохицуулдаг гэж үзэж байв. Түүний тодорхойлсон энэ зүй тогтлыг зах зээлийн тухай Сейгийн хууль гэнэ.

Харин 1930-аад оны үед **неолиберализм** буюу шинэ либерализмын урсгал гарч ирсэн бөгөөд 1980-1990-ээд онд энэ нь эдийн засгийн нэг үзэл суртал болон хөгжжээ. Сонгодог либерализм эдийн засаг дахь төрийн оролцоог үгүйсгэдэг бол неолиберализм хүлээн зөвшөөрдөг, гэхдээ энэ нь чөлөөт зах зээлийн зарчим, өрсөлдөөнийг дэмжихэд чиглэгдэх ёстой хэмээн үздэг⁹. Эдийн засгийн хөгжил, дэвшилд хүрэх гол арга зам бол чөлөөт зах зээл, чөлөөт өрсөлдөөн бөгөөд үүний үр дүнд эдийн засгийг өсгөж, нийгмийн шударга байдлыг хангаж болно.

Неолиберализмын нэг урсгал болох монетаризмын гол төлөөлөгч нь АНУ-ын эдийн засагч М.Фридман бөгөөд тэрбээр мөнгөний тооны онолыг хөгжүүлж, мөнгөний нийлүүлэлтийг тодорхой хэмжээнд хянаж байх, тэгэхдээ түүнийг ДНБ-ний өсөлтийг ямар хэмжээнд хангахаас хамааран зохицуулж болохыг тодорхойлсон. Ийм аргаар инфляцийг бас хянаж болно гэж тэрээр үзэж байв.

Австрийн эдийн засагч Фридрих Хаейк социализмын төлөвлөгөөт эдийн засгийг шүүмжилж, зөвхөн нээлттэй, зах зээлийн эдийн засаг хувь хүний идэвх санаачлагыг дэмжиж, ажил эрхлэх, хөрөнгө хуримтлуулах эрх чөлөөг нээдэг гэж бичиж байв.

⁹ Neoliberalism, www.investopedia.com

Неолиберализм нь 20 дугаар зууны дунд үед үүссэн социаль либерализмын эсрэг үзэл баримтлал болон өргөжсөн. Социаль либерализм нь зах зээлийн өрсөлдөөнийг төрийн зохицуулалт болон нийгмийн хамгааллын системтэй хослуулах боломжтой гэж үздэг. Хувь хүн өөрийгөө хөгжүүлэх, өөрийгөө тодорхойлох эрхийг хангах нь либерализмын гол зарчим. Гэхдээ энэ эрхээ хэрэгжүүлэхэд дан ганц хувь хүний хичээл зүтгэл хангалтгүй.

Ялангуяа хүн бүрт хөгжиж боловсрох гарааны адил тэгш нөхцөл боломжийг хангах явдал төр засгийн оролцоогүйгээр бүтэхгүй юм. Төр засаг нийгмийн нийт бүтээгдэхүүнийг дахин хуваарилах замаар түүний нэг хэсгийг нийгмийн эмзэг бүлгийнхэнд хүртээх, тэдний нийгмийн хамгааллыг бэхжүүлэх үүрэгтэй бөгөөд үүний үр дүнд нийгэм, улс төрийн тогтвортой байдал, шударга ёс хангагдана. Нийгмийн ядуу хэсгийн амьдралын нөхцөлийг сайжруулах нь дотоодын зах зээлийг өргөтгөж, эдийн засгийн өсөлтийг хурдасгана. Ингэснээр чөлөөт зах зээл үеийн капитализмын зөрчлийг шийдвэрлэж, нийгмийн хандлагатай эдийн засаг бүхий капитализмыг бүрдүүлнэ гэж социаль либерализм үздэг байна.

Хүн амын боловсрол, эрүүл мэндийн салбарт аль болох адил тэгш нөхцөл бүрдүүлэх, ахмад настнуудын тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэтгэмжийн системийг хөгжүүлэх зэрэг социаль асуудлуудыг төр засаг хариуцахаас өөр аргагүй. Үүний тулд зах зээлийн эдийн засгийг төрийн зохицуулалттай хослуулах зайлшгүй шаардлага үүснэ. Төрийн гол үүрэг бол татварын оновчтой тогтолцоо бүрдүүлж, улсын нэгдсэн болон орон утгийн төсвийн тусламжтайгаар хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэж явдал юм.

Татварын төрөл ба хувь хэмжээ нь либерал, консерватив буюу барууны хүч ба социаль демократ, социалист буюу зүүний хүчний бодлогын гол ялгааг харуулна. Барууны хүчнийхэн ашиг, орлогын татварыг нэмэгдүүлэх нь бизнес эрхлэгчдийн ашиг, хуримтлалыг багасгаж, эдийн засгийн

өсөлтийг удаашруулдаг гэж үздэг бол зүүний хүчнийхэн татварын хувь хэмжээг өсгөх замаар хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг найдвартай шийдвэрлэх боломжтой гэж зүтгэдэг.

Үүнээс үзэхэд эдийн засгийн либерализм ба социаль либерализм хоёр эсрэг тэсрэг байр суурьтай юм. Гэвч өнөө үед тэдгээрийн зөрчлийг намжааж, нийгмийн хамгааллын либерал улсыг (Liberal Welfare State) хөгжүүлэх нь чухал зорилт болж байна¹⁰.

Нийгмийн хамгааллын либерал улсын жишээнд АНУ, Их Британи, Австралийг дурдаж болох юм. Нийгмийн хамгааллын салбарт АНУ-ын баримталдаг зарчим бол индивидуализм буюу аминч үзэл, хөндлөнгөөс үл оролцох, хамгийн наад захын хэрэгцээг хангах (residualism), ядуурлыг шийтгэл гэж үзэх явдал юм. Ийм ч учир АНУ-д нийгмийн хамгааллын салбарт “workfare” хэмээх системийг нэвтрүүлжээ¹¹. Уг системийн дагуу улсаас нийгмийн хамгааллын тусламж авахын тулд тухай иргэн ажил идэвхтэй хайж байх, мэргэжлийн сургалтанд хамрагдсан байх ёстой. Эсхүл тухайн хүний хөдөлмөр эрхлэх чадваргүйг нь нотолсон байх хэрэгтэй.

Хүмүүсийг нийгмийн хамгааллын тусламжаас хурдан гаргахын тулд хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого хэрэгжүүлж байна. Энэ нь хүмүүст ажил олоход нь туслах, хүмүүн капиталд хөрөнгө оруулах, өөрөөр хэлбэл, хүмүүсийг янз бүрийн мэргэжлийн сургалтанд хамруулах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, ажлын байр хадгалахад нь туслах зэрэг бодлого, арга хэмжээг хамарна. Өөрөөр хэлбэл, уг бодлого нь зах зээлийн системийн алдаа, доголдлыг арилгахад чиглэгдэж байна.

Үүнээс үзэхэд АНУ-ын нийгмийн хамгааллын бодлого нь хавтгайрсан халамжийг үгүйсгэх, ажил хөдөлмөрөөс зугтааж, нийгмийн халамжийн тусламжаар амьдрах гэсэн зарим

10 *Liberal Welfare state, The Routledge Handbook of the Welfare State, London*

11 *Workfare, www.investopedia.com*

хүний явцуу бодлыг таслан зогсоох, гагцхүү хөдөлмөрлөж байж амьжиргаагаа хангана гэсэн үзэл хандлагыг хүмүүст баттай шингээхэд чиглэгдэж байна. АНУ-ын холбооны засгийн газар хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэдэггүй, үүнийг голчлон холбооны улсын засгийн газрын түвшинд болон ажил олгогчдын хүрээнд шийдвэрлэдэг ажээ.

Гэтэл социал-демократ чиглэлтэй улсуудад, тухайлбал, Швед, Финлянд, Норвеги зэрэг Скандинавын орнууд нийгмийн хамгаалал, халамжийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлдэг, нийгмийн халамжийг хүн бүрт хүргэх зорилготой ажилладаг ажээ. Энэ бүхнээс үзэхэд тухайн улс нийгмийн хамгааллын ямар чиглэлийн бодлого үр ашигтай болохыг сайтар судалж, өөрийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх нь чухал юм.

3. Монголын эдийн засгийн бодлого (Economic policy of Mongolia)

1990 оны хавар Сайд нарын Зөвлөлийн даргын өгсөн чиглэлийн дагуу эдийн засагч эрдэмтдийн баг байгуулж ажиллуулсан бөгөөд энэ багийнхан “Зах зээлийн эдийн засагт шилжих үзэл баримтлал” хэмээх баримт бичгийн төслийг бэлтгэсэнээ “Үнэн” сонины 1990 оны 6 дугаар сарын 6-ны дугаарт хэвлүүлсэн байна. Мөн 1990 оны 11 дүгээр сарын сүүлээр тэр үед эрх баригч байсан МАХН-ын Төв Хорооны 5 дугаар бүгд хурал хуралдаж, “Зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдсон зарим асуудлаар МАХН-ын баримтлах байр суурь” хэмээх баримт бичгийг хэлэлцэж баталсан, мөн Засгийн газраас иргэн бүрт 10 мянган төгрөгийн эрхийн бичиг өгч, өмч хувьчлах тухай шийдвэр гаргасан. 1991 оны 1 дүгээр сард “Эдийн засгийг зах зээлийн зохицуулалтад шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 20 дугаар тогтоол батлагдав. Энэ бүхэн нь манай улс зах зээлд шилжих шилжилтийг бодитой хэрэгжүүлэх үндэс суурь болж өгсөн юм. Ийнхүү тус улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос

зах зээлийн эдийн засагт шилжих онол, үзэл баримтлал, баримт бичгүүдтэй болж, улмаар уг шилжилтийг бодитой хэрэгжүүлэх ажилд 1991 оноос шуудран орсон билээ.

Харин манай улс 1991 онд Олон улсын валютын сан ба Дэлхийн банкинд гишүүнээр элсэж, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээр Вашингтоны зөвшилцөл гэх зөвлөмжийг дагах болсон юм. Уг зөвлөмжийг Олон улсын валютын сан, Дэлхийн банк, АНУ-ын Сангийн яам хамтран гаргасан бөгөөд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнууд болон хөгжиж буй орнуудад зориулжээ. Уг зөвлөмжид бараа бүтээгдэхүүний үнийг зах зээлийн зарчмаар тогтоох, өмч хувьчлалыг нэн даруй хийх, төр, хувийн хэвшлийн бүтцийг зааглах, удирдлагын механизмыг зах зээлд нийцүүлэх, өөрөөр хэлбэл, эдийн засаг дахь төрийн оролцоог хумих, өрсөлдөөний тогтолцоог бий болгох зэрэг асуудлыг тусгасан. Товчоор хэлбэл, өнгөрсөн 30 гаруй жилд Монгол Улс нийгмийн өмчид тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагтай орон болох замаар замнаж байна.

Тэгэхдээ тус улс зах зээлийн эдийн засгийн ямар загвараар хөгжиж байна гэдгийг авч үзэх шаардлагатай. Зах зээлийн эдийн засаг нь либераль буюу чөлөөт эдийн засгийн загвар, Азийн загвар, Европын буюу консерватив загвар, нийгмийн чиглэлтэй буюу социал-демократ /Скандинавын/ зэрэг загваруудтай. Эдийн засгийн хөгжлийн хэлбэр, загвар нь засаглалын болон өмчийн голлох хэлбэр, эдийн засаг дахь төрийн оролцоо, зах зээлийн харилцааны онцлог, санхүүжилтийн эх сурвалж, хэмжээ, инновацийн түвшин, эдийн засаг нээлттэй эсэх зэргээс болон тухайн орны түүх, нийгэм, соёлын онцлогоос хамаарна. Хүснэгт 1-д зах зээлийн эдийн засгийн хөгжлийн загваруудыг харьцуулав.

Хүснэгт 1. Зах зээлийн эдийн засгийн загваруудыг харьцуулах нь¹²

Загвар	Улс	Эдийн засаг дахь төрийн оролцоо (төрийн хэвшилд ажиллагч-дын хувь)	ДНБ-нд улсын төсвийн зарла-гын эзлэх хувь	Нийгмийн тэгш байдалд болон нийгэмд хандах хандлага	Эдийн засаг дахь төрийн зохицуулалтын хэр хэмжээ	Цөлөөт өрсөлдөөний нөхцөл боломж
Либераль	АНУ	17.6	19.9	Нийгмийн тэгш байдлыг гол зорилгоо болго-доггүй, харин бага орлоготой хүн амд дэмжлэг үзүүлдэг. Хувийн идэвх санаачлагыг өөг-шүүлэн дэмждэг.	Төрийн зохицуулалт бага, зах зээлийн зарчмыг голлодог.	Цөлөөт өрсөлдөөн харьцангуй эрчимтэй өрнөдөг.
	Их Британи	21.5	27.4			
Азин	Япон	12.9	17.3	Нийгмийн тэгш байдлыг чухалчилдаггүй. Хамт олонч үзлийг дэмждэг.	Төрийн зохицуулалт, төлөвлөлт их, бөгөөд түүнийг зах зээлийн механизмтай хослуулдаг.	Цөөн том компаниуд эдийн засагт голлох байр суурь эзэлдэг.
	Өмнөд солонгос	11.6	19.6			
Европын (консерватив)	Герман	15.3	10.0	Нийгмийн дундаж ангийг өргөтгөж бэхжүүлэхийг эрмэлздэг.	Төрийн зохицуулалтыг зах зээлийн механизмтай зохистой хослуулдаг.	Том, дунд, жижиг аж ахуйн нэгжүүдийн аль алиных нь хөгжих нөхц-лийг хангахыг эрмэлздэг.
	Франц	28.0	13.0			
Нийгмийн Чиглэлтэй	Швед	29.9	48.5	Нийгмийн тэгш байдлыг гол зорилгоо болгож хэрэгжүүлдэг. Нийгмийн чиг баримжаат үзлийг голлодог.	Төрийн зохицуулалт их, түүнийг гатвар, төсөв, нийгмийн хамгаалалтыг бодлогоор дамжин хүчтэй хэрэгжүүлдэг.	Хувийн компаниуд өрсөлдөх нөхцөл бололцоо хангалттай.
	Норвег	35.6	45.6			

12 Б.Батхшиг, Монгол дахь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн асуудлууд, УБ, 2020, 29-30 дахь тал

Хүснэгт 1-ээс харахад Швед, Норвег зэрэг нийгмийн чиглэлтэй зах зээлийн эдийн засгийн загварын хувьд улсын төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өндөр, эдийн засаг дахь төрийн оролцоо ч харьцангуй их байна. Гэтэл либераль загвартай орнуудад дээрх үзүүлэлтүүд эсрэгээрээ бага байна.

Монгол Улс дээрх загваруудаас алийг нь хэрэгжүүлж байна вэ гэвэл энэ нь эрх барьж буй намын мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалаас ихээхэн хамаарч байна. Өнгөрсөн 30 гаруй жилийн ихэнхэд нь засгийн эрхийг барьж байгаа Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөрт “Монгол Ардын Нам нийгмийн ардчилал, үндэсний эрх ашгийг үзэл баримтлалынхаа эш үндэс болгож иргэний эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг дээдлэн эрхэмлэнэ. Хүний хөгжлийг нийгмийн дэвшлийн шалгуур гэж үздэг иргэн төвтэй хөгжлийн чиг шугамыг тууштай баримтлана. Хүн амаа өсгөх бодлогын хүрээнд хүүхэд, залуучууд, өндөр настныг илүү анхаарч, гэр бүлийн хөгжлийг онцлон дэмжиж, хүйсийн тэгш эрхийг хангана... Бид Мөрийн хөтөлбөрөө Монгол Улсаа хөгжүүлэх төрийн бодлогын тулгуур үндэс болгон тунхаглан тодорхойлж байна.”¹³ гэж заажээ. Тус нам ийнхүү социал-демократ үзэл баримтлалаа тунхагласан тул түүний байгуулсан Засгийн газар зах зээлийн эдийн засгийн социал-демократ буюу нийгмийн чиглэлтэй загварыг түлхүү хэрэгжүүлж байна.

Харин 1996-2000, 2012-2016 онуудад засгийн эрхийг барьж байсан Ардчилсан нам либераль чиглэлийн бодлого явуулж ирсэн. Энэ нь том аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, суурь үнийг чөлөөлөх, гадаад худалдааг бүрэн либеральчилж, импортын татварыг тэглэх зэрэг арга хэмжээ авснаар тодорхой харагдсан.

Энэ бүхнээс дүгнэхэд Монгол дахь зах зээлийн эдийн засгийн харилцаа либераль болон социал-демократ загвар луу ээлжлэн татагдаж, эцсийн дүнд холимог маягийн загвар тогтоход хүргэжээ. Эдийн засаг дахь төрийн

13 Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр, www.nam.mn

оролцоо харьцангуй их байгаа нь зах зээлийн хууль, зарчмуудын үйлчлэлийг сулруулж, бизнес эрхлэгчдийн идэвх санаачлага, бизнес сэтгэлгээг мохоож байгааг зөвтгөх аргагүй. Өнгөрсөн жилүүдийн практикаас харахад төрийн өмчит Хөгжлийн банкнаас болон Засгийн газрын янз бүрийн сангаас аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох, үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авч ирсэн бөгөөд энэ бүгд зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг боомилж, эцсийн дүнд эдийн засгийн өсөлтийг сааруулсан билээ.

Тухайлбал, Чингис бондын мөнгийг дотоодын аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлсэн боловч дийлэнх хэсэг нь эргэн төлөгдөх баталгаагүй болжээ. Бондын мөнгийг улсын эдийн засагт нэн хэрэгтэй, ач холбогдолтой томоохон төслүүдэд төвлөрүүлэн зарцуулахын оронд янз бүрийн олон жижиг төсөлд цацан олгожээ. Мөн бондын мөнгийг томоохон төслүүдэд зарцуулахдаа эдийн засаг, санхүүгийн тооцоо, судалгааг сайтар хийгээгүйгээс зарим төслийн гүйцэтгэл, үр ашиг муу байна.

Монгол Улсын Засгийн газраас Монголбанкт хамтран 2012-2016 онд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүнийг үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлсэн. Гэвч үнэ тогтворжуулах хөтөлбөр нь гүйлгээн дэх мөнгөний тоог ихээхэн нэмэгдүүлсэн учир 2017 онд инфляцийн түвшин дахин өсөж, 6.4 хувьд хүрчээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний цаасан мөнгө гүйлгээнд оруулснаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг үлэмж хэмжээгээр унагасан юм. 2012 онд 1 ам доллар 1393 төгрөгтэй тэнцэж байсан бол уг хөтөлбөр дууссан 2016 онд 2490 төгрөг болжээ. Энэ нь эргээд импортын барааны үнэ өсөх нөхцлийг бүрдүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Тариалан эрхлэх сан, “Цэвэр агаар” сан гэх мэт Засгийн газрын тусгай сангууд хэдийгээр дурдсан чиглэлүүдээр хүү багатай зээл өгч, үйлдвэрлэлийг дэмжих сайхан зорилго тавьсан боловч тэр бүр тэгш шударга хэрэгжүүлж чадсангүй.

Эдгээр сангаас төр засгийн өндөр албан тушаалтнууд эрх мэдлээ ашиглан өөрсдийн хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдэд хямд зээл авч өгч байсан нь илэрсэн билээ. Тэгээд ч газар тариалангийн зарим компани бага хүүтэй зээл авч, үлдсэн нь өндөр хүүтэй зээл дээр унах нь зах зээлийн шударга өрсөлдөөний зарчмыг зөрчиж байгаа хэрэг юм.

Эдийн засагт төрөөс ийнхүү хэт оролцох нь зах зээлийн зарчмыг гуйвуулж, улмаар эдийн засаг хэвийн үйлчлэх нөхцөлийг боогдуулдаг байна. Иймд Монголын эдийн засгийн хөгжлийн загварыг зөв сонгох, ингэхдээ Монголын өөрийн онцлогийг харгалзан үзэх, хамгийн гол нь зах зээлийн либераль хандлагыг түлхүү баримтлах нь нэн чухал юм.

Монголд зах зээлийн механизм, төрийн зохицуулалтыг зохистой хосолсон, тэгэхдээ эдийн засаг дахь төрийн оролцоог эрс багасгасан, чөлөөт өрсөлдөөнийг тэтгэсэн, нийгмийн тэгш байдал тогтоохыг дэмжсэн, хувийн сонирхлыг хамт олонч үзэлтэй уялдуулсан загвар зохимжтой гэж бодож байна. Тэгэхдээ эрдэс баялаг болон мал аж ахуйн түүхий эдийг аль болох иж бүрэн боловсруулах аж үйлдвэрлэл тэргүүлсэн эдийн засгийн зохистой бүтцийг бий болгох, эдийн засаг, дэд бүтцийн салбаруудын харилцан уялдаа холбоо, найрслыг хангах, шинэ эдийн засгийн загваруудыг нутагшуулах, гадаад худалдаа, эдийн засгийн харилцааны таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг хөгжүүлэх нь Монголын эдийн засгийн хөгжлийн загвар байх ёстой.

Монгол Улс нийгмийн хамгааллын улсын аль загварыг хэрэгжүүлж байна гэсэн асуулт гарна. Өнөөгийн байдлыг авч үзвэл тус улс социал-демократ загварт илүү ойр байна гэж хэлж болно. Өмнө нь 70 орчим жил социалист маягийн хэлбэрээр хөгжиж, бүх нийтийн үнэгүй боловсрол, эрүүл мэндийн болон тэтгэвэр, тэтгэмжийн улсын нэгдсэн тогтолцоотой явж ирсний эрч буюу инерц эдүгээ зах зээлийн харилцаанд орсон ч гэсэн хадгалагдаж, нийгмийн хамгааллын тогтолцоо хэт хавтгайрсан байдалтай байна.

Нийгмийн хамгаалын тогтолцоо нь нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Манай улсад тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал, ажилгүйдлийн даатгал зэрэг нийгмийн даатгалын төрлүүд бий.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо 2021 оны байдлаар 459693, тэтгэмж авагчдын тоо 288568, нийлээд 748261 хүн байсан нь нийт хүн амын 21.9% болж байна.¹⁴ 2000 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо 254.4 мянга байсан бол 2021 онд 459.7 мянга болж, 80.7%-иар нэмэгджээ.

Монгол Улсын хувьд тэтгэврийн тогтолцооны хуваарилалтын хэлбэрийг ашиглаж ирсэн бөгөөд 1999 онд “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хууль батлагдсан боловч түүнийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна. Эдүгээ социализмын үед хэрэглэж байсан тэтгэврийн тогтолцооны хуваарилалтын хэлбэр бараг хэвээрээ үргэлжилж байгаа бөгөөд зах зээлийн харилцааны зарчимд нийцсэн тэтгэврийн хуримтлалын тогтолцоог нэвтрүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Тэтгэврийн тогтолцооны хуваарилалтын хэлбэр гэдэг бол одоо ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор одоо тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тэтгэврийг олгох хэлбэр юм. Үүнийг эв санааны нэгдлийн зарчим гэж бас нэрлэдэг. Харин тухайн хүн ажил эрхлэх хугацааныхаа турш тэтгэврийн шимтгэлээ өөрийн нэр дээр хуримтлуулж, тэтгэврийн насанд хүрэхийн хамт түүнээсээ тэтгэвэр авах хэлбэрийг хуримтлалын хэлбэр гэнэ.

Монгол Улсад 2021 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо давхардсан тоогоор 2552.2¹⁵ мянга болжээ. Өөрөөр хэлбэл, нийт хүн амын 74.8 хувь нь нийгмийн халамжид хамрагджээ. Тус улс үндсэндээ хөдөлмөрийн

¹⁴ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2021, 11 ба 168 дахь тал

¹⁵ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2021, 170 дахь тал

биш, халамжийн улс болох тийш замнаж байна. Нийгмийн халамжид хамрагдсан хүний тоо 2000 онд 110500 байсан бол 2021 онд 2552200 болж, 23 дахин өссөн байна.

Нийгмийн халамжид хамрагдагсдын 47.8 хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж, нэг хүүхэд сард 100 мянган төгрөгийн тэтгэмж авч байна. Ер нь нийгмийн халамжийн төрөл улам бүр олширч, хавтгайрсан шинжтэй болжээ. Тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмж, үүнд асаргааны тэтгэмж, бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний тэтгэмж, тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний тэтгэмж, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж, ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, насны хишиг гэх мэт 30 төрлийн халамж, үйлчилгээг үзүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа телевизэд өгсөн ярилцлагадаа “Хүнсний талон авч байгаа 230 мянган хүнээс 110 мянга нь хөдөлмөрийн чадвартай хүмүүс байна. Тэдний дотор мянгат малчин, боломжтой амьдралтай хүмүүс ч байсан.... Манай улсын хүн амын 3.4% нь хөдөлмөрийн чадвараа алдсан гэж тогтоолгосон. Гэтэл зарим аймаг, суманд хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүсийн тоо улсын дунджаас 2-3 дахин өндөр байгаа нь анхаарал татсан.”¹⁶ гэж хэлэв.

Үүнээс үзэхэд нэг хүн, нэг өрх олон янзын нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг давхар авч, ажил, хөдөлмөр эрхлэхгүйгээр амьдарч болохоор болжээ.

16 “25 дугаар суваг” телевизийн “Ам нээвэл...” нэвтрүүлэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа оролцож өгсөн ярилцлага, 2021- 9-21

Иймд нийгмийн халамж, үйлчилгээний олон төрлийг цөөлж, давхардлыг арилган, халамж хүртэх ёстой хүмүүст амьжиргааг нь хангахуйц хэмжээгээр өгөх нь зүйтэй.

Нийгмийн халамжийн үйлчилгээний хэмжээ ийнхүү ихээр нэмэгдэж, 2021 онд 1.9 их наяд төгрөг болж 2018 оныхоос 3.2 дахин өсчээ.¹⁷ Энэ нь 2021 оны улсын нэгдсэн төсвийн зарлагын 12.6 хувийг эзэлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ нэмэгдэхийн хамт ядуурал буурч байх учиртай. Гэтэл 2020 оны байдлаар тус улс дахь ядуурлын хамралтын хүрээ 27.8% байгаа нь ядуурал олигтой буураагүйг харуулж байна.

Сүүлийн үед Монгол Улсын Засгийн газар “халамжаас хөдөлмөрт” гэсэн уриа дэвшүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг хумих оролдлого хийж буйг сайшаалтай. Тус улс дахь халамжийн үйлчигээний тогтолцоог шинэчлэхдээ АНУ-ын туршлагыг нэвтрүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн чадвартай хүмүүст нийгмийн халамжийг өгөхгүй байх, өгсөн ч зөвхөн тодорхой хугацаагаар, тухайлбал, ажил хайж байх үед нь өгч, аль болохоор хөдөлмөр эрхлэх сонирхол, шаардлагыг төрүүлэх хэрэгтэй.

Хүн амын дундах орлогын ялгааг багасгах, ялангуяа ядуурлыг арилгах нь тус улсын эдийн засаг, нийгмийн бодлогын гол зорилт байх ёстой. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын шинжилгээ, түүнээс урган гарах стратегид тулгуурлан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь дараах асуудлуудыг эн тэргүүнд шийдвэрлэх нь чухал байна. Үүнд:

- Монголын уламжлалт соёл, аж төрөх ёсоо дээдэлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлс, үндэсний бахархлыг бий болгох, түүнд тулгуурлан үндэсний онцлогтой бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгон гадаад орнуудад таниулах;

17 Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2021, 151 дэх тал

- Монгол хүний аюулгүй байдлыг хангаж, хөгжүүлэх, иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх боломжийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх;
- Нийгмийн тэгш бус байдлыг халж, дундаж давхаргыг эрс нэмэгдүүлэх;
- Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох;
- Газрын хэвлийн дэх, түүний дээрх баялгаа үндэсний, иргэн бүрийн баялагт хөрвүүлэх, баялгийн сангийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх;
- Өрсөлдөх чадвар бүхий, өндөр технологид суурилсан эдийн засгийн салбаруудыг хөгжүүлж, эдийн засгийн бүтцийг олон тулгуурт болгох;
- Орлогын дахин хуваарилалтыг сайжруулах, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд санхүүгийн салбарт шинэчлэл хийх;
- Мэдлэг, технологи болон инновацид суурилсан эдийн засаг руу шилжиж буй глобал чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах;
- Шинжлэх ухаан, инновацийг төрийн бодлого, үйлдвэрлэлд тасралтгүй нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.¹⁸ гэжээ.

Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сард “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” тогтоол баталсан бөгөөд энэхүү бодлого нь «Алсын хараа-2050» Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. «Шинэ сэргэлтийн бодлого»-ын хүрээнд 1/ боомтын сэргэлт, 2/ эрчим хүчний сэргэлт, 3/ аж үйлдвэржилтийн сэргэлт, 4/ хот, хөдөөгийн сэргэлт, 5/ ногоон хөгжлийн сэргэлт, 6/ төрийн бүтээмжийн сэргэлт гэсэн зургаан багц асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөжээ.¹⁹

18 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УБ, 2019, 48-49 дэх тал

19 “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Эдгээр зорилтыг шийдвэрлэх, ялангуяа хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзэж байна.

Нэгд, Тус улсад уул уурхай, олборлолт давамгайлсан, боловсруулах үйлдвэрлэл хоцорсон эдийн засгийн өрөөсгөл бүтэц бүрдэх хандлагатай болжээ. Энэ хандлагыг зогсоож, инновацид тулгуурласан боловсруулах аж үйлдвэр тэргүүлсэн олон тулгуурт эдийн засгийн зохистой бүтцийг бүрдүүлэх нь Монголын хөгжлийг хурдасгах гол чиглэл мөн.

Хоёрт, бүсийн төв бүрт мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах хөнгөн болон хүнсний үйлдвэрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр байгуулж, бүтээгдэхүүнээ борлуулах дотоод, гадаад зах зээлийн асуудлыг хамтад нь шийдэх хэрэгтэй.

Гуравт, цаашид уул уурхайн орд газруудыг ээлж дараатай эзэмших нарийн төлөвлөгөө гаргах, тэгэхдээ эрдэс түүхий эдийг иж бүрэн боловсруулж, нэмэгдсэн өртгийн үйлдвэрлэлийг өсгөх, түүнээс олсон ашгийг зохистой хуваарилж ашиглабал зохино. Уул уурхайн баялгийн олборлолт, экспортын орлогыг хуримтлуулан баялгийн санг бүрдүүлэх, түүнийг ашиглан эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, дэд бүтцийг хөгжүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах, нийгмийн салбарыг хөгжүүлэх зорилтыг шийдвэрлэх нь зүйтэй.

Дөрөвт, хүн амын дийлэнх олонх болох ажиллагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, дундаж цалин хөлсийг тухайн гэр бүлийн хэвийн амьдрах, сурч боловсрох нөхцлийг хангахуйц хэмжээнд хүргэх хэрэгтэй. Үүний тулд жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж байх нь зүйтэй.

Ашигласан ном, зохиол

Монгол хэл дээр:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УБ, 2019
2. Б.Батхишиг, Монгол дахь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн асуудлууд, УБ, 2020
3. Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр, www.nam.mn
4. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2021
5. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
6. “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Англи хэл дээр:

1. Adam Smith, An inquiry into Nature and Causes of the Wealth of Nations, MetaLbri, 2007, Book IV
2. Liberal Welfare state, The Routledge Handbook of the Welfare State, London
3. Liberalism, The Free Encyclopedia Wikipedia
4. Neoliberalism, www.investopedia.com
5. Welfare State, www.sciencedirect.com
6. Welfare State, The Free Encyclopedia Wikipedia
7. Workfare, www.investopedia.com

Орос хэл дээр:

1. Государство всеобщего благоденствия, www.bigens.ru

5

**Тавдугаар бүлэг.
Монгол Улсын нийгмийн хамгаалал,
түүний эрх зүйн зохицуулалт***Судлаач Ц.Баянмөнх***1. Нийгмийн хамгааллын талаарх ойлголт**

Хүний нийгмийн үүсэлтэй нэгэн зэрэг нийгмийн хамгааллын хэрэгцээ үүсэн бий болсон байдаг. Нийгэм-эдийн засаг, улс төрийн байгууламжаас үл хамаарч хүн оршин байгаа нөхцөлд түүний мөн чанар, хүн гэсэн утгаар хамгаалах, амьдрах нөхцөлийг хангах нь зүй ёсны асуудал болон гарч ирнэ. Ялангуяа хүн хөгшрөх, хүүхэд төрөх зэрэгт хүүхдийг, настныг хамгаалах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх, иргэдийг халамжлах нь төрөөс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үүргийн нэгэн зайлшгүй шаардлага болдог байна.

Нийгмийн хамгааллын үндсэн зорилго нь хүний төрөлхийн ялгаатай байдлыг харгалзан үзэж, дэмжлэг шаардлагатай байгаа хэсэгт, мөн бие даан амьдрах боломж нөхцөл хязгаарлагдаж эрсдэлтэй нөхцөл байдалд орсон үед төрөөс тусгайлан тусламж үзүүлэхэд чиглэдэг.

Нийгмийн хамгааллын талаар тодруулбал манай улсад 1940-өөд оноос “нийгмийн хангамж” гэсэн ойлголтыг хэрэглэж ирсэн бөгөөд зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш “нийгмийн хамгаалал” гэсэн нэр томъёог хэрэглэх болсон.

Нийгмийн хамгаалал нь зөвхөн нийгмээс хамааралтай эрсдлийг зөв тодорхойлж, өртсөн тохиолдолд хамгаалах орчинг бүрдүүлэх бөгөөд энэ ойлголт нь зөвхөн нийгмийн даатгал болон нийгмийн халамж, үйлчилгээний үйл ажиллагаагаар үл хязгаарлагдана. Бүх нийтийн эрүүл мэнд, боловсрол, эрүүл орчин-ахуй, экологийн тэнцвэрт байдал

гэсэн үзүүлэлтүүд нийгмийн даатгал, нийгмийн халамж, нийгмийн үйлчилгээний үйл ажиллагаатай нийлж, цогц байдлаараа нийгмийн хамгааллыг бүрдүүлэх бөгөөд гагцхүү ийм тохиолдолд нийгмээс хамааралтай эрсдлийг бууруулах, тодорхой түвшинд байлгахад нөлөөлдөг орчинг бүрдүүлэх юм гэж үзэх нь нийгмийн хамгаалал хэмээх ойлголтын өргөн утга юм. Харин явцуу утгаараа нийгмийн гишүүд өвдөх, өтлөх, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, нас барах болон олон хүүхэдтэй өрх толгойлсон, орлогын хомсдолтой гэр бүлд амьдрах бололцоо олгох үүднээс үзүүлж байгаа тэтгэвэр, тэтгэмж, асрамжлах, халамжлах үйлчилгээг нийгмийн хамгаалал гэж ойлгож болно.

Нийгмийн хамгааллын эрх зүй нь иргэдийн нийгмийн хамгааллын туслалцаа авах Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах үүднээс мөнгөн төлбөр, тусламж, эм, эмнэлгийн үйлчилгээ, асрамж, халамжийн үйлчилгээг эрх бүхий байгууллагаас нийгмийн гишүүдэд төвлөрсөн хөрөнгийг хуваарилах замаар хүртээж байгаа нийгмийн харилцааг зохицуулж эрх зүйн хэм хэмжээний цогц юм. Нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулах зүйл болох бие даасан харилцаанд нийгмийн даатгал, нийгмийн халамж, нийгмийн үйлчилгээтэй холбогдох харилцаа багтана.

Нийгмийн даатгал нь хувь хүний орлого олж амьдрах чадвар нь ямар нэгэн хэмжээгээр буурч нийгмийн баталгаа алдагдах зайлшгүй тохиолдлоос үүссэн хохирлыг нийгмийн даатгалын сангаас нөхөн төлөхтэй холбогдсон харилцаа юм.

Нийгмийн халамж нь эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа ажээ.

Нийгмийн хамгаалал нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийн үндэс суурийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, хүн амын тогтвортой өсөлтийг хангах үр дүнтэй арга учир улс орны хөгжлийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ утгаараа нийгмийн хамгаалал нь эдийн засгийн, нийгмийн, хүн ам зүйн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Эдийн засгийн талаас орлогын дахин хуваарилалт хийх замаар ядуу, эмзэг бүлгийнхэний орлогыг нэмэгдүүлэх, эрсдэлд өртөн орлогын түвшин буурах үед түүнийг тодорхой түвшинд нөхөх, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн дээр өрх, иргэдийн орлогын баталгаат байдлыг хангах зэрэг үүргийг дурдаж болно. Нийгмийн хамгаалалд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулах, хөдөлмөрийн чадвараа алдах, өндөр наслах зэрэг эрсдлийн үед иргэн бүрт хэвийн амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх нийгмийн шинжтэй чиг үүрэг ч бий. Түүнээс гадна нийгмийн хамгааллын хүрээнд төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн, гэрлэлт зэрэг хүн ам зүйн үйл явцад нөлөөлөх зорилгоор тэтгэвэр, тэтгэмж олгох, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг¹.

2. Монголын нийгмийн асрамж, халамжийн уламжлал

Монголчууд бид нэн эртнээс ахмад настнаа хүндэтгэх, асрах, халамжлах, тэжээн тэтгэх, хамгаалах уламжлал, соёлтой ард түмэн билээ. Үүний тод жишээ бол Чингисийн эзэнт гүрний үеэс ахмадыг хүндлэх, халамжлах үйл ажиллагааг төрийн бодлого, шийдвэрийн түвшинд авч үзэж, хэрэгжүүлж байсан талаар баримт мэдээлэл түүхэн сурвалжуудад үлджээ. Тухайлбал, Чингис хаан өтгөс, нялхасыг өөрийн үрс мэт өршөөн үзнэ гэх зарчмыг баримталдаг байсан бөгөөд 1218 оны улаан хулгана жилийн цагаан сарын шинийн нэгний өдөр гаргасан зарлигтаа: “Миний эх (Өэлүн)-ийн нас сүүдэр далан долоо хүрч өндөр болсон учир их хүү (Чингис хаан)-

¹ Б.Нарантулга нар. Өндөр насны тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал. Судалгааны тайлан. Удирдлагын академи. УБ., 2019. 4 дэх тал

гээс шар алт мянган лан, цагаан мөнгө түмэн лан, зодон арван түмэн хэсгийг гаргаж, миний харьяат 892 хот, балгадын сан хөмрөгийг нээж, миний харьяат 60 наснаас дээшихэд 3 хувь, 90 наснаас дээшихэд 4 хувь, 100 наснаас дээшихэд 5 хувь, 110 наснаас дээшихийг надад бараалхуул, өвөрмөц шагнана. 120 наснаас дээшихийг олмогц урьд улсын “Кувв луу” цол өргөж, таяг тулуулан надад бараалхуул, өөр өргөмжлөл бий. Хэрэв түүнээс дээш давсан аваас сүйх тэргэнд суулгаж дамнан ирүүлж бараалхуул ангид ялгал буй. Энэхүү нэгэн хувьд нэг лан мөнгө, нэгэн бөс, арван суулга амуу будааг хэмжээ болго. Наян нас гарсан настанд шар алт нэг цэнг нэмж өг”² гэжээ. Үүнээс нас ахих бүрт ахмадад үзүүлэх шан харамж нэмэгдэж, хайр хүндлэл ихсэх бодлого баримталж, уламжлагдсан байна. Мөн байгалийн гамшиг, дайн дажны улмаас үүссэн хоосрол, ядуурлыг арилгах, настан буурлууд, өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийг асран тэтгэж байсан бөгөөд Монгол Улсын тулгар төр анх байгуулагдсан үеэс (1206 он) энэ асуудал төрийн бодлогын хэмжээнд чухал асуудал болон тавигдаж байжээ.

Чингисийн эзэнт гүрний үед “Үгээгүй ядуусыг асран тэтгэх” тусгай зориулалтын сантай байсан талаар олон баримт Монголын нууц товчоонд бий. Өгөөдэй хаан сангийн үйл ажиллагааг үргэлжүүлэхийн зэрэгцээ “өнчин ядуусыг тэтгэх, тэднээс албан татвар авахгүй байх зарлиг гаргаж байжээ”³.

Өнө эртнээс улбаатай бусдад туслах эрмэлзлэл, харилцан туслалцаа, нийгэмшил зэрэг үйл явц аажмаар өөрчлөгдсөөр XIII зууны үеэс нийгмийн бодлого, нийгмийн хамгааллын үндсэн зарчим үүсчээ⁴ гэж зарим судлаачид дүгнэсэн байна. Үүнд ахмадын нийгмийн хамгааллын бодлого ч мөн адил хамаарахыг дээрх баримтууд харуулж байна.

Ардын хувьсгалаас өмнөх монголын түүхийн зарим үед тухайн үеийн нийгэм, төрийн нөхцөл байдал, онцлогтой

2 В.Илжиниши. *Хөх судар. 1553-1554 дахь тал*

3 *Нийгмийн халамжийн бодлогын үр нөлөө. Удирдлагын академи, Удирдлага, удирдлагын бодлого судлалын хүүрээлэн. УБ. 2009. 43 дахь тал*

4 Г.Оюунцэцэг, Ч.Дагвадорж. *Нийгмийн удирдлагын онол, арга зүйн асуудлууд. УБ. 2003. 7 дахь тал*

холбоотойгоор ард иргэдийн халамжийн бодлого орхигдож байсан үе ч бийг зарим бүтээлд тэмдэглэсэн байдаг.⁵

Харин Богд хаант засгийн үед Монгол төрийн нийгмийн хамгааллын бодлого, уламжлал сэргэх үйл явцын эхлэл тавигдсан гэж хэлж болно. Үүний тод жишээ нь 1880 онд буюу Манжийн эрхшээлд байсан Богд хаант засгийн үед зуд болж, хөдөөнөөс хүрээрүү чиглэсэн нүүдэл хөдөлгөөн нэмэгдэж, хүрээнд хулгай дээрэм ихсэх хандлагатай байсан учир Тэтгэврийн сангийн газрыг байгуулж байжээ.

1911 оны “Зарлигаар тогтоосон Богд хаант Монгол Улсын цаазын бичиг” нь өнчин, ядуусыг асран тэтгэх, тэдгээрт тухайн аймаг хошууны ноёд түшмэдээс олгох өглөг, халамжийн хувь хэмжээг тогтоосон бөгөөд хэрэв зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсноороо нийгэм хамгааллын түүхэнд чухал байр суурь эзлэх баримт бичгийн нэг болсон юм. Мөн Монгол Улс Манж гүрнээс салж, бие даан тусгаар тогтносон улс болохоо зарлан VIII Богд Жавзандамбыг эзэн хаанаар өргөмжлөхөд тэрбээр нэг удаагийн хишиг тараах зарлиг буулгаж, 70-80 настан бүрт гурван лан буюу дөрвөн унци мөнгө, 80-90 настан бүрт зургаан лан буюу найман унци мөнгө, 90-ээс дээш настан бүрт есөн лан буюу 12 унци мөнгө олгож байсан нь түүхэн баримтуудад үлджээ⁶.

Ахмад настанд халамж, хүндэтгэл үзүүлэх бодлого нь Чингисийн их гүрний үеэс өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн бөгөөд үүнийг манай төрийн бодлогын залгамж чанарын илэрхийлэл гэж үзэж болно. Гэхдээ түүхийн энэ хугацаанд хамаарах ахмад настны асрамж, халамжийн талаар төрөөс хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүд нь тэдний аж амьдралын үндсэн баталгаа болж байгаагүй ч өвөг, дээдэс, ахмад настнаа хүндлэх, асран халамжлах үүргийг үр хүүхэд, ах дүү, хамаатан садан айл хотлоороо хүлээдэг байсан уламжлалт соёлтой ард түмэн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

5 БНМАУ-ын Хөдөлмөр нийгэм хангажийн улсын хорооны мэдээлэл. 1978. №1. 7 дахь тал
6 Ж.Амарсанаа. Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ. 2012. 15 дахь тал

Монгол Улсад Ардын хувьсгал ялснаар төр, нийгмийн зохион байгуулалт үндсээрээ өөрчлөгдсөн бөгөөд нийгмийн хангамжийн бодлого, үзэл баримтлал нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн онолын зарчимд тулгуурлан хөгжих болсон байна.

1921-1940 онд нийгмийн хангамжийн зарим төрөл, хэлбэр бий болж үндэс, суурь тавигдсан бөгөөд энэ үед гэр орон, хоол хүнс, хувцас, шаардлагатай бол үнэ төлбөргүй эмчлэх зэрэг тусламж үзүүлэх талаарх зохицуулалтууд тусгагдаж байв. 1940 оны Үндсэн хуульд “БНМАУ-ын биеийн хүчнийг үнэлэх ард иргэн нь нас хөгшрөх цагт, мөн түүнчлэн өвчин хүрэх буюу хөдөлмөрийн чадвараа гээгдүүлэх ахул эдийн тусламж олгох эрх эдэлнэ. Энэхүү эрх нь нийгмийг аюулаас хамгаалах журмаар улсын бүх хөлслөн авагчдын зардлаар хангагдах ба хөдөлмөрчин ард түмэнд эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүйгээр үзүүлэх хийгээд рашаан усыг дэлгэрүүлэх зэргээр хангагдах болно” хэмээн заасан. Энэ заалт нь нийгмийн хамгаалал, нийгмийн хангамжийн талаар Үндсэн хуульд тусган баталгаажуулснаараа онцлогтой байв.

Улмаар 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд “БНМАУ-ын иргэд нас хөгшрөх, өвдөх, хөдөлмөрийн чадвар алдах, тэжээгчээ алдахад эдийн засгийн тусламж авах эрхтэй. Нийгмийн даатгал, улсын тэтгэвэр, хоршооллын байгууллагын тусгай фондын системээр дамжуулан хөдөлмөрчдөд тусламж олгож, амралт сувиллын газрыг олшруулан, эмнэлэгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлж, хөдөлмөр хамгааллыг хөгжүүлж энэхүү эрхийг хангана” хэмээн зааж байв.

Энэ цаг хугацаанд төрөөс хэрэгжүүлсэн нийгмийн хангамжийн бодлого, эрх зүйн орчин нь тухайн нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлж ахмад настнуудын нийгмийн хамгааллын эрхийг тодорхой хэмжээнд хамгаалж, анхаарч байсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

3. Монголын нийгмийн шилжилтийн үеийн буюу 1990-1995 оны нийгмийн хамгааллын бодлогын онцлог

Монгол Улс 1990 оноос зах зээлийн харилцаанд шилжсэнээр нийгмийн суурь үзэл баримтлалд нийцүүлэн хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэтгэл хийж, төрөөс иргэдийн амьжиргааны баталгаа алдагдах, хүнд хэцүү, эрсдэлтэй байдалд орох, бие даан амьдрах бололцоогүй болох үед тусламж, дэмжлэг үзүүлэх, наад захын хэрэгцээг хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор нийгмийн хамгааллын шинэ бодлого хэрэгжүүлэх шаардлага бий болов.

Нийгмийн тогтолцооны шилжилтийн үед зах зээлийн эдийн засгийн онолын баримжаатай нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдүүлэхийг зорьж Улсын Бага Хурлаас 1990 онд БНМАУ-ын тэтгэврийн хууль, 1991 онд БНМАУ-ын тэтгэмжийн тухай хууль, мөн онд Тэтгэврийн сангийн дүрмийг тус тус баталж дараах өөрчлөлтийг хийсэн байна. Үүнд:

- Тэтгэврийг дотор нь хөдөлмөрлөсний (насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр хамаарна) ба нийгмийн халамжийн гэсэн хоёр төрөлтэй байхаар зохицуулсан;
- “Тэтгэврийн сан”-г бий болгосон;
- Нийтдээ 25 жил ажилласан 60 насанд хүрсэн эрэгтэй, 20 жил ажилласан, 55 насанд хүрсэн эмэгтэй насны тэтгэвэр авах эрхтэй ба нийтдээ 32-оос дээш жил ажилласан 55 насанд хүрсэн эрэгтэй, 27-гоос дээш жил ажилласан эмэгтэй өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр (1993 оны нэмэлт, өөрчлөлтөөр үүнийг 50 нас хүрсэн байхаар өөрчилжээ) тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байхаар тусгасан;
- Зөвхөн байгууллага, үйлдвэрийн газар нь ажилчдын нэрийн өмнөөс нийгмийн даатгалын шимтгэл төлдөг зохицуулалт өөрчлөгдсөн;
- Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагын эзэд, хувиараа хөдөлмөр

эрхлэгчдийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, халамжийн сангийн эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгөөр бүрдэх болсон;

- Ажилтан, албан хаагчдын тэтгэврийн зохицуулалтаас гадна хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн зохицуулалтыг тусгасан;
- Нийгмийн халамжийн тэтгэврийг бий болгосон байна.

Эдгээр шинэлэг зохицуулалт нь зах зээлийн харилцааны жишигт нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тогтолцоог бий болгох анхны алхам байв.

Мөн өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч байгаатай холбоотой улсын байгууллагад ажиллагсад, хоршоолол, хувийн үйлдвэр, аж ахуй нэгжийн ажилчдад бүгдэд адил зарчим үйлчилж эхлэв. Өөрөөр хэлбэл, бүх иргэдийн хувьд ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан өндөр насны тэтгэвэр тогтоолгох боломжтой болов.

Дээр дурдсанчлан тус хуулиар нийгмийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэл, суурь зарчимтай холбоотой хэд хэдэн чухал зохицуулалт хийсэн ч нийгмийн тогтолцооны шилжилтийн эхлэл болох энэ үед социалист хуулийн хэм хэмжээг бүр мөсөн өөрчилж чадаагүй юм.

1991 онд БНМАУ-ын Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийг баталсан ба энэ хуулийн зорилго нь БНМАУ-ын Тэтгэврийн санд нийгмийн даатгалын шимтгэл төлөхтэй холбоотой харилцааг зохицуулах байв. Хуульд дараах субъектууд нийгмийн даатгалын шимтгэл заавал төлөх үүрэгтэй байхаар тусгасан байна⁷. Үүнд:

- Төрийн үйлдвэрийн газар
- Улс, орон нутгийн төсвөөр санхүүждэг байгууллага
- Олон нийтийн болон шашны байгууллага
- Хоршоолол, хувийн үйлдвэрийн газар, пүүс
- БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хувь нийлүүлсэн болон БНМАУ-ын хуулийн этгээдийн

7 Төрийн мэдээлэл сэтгүүл. 1991. №3. 209 дэх тал

- эрх бүхий гадаадын үйлдвэрийн газар, байгууллага
- БНМАУ-ын иргэнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байгаа гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүмүүс.

Мөн хуулиар хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэн өөрөө хүсвэл сайн дурын үндсэн дээр тогтоосон хувь хэмжээгээр шимтгэл төлж улсын нийгмийн даатгалд хамрагдах боломжийг бий болгосон.

1993 онд Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийг баталж, иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу даатгалын хураамж төлж, даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, даатгуулагчийг хэвтэн эмчлүүлэхэд гарах эмчилгээ, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлөх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Ардчилсан Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурласан нийгмийн хамгааллын бодлого

Монгол Улс өдгөө дагаж мөрдөж буй Үндсэн хуульдаа иргэний баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг тунхаглахдаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах; эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах; өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах; хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах болон нийгмийн бусад хүрээний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхээр заасан байдаг. Тодруулбал, Үндсэн хуульд заасан иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх буюу 16 дугаар зүйлийн 5 дахь заалтад “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” хэмээн заасан нь нийгмийн хамгаалалд хамаарах үндсэн зохицуулалт болсон юм.

1994-1995 онд Монгол Улсад нийгмийн хамгааллын шинэ тогтолцоо бүрдэхэд нөлөөлсөн эрх зүйн хэм хэмжээний актуудыг батлан гаргасан байна. Ялангуяа, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн багц хуулиудыг

батлан гаргасан нь нийгмийн хамгааллын харилцааг шинэ түвшинд гаргаж, нийгмийн гишүүдийг эдийн засгийн идэвхитэй хүн ам, тусламж дэмжлэг хүртэгсэд гэж ангилан тус бүрт нь тохирсон нийгмийн хамгааллын арга механизмыг бүрдүүлж, нийгмийн даатгал болон нийгмийн халамж гэсэн 2 үндсэн төрөл бий болжээ.

Нийгмийн даатгалын багц хуулиуд 1994 онд батлагдсан. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай
- Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай
- Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулиуд багтаж байна.

Эдгээр багц хуульд тодорхой хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн ба одоог хүртэл хүчин төгөлдөр, тогтвортойгоор үйлчилж байна.

Нийгмийн халамжийн багц хуулиудыг 1995 онд баталсан. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай хууль
- Нийгмийн халамжийн сангаас хүн амын эмзэг хэсэгт төрөөс үзүүлэх нийгмийн ба асрамжийн үйлчилгээний тухай хууль
- Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Тахир дутуу хүний нийгмийн хамгаалал, түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай хуулиуд багтаж байна.

Эдгээр багц хуулийг баталснаас нь хойш хэд хэдэн удаа шинэчлэн найруулжээ. Тухайлбал, Нийгмийн халамжийн хуулийг 3 дахь удаагаа шинэчлэн баталсан бол ахмад настны нийгмийн халамжийн чиглэлийн бие даасан хуулийг ч мөн төдий хэмжээнд шинэчлэн найруулж батлаад байна.

Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн багц хуулиудыг баталсан нь төрөөс зайлшгүй дэмжлэг тусалцаа үзүүлбэл зохих иргэдийн ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхийг⁸ хангаж, хамгаалах нийгмийн хамгааллын тогтолцоог олон улсын хэм хэмжээ, зарчимд нийцүүлэх томоохон алхам болсон байна.

Дээрх эрх зүйн орчны дорвитой, цогц өөрчлөлт шинэчлэл нь зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, ардчилсан нийгмийн суурь зарчимд нийцсэн нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Өдгөө ч нийгмийн хөгжлийн чиг хандлагыг дагаж нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомжийг өөрчлөх, шинэчлэх үйл явц тасралтгүй үргэлжилсээр байгаа билээ.

Нийгмийн даатгалын тухай хуулийг 1994 оноос батлан хэрэгжүүлж байна. Иргэн нь өөрийн хөдөлмөрөөр амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх боломж нөхцөл хязгаарлагдсан үед тэдэнд тогтмол хугацаанд зохих хэмжээний дэмжлэг үзүүлэх, эд мөнгөний тусламж өгөх нь төрийн нэгэн чиг үүрэг мөн. Өөрөөр хэлбэл, ахмад настныг орлогын баталгаагаар хангагдаж, ядууралд өртөхгүйгээр амьдрах бололцоог төрөөс бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэ утгаараа нийгмийн хамгааллын үйл ажиллагааны гол төрөлд өндөр насны тэтгэвэр зүй ёсоор хамаарна.

Өндөр насны тэтгэвэр нь сар бүр авч байсан цалин хөлстэй нь дүйцүүлэн, шимтгэл төлсөн хугацааг нь харгалзан

8 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/А/III тогтоолоор батлагдсан Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйл

нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас насан туршид нь олгож байгаа мөнгөн хөрөнгө юм⁹. Монгол Улсын хувьд ахмад настны тэтгэврийн даатгал нь нийгмийн хамгааллын үндсэн арга хэмжээ мөн. Нийгмийн даатгалын багц хууль батлагдахаас өмнө манай улс цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо буюу дахин хуваарилах аргаар тэтгэврийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлдэг байсан бол багц хууль батлагдсанаар тэтгэврийн тогтолцоогоо шимтгэл төлдөг даатгалын зарчмаар шинэчилж, нийгмийн хамгааллын эх үүсвэрийг баталгаатай болгох зорилгоор бие даасан 5 сан байгуулж, санхүүжилтийг тодорхойлсон байна. Мөн заавал даатгуулагчийн шимтгэл төлөх үүрэг, хувь хэмжээг тусгасан байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад өндөр насны тэтгэврийн даатгалын сангийн эх үүсвэр нь удаан хугацаанд, олон иргэдийг хамарч нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлдэг тул эрсдэлтэй нөхцөл байдалд орох болсон тул тус санг тогтвортой, баталгаатай байлгахын тулд Нийгмийн даатгалын тухай хуульд 1999 онд нэмэлт өөрчлөлт оруулж, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг тус тус батлан гаргажээ.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль нь тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтоон олгох буюу даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хуримтлал үүсгэн өсгөх (хүү тооцох), тэтгэвэрт гарах эрх үүссэн үеэс буцаан авах боломжийг бүрдүүлсэн.

Тус хуульд 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данстай байхаар зааж, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих анхны

9 Ц.Давхарбаяр, Г.Жаргал. Нийгмийн хамгааллын эрх зүй. УБ. 2010. 90 дэх тал

оролдлогыг хийсэн нь онцлох дэвшилттэй алхам болсон юм. Нэрийн дансны хуримтлалаас хүү тооцох, өндөр насны тэтгэвэр тогтоолгоход сонголт хийх эрх зэрэг олон чухал зохицуулалтыг оруулсан. Гэвч хууль нь нийгмийн даатгалын сангийн мөнгөн хуримтлал хангалтгүйгээс шалтгаалж хэрэгжээгүй. Энэ талаар олон судалгаа, баримт, мэдээлэл бий.

Нийгмийн халамжийн хүрээний бодлого, хууль, эрх зүйн орчны талаар товчхон авч үзье.

Хүн бүр байгалиас тэгш бус байдгийг хүлээн зөвшөөрч хүнлэг ёсыг төлөвшүүлэх нь ардчилсан нийгмийн чухал үнэт зүйлсийн нэг юм. Социалист орнуудад халамжийн эрх хэмээх ойлголт байгаагүй бөгөөд энэ нь барууны капитализмын хүрээнд бий болсон хүчин зүйл¹⁰ хэмээн судлаачид тэмдэглэдэг. Манай улс 1995 онд Нийгмийн халамжийн тухай бие даасан хууль баталж, тус хэм хэмжээнд ахмад настан нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авах эрхийг хуульчилж, хувь хэмжээг тогтоосон. Энэ хуулийг 1995 онд баталснаас хойш 1998, 2005, 2012 онуудад шинэчлэн баталж, хэрэгжүүлж байна.

2012 онд шинэчлэн баталсан Нийгмийн халамжийн тухай хуульд нийгмийн халамжийн үйл ажиллагааг:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр
2. Нийгмийн халамжийн тэтгэмж
3. Нийгмийн халамжийн үйлчилгээ
4. Нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн 4 төрөлтэй байхаар тусгаж, үүнд ахмад настанд чиглэсэн үйл ажиллагааг дараах байдлаар заажээ.

Өмнөх хуулиудын адилаар нийгмийн халамжийн сангаас ахмад настан тэтгэвэр авах эрхийг хадгалсан бөгөөд ингэхдээ нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх

10 Jon Elster, *C.O. Institutional Design in Post-communist Societies Rebuilding the Ship at sea*. Cambridge: Cambridge University Press. 1998

үүсээгүй эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэнийг хамруулахаар заасан нь өмнөх хуулиудад байсан “тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангийн хүнгүй” гэснийг хасчээ. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настанг гэр бүлдээ авч асрамжилж байгаа, мөн эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настанг асарч байгаа иргэнд нийгмийн халамжийн тэтгэмж олгох өмнөх хуулийн зохицуулалт хэвээр хадгалагджээ. Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл нь мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэсэн 2 төрөлтэй байх өмнөх хуулийн зохицуулалт хэвээр хадгалагджээ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно. Харин төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэж асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах ажиллагаа хамаарах юм. Эдгээр үйлчилгээд ахмад настны хамрагдах боломжийг хуульчилсан байна.

2012 оны Нийгмийн халамжийн тухай хуулийн онцлог зохицуулалтын нэг нь халамжийн үйл ажиллагаанд “нийгмийн хөгжлийн үйлчилгээ”¹¹ гэсэн төрлийг 1 бүлэг болгон шинээр оруулж, тус бүлэгт:

- Боловсролыг дэмжих
- Эрүүл мэндийг дэмжих
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх гэсэн 3 төрлийн үйлчилгээний хэлбэрийг тусгасан явдал байв.

11 2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар бүлэг

Халамжийн үйлчилгээнд зайлшгүй хамрагдах шаардлагатай ахмад настны асрамжид байдаг хүүхэд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт эдлэх, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай ахмад настанд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ буюу хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох, халуун хоол, цайгаар үйлчлэх гэсэн үйлчилгээнд хамрагдахаар заасан нь шинэлэг зохицуулалтууд болжээ.

1990 онд хийсэн нийгмийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд Үндсэн хуульт ёсны чухал үнэт зүйлийн нэг болох хүн бүр байгалиас тэгш бус байдгийг хүлээн зөвшөөрч хүнлэг ёсыг төлөвшүүлэхийг эрмэлзэн хүн амын шаардлагатай хэсэгт нийгмийн халамжийн бодлого тодорхойлж, олон хууль тогтоомж баталж, шинэчилж сайжруулсаар ирсэн байна. Нийгмийн даатгалын тухай хуулийг 1994 онд, Нийгмийн халамжийн хуулийг 1995, 1998, 2005, 2012 онуудад шинэчлэн баталж, нийгмийн халамжийн сангаас олгох өндөр насны тэтгэвэр болоод халамжийн болон асрамжийн үйлчилгээний үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн нь хөдөлмөрийн чадвар буурах, өвдөх болон нийгмийн бусад эрдэлд өртөх үед энэ эрсдлийг бууруулах, зайлшгүй нийгмийн халамж шаардлагатай бүлгийн наад захын амьдралын хэрэгцээг хангахад чиглэсэн суурь хэм хэмжээ болж байна.

4. Нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, зорилт

Монгол Улсын өнгөрсөн 30 жилийн туршлагад үндэслэн ирэх 30 жилийн хөгжлийг тодорхойлсон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг Засгийн газраас өргөн мэдүүлсэнийг Улсын Их Хурлаар хэлэлцэн 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталлаа. Энэ хөгжлийн бодлогын баримт бичиг нь 3 үе шаттайгаар, 30 жилийн хугацаанд хэрэгжих 9 зорилго, 47 зорилтоос бүрдэх ба

“Хүний хөгжил” зорилгын хүрээнд ахмад настанд чиглэсэн дараах зорилт, хүрэх үр дүнг тусгасан байна.

“Эрүүл мэнд” зорилтын хүрээнд Монгол Улс 2050 он гэхэд “Эрүүл насжилтаар бүсийн хэмжээнд тэргүүлэх 10 орны нэг болж, хувь хүний ген, хоол тэжээлийн болон эрүүл мэндийн онцлогт чиглэсэн хиймэл оюун ухаанд тулгуурласан үйлчилгээ нэвтэрнэ” гэсэн зорилт тавьжээ. Энэ зорилтод эрүүл насжилтыг чухалчилж байгаа нь ахмад настны эрүүл мэндийн үзлэг, эмнэлэгийн үйлчилгээний хүртээмж, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэхүйц ахиц гаргахыг зорьжээ.

“Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл” зорилтын хүрээнд 2030 он гэхэд “Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ”, “Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.”, “Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно” гэсэн зорилтууд тусгагджээ. Хүн амын бүлгүүд, хүн амын эмзэг бүлэг, зорилтот бүлэг гэдэгт ахмад настан хамрагдах бөгөөд тэдгээрт чиглэсэн нийгмийн халамж үйлчилгээг тэдний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх ажээ. Энэ зорилтын 2 дугаар үе шатны хүрээнд 2040 он гэхэд “Зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээ, орон нутгийн онцлогт нийцсэн халамжийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлсэн байна” гэсэн нь одоогийн нийгмийн халамж, дэмжлэгийг хүрэлцэхүйц хэмжээнд хүргэхээс гадна шинэ төрлийн үйлчилгээг судлан хэрэгжүүлэх ажээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ахмад настны нийгмийн хамгаалал, тэтгэвэр, тэтгэмжийн талаар шууд зааж тусгасан дараах зорилтуудыг тусгажээ. Тухайлбал, 2030 он гэхэд тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байх бол 2040 онд тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд

хэсэгчлэн шилжиж, 2050 онд бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлэх, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгох, тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын орлогын өгөөж болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлдэг болох зорилтууд тусгагджээ.

Мөн 2040 он гэхэд ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулсан байх зорилт тусгагдсан байна.

Ашигласан ном, зохиол

1. Ж.Амарсанаа Монгол улсын Үндсэн хуулийн товчоо. УБ., 2012
2. БМНАУ-ын Хөдөлмөр нийгэм халамжийн Улсын хорооны мэдээлэл. 1978. №1
3. Ж.Давхарбаяр, Г.Жаргал Нийгмийн хамгааллын эрх зүй. УБ, 2010
4. В.Инжинаши, Хөх судар. УБ, 2006
5. Б.Наранцэцэг нар, Өндөр настны тэтгэвэрийн тогтолцооны өнөөгийн байдал. УБ, 2019
6. Г.Өнөрцэцэг, Ж.Дагвадорж, Нийгмийн удирдлагын онол арга зүйн асуудлууд.
7. Jon Elster , С.О. Justitutional Design in Post-Communist Societies. Cambrdge . 1998

6

Зургаадугаар бүлэг. Олон улсын харилцаа олон өнгө, төрхтэй шинжлэх ухаан болох нь

Судлаач Н.Соёлгэрэл

Олон улсын харилцаа бол улс төрийн шинжлэх ухааны салбарт хамаарагддаг нэг үндсэн чиглэл мөн билээ. Олон улсын харилцааны ахисан түвший судалгааны аргазүй нь улс төрийн шинжлэх ухааны категориудад тулгуурлана. Категори (category) буюу (ай) нь үнэн байдал болон олон улсын харилцааны танин мэдэхүйн үзэгдэл, юмсын хамгийн ерөнхий, хамгийн гол шинж, тал, харилцааг тусгасан үндсэн ойлголтыг илэрхийлнэ¹.

Олон улсын харилцаа хэмээх нэр томъёо нь анх XVIII-XIX зууны үед бүрэн эрхт төрт улсуудын систем бий болсноор анх үүссэн гэж үздэг. Орчин үеийн дэлхийн улс төрийн үндсэн зарчмыг 30 жилийн дайны дараа 1648 онд “Вестфалийн олон улсын харилцааны систем” тавьсан юм. Энэ үед Европт үндэстэн-улсууд үндсэндээ бүрэлдсэн. Дэлхий аж үйлдвэрийн хөгжлийн замд орсноор хатуу төвлөрсөн засаглалтай улс үндэстэн буй болсон юм. Энэ үеэс Европын түүх дэлхийд шинэ үеийг эхлүүлсэн.

Европ дахь хүчний гол төвүүд нь Испани, Португали, Голланд болж дараа нь Англи, Франц, Швед дэлхийг хуваахын төлөө тэмцэлд орсон. Үүсч бүрэлдсэн үндэстэн-улсууд өөрийнхөө хилийг хэлний шинж болон байгаль газарзүйн заагийг тооцож тогтоосон. Ийм дэлхийн дэг журам Наполеоны хаанчлал ба Консулын алба, эрх мэдэлтнүүдийг сольсон Францын хувьсгал хүртэл 150 жил туршид оршин тогтносон.

XVII-XVIII зуунд Европт нийгмийн шинэ хүч - хөрөнгөтөн үүссэн. Хаант засаглалыг түлхэн унагахын төлөөх Францын хувьсгал дэлхийд ноёрхлоо тогтоохыг оролдсон Наполеоны

¹ Д.Уламбаяр “Олон улсын харилцааны ахисан түвшний судалгааны онол-аргазүйн зарим асуудал” Олон Улс Судлал №1, 2015 он: 5-22 хуудас

засаглалд хүргэсэн юм. Гэвч Наполеон Францыг олон улсын харилцааны хүчний төв болгож чадсангүй. Английн эвслийг цэрэг, эдийн засаг, улс төр болон бусад арга хэмжээгээр боомилох гэсэн Наполеоны бодлого амжилтгүй болж, Оросыг татан оруулсан юм. Прусс, Австри түүнд тодорхой тусламж үзүүлснээр Наполеон гутамшигтайгаар ялагдав.

Геополитикийн хүчний шинэ хуваарилалт 1814-1815 оны Венийн их хурлаар бэхжиж, “Венийн систем” гэж нэрлэгдсэн олон улсын харилцааны шинэ дэг журам бүрэлдлээ. Түүний зохион байгуулалтын үндэс нь газарзүйн орон зайг хянах эзэнт гүрний зарчим байв. Дэлхийн хүчний төвүүд нь Орос, Австри-Унгар, Британийн колонит гүрэн (1876 онд ингэж тунхагласан), Герман (1871 оноос) ба хэрэг дээрээ XIX зууны дундаас колонийн гүрэн болсон Франц (БНУ-ын хэлбэрээр үлдсэн) байв. 1877 оноос Туркийн султан “Османы эзэн хаан” цолтой болсон. Турк Ойрхи дорнод ба Зүүн өмнөд Европт чухал үүрэг гүйцэтгэж байв. Орос XIX зууны дунд хүртэл Европт зонхилж, Англи, Австри, Франц Туркийн эсрэг идэвхтэй зогсож байв. 1853-1856 оны Крымийн дайны үед үнэн хэрэгтэй бүх Европ Оросын эсрэг боссон байлаа. Крымийн дайнд Орос ялагдсаны дараа Венийн систем зарим өөрчлөлтөнд оров. Оросын хувьд бодит тусламжаас илүү тээр дараа болж байсан хаадын “Ариун холбоо” задарч түүний сүйрлээр Европ дахь Оросын ноёрхлын үе төгсч, улс оронд ямар ч тус нэмэр авчирсангүй.

Аж үйлдвэрийн хувьсгалын ололтыг XIX зууны эцэст амжилттай хэрэглэснээр ялангуяа АНУ, Герман хүчирхэгжив. Америкчууд удам эх газартаа эзэн болж Куба, Филиппинээс Испанийг хөөж, тэнгис орчмын зах зээлийг идэвхтэй. эзэмшлээ. Герман “төмөр канцлер” Отто Бисмаркийн удирдлагаар Герман, Австри-Унгар, Итали гурав “Гурвын холбоо” байгуулсан. Өөр хүчирхэг цэргийн бүлэглэл “Антант”-ыг Англи, Франц, Орос гурав байгуулав.

Бүлэглэлүүдийн зорилго нь Европын шинээр хүчирхэгжсэн улсуудыг нөлөөллийн хүрээ тогтоохыг хүлээн зөвшөөрөхгүй

байх явдал байсан юм. 1914-1918 оны дэлхийн I дайнд “Гурвын холбоо” ялагдсаны дараа “Версалийн үе” эхэлсэн.

Дэлхийн I дайнд бүхнээс илүү АНУ завшсан юм. 1922 оны Вашингтоны бага хурлаар АНУ хүчээ харуулж, Англитай тэнгисийн цэргийн флотоор тэнцүү эрхтэй болж, далайн уудмыг хянаж болох, далайн чухал холбоо харилцааг хянах боломжийг АНУ-д олгосон. Ялагч орнуудын санаачилгаар, Герман ба Зөвлөлт Орос хоёрын хооронд Англи, Францын хяналтан дорх “буфер” буюу жижиг улсуудыг байгуулжээ. Ингэж эх газрын хоёр их гүрнийг шууд харилцах боломжгүй болгож бие биеээс нь тусгаарласан юм. Дэлхийн дэг журам тогтоох нь Зөвлөлт Орос, Герман, Хятадын эсрэг чиглэгдэж байв.

Дэлхийн II дайн олон улсын харилцааны “Версалийн систем”-д цэг тавив. ЗХУ энэ дайны хүндийг үүрч, хүн ам, эд материалын асар их хохирол амссан боловч дайны өмнөхөөс илүү цэрэг стратегийн хувьд бэхжин дайнаас гарч чадлаа. Орос өөрийгөө тойруулан хүчирхэг геополитикийн бүлэглэл байгуулав.

1945 онд Герман, түүний холбоотныг ялсны дараа Европт үүссэн шинэ хүчний тэнцвэрийг тэмдэглэж Берлинээс холгүй орших жижиг хотод Потсдамын системийн гэрээнд гарын үсэг зурснаар “Потсдамын үе” эхэлсэн. Энэ нь үнэн хэрэгтээ дэлхий ЗХУ болон АНУ гэсэн хоёр туйлд шилжсэнийг хуульчлан батлав.

Эдгээр туйлын эсрэг тэсрэг байдал нь олон улсын харилцааны Потсдамын үеийн агуулгыг тодорхойлдог. Түүний шинж төрх нь эсрэг зогссон хоёр хүчирхэг бүлэглэл, хүйтэн болон цөмийн дайны хоорондох хүчний тэнцвэрийн онолоор тодорхойлогдож байв. ЗХУ-ын эдийн засаг шинжлэх ухаан техникийн хувьсгалын шинэхэн ололтыг бага хүлээн авч, ЗХУ-ын улстөрийн удирдагчид улсынхаа технологийг шинэчлэх нь зайлшгүй болохыг ухамсарлаагүйгээс Потсдамын дэлхийн дэг журам 1992 онд ЗХУ задарснаар дэлхийн хоёр туйлт бүтэц бутарсан юм.

Хүйтэн дайны төгсгөлд ЗХУ задран унаснаар дэлхийн II дайны дараа үүссэн олон улсын харилцааны хоёр туйлт систем төгсгөл болж, дэлхийн шинэ дэг журам бүрэлдэх үйл явц эхэлсэн. Тэр үеэс өнөөг хүртэлх хугацаанд олон улсын харилцаанд “нэг туйлт систем” бий болоод байгаа хэмээн судлаачид дүгнэдэг. Олон улсын харилцаанд манлайлагч их гүрэн болох АНУ болон бусад гүрний хоорондын ялгаа их байснаас 1990-ээд оны сүүл үеийн олон улсын харилцааг үндсэндээ “нэг туйлт” хэмээн тодорхойлдог.

Дэн Сяопины эхлүүлсэн “нээлттэй бодлого”-ын үр дүнд БНХАУ-ын эдийн засаг хурдтай өсч, дэлхийн 2 дахь том эдийн засаг болж олон улсын харилцаан дахь хүч, нөлөө нь нэмэгдсэн. АНУ-ын ашиг сонирхол нь Ази-Номхон далайн бүсэд Вашингтоныг сорих, цаашлаад үндэсний аюулгүй байдалд нь аюул учруулах ямарваа нэг улс гүрэн гарч ирэхээс сэргийлэхэд оршдог² бөгөөд энэ ашиг сонирхлыг нь Хятадын “өсөлт” хөндөж буй нь нууц биш юм. АНУ-ын Ерөнхийлөгчийн Хятадтай эхлүүлсэн “худалдааны дайн” улам хурцдаж, “технологийн дайн” болж өргөжсөн төдийгүй Япон, Энэтхэг, Австрали зэрэг холбоотон, түншийнхээ тусламжтайгаар “дөрвөн талт”, “гурван талт” зэрэг механизмын хүрээнд Хятадын нөлөөг “тогтоон барих” бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж байна.

Дэлхийн I дайны дараа дахин ийм хэмжээний томоохон дайныг гаргуулахгүй байх зорилгоор “Үндэстнүүдийн холбоо”-г байгуулсан боловч энэхүү олон үндэстний байгууллагыг үндэслэгч АНУ-ын Ерөнхийлөгч Вүдро Вильсоны дэвшүүлсэн энэхүү санаачилгыг АНУ-ын Конгресс дэмжээгүйн зэрэгцээ ЗХУ гадна үлдсэн нь тус байгууллагын хувь заяанд сөргөөр нөлөөлсөн билээ. Улмаар их гүрнүүд дэлхийн II дайнаас сэргийлж чадсангүй. Дайнд ялсан холбоотнууд олон улсын эрх зүй, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, нийгмийн асуудлууд болон хүний эрхийн талаар хамтран ажиллах зорилгоор 1945 оны 10 дугаар

2 *Jing-dong Yuan, "Friend or Foe: The Bush Administration and U.S. China Policy in Transition", East Asian Review Vol. 15, No. 3 (Autumn 2003): 44-45*

сарын 24-ний өдөр Нэгдсэн Үндэстний байгууллагын үндэс суурийг АНУ-ын Сан-Франциско хотод тавьсан билээ. Өнөөдөр тус байгууллагад 193 улс гишүүнээр элсээд байгаа бөгөөд бүгд Ерөнхий Ассамблейд ордог юм. Харин НҮБ-ын 6 гол байгууллагын нэг нь болох Аюулгүйн Зөвлөлд 5 байнгын, 10 байнгын бус гишүүн орон багтдаг бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд өрнөж буй шинэчлэлийн талаарх асуудлын гол шалтгаануудын нэг нь болж байна.

Өнөөдөр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл геополитикийн хувьд өнөө үеийн дэлхийн бодит байдалд нийцэхгүй байгаа гэж олон улсууд үзэж байна. Жишээлбэл, Латин Америк болон Африкийн бүсүүд ямар ч төлөөлөлгүй байгаа. Тиймээс Аюулгүйн Зөвлөлд шинэчлэл хийх шаардлагатай хэмээн цөөнгүй улс үзэж байгаа юм. Шинэчлэлийг гишүүнчлэл, ажлын арга барил болон ил тод байдал, хориг тавих гэсэн асуудлуудтай холбож байна. 1993 оноос эхлэн Ерөнхий Ассамблей тус шинэчлэлийн талаар ярьж эхэлсэн бөгөөд олон төрлийн хувилбаруудыг санал болгож, хэд хэдэн улс байнгын төлөөлөгчдийн суудалд нэрээ дэвшүүлсэн байна. Гэвч энэхүү асуудал нь тийм ч амар шийдэгдэхгүй байгаа бөгөөд өнөөг хүртэл эцсийн шийдвэр гараагүй байгаа билээ.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын болон байнгын бус гишүүний тоог тэгш, шударга үндсэн дээр өргөтгөх, ингэхдээ, байнгын болон байнгын бус гишүүдийн тоог нэмэгдүүлж, хөгжиж буй болон хөгжингүй орнуудын төлөөллийг зохих ёсоор хангах, ажлын арга барилыг өөрчлөх, АЗ болон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хоорондын харилцаатай холбоотой өөрчлөлт хийх шаардлагатай байна.

НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүдийн тоо нэмэгдүүлэх саналыг Бразил, ХБНГУ, Энэтхэг, Японы зүгээс тавьж, G4 хэмээх бүлгийг байгуулан ажиллаж байна. АЗ-ийн одоогийн байнгын гишүүд болох АНУ, Их Британи, ОХУ, Францын зүгээс дээр дурдсан орнуудын хүчин чармайлтыг дэмжиж

байгаагаа илэрхийлсэн³ боловч бусад орны эсэргүүцэлтэй тулгараад байна. Тухайлбал, Пакистан улс БНЭУ-ыг АЗ-ийн байнгын гишүүн болохыг эсэргүүцэж байгаа бол Итали, Испани улс ХБНГУ-ыг, Мексик, Аргентин, Колумб Бразилийг, БНСУ Японыг тус тус эсэргүүцэж байгаа юм.

НҮБ-ын АЗ-ийг шинэчлэх сонирхол өнөөгийн АЗ-ийн байнгын гишүүдэд байхгүй төдийгүй энэ асуудлаар хоорондоо зөрчилдөж байна. Энэ тухайд, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутереш “Өнөөгийн АЗ нь өнөөдөр бүрэлдэн тогтсон дэлхий ертөнцийн нөхцөл байдалтай нийцэхгүй байна. Миний бие энэ талаар нухацтай яриа хэлэлцээ өрнүүлэхийг гишүүн орнуудад уриалсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр энэ асуудлыг хөндөхийг миний зүгээс хүсч байгаа хэдий ч байнгын гишүүд санал нийлэхгүй хэвээр байна”⁴ гэжээ.

НҮБ-ын Дүрмийн V бүлгийн хүрээнд АЗ-ийн байнгын гишүүдэд олгосон “вето эрх” нь НҮБ-ын олон улсын хямрал, мөргөлдөөнийг шийдвэрлэхэд үр дүнтэй арга хэмжээ авахад гол тээг болдог хэмээн судлаачид үздэг. Жишээ дурдахад, 1968 онд Варшавын гэрээний 4 улс Чехословакт цэргийн хүч хэрэглэсэн асуудал, Вьетнамын дайн, ЗХУ-ын Афганистанд явуулсан дайн асуудлаар НҮБ-ын АЗ-өөс тогтоол гаргаагүй нь АЗ-ийн байнгын гишүүдийн вето эрхээс шалтгаалсан юм.

АЗ-ын байнгын гишүүдийн олон улсын зөрчил, маргаантай асуудлаар илэрхийлж буй байр суурийг авч үзвэл, тэдний хооронд илт хуваагдал үүссэнийг харж болно. АЗ-ийн хүрээнд ОХУ, БНХАУ нь байр сууриа уялдуулан ажиллаж байна. Тухайлбал, Иранд хориг тавих асуудлыг ОХУ эсэргүүцсэнтэй нэгэн адил байр суурийг БНХАУ баримталж байсан бол Ливийн асуудлаарх санал хураалтад ОХУ түдгэлзсэн бол БНХАУ мөн адил үйлдэл хийсэн.⁵ ОХУ-аас

3 VOA “UN Security Council Reform May Shadow Annan’s Legacy” (Nov 1, 2006) <https://web.archive.org/web/20061102142909/http://voanews.com/english/2006-11-01-voa46.cfm>

4 CNN Brazil “Secretário-geral da ONU diz que Covid-19 deixou o mundo de joelhos” <https://www.cnnbrasil.com.br/internacional/secretario-geral-da-onu-diz-que-a-covid-19-deixou-o-mundo-de-joelhos/>

5 Василий Кашиш “Выйти из тени” Россия в глобальной политике №2 2012 Марта/ Апрель <https://globalaffairs.ru/articles/vyiti-iz-teni/>

Сирийн асуудлаар нэгдмэл байр суурийг илэрхийлэх шахалт БНХАУ-ын дипломатуудад үзүүлсэн байх талтай хэмээн үздэг⁶. Түүнчлэн, Сирид хориг тавих асуудлаар ОХУ, БНХАУ-ын аль аль нь эсэргүүцсэн байр суурьтай байсан юм. Нөгөө талд нь, Өрнөдийн гэгддэг АНУ, Их Британи болон Франц байр сууриа нэгтгэж байна.

Колумбын их сургуулийн тодорхойлолтоор, олон улсын харилцааг олон улсын аюулгүй байдал (дайн, мөргөлдөөн, энх тайван гэх мэт асуудлууд) болон олон улсын эдийн засаг (худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын санхүү гэх мэт) гэсэн хоёр үндсэн салбарт хуваагддаг⁷.

Олон улсын аюулгүй байдал судлал: Олон улсын харилцааны шинжлэх ухааны нэг бүрэлдэхүүн хэсэг нь олон улсын аюулгүй байдал судлал юм. Олон улсын аюулгүй байдал судлалын эхлэл нь дэлхийн I дайны дараа тавигдсан. Дэлхийн I дайны аюул гамшгийг дахин давтахгүй байх гэсэн хүсэл эрмэлзлийн улмаас олон улсын харилцаа нь түүх, газар зүй, олон улсын эрх зүйгээс ялгагдах зорилгоор олон улсын аюулгүй байдал хэмээх шинэ судлагдахууныг 1919 онд бий болгосон. Олон улсын аюулгүй байдал нь “хүйтэн дайн”-аас өмнө цэрэг, дайн буюу уламжлалт аюулгүй байдлын асуудлуудыг судалдаг байсан бол 1990-ээд оноос шинээр гарч ирсэн аюул заналуудад анхаарах болсон. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдал судлалын шинэ параметер нь даяаршил, аюул судлал, хүний аюулгүй байдал болон аюулгүй байдалжуулалтад төвлөрч байна.

Уламжлалт бус аюулгүй байдлын асуудлууд нь ихээхэн өргөн хүрээг хамардаг. Эдгээрээс заримыг нь жишээ болгон дурдъя.

Уур амьсгалын өөрчлөлт: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дэлхий дулаарч байгаа нь хүн, амьтан, ургамлын амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлж байна. Уур амьсгалын

6 *‘With Rare Double UN Veto on Syria, Russia and China Try to Shield Friend’* <http://www.heraldtribune.com/article/20111005/ZNYT03/110053039?p=4&tc=pg>

7 *Columbia University “International Relations”* <https://polisci.columbia.edu/content/international-relations>

өөрчлөлтийг өдөөгч гол шалтгаан нь нүүрс хүчлийн давхар ислийн ялгаралт юм. Үр дүнд нь, өнөөдөр дэлхий 1800-аад оны сүүлээс 1.1°C орчим хэмээр дулаарсан байна. Сүүлийн 10 жил (2011-2020) түүхэн дэх хамгийн дулаарсан он жилүүд байв.

Дэлхийн дулаарлын дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад хоёр хэмээс хэтрүүлэхгүй байж чадсан цагт дэлхийн дулаарлаас үүдэх ирээдүйн гамшигт үр дагавраас зайлсхийх боломж нээгдэнэ. Уг зорилтыг 2015 оны Парисын хэлэлцээрт тусган, дэлхийн дулаарлыг 1.5 хэмд хязгаарлах амлалтыг дэвшүүлсэн түүхэн ач холбогдол бүхий олон улсын гэрээ, хэлэлцээр юм.

2015 оны Парисын хэлэлцээрт нийцүүлэн, “цэвэр тэг” болгох зорилтыг тавьсан орнууд цөөнгүй байна. Жишээ дурдвал, Их Британийн 2008 онд батласан Уур амьсгалын тухай хуулинд зааснаар, тус улс нь 2050 онд нүүрстөрөгчийн давхар ислийн 1990 оны хэмжээнээс 100 хувь бага болгох зорилт тавьж, улмаар энэ зорилтоо 2019 онд шинэчилж, 2050 онд “цэвэр тэг” болгох зорилт дэвшүүлсэн нь хөгжингүй орнууд дундаа анхдагч болсон. Герман, Франц, Испани, Норвеги, Дани, Швейцарь, Португал, Шинэ Зеланд, Чили, Коста Риста зэрэг улсууд 2050 он гэхэд, Швед 2045 онд, Исланд, Австри 2040 онд, Финланд 2035 онд “цэвэр тэг” болгох зорилт” дэвшүүлээд байна. АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден 2050 он гэхэд тус улсад “нүүрстөрөгчийн саармаг байдал”-ыг бий болгох бол дэлхийн хоёрдахь том эдийн засаг болох БНХАУ нь 2060 он гэхэд энэ зорилтыг биелүүлэхээ амласан. Европын Холбоо нь 2050 он гэхэд “нүүрстөрөгчийн саармаг байдал”-д хүрэх амлалт авч, Европын уур амьсгалын тухай хуулийг баталж улс төрийн болон эрх зүйн хувьд амлалтаа баталгаажуулаад байна.

Үндэстэн дамнасан гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодис: Газар зүйн байршлын хувьд Төв Азийн бүс нутагт оршдог нь Монгол Улсыг уламжлалт бус зарим аюулд эмзэг,

мэдрэмтгий болгож байна. Төв Азийн бүс нутаг нь дэлхийн хамгийн том опиум, героин үйлдвэрлэгч Афганистантай хөрш зэргэлдээ оршдог төдийгүй хар тамхины дэлхийн хамгийн том хууль бус зах зээл болох Хятад, Орос, Европ руу хууль бус хар тамхи тээвэрлэх хамгийн тохиромжтой зам болдог нь санаа зовоосон асуудал болсоор ирсэн.

Дэлхийн опиумын үйлдвэрлэлийн 90 гаруй хувь, түүнээс гаргаж авсан героин нь Афганистанаас үүсэлтэй гэсэн НҮБ-ын судалгаа бий. Афганистанд опиумыг хууль бусаар тарьж ургуулдаг газрын хэмжээ Талибанчуудын дэглэм унаснаас хойш тогтмол нэмэгдсэн бөгөөд 2007 онд гэхэд 17%-иар нэмэгдэж, 193000 га-д хүрчээ. Опиумыг хөрш орнууд руугаа экспортлож 4 сая ам.долларын орлого олдог нь Афганистаны ДНБ-ий талаас илүү хувийг эзэлж байна.

Афганистанд тариалан боловсруулсан хар тамхины тал хувь нь Иран, Пакистанаар дамжиж, тал орчим хувь нь Төв Азийн улсуудаар дамжиж эргэлтэнд орж байв. Энэ нөхцөлд Иран улс хар тамхины хууль бус худалдаачидтай хатуу тэмцэж байсан учраас Төв Азийн улсуудаар ихэнх хэсгийг дамжуулан тээвэрлэх болсон. 2010 оны байдлаар үүний нөлөөгөөр хар тамхины хууль бус хэрэглээ Төв Азийн улсуудад бодит аюул занал болж хувирсан. НҮБ-ын үнэлгээгээр Казахстанд 165-186 мянган хүн, Кыргызэд 80-100 мянга, Тажикистанд 45-55 мянга, Узбекистанд 65-91 мянга, Туркменистанд ойролцоогоор 5 мянган хүн хар тамхинд донтсон гэсэн судалгаа бий.

Хүн худалдаалах гэмт хэрэг: НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Палермогийн протоколд тодорхойлсноор, “хүн худалдаалах” гэдэгт хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх эсвэл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан

ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсвэл өөр этгээдийг эрхэндээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх буюу ашиг олох зэрэг аргаар урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуух буюу хүлээж авах үйлдлийг ойлгодог. Монгол Улс тус протоколд 2008 онд нэгдэн орсон билээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтыг зорилго, үйлдэл, арга хэрэгслээр нь 3 үндсэн бүлэгт хуваан авч үзэж, бүх илрэлийг нь энэ гэмт хэрэгт хамруулдаг. Хүнийг мөлжих зорилгоор гэдэгт биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харьцаанд хүчээр оруулан мөлжих, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төстэй заншил хэрэглэх, эрх чөлөөгүй байлгах, эд эрхтнийг нь авах зэрэг үйлдлүүдийг “хүн худалдаалах гэмт хэрэг”-т хамруулан авч үздэг. Мөлжих зорилгоор хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд, охидыг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуух буюу хүлээж авах зэрэг үйлдлэл, үйл явцыг мөн хүн худалдаалах гэж үздэг.

Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж байгаа 10 хүн тутмын 1 нь хүчээр биеэ үнэлж, хохирогч болж байхад 9 нь хүчээр хөдөлмөр эрхэлдэг гэсэн тооцоог Олон улсын хөдөлмөрийн байгууллага гаргасан байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд тайлагнасанчлан хүн худалдаалах гэмт хэрэгтнүүд Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоод, гадаадын хохирогчдыг мөлжиж, мөн хилийн чанадад монголчуудыг мөлжлөгт оруулж байна. Гэмт этгээдүүд албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон гадаад иргэдийг Монгол Улсаар дамжуулан Орос, Хятад зэрэг улс руу худалдаалдаг байж болзошгүй байна.

Кибер гэмт хэрэг: Кибер гэмт хэргийг улсын эдийн засагтай зүйрлэвэл, 2021 онд дэлхийн хэмжээнд нийт 6 их наяд ам.долларын хохирол учруулснаас үзэхэд АНУ, Хятадын дараа орох дэлхийн 3 дахь том эдийн засаг болох байсан. Дэлхийн хэмжээнд кибер гэмт 2015 онд 3 их наяд ам.доллар хохирол учруулсан бол ирэх 5 жилийн хугацаанд жил бүр 15

хувиар нэмэгдэж, 2025 он гэхэд жилд 10.5 их наяд ам.долларт хүрнэ хэмээн Cyber security Ventures-ээс таамаглаж байна. Кибер гэмт хэрэг нь жил тутам байгалийн гамшгийн учруулсан хохиролоос илүү хохирол учруулж, инновац, хөрөнгө оруулалтад зарцуулах ёстой нөөц баялгийг хий дэмий үрэхийн зэрэгцээ гэмт хэрэгтнүүд мансууруулах бодисын худалдаанаас олох ашгаас илүүг олж байна⁸.

Хакерууд программын тусгай хангамжийг ашиглан мэдээллийн систем, харилцаа холбооны сүлжээг эвдэх, мэдээллийн баазыг устгахад голчлон анхаардаг. Энэхүү халдлагын нэг онцлог бол үйл ажиллагааны үр дүн нь гарахаас нааш харагдахгүйд оршдог юм. Пентагон, Цагаан ордон руу довтолсон томоохон хэмжээний кибер халдлагууд болсон. Их 20-ийн орнуудын тэргүүн нарын хувийн мэдээллийн баазыг эвдсэн, “Исламын улс”-ын Sony компанийн эсрэг довтолгоо хийж, J.P Morgan Chase банкны мэдээллийн баазыг устгасан зэрэг үйлдлийг дурдаж болох юм.

Олон улсын харилцаанд геополитик нь тухайн улсын гадаад бодлогыг ойлгох, газарзүйн өгөгдөлд тулгуурлан улс төрийн аливаа үйлдлийг нь тайлбарлах, урьдчилан таамаглах арга зүй бөгөөд газар зүйн өгөгдөл, орон зайн тухай уламжлалт ойлголтод эх газар, далай тэнгис, сансар огторгуй, цаашлаад цаг уур, байгалын баялаг, газар зүйн бусад онцлог багтдаг байсан. Улс орны гадаад бодлого, хоёр улсын харилцаа, түүнчлэн дайн тулаан дээр дурдсан газар зүйн өгөгдлөөс шууд болон шууд бус хамааралтай байсаар ирсэн.

Геополитик: Геополитик гэсэн ойлголт нь юуны өмнө ихээхэн өргөн хүрээгээр тайлбарлагдана. Энэ шинжлэх ухаан өөрийн хэлбэр төрх, шинж чанар байхгүй, түүний хил эдийн засаг, улстөр, цэрэг-стратегий, байгалийн нөөц, экологи ба олон улсын харилцаа, гадаад бодлого зэрэг салбаруудын судлах зүйлтэй холилдсон байдаг. Олон

8 Cybercrime Magazine “Boardroom Cybersecurity 2022 Report” (Aug 10, 2022) <https://cybersecurityventures.com/boardroom-cybersecurity-report/#:~:text=Cybercrime%20is%20predicted%20to%20cost,suite%20executives%20are%20paying%20attention>

судлаачид геополитикийг улсын стратегийн чадавхид их нөлөө үзүүлдэг, хоорондоо харилцан нөлөөлдөг, газарзүй, түүх, улс төрийн ба бусад хүчин зүйлсийг цогцолбороор судалдаг гэж үздэг.

Шведийн эрдэмтэн Рудольф Челлен (1864-1922) шинжлэх ухаанд анх “геополитик” гэсэн ойлголтыг оруулж ирсэн. Тэрээр энэ ухааныг “Улс орныг газарзүйн биет буюу орон зайн үзэгдэл гэж үзэх сургаал” гэж тодорхойлсон. Геополитик улсыг тогтвортой хувиршгүй байнгын зүйл биш, харин динамик хөдөлгөөнд оршдог амьд зүйл гэж үздэг. Ийм хандлагыг Германы онолч Фридрих Ратцель (1844-1904) санал болгосон.

Дэлхийн дэг журам өөрчлөхтэй зэрэгцэн геополитикийн тухай ойлголт өөрчлөгддөг. Түүхэн нөхцөл байдалд нь тохируулан геополитикийг ойлгох нь чухал. XX зууны эхэн үед Челлен болон бусад сэтгэгчид геополитикийг физик газарзүй болон улс төрийн шинжлэх ухааны хоорондын харилцаа холбоо судалдаг мэдлэгийн хэсэг хэмээн ойлгож байв.

Хэлфорд Маккиндер, Альфред Тайер Мэхэн, Николас Спайкман, Жеймс Бюрнхам нарын гаргасан онол, ойлголтууд нь геополитикийг алдартай болоход нөлөөлсөн. Тэд өнгөрсөн үйл явдал дээр тулгуурлан ирээдүйг таамаглаж чадснаараа геополитикийг ач холбогдолтой болгосон. Тухайлбал, 1920-аад оны эхэн үед болон 1943 онд Х.Маккиндер 1949 онд байгуулагдсан НАТО-гийн үүслийг тайлбарлаж чадсан. Ж.Бюрнхам 1940-аад оны сүүл болон 1950-аад оны эхээр Төв болон Зүүн Европт Зөвлөлтийн нөлөөг хязгаарлах стратегийг санал болгож, 1980-аад онд Рейганы засаг захиргааны амжилттай бодлогыг урьдчилан таамаглаж чадсан.

Геополитикийн үндсийг тавьсан анхны бүтээлүүдийг Германы газар зүй, улс төрийн шинжлэх ухааны профессор болох Фридрих Ратцель, Шведийн Рудольф Челлен нар туурвисан. XIX зууны сүүлийн хэдэн арван жилд газар,

колониудын хомсдол үүссэнтэй холбоотойгоор Европын улсууд тэлэх бодлого явуулах онолын үндсийг тавьсан.

Хэдийгээр Германд алдартай боловч РЧеллений улс төрийн үзэл нь Blut und Boden (Цус ба хөрс) гэх үндэсний нэгдлийг төдийлөн ойшоодоггүй харин олон соёлын нэгдэл болох Герман космополитан нэгдлийг илүүд үзэж, аажимдаа нэгдсэн төв удирдлага бүхий улс орнуудын эрх чөлөө, бие даасан байдлыг хүндэтгэдэг олон улс үндэстнүүдийн нэгдэл бий болгохыг дэмждэг байв. РЧеллений төсөөлж байсан тэрхүү нэгдэл нь Карл Шмидтийн хожим нь төсөөлж байсан Grossraum -тай ихээхэн төстэй бөгөөд дэлхийн II дайны дараа байгуулагдсан НАТО-тай практикийн хувьд төстэй. Карл Шмидттэй нэгэн адилаар, РЧеллен Эх газрын эсвэл үгүй ядахдаа Төв Европын хамгаалагч нь Герман улс байна гэдэгт итгэж байсан.

Фридрих Ратцель геополитик бие даасан шинжлэх ухаан болох эхлэлийг тавьжээ. Тэрээр улс орны шинж байдлыг судалсан. Улс орны органик өсөлтийн онолыг боловсруулжээ. Ингэхдээ улс орныг төрж, өсч бойжин, доройтон үхдэг биологийн амьд организмтай адилтган авч үзжээ. Ф.Ратцель аливаа соёл иргэншил буюу улс нь хүрээлэн буй орчин, хөрс, цаг уур, газар зүйн байршил зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан хөгжлийн янз бүрийн түвшинд оршдог хэмээн үзээд “улс орон бол хөрсөн дээр ургасан амьд биет” хэмээн дүгнэв. Улс орны мөн чанар, гол шинж нь түүний газар нутаг, газар зүйн байрлалаар тодорхойлогдох ба улс орон хөгжин цэцэглэх, хүчирхэгжих нь газар нутаг, түүний орчин нөхцөлд дасан зохицож, идээшин оршихоос хамаарна.

Альфред Мэхэн бол Америкийн тэнгисийн цэргийн офицер, түүхч байсан бөгөөд АНУ-ын Тэнгисийн цэргийн академийн профессороор ажиллаж байв. Зааж байсан лекцүүдээ нэгтгэн А.Мэхэн “Түүхэн дэх Тэнгисийн хүчний нөлөө, 1660-1783 он” нэртэй номоо 1890 онд хэвлүүлсэн. Энэ номонд, улс үндэсний түүхэн давамгайлалд нөлөөлөх тэнгисийн хүчний

тэргүүлэх ач холбогдлын талаар өгүүлсэн. Далай тэнгисийн хүч нь хуурай газрын хүчнээс илүү чухал хэмээн тэрээр номлож байв.

Хоёрдахь ном болох “Францын хувьсгал болон Эзэнт гүрэн дэх тэнгисийнх хүчний нөлөө, 1793–1812 он” цэрэг арми болон далайн худалдааны хяналтанд оруулахын хоорондын харилцан хамаарлыг онцолсон. Далайн тэнгисийн их гүрнүүд нь хуурай газрын их гүрнүүдээс илүү амжилттай байсан. Жишээ нь, Наполеоны үед Франц эцэстээ Их Британид ялагдсан. Далайн худалдааг хяналтанд оруулах нь дайны төгсгөлийг шийдвэрлэнэ гэж үзсэн байна.

Эдгээр 2 ном нь Их Британи, Германы бодлогод нөлөөлснөөр, тэд Дэлхийн I дайны өмнө нь тэнгисийн хүчээ нэмэгдүүлж, зузаатгахад анхаарчээ. Мөн АНУ тэнгисийн цэргийн хамгийн хүчирхэг гүрэн болоход нөлөөлсөн (1900 он гэхэд АНУ дэлхийд 3 дугаарт орох тэнгисийн цэрэгтэй улс болсон). Дэлхийн түүхэн дэх хамгийн өндөр хөгжил цэцэглэлтэд хүрсэн Грек, Ром, Голланд, Британи зэрэг улсууд хүчирхэг тэнгисийн цэрэгтэй байсан бөгөөд түүнийхээ ачаар, худалдааны хөлөг онгоцуудаа хамгаалан, худалдааг хөгжүүлсэн. Тиймээс АНУ нь тэнгисийн цэргийг хөгжүүлэх замаар дэлхийн даяар хүчээ нэмэгдүүлэн, худалдаа, хөгжил цэцэглэлтийг бий болгох хэрэгтэй. Хүчтэй, орчин үеийн тэнгисийн цэрэг нь Америкийн бизнесийн ашиг сонирхлыг хамгаалах болно гэжээ.

Геополитикийн сүүлийн үеийн онолчдыг авч үзвэл, 1970-1980-аад оны үед Баруун Европт тэр дундаа Англи, Франц, Италид геополитикийн шинэ урсгалууд гарч ирсэн. Эдгээрийн нэг нь Мондиализмын онол буюу дэлхий нэг болох тухай санаа байв.

АНУ-д Н.Спайкмений атлантист чиглэлийг цааш нь хөгжүүлж, боловсронгуй болгох оролдлогууд хийгдэж Д.Мейниг, У.Кирк, Х.Киссинжер зэрэг геополитикчид өөр өөрсдийн онолын санааг боловсруулан гаргаж байсан. Ф.Фукуяма, С.Хантингтон, З.Бжежинский нарын нео-атлантист чиглэлийн

геополитикчид геополитикийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулжээ.

Глобалчлал (Даяаршил): Глобалчлалыг дэлхий даяар хүмүүс, байгууллагуудын өсөн нэмэгдэж буй хэлхээ холбоо, харилцан хамааралыг илэрхийлдэг интернациональ ижил утгаар ойлгох нь бий. Хэдийгээр эдгээр нэр томъёо нийтлэг зүйлүүд олонтой боловч хоорондоо ялгаатай.

Интернациональци нь онолын хувьд тодорхойлогдоогүй нэр томъёо юм. Энэ нь үндэсний болон соёлын хил хязгаараас халин явагдаж буй бизнесийн процесс юм. Харин глобалчлал нь эсрэгээрээ, харилцан хэлхээ холбоотой байдлын нарийн түвэгтэй байдлыг илэрхийлдэг.

Глобалчлал нь үйл явц, онолын аль аль нь юм. Глобалчлалын онолтой хамгийн их холбогддог Роланд Робертсон глобалчлалыг орчин үеийн дэлхийн хурдаа авч буй нягтаршил, дэлхийг нэг бүтэн зүйл хэмээн ойлгох ойлголт эрчимжиж буй байдал хэмээн тодорхойлсон. Улс орнуудын хоорондох бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, хүн, мэдээлэл, технологийн чөлөөтэй урсгалын үр дүнд бий болсон дэлхийн эдийн засаг, соёл, хүн амын хоорондох эрчимтэй нэмэгдэж буй харилцан хамаарлыг глобалчлал хэмээн үздэг.

Эрт дээр үеэс тээвэр, технологийн ачаар хүмүүс алс хол газар оронд суурьшин бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн, солилцдог байв. Гэхдээ XIX зуун хүртэл дэлхийн нийтийг хамарсан интеграцлагдчлах үйл явц явагдаагүй байсан юм.

Европын орнуудын колончлол, худалдааны үйл ажиллагааны дараа глобалчлалын эхний давалгаа үүссэн. Үүнд, уурын хөдөлгүүр, төмөр зам, цахилгаан шуудан болон бусад технологийн нээлтүүд нөлөөлсний зэрэгцээ улс орнуудын хоорондын хамтын ажиллагаа нэмэгдсэн явдал хамгийн гол нөлөө үзүүлсэн.

Дэлхийн I дайн, түүнийг дагалдан гарсан протекционизм,

АНУ-д болсон “Их хямрал”-ын хор уршиг болон Дэлхийн II дайн нь глобалчлалын үйл явцыг сарниулсан. Дэлхийн II дайны дараа АНУ нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг сэргээх хүчин чармайлтыг тэргүүлж байсан нь глобалчлалын 2 дахь үе шатыг эхлүүлсэн. Олон улсын хамтын ажиллагаанд гарч буй технологийн ахиц, дэвшлийн үр дүнд дэлхий хэзээ хэзээнээс илүү холбоотой болж, харилцан хамаарал нэмэгдсэн.

Роберт Кеохане, Жозеф Най нар глобалчлалыг 3 хэмжигдэхүүнтэй хэмээн тодорхойлсон. Үүнд:⁹

- Улс төрийн глобалчлал
- Эдийн засгийн глобалчлал
- Нийгмийн глобалчлал

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас глобалчлал ухралтанд ороод байна. Улс орнууд эдийн засгийн хувьд бие биенээсээ хамааралтай байх нь ямар их эрсдлийг авчирч болохыг Ковид-19 харуулснаар улс орнууд үндэсний бие даасан байдлаа сэргээхийг эрмэлзэх хандлагатай байна. Ковид-19 нь эдийн засгийн даяаршлыг эргэн харахад хүргэж, олон улсын нийлүүлэлтийн хэлхээг удирдан зохицуулж ирсэн арга замыг үндсээр өөрчлөх шаардлага тулгарсныг ил болгов¹⁰.

Цар тахлын улмаас үндэсний засгийн газрууд протекционист бодлого баримтлан, гадаадын нийлүүлэгчүүдээс хамаарах хамаарлаас зайлсхийхийн тулд үйлдвэрлэлийг дотооддоо явуулахыг шаардсанаар дэлхийн өртгийн хэлхээ сүйрэлд орох нөхцөл үүсээд байгаа дэлхий даяар нүүрлээд буй “ложистикийн хямрал” харуулж байна. Цаашдаа бүс нутаг хоорондын болон бүс нутаг дотоодын нэмүү-өртгийн хэлхээнд оролцох компаниудын оролцоо буурна. Хүчтэй хямрал нь глобалчлалд бүтцийн хувьд сөрөг нөлөөлж

9 Joseph Nye “Globalism Versus Globalization” (April 15, 2002) <https://www.theglobalist.com/globalism-versus-globalization/>

10 DW “Coronavirus outbreak hitting German supply chains with fears of economic paralysis” <https://www.dw.com/en/coronavirus-outbreak-hitting-german-supply-chains-with-fears-of-economic-paralysis/a-52554823>

болохыг 2008 оны санхүүгийн хямрал харуулсан. Энэ хямралын өмнө глобалчлал амжилттай явагдан нэмүү-өртгийн даяар хэлхээний өртөг шингэсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь дотоодод өртөг шингээж бүтээсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамаагүй илүү өсч байв. Гэтэл хямрал болж нэмүү-өртгийн даяар хэлхээний өсөлт удааширч, хямралын өмнөх түвшиндээ эргэн ороогүй юм. Коронавирус ч үүнтэй адил нөлөө үзүүлсэн юм.

Олон улсын эрх зүй: Голландын улс төрийн зүтгэлтэн, дипломатч, хуульч, нэрд гарсан хууль зүйч Гуго Гроци (1625) “Дайн ба энх тайвны тухай 3 ном” зохиолдоо олон улсын эрх зүйн салбарын хэм хэмжээг анх удаа эмхэтгэж гаргасан нь олон улсын эрх зүйн үндсийг нь тавьсан гэж үздэг. Үүнд:

- Дайны үед хувийн өмчид үл халдах зарчим
- Олзлогсод, шархагдагсадтай хүмүүнлэг ёсоор харилцах зарчим
- Дайны үед үйлдсэн гэмт хэргийн төлөө шийтгэл хүлээх хэм хэмжээ
- Тэгш, тэгш биш гэрээний хоорондын ялгааг үндэслэлтэй гаргаж гэрээгээр хүлээсэн үүргээ дагаж мөрдөхийн чухлыг заасан байна

Олон улсын түгээмэл эрх зүй (public) олон улсын субъектуудын хоорондын харилцааг зохицуулдаг. Тусгай (private) гадаадын оролцоо бүхий иргэний эрх зүйн харилцааг (гадаад худалдааны хэлцэл, гадаадын иргэний зохиогчийн ба бүтээгчийн эрх, өмч хөрөнгө өвлөх гэр бүл, хөдөлмөрийн харилцааг) зохицуулдаг.

Бүх улс заавал дагаж биелүүлвэл зохих нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зарчим, хэм хэмжээний цогцыг олон улсын түгээмэл эрх зүй гэнэ. Үүнд:

- Улс гүрний бүрэн эрх
- Тусгаар тогтнол
- Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх
- Бусдын дотоод хэрэгт үл оролцох зарчим, хэм хэмжээ орно.

Үүнээс гадна зөвхөн хоёр болон цөөн тооны улс гүрэн заавал биелүүлвэл зохих хэм хэмжээ (гэрээ болон заншлын) байдаг бөгөөд үүнийг орон нутгийн хэм хэмжээ гэнэ.

Ашигласан материал, ном зүй:

1. Василий Кашин “Выйти из тени” Россия в глобальной политике №2 2012 Марта/Апрель <https://globalaffairs.ru/articles/vyjti-iz-teni/>
2. Дуламбаяр “Олон улсын харилцааны ахисан түвшний судалгааны онол-аргазүйн зарим асуудал” Олон Улс Судлал №1, 2015 он: 5-22 хуудас
3. CNN Brazil “Secretário-geral da ONU diz que Covid-19 deixou o mundo de joelhos” <https://www.cnnbrasil.com.br/internacional/secretario-geral-da-onu-diz-que-a-covid-19-deixou-o-mundo-de-joelhos/>
4. Columbia University “International Relations” <https://polisci.columbia.edu/content/international-relations>
5. Cybercrime Magazine “Boardroom Cybersecurity 2022 Report” (Aug 10, 2022) <https://cybersecurityventures.com/boardroom-cybersecurity-report/#:-:text=Cybercrime%20is%20predicted%20to%20cost,suite%20executives%20are%20paying%20attention>
6. DW “Coronavirus outbreak hitting German supply chains with fears of economic paralysis” <https://www.dw.com/en/coronavirus-outbreak-hitting-german-supply-chains-with-fears-of-economic-paralysis/a-52554823>
7. Herald Tribune “With Rare Double UN Veto on Syria, Russia and China Try to Shield Friend’” <http://www.heraldtribune.com/article/20111005/ZNYT03/110053039?p=4&tc=pg>
8. Jing-dong Yuan, “Friend or Foe: The Bush Administration and U.S. China Policy in Transition”, East Asian Review Vol. 15, No. 3 (Autumn 2003): 44-45

9. Joseph Nye “Globalism Versus Globalization” (April 15, 2002) <https://www.theglobalist.com/globalism-versus-globalization/>
10. VOA “UN Security Council Reform May Shadow Annan’s Legacy” (Nov 1, 2006) <https://web.archive.org/web/20061102142909/http://voanews.com/english/2006-11-01-voa46.cfm>

7

**Долоодугаар бүлэг.
Монгол Улсын гадаад бодлого***Судлаач Н.Соёлгэрэл*

Энэ зуунд дэлхийн улс түмэнд түншлэлийн харилцааны ач холбогдол улам бүр өссөөр байна. Нэг улсын гадаад бодлого гэхэд л бүс нутгийн, магадгүй дэлхий дахины нөхцөл байдал, чиг хандлагад нөлөөлж байгааг өнөөгийн олон улсын тавцанд өрнөж буй үйл явдлууд харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл харилцаа, хамтын ажиллагааны бүхий л салбарт улс орнуудын хоорондын хамаарал хийгээд бодлого, чиглэлийн уялдаа холбоо улам бүр өсөн нэмэгдэж байна. Тиймээс аливаа чухал асуудлыг, түүний дотор энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж, бататган бэхжүүлэхээс эхлээд хүн төрөлхтөний оюун санааг чилээж байгаа нийтлэг асуудлуудыг өргөн хүрээнд харж, хариуцлагатай, ухаалаг бодлого хэрэгжүүлэх явдал улс орнуудад чухал болжээ.

Монгол Улс эдүгээ дэлхийн хамтын нийгэмлэгийн тэгш эрхт гишүүн төдийгүй олон улсын энх тайван, аюулгүй байдал, ардчиллын үнэт зүйлсэд тулгуурласан идэвхтэй гадаад бодлого явуулдаг, гадаад ертөнцөд хүлээн зөвшөөрөгдсөн түнш болоод байгаа нь гадаад бодлогын маань амжилт, нэгэн ололт юм.

Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, геополитикийн орчин зэрэг олон зүйлээрээ бид дэлхийн бусад улсаас онцгойрон ялгарч байна. Эдийн засаг, цэрэг батлан хамгаалах, хүн ам зүйн хүчин зүйлс, чадавхаараа олон улсад тэргүүлэх хоёр их гүрэнтэй хил залгахын зэрэгцээ Зүүн хойд Ази болон Төв Ази гэсэн Евразийн нөлөө бүхий хоёр том бүс нутгаар хүрээлүүлэн оршдог. Газар зүйн энэхүү хүрээлэл нь хүн ам зүй, улс төр, эдийн засаг, соёлын томоохон нөлөөллийг бий болгож байна. Тодруулбал, бидний умард талаас Оросын улс төр, эдийн засаг, хүчний

нөлөө, өмнө талаас Хятадын эдийн засаг, соёл, хүн ам зүйн хүчин зүйлийн нөлөө, дорно, өрнө талаас хөгжингүй болон хөгжиж байгаа улсуудын шинэ тутам илэрч буй нөлөө хүч түрсэн геополитикийн орчин нэгэнт бүрэлдэн тогтжээ. Түүнчлэн ортодокс славян, дорны күнз, исламын ертөнц болон уламжлалт буддизм гэсэн томоохон соёл иргэншлүүдийн огтолцолд Монгол Улс оршдог. Газар зүйн эдгээр нөхцөл, хүчин зүйлийн зэрэгцээ техник, технологи, зөөлөн хүчний нөлөөгөөр өрнийн соёлын элементүүд нэвтэрч, нийгмийн амьдралын уламжлалт хэв маяг шинэчлэгдэж байна.

Бидний оршин буй энэхүү орон зайн геополитикийн нөхцөл байдал биднээс илүү алсын хараатай, ухаалаг, мэдрэмжтэй байхыг шаарддаг. Ингэж чадвал бидний тусгаар тогтнол баталгаажих учиртай. Үүнийг ч бид соргогоор мэдэрч, тусгар тогтнол бүрэн эрхт байдлаа улс төр, дипломтын аргаар хангаж, энхийг эрхэмлэсэн, идэвхтэй гадаад бодлого явуулан дэлхийн улс түмэнтэй харилцаж байгаа билээ.

Гадаад бодлогын эрх зүйн үндэслэл, суурь баримт бичгүүд

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, түүний үзэл санааны дагуу улс төр, нийгэм-эдийн засгийн шинэ бодлого явуулж эхэлж байх үед төрөөс үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, батлан хамгаалах чиглэлээр баримтлах бодлогын үндсийг тодорхойлсон баримт бичгүүд гарсан юм. Тиймээс Монгол Улсын шинэ гадаад бодлого 1992 оны Үндсэн хуулиас эхлэлтэй билээ. Тэнд анх удаа Монгол Улс олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим хэм хэмжээг баримталсан гадаад бодлого явуулах талаар тусгасан юм. Өөрөөр хэлбэл дагуул улсын гадаад бодлогоос татгалзах хэрэгтэй болсон. Учир нь, ерээд оны эхээр хүйтэн дайн төгсгөл болж, ЗХУ задарснаар Монголын гадаад бодлогод зарчмын өөрчлөлт хийх шаардлага бий болов. Монгол Улс өөрийн гэсэн гадаад бодлоготой байх ёстой болсон ба түүнийг хуульчилсан үзэл баримтлалтай болох асуудал энэ үеэс яригдаж эхэлсэн юм.

Гадаад бодлогын анхны үзэл баримтлалыг 1994 онд боловсруулах, батлах үеийн нөхцөл байдал их өвөрмөц байлаа. “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж заасан юм. Хүйтэн дайн төгсөхтэй зэрэгцэн олон улсын харилцааны шинэ тогтолцоо бүрэлдэж байсан цаг үе байлаа. Бидний багтаж байсан социалист систем, ЗХУ задарч, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл тарсан. Зөвлөлтийн цэрэг Монголоос гарав. Товчоор хэлбэл эдгээрийн холбоотон байсан Монгол Улсын гадаад нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн. Эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалах, баталгаажуулах арга механизмыг олох шаардлага үүссэн. Өрнөдийн олон улс оронтой эв зетэй харилцан, энх тайвнаар зэрэгцэн оршиж, түншүүд болсноор ардчилал, зах зээлийг хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллах шаардлагатай байв. Эдгээрийн төлөө АНУ, Япон, Англи, Герман, Франц, Солонгос зэрэг улсад Монгол Улсын гадаад бодлогыг танилцуулах, хоёр хөрш болох ОХУ, БНХАУ-тай харилцаагаа шинэ нөхцөл байдалд нийцүүлэн хөгжүүлж, цаашид хэрхэн хамтран ажиллах бодлогоо тодорхойлох хэрэгтэй болсон юм. Ингээд эдгээрийг тусгаж чадсанаараа анхны 1994 оны үзэл баримтлал бол Монголын гадаад бодлогын нэг үеийн түүхийг төгсгөж, шинэ үеийн түүхийг эхлүүлсэн юм².

Монголын гадаад бодлогын шинэ үеийн түүхэнд хэд хэдэн томоохон өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, гадаад бодлогын шинэ зорилт, зарчим, чиглэл болон шийдвэр гаргах шинэ арга механизмтай болсон. ОХУ, БНХАУ-тай шинэ маягийн харилцааг тогтоон, ОХУ-тай 1993 онд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, 2009 онд Стратегийн түншлэлийн харилцаа тогтоов. Эдгээрт урьдын дагуул улс биш, эрх тэгш харилцаатай байх тухайгаа дурдсан билээ. БНХАУ-тай 1994 онд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”, 2011 оноос “Стратегийн түншлэлийн харилцаа”

1 10 дугаар зүйл, Үндсэн хууль (1992)., <https://legalinfo.mn/mn/detail/367>

2 “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жил”. https://www.kas.de/documents/252038/253252/7_dokument_dok_pdf_40579_1.pdf/6bb1975d-7226-ba1b-cb1f-57ecc8a4cda7?version=1.0&t=1539652923308

тогтоосон³. Өрнөдийн орнуудтай ойртох бодлогын хүрээнд “гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Аливаа цэрэг, улс төрийн эвслээс ангид байх зорилгод нийцүүлж, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн болсон. Цөмийн зэвсэггүй бүс хэмээн өөрийгөө тунхагласан билээ.

Өнгөрсөн зууны ерээд он гартал 70 жилийн хугацаанд Монгол улс дан ганц ЗХУ-ыг л түшиглэн гадаад бодлого хэрэгжүүлж байсан бол 1994 оноос ийнхүү Монгол улс шинэ “олон тулгуурт” гадаад бодлого хэрэгжүүлэх болсон. Олон тулгуурт гадаад бодлогын цөм нь БНХАУ, ОХУ хоёр хөрш орон болон барууны нөлөө бүхий том гүрэнтэй тэнцвэртэй харилцах явдал юм.

Улмаар Монгол Улс 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалаа 2011 онд шинэчлэн, АНУ тэргүүтэй өрнөдийн болон Азийн өндөр хөгжилтэй, ардчилсан улсуудыг “гуравдагч хөрш” хэмээн хүлээн зөвшөөрсөн. Монгол Улсын дотоод болон гадаад орчинд ч томоохон өөрчлөлтүүд ажиглагдаж, үүнд зохицохын зэрэгцээ гадаад бодлогынхоо нэгдмэл, залгамж чанарыг хадгалж, олон тулгуурт гадаад бодлогоо бататгахын тулд гадаад бодлогын үзэл баримтлалаа шинээр томъёолсон. Нөгөөтэйгүүр 1994 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн, 2010 онд шинэ баримт бичигтэй болсон тул үүнд нийцүүлэн 2011 онд гадаад бодлогын шинэ үзэл баримтлалыг баталсан. Энэхүү баримт бичигт ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэхээр тусгасан⁴. Эндээс өмнөх баримт бичгийн нэгэн адил Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь хоёр хөрштэйгээ харилцах харилцаа болох нь ойлгогдоно. Харин гадаад бодлогын удаах чиглэлд ихээхэн өөрчлөлт гарав. Тухайлбал АНУ, Япон,

3 “Хөрш орнууд”, <https://mfa.gov.mn/mongolian-foreignpolicy/%D0%B4%D0%B8%D0%B F%D0%>

4 “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал”, 2011 он

Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр болсон. Энэ нь гадаад бодлогын шинэ үзэл баримтлалын хамгийн чухал хэсэг болж байгаа юм.

Монгол Улсын гадаад бодлогын онцлог

Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал болох тухай бодлогын гол баримт бичигтээ тусгаж өгчээ. Түүнчлэн “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн”, “Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна” хэмээн зорилго, зорилтуудаа тодорхойлсон.

Олон намын системд шилжиж, олон ургалч үзлийг дээдлэж эхэлсэн үед улсын гадаад бодлого маш цэгцтэй байх ёстой юм. Энэ үүднээс олон тулгуурт гадаад бодлоготой байх, эдийн засгийн гадаад бодлогод нээлттэй байх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зэргийг гадаад ертөнц, олон улстай харилцахдаа гол болгосон юм. Тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүтэн бүрэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлаа улс төр, дипломатын аргаар баталгаажуулахад цөмийн зэвсэгтэй орнуудын дэмжлэгийг авах үүднээс “Монгол Улсын нутаг дэвсгэрийг цөмийн зэвсгээс ангид бүс болгох тухай Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат НҮБ-ын 47-р чуулганы индэр дээрээс 1992 онд зарлан мэдэгдсэн. Энэ санаачилгыг Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганы тогтоолоор дэмжиж, Цөмийн зэвсэгтэй таван гүрний мэдэгдэл гарч, улмаар Тунхаглал болон гүнзгийрсэн юм.

Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сангийн болон Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болсноор Монгол Улсын эдийн засгийн уналтыг зогсоож тогтворжуулах, өсөлтийг эхлүүлэх суурийг тавьсан. АНУ, Япон Улсуудын шууд оролцоо, дэмжлэгийг авч, Хандивлагч орнууд, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд Монголын эдийн засаг хүнд байдлаас харьцангуй богино хугацаанд гарч тогтворжиж эхэлсэн юм. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулахад Гадаад хэргийн яам, сайд Ц.Гомбосүрэн болон Ерөнхийлөгчийн зөвлөх Р.Батаа, Ж.Энхсайхан нар чухал үүрэг гүйцэтгэжээ.

Хоёр талын харилцааны тухайд тухайн улстай хөгжүүлж буй хоёр талын харилцааны агуулга, ач холбогдлоос нь хамааруулж Монгол Улсыг өнөөдөр дараах 4 эрэмбээр түншлэлийн харилцаагаа хөгжүүлж байгааг судлаач Ц.Батбаяр тодорхойлжээ. Үүнд, нэгдүгээрт, Стратегийн түншлэлийн харилцаа (ОХУ, БНХАУ, Энэтхэг, Япон, АНУ, БНСУ); хоёрдугаарт, иж бүрэн түншлэлийн харилцаа (ХБНГУ, Турк); гуравдугаарт, өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа (Канад, Австрали, Казахстан); дөрөвдүгээрт, түншлэлийн харилцааг (бусад орон) нэрлэжээ⁵.

Түншлэлийн харилцааны хамгийн өндөр түвшин буюу Стратегийн түншлэлийн харилцааг Монгол Улс ОХУ-тай 2009 оноос, БНХАУ-тай 2011 оноос, Японтой 2010 оноос, БНЭУ-тай 2015, АНУ-тай 2019 оноос хойш хөгжүүлж байна. Ингэхдээ Стратегийн түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцлийг иш үндэс болгож байна. Түншлэлийн энэхүү хэлбэр нь хоёр улсын хоорондын харилцааны хамгийн өндөр түвшинг илэрхийлэх бөгөөд урт хугацааны тогтвортой, итгэмжилсэн харилцааг тогтоож, өндөр дээд хэмжээний айлчлалын давтамжийг ойртуулан харилцах илэрхийлэл болох учиртай. Олон улсын болон бүс нутгийн томоохон асуудлаар хамтран ажиллан, хөрөнгө оруулалтаа харилцан хамгаалж, нэмэгдүүлэн, чөлөөт худалдааны

5 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жил", https://www.kas.de/documents/252038/253252/7_dokument_dok_pdf_40579_1.pdf/6bb1975d-7226-ba1b-cb1f-57ecc8a4cda7?version=1.0&t=1539652923308

хэлэлцээр байгуулах зэргээр эдийн засаг, худалдааны урт хугацааны тогтвортой харилцаа тогтооно. Батлан хамгаалах салбарт бие биендээ техникийн туслалцаа үзүүлэх, цэргийн мэргэжилтэн бэлтгэхэд туслах зэргээр хамтран ажиллах бол соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрүүлнэ.

Түншлэлийн харилцааны дараагийн түвшин болох иж бүрэн түншлэлийн харилцааг Монгол Улс Турктэй 2005, ХБНГУ-тай 2008, оноос хойш тус тус хөгжүүлж байна. Ингэхдээ иж бүрэн түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцлийг баримталж байна. Нэн тэргүүнд улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрсэн байх ба худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж, хөрөнгө оруулалтыг харилцан дэмжин, боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёл, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт идэвхтэй хамтран ажиллах учиртай. Батлан хамгаалах салбарт мэдээлэл, туршлага солилцох, мэргэжилтэн бэлтгэх зэргээр хамтран ажиллах ба ийнхүү улс төр, эдийн засаг, нийгэм соёлын бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж буй учир иж бүрэн түншлэл хэмээн нэрлэгддэг.

Түншлэлийн харилцааны гуравдугаар түвшин буюу өргөн хүрээтэй түншлэлийн харилцааг Монгол Улс Канадтай 2004 оноос, Австрали, Казахстантай 2007 оноос хойш тус тус хөгжүүлж байна. Өргөн хүрээтэй түншлэлийн хүрээнд улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрч, эдийн засгийн тодорхой салбаруудад хамтын ажиллагаа хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, соёл, хүмүүнлэгийн салбарт харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж эхэлнэ. Цаашид харилцаа, хамтын ажиллагааг өөр бусад салбарт хөгжүүлэхийг эрмэлзэх ба өргөн хүрээтэй түншлэл нь улс төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарыг биш, харилцан сонирхсон хэд хэдэн салбарыг онцлон хамардгаараа иж бүрэн түншлэлээс ялгаатай, зэрэглэлийн хувьд түүнээс доогуур түвшний харилцаа хэмээн ойлгож болно.

Харин түншлэлийн харилцааны ерөнхий нөхцөл гэдэгт талууд байнгын харилцаатай байж, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг ойлгоно. Улс төрийн харилцаа тогтмолжиж, эдийн засаг, худалдааны харилцаа зарим чиглэлээр хөгжиж эхлэх ба боловсрол, шинжлэх ухаан, соёл, хүмүүнлэгийн салбарт харилцаа, хамтын ажиллагаа нэмэгдэх учиртай аж. Түншлэлийн харилцаа нь хоёр улс хамтран ажиллах эхний түвшин бөгөөд ердийн дипломат харилцаатай харьцуулахад байнгын шинжтэй, цаашид аль ч салбарт хамтран ажиллах өргөн боломж нээгдэж байгаагаараа онцлог.

2010 онд шинэчлэн баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй, ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” хэмээн заасан. Түүнчлэн 2011 онд шинэчлэгдсэн Гадаад бодлогын үзэл баримтлалын зүйл 14.2 –т “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” гэж заасан байдаг. Энэ нь “гуравдагч хөрш” хэмээх томъёолол манай гадаад бодлогыг тодорхойлогч албан ёсны, үндсэн баримт бичгүүдэд анх удаа орсон явдал болсон юм.

Монгол Улсын гадаад бодлогын гол чиглэлүүд

Хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах нь

Монгол Улс хоёрхон хөршөөр хүрээлэгдсэн, геополитикийн онцгой байршилтай ардчилсан орон билээ. Хэдий хоёрхон хөрштэй ч орчин үеийн олон улсын харилцааны жам ёсоор бид олон улс оронтой нээлттэй харилцаж байна. Монгол Улсын хоёр хөршийн маань нэг ОХУ газар нутгийн хэмжээгээрээ, БНХАУ хүн амын тоогоороо дэлхийд тэргүүлэгч улсууд билээ. Цаашлаад эдийн засаг, үндэсний нийт орлого, батлан хамгаалах чадавх зэрэг олон үзүүлэлтээрээ дэлхийн

улсуудын жагсаалтын эхний эгнээнд эрэмблэгдэж байна.

Монгол Улсын хөгжлийн стратегийн тэргүүний зорилтын нэг бол гадаад орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны аюулгүй байдлыг хангахад оршдог. Чингэхдээ гадаад бодлогын тэнцвэртэй байдлыг хангах нь манай орны оршин тогтнох нөхцөл, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах гол үндэс болно. Манай орны гадаад орчны хамгийн ойрын хүрээлэл болох хоёр хөрш маань Монгол Улсын аюулгүй байдал, хөгжлийн чухал хүчин зүйл болсоор ирсэн.

Өмнөд хөршийн тухайд, Монгол, Хятадын харилцаа өнөө үед иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн ч түүхийн явцад янз бүрийн сорилт, шалгууруудыг даван туулж өдий хэмжээнд хүрснийг дурдах нь зүйтэй. Өнөөдөр БНХАУ дэлхийн хоёр дахь том эдийн засаг, хэрэглээний зах зээл, худалдааны хамгийн том орон болж түүний дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь улам бүр өсч, олон улсад эзлэх жин нөлөө нь тасралтгүй нэмэгдэж байна.

БНХАУ Монгол Улсын хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулагч улс билээ. Монголын хувьд Хятад нь газар нутгийн хувьд хамгийн ойр, асар том зах зээл, Хятадын хувьд Монгол нь хэрэгцээт байгалийн нөөцөөр баян улс юм. Тиймээс хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцаа харилцан бие биенээ нөхөх шинжтэйгээр хөгжиж ирсэн. Цаашид харилцан өгөөжтэй, үр ашигтай хөгжүүлэх тухайд анхаарах асуудал нэлээд буй учир урд хөрштэйгөө илүү тааламжтай нөхцөлөөр худалдаа хийх, өөрийн улсын экспортын чадамж, цар хүрээг өргөтгөх нөхцөл бололцоог байнга эрэхийлэх хэрэгтэй.

Монгол, Хятадын эдийн засгийн харилцааны чухал хэсэг нь хөрөнгө оруулалт бөгөөд гадны хөрөнгө оруулалт нь эдийн засгийн хөгжлийн том хөшүүрэг тул дотоодын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. Иймээс бид Монголын эдийн засгийн хөгжилд үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлагатай байна.

Түүнчлэн хоёр талын харилцаа хүнээр дамжин хэрэгжих тул талуудын соёл боловсрол, нийгмийн харилцааг улам илүү хөгжүүлэх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд олон мянган монгол залуучууд Хятадын их дээд сургуулиудад суралцан мэдлэг, боловсролоо дээшлүүлж байна. Монголчууд ажил хэрэг, соёл боловсрол, эмчилгээ, аялал жуулчлалын шугамаар Хятад руу зорчих нь ихэссэн, хятад бизнесменүүдтэй янз бүрийн түвшний харилцаа холбоотой тогтоох болсны үр дүнд Хятад орон, хятад үндэстний талаарх үзэл ойлголт нэлээд өөрчлөгдөж байна.

Монгол Хятадын өнөөгийн харилцааг шинэ агуулга, зорилгоор баяжуулж, Хятадын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг сайтар судлан боловсруулж, өнөөгийн нөхцөл байдалд тохирсон том, жижиг хөрш орнуудын харилцан ашигтай түншлэлийн харилцааны шилдэг загварыг бий болгож, хоёр орны харилцааг улам илүү хөгжүүлэхэд бидний үүрэг оролцоо ихээхэн чухал байна.

Олон улсын анхаарлыг татаад буй БНХАУ-ын “Бүс ба зам” санаачилга нь эртний түүхт торгоны замын улбаагаар орчин цагт усан болон хуурай замаар Хятадыг өрнөдтэй холбох БНХАУ-ын гадаад бодлого, эдийн засгийн стратеги юм. Урт хугацаандаа “Бүс ба зам” санаачилгын дүнд Хятад, Евразийг дамнасан худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, харилцаа холбоо сайжирна. Мөн санаачилгад хамрагдаж буй улсууд дахь Хятадын эдийн засгийн хөшүүрэг нэмэгдэх нь дамжиггүй. Ингэснээр Хятадад бүс нутгийн түвшинд эдийн засгийн хамтын ажиллагааг зохицуулах дүрэм журмыг тогтоох эрх мэдэлтэй субъект болон төлөвших боломж бүрдэнэ. Өдгөө 152 орон, олон улсын байгууллагуудыг хамарсан “Бүс ба зам” санаачилга нь дэд бүтцийн хөгжил, хөрөнгө оруулалтын дэлхий хэмжээний стратеги болоод байна⁶.

6 Parliament of Australia, “China’s ‘One Belt, One Road’ initiative”. https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Library/pubs/Briefing-Book45p/ChinasRoad

Умард хөршийн тухайд, ОХУ олон улсын тавцан дахь их гүрний байр сууриа бэхжүүлэхээр зорьж буй. Аюулгүйн, нөлөөний бүсээ хадгалж үлдэх чиглэл дэх Кремлийн гадаад бодлогын үндэс нь⁷ өрнөдийг сөрсөн “консерватив”⁸, орос ертөнц, соёлыг хамгаалах ёстой гэж үздэг “славянофил” болон Атлантын ертөнцийн эсрэг сөрөн зогссон орон зайн “Евразийн үзэл санаа” зэрэг болж байна. Цаашлаад XXI зууны ОХУ-ын гадаад бодлогын чиг баримжааг тодорхойлоход дэлхий дахинд нэр, нөлөөгөө хүлээн зөвшөөрүүлэхийн төлөөх түүний тэмүүлэл, дэлхийн улс төрийн гол тоглогчдын нэг болох хүсэл, их гүрэн байх эрмэлзлэл, аюулгүй байдлаа хангах хүчин зүйлүүдийг заавал тооцож үзэх шаардлагатай.

Оросын зүгээс Зүүн хойд Ази болон Ази Номхон далайн бүс нутагт баримтлах бодлого, стратеги нь Алс Дорнодын бүс нутгаа хөгжүүлэх, тус бүс нутаг дахь байгалийн баялагаа эргэлтэд оруулж хүн амын суурьшилтыг идэвхижүүлэх зорилготой. Үүний тулд Оросын зүгээс Зүүн хойд Азийн бүс нутгийн улсуудтай их гүрний байр сууриа бэхжүүлэх үүднээс харилцаагаа хөгжүүлэхийг эрмэлзэж, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгоход чиглэсэн дипломат бодлого явуулж байна. Учир нь XXI зууны ОХУ-ын хөгжлийн тэргүүлэх чиглэл хэмээн зарласан Сибирь, Алс Дорнодын бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг тус бүс нутгийн харилцаанд татан оролцуулах гүүр болсон дэд бүтэц, далайн боомтууд Умард Солонгостой хил залгаа оршдогт тул аюулгүй байдлаа хангахгүйгээр эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг авчрах боломжгүй юм.

Түүнчлэн Евразийг дамнан орших газар зүйн байрлалын давуу талаа ашиглан улс төр дипломат, эрчим хүчний стратеги, дэд бүтцийн тогтолцоог зангидан “Их Евразийн түншлэл” хэмээх санаачилгыг 2015 онд В.Путин Холбооны Зөвлөлд тавьсан илгээлтдээ дэвшүүлэн, Европын төдийгүй

7 Ж.Баттөр, “В.Путины гадаад бодлогын үзэл санааны үндэслэл”, Стратегийн судалгаа №75, 2016 он

8 В.Путины гадаад бодлогод “Царь” болон ЗХУ-ын гэж хэлж болох өнгөрсөн үеийн итгэл үнэмшил бат нөлөөтэй. Орчин цагийн Орос оронд автократ, ортодокс, үндэсний үзэл хэмээх үзэл санаа нь XIX зууны дунд үед ямар байсан яг тэр хэвээр хүч нөлөөтэй байгаа нь үүний илрэл юм.

Ази номхон далайн их гүрэн болох хэтийн зорилтоо илэрхийлж байв. ЗХУ нуран унасны дараа хүмүүсийн сэтгэлгээнд үлдсэн хоосон орон зайг нөхөхөөр “Евразийн үзэл санаа” хэмээх ойлголтыг Москва дэвшүүлэх болж, улмаар Евразийн эдийн засгийн холбоог байгуулсан билээ. Тус холбоо нь гишүүн орнуудынхаа эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндсийг бий болгох, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, гишүүн орнуудын хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэхээр зорьж байгаа.

Дэлхийн их гүрэн байхын тулд Орос тэнгисийн хүчинтэй байх ёстой. Гэвч НАТО-гийн тэлэлт Хар тэнгисийн баруун эрэг, Турк, Грект хүрсэн. Иймээс Оросын тэнгисийн хүчин Хар тэнгисээр дамжин, Газар дундын тэнгис рүү гарахад хүндрэлтэй. Балтийн улсууд мөн НАТО-гийн гишүүн болсон. Польш, Литвийн хооронд орших тал талаараа хүрээлэгдсэн Калининград Орост байх боловч Калининградын нөгөө талд нь НАТО-гийн гишүүн Дани оршдог. Стратегийн ач холбогдолтой газруудад НАТО байрласан байгаа нь Оросын далай тэнгист хүчнээ байрлуулах боломжийг нь тасалдуулж байна.

Нөгөө талд, Оросын холбоотон Беларусь орших бөгөөд Беларусаар дамжин Польшид хүрч, цаашлаад Умард Европын тал газраар дамжин Европ руу гарах боломжтой. Гэвч Польш мөн л НАТО-гийн гишүүн. Тиймээс л Украин нь Оросын хувьд улам бүр стратегийн ач холбогдолтой болсон. Геополитикийн энэхүү эрмэлзлэлээс улбаалан 2014 оны болон өнөөгийн Украины хямрал үүссэн болохыг судлаачид нотолж байна.

Хоёр талуудын харилцаа, гурван талт бүтэцээс гадна бүс нутгийн болон дэлхий нийтийг хамарсан олон улсын байгууллагуудын хүрээн дэх үйл ажиллагаа чухал болж байна.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого

“Гуравдагч хөрш” хэмээх ойлголтыг 1990 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкерийн Монгол Улсад хийсэн айлчлалтай холбон тайлбарладаг. Айлчлалынхаа үеэр Ж.Бейкер “...Та бүхэн хэдийгээр хоёр хөрштэй ч АНУ-ыг оролцуулаад гурван том улстай сайн хөршийн харилцаатай байж болох юм” хэмээсэн байдаг⁹. Цаг хугацааны хувьд тухайн үед хүйтэн дайн төгсгөл болж, хоёр систем задран унаснаар гадаад бодлогоо Монгол Улс бие даан тодорхойлох шаардлагатай болоод байлаа. Улс төр, нийгэм, эдийн засгийн хүрээний өргөн хүрээтэй шинэчлэлийг хэрэгжүүлэхийн тулд хоёр хөршөөс маань бусад гадаад ертөнцийн тусламж дэмжлэг бидэнд нэн чухал болоод байв. Тиймээс АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын хэлсэн үг судлаач, дипломатчдын анхаарлыг даруй татаж, сэтгэлгээ, бүтээлд нь боловсрогдон явсаар эдүгээ манай гадаад бодлогын томоохон чиглэл болон тогтжээ.

Дашрамд дурдахад, Монгол Улсын ХХ зууны түүхээс харахад манай гадаад орчны нөхцөл байдал хувьсан өөрчлөгдөж, Монгол Улс харьцангуй бие даасан гадаад бодлого явуулах боломж бүрдэх бүрд гуравдагч улсуудтай холбоо тогтоохыг оролдсон байдаг. Тухайлбал, 1911 онд Богд хаант Монгол Улсыг байгуулсны дараахан Гадаад хэргийг бүгд ерөнхийлөн шийтгэх яамнаас Франц, Англи, Герман, АНУ, Бельги, Япон, Дани, Нидерланд, Австри гэсэн есөн улсад ноот бичиг илгээж, дипломат төлөөлөгчид солилцох, харилцан гэрээ байгуулах, худалдаа нэвтрүүлэх саналыг тавьж байсан. Үүний дараагаар 1989 онд олон улсын харилцаанд ноёлсон хоёр туйлт систем задарснаар гадаад орчин маань мөн л эрс өөрчлөгдөн шинэчлэгдсэн. Монгол Улс социалист тогтолцооноос ардчилсан тогтолцоо руу шилжсэнээр дэлхий ертөнц нээгдэн, хоёр хөрш орны харилцаа хэвийн түвшинд очсоноор бид үндэсний ашиг сонирхлоо дээдэлсэн, бие даасан орчин үед нийцсэн гадаад бодлого явуулах боломжтой болсон юм. Энэхүү гадаад бодлогын нэг

⁹ Гадаад харилцааны төв архив. ГХЯ

чиглэл бол олон улсын харилцаанд бидний оролцооны уян хатан байдлыг сайжруулахад түшиц болж байгаа “гуравдагч хөрш”-ийн бодлого юм. Газар зүйн байршил нь заяагдмал хүчин зүйл тул бид төдийгүй дэлхийн ямар ч улс үндэстэн хөршөө сонгодоггүй. Харин “гуравдагч хөрш”-ийн бодлого өөр хэн нэгнийг сонгох альтернатив сонголтыг бидэнд бий болгож байгаа гадаад бодлогын ухаалаг шийдэл юм.

“Гадаад бодлогын үзэл баримтлалын (1994) 1.2-т “...бүх улс оронтой найрсаг харилцаатай байж... бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар...” тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хангана хэмээгээд 2.12.2-т нь “...АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын хөгжилтэй гүрнүүдтэй...” харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх явдлыг бодлогын хоёр дахь чиглэл болгон заасан нь “гуравдагч хөршийн бодлогыг”-ыг цохон нэрлээгүй боловч зарлан тунхагласан хэрэг байсан юм. Улмаар 2011 оны Гадаад бодлогын үзэл баримтлалд “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” гэж цохон нэрлэсэн. Монгол Улс уг бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж байгаа билээ.

Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь хоёр хөршөөс бусад улсуудтай хоёр болон олон талт харилцааг хөгжүүлэх боломж олгодог. Улс төр, эдийн засаг, цэргийн хувьд хүчирхэг Орос, Хятадын дунд оршдог, далайд гарцгүй Монгол Улс энэхүү бодлогоо олон улсын харилцаанд аядуу бодлого баримталж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц зэрэг чухал салбаруудын хүрээнд олон улстай харилцаагаа хөгжүүлэх боломж гэж харах ёстой.

Олон улсын энхийн үйлсэд оруулж буй бидний хувь нэмэр, оролцоо бол “гуравдагч хөрш”- ийн бодлогын хамгийн бодитой хэрэгжиж буй чиглэл юм. Өрнө, дорнын хөгжингүй улсуудтай хөгжүүлж буй цэрэг, батлан хамгаалах салбарын харилцаа бол Монгол Улсын идэвхтэй гадаад бодлогыг олон улсад эерэгээр таниулж байгаа билээ. Түүнчлэн оршин буй бүс нутагтаа энх тайван тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт хамтын ажиллагааны механизмуудын оролцоог дэмжин ажиллана хэмээн аюулгүй байдал, гадаад бодлогын баримт бичгүүддээ тусгасан үзэл санаа, зорилго зорилт хэрэгжиж буйн нэг баталгаа болж байгаа юм.

Монгол Улс Үндсэн хуульдаа “...энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна ...” гэж тунхагласан нь манай улс олон улсын аюулгүй байдал, энхийн үйл хэрэгт дэмжлэг үзүүлэх арга замыг эрэлхийлж байдгийг харуулж буй билээ. Улмаар дэлхий дахины энхийн үйл хэргийг дэмжих, түүнд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах төрийн гадаад бодлогын хүрээнд Зэвсэгт хүчний алба хаагчдыг Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах болсон юм. Зэвсэгт хүчний цэргийн баг 2002 оноос эхлэн өнгөрсөн хугацаанд Ирак, Косово, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улс, Сьерра Леон, Чад, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Судан, Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс зэрэг олон улс оронд олон улсын эрх зүй, Монгол Улсын хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг баримтлан энхийг дэмжих ажиллагаанд давхардсан тоогоор хорин мянга гаруй алба хаагчид үүрэг гүйцэтгээд байна.

Монгол Улс даян дэлхийн энхийн үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулж ирсэн өнгөрсөн 20 жилийн үйлс нь манай төр засаг алсыг харсан зөв бодлого явуулж ирснийг нөгөө талаар Монгол Улс НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцооноор тус байгууллагын дүрмээр хүлээсэн бүрэн эрхт гишүүнийхээ үүргийг нэр төртэй биелүүлж байгааг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө илтгэн харуулж буйн зэрэгцээ улсынхаа бүрэн эрхт байдлыг бэхжүүлж буй хэрэг билээ.

Олон талт хамтын ажиллагаа

Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа бататган бэхжүүлэхийн зэрэгцээ даян дэлхийн улс орнуудын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэн харилцдаг бөгөөд үүнийгээ ч улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улс бусад улстай харилцахдаа бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, түүнчлэн хоёр талын харилцааны үндсэн баримт бичгүүдэд заасан бусад зарчмыг удирдлага болгоно” хэмээн тусгасан юм.



Эдүгээ Монгол Улс НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын нэр хүнд бүхий бусад томоохон байгууллагууд, нийт 60 гаруй байгууллагын гишүүн болж, олон улсын 300 гаруй гэрээ, хэлэлцээр, конвенц, протокол,

дүрэм, акт, пакт, зөвлөмж, тунхаглалд нэгдэн орж тэдгээрийн хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн дэлхийн 190 гаруй улстай дипломат харилцаа тогтоон харилцаж байгаа. Эдгээр баримтууд Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах түшиц болно. Сүүлийн үед бүс нутаг, дэлхий дахинаа өрнөж буй улс хоорондын харилцаан дахь ээдрээтэй олон асуудал, ялангуяа Монгол Улсын хоёр болон “гуравдагч хөрш”-үүдийн хоорондын зөрчилд ухаалаг бодлого баримталж, гадны түншүүдтэйгээ тэнцвэртэй харилцах суурь болж байна.

Аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах, дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах, дуу хоолойгоо хүргэхэд бидэнд олон талт хамтын ажиллагаа чухал үүрэгтэй юм. Монгол Улс 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсноос хойш тус байгууллагын үндсэн зорилго, зарчмуудыг тууштай дэмжиж, өөрийн хувь нэмрээ оруулж, идэвхтэй хамтран ажиллаж ирсэн.

Манай улс олон улсын энх тайван, аюулгүй байдал, зэвсэг хураах, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, ардчилал, засаглалыг бэхжүүлэх, эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн олон асуудлаар Ерөнхий Ассамблейн нийт 90 гаруй тогтоол санаачлан хэлэлцүүлж батлуулсан. Өдгөө “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай”, “Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай”, “Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүргийн тухай”, “Бичиг үсгийн боловсролын тухай”, “Ардчиллын боловсролын тухай” гэсэн Ерөнхий Ассамблейн 5 тогтоолыг тогтмол санаачлан батлуулж буй.

Монгол Улс 2000 оноос хойш зохион байгуулсан тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн санхүүжилт, гамшгийн эрсдлийг бууруулах болон далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дамжин өнгөрөх хамтын ажиллагааны

асуудлаарх томоохон хурал, дээд хэмжээний уулзалтуудад оролцож, тэдгээрээс гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж ирсэн. НҮБ нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчныг хамгаалах, ардчиллыг дэмжих, хүний эрхийг хамгаалах хүчин чармайлтыг дэмжиж ирсэн. Өнөөдрийн байдлаар НҮБ-ын системийн байгууллагууд, сан, хөтөлбөрийг төлөөлсөн 11 байгууллага Монгол Улсад суурин ажиллаж, манай хөгжлийн бодлого, үйл ажиллагааны чухал түнш байсаар ирлээ.

Хельсинкид 2006 онд болсон Ази, Европын дээд түвшний уулзалт буюу АСЕМ-ын төр, засгийн тэргүүн нарын бага хурлын үеэр манай улс АСЕМ-ын гишүүн болсон. АСЕМ-ын орнуудын Шилжилт хөдөлгөөн, суурьшилтын асуудлаарх цагаачлалын албаны удирдлагуудын 10 дугаар хурлыг Улаанбаатар хотноо 2011 онд, Ой болон усны асуудлаарх АСЕМ-ын Байгаль орчны сайд нарын чуулга уулзалтыг 2012 онд, АСЕМ-ын Дээд түвшний уулзалтыг 2016 онд Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулсан.

Монгол Улс нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-д 2012 онд элссэн. Гишүүн орны хувьд манай улс тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлийн (цэрэг, улс төрийн; эдийн засаг, байгаль орчин; хүний аюулгүй байдал) хүрээнд тухайлбал, терроризм, хил гааль, цагдаа, мансууруулах бодистой тэмцэх алба, хилийн менежмент, хүний аюулгүй байдлын асуудлуудад түлхүү анхаарч, тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Цөмийн зэвсгээс ангид статус

Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах тухай гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд манай улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулганы үеэр зарласан. Өнгөрсөн 28 жилийн хугацаанд түүнийгээ эрх зүйн үндэстэй болгон баталгаажуулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж ирсэн.

Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй хэмээн зарласан явдлыг олон улсын хамтын нийгэмлэг сайшаан хүлээн авч, дэмжлэгийг үзүүлж байсан бөгөөд үүний илрэл болж “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолыг анх 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганаар батлуулсан.

1998 оноос хойш 2 жил тутам батлагдаж байгаа Ерөнхий Ассамблейн “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолд “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах, улс төр, эдийн засаг, экологийн аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэх” тухайд Монгол Улстай хамтран ажиллахыг НҮБ-ын гишүүн улсуудад уриалсан байдаг.

Цөмийн зэвсэг бүхий 5 гүрэнтэй явуулсан яриа хэлэлцээний дүнд Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусийг дэмжих зорилгоор дээрх 5 улс 2000 онд Хамтарсан мэдэгдэл, 2012 онд Хамтарсан тунхаглал гаргасан¹⁰.

Эцэст нь өнөө хүртэл явуулж ирсэн гадаад бодлогынхоо ачаар Монгол Улс нь олон улсын харилцааны бүрэн эрхт нэгэн оролцогч болж чаджээ. Монгол Улс нь НҮБ, ДХБ, ДБ, АХБ, АСЕМ зэрэг олон улсын байгууллагын гишүүн бөгөөд 10 орчим олон улсын байгууллагатай эрчимтэй хамтран ажиллаж байна. Монголд Улс 2022 оны байдлаар дэлхийн 193 оронтой дипломат харилцаатай байна. Тэдгээрт Монгол Улсын Элчин сайдын яам болон Ерөнхий Консулын газар, Консулын төлөөлөгч үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн үүнээс гадна Монгол Улсын Өргөмжит консулууд мөн бусад улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа. Улаанбаатарт гадаадын хорь гаруй орны Элчин сайдын яам, орон нутагт гадаадын (ОХУ-Дархан, БНХАУ-Замын-Үүд) Ерөнхий консулын газар үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнчлэн 2020 оны байдлаар Монгол Улсын энгийн паспорттай иргэд дэлхийн 19 оронд визгүй зорчиж байгаа бөгөөд албан, дипломат паспорттой иргэд дэлхийн 45 оронд визгүй зорчиж байна.

¹⁰ ЦӨМИЙН ЗЭВСГЭЭС АНГИД СТАТУС”, <https://mfa.gov.mn/%D1%86%D3%A9%D0%BC%D0%B8%>

Ашигласан материал, ном зүй:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ 1994.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ 2010.
3. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, УБ 2011.
4. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, УБ 2015.
5. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, УБ 2020.
6. “Монгол улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны асуудлууд”, МУИС-ОУХНУС-ийн өгүүллийн эмхтгэл, УБ, 2019.
7. Ц.Батбаяр. “Монгол ба Их Гүрнүүд ХХ Зуунд”. 1 боть. УБ, 2015
8. “ХХ ЗУУНЫ МОНГОЛ: Түүх, Соёл, Геополитик, Гадаад Харилцааны Тулгамдсан Асуудлууд”. ШУА, МУИС-ОУХНУС. УБ, 2017
9. “МОНГОЛ УЛСЫН ГУРАВДАГЧ ХӨРШИЙН БОДЛОГО. МОНГОЛ-ЕВРОП: БОДЛОГО, ЗОРИЛТ”. Эрдэм Шинжилгээний Цуврал Бага Хурлын Эмхтгэл. УБ, 2012
10. “МОНГОЛ УЛСЫН ГУРАВДАГЧ ХӨРШИЙН БОДЛОГО: ХАМТЫН АЖИЛЛАГААГААР АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ НЬ”. Эрдэм Шинжилгээний Цуврал Бага Хурлын Эмхтгэл. УБ, 2013
11. SOYOLGEREL Nyamjav “Eurasian Geostrategies: A Chinese-Russian Condominium over Eurasia and the Involvement of Mongolia”, ERINA Journal, 2017
12. Монгол-Энэтхэгийн Стратегийн түншлэлийг улам бэхжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл, Гадаад харилцааны яам, 2019.09.20 <http://www.mfa.gov.mn/?p=52581>

13. XX зууны Монгол: түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд, УБ, 2017
14. Д.Төмөртоогоо “Монгол судлал бол гадаад бодлогын нэг хэсэг” 2015.01.08 <http://vip76.mn/content/29127>
15. Jargalsaikhan Mendee, Mongolia’s Quest for Third Neighbours: Why the European Union? EUCAM Policy Brief / No. 25, July 2012 <https://eucentralasia.eu/2012/07/mongolias-quest-for-third-neighbours-why-the-european-union/>
16. Alicia Campi, Ragchaa Baasan. “The Impact of China and Russia on United States-Mongolian Political Relations in the Twentieth Century”. 2014
17. “China’s Evolving Approach to Economic Diplomacy” Asia Policy Vol. 22 pp. 157- 191 Hudson, J (2015)
18. “Central Asia in a Reconnecting Eurasia” CSIS <https://www.csis.org/analysis/central-asia-reconnecting-eurasia> Lain, S (2014)
19. “China’s Strategic Presence in Central Asia” Xinhua http://news.xinhuanet.com/english/china/2013-09/07/c_132700695.htm Lee, J Y, Kisoon H, and Ling, J (2015)

ДАА** 320
ННА* 66
У-314



УЛСТӨР & НИЙГЭМ ДЭЭЖ МЭДЛЭГ

УЛСТӨР & НИЙГЭМ

ДЭЭЖ МЭДЛЭГ



Монгол дахь Конрад-Аденауэр-Сан
Меру Тауэр, 8 давхар
Жамьян гүний гудамж 18-2
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот 14210
Монгол Улс

www.kas.mongolia
www.facebook.com/kas.mongolia
www.kas.edu.mn

